



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



2018-2019 оны хичээлийн
ЖИЛИЙН ТАЙЛАН



1959
ШУТИС

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

Улаанбаатар хотноо
2020 оны
12 сард
10 сард
10 сард



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛЬ**

2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот

Хянасан:

Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзориг
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Арслан

Эмхэтгэсэн:

ЗХНГ-ын мэргэжилтэн Ш.Доржсүрэн

Үсгийн гагнитур: Times New Roman

Хэвлэлийн хэмжээ: B5 /176x250/

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо:

ШУТИС, Хэвлэлийн газарт хэвлэв



Өмнөх үг	
Нэг. Удирдлага, зохион байгуулалт	8
1.1. Удирдах зөвлөлг	8
1.2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа.....	10
1.3. Захирлын зөвлөл	12
1.4. Хөгжлийн хөтөлбөр төлөвлөлт.....	13
1.4.1. Төсөв, төлөвлөлтийн талаар.....	14
Хоёр. Сургалтын үйл ажиллагаа	28
2.1. Бакалаврын сургалт.....	28
2.1.1. Элсэлт	28
2.1.2. Сурагцагчдын тоо, үнэлгээний голч дүн (gra).....	35
2.1.3. Улирлын шалгалт	40
2.1.4. Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт	41
2.1.5. Судалгаа.....	43
2.1.6. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	47
2.1.7. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт	48
2.1.8. Төгсөлт.....	49
2.1.9. Судалгаа.....	52
2.1.10. Бусад.....	53
2.2. Магистрын сургалт.....	53
2.2.1. 2018-2019 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт	53
2.2.2. Магистрантурын элсэлт	55
2.2.3. Магистрантурын сургалтын төгсөлт	55
2.3. Докторын сургалт	58
2.3.1. Докторантурын сургалтын элсэлт.....	59
2.3.2. Докторантурын сургалтын төгсөлт.....	60
2.4. Нээлттэй боловсролын төв	65
2.4.1. Удирдлага зохион байгуулалтын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	65
2.4.2. Сургалтын чанар, орчин, хүртээмжийг дээшлүүлэх	65
2.4.1. “Эрдэм шинжилгээ, инноваци, судалгаанд суурилсан инновацийг хөгжүүлэх	68
2.4.2. Сургалтын үйл ажиллагаа:	69
2.4.3. Төгсөлт.....	70
2.4.4. Багшлах эрх олгох сургалт.....	70
2.4.5. Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар, уулзалт	70
Гурав. Эрдэм шинжилгээ, инноваци	78
3.1. Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа	78
3.2. Судалгаа, боловсруулалтын ажил.....	85
3.3. Судалгааг дэмжих технологийн сан.....	86
3.4. Улсын захиалгат төсөл, хөтөлбөр.....	88
3.5. Гадаадтай хамтарсан улсын захиалгат төсөл	90
3.6. Олон улсын санхүүжилттэй төсөл.....	91
3.7. “Инженер технологийн дээд боловсрол” (m-jeed) төсөл.....	93
3.8. Гэрээт ажил.....	97
3.9. Судалгааны хүрээлэн, төв	100
3.10. Гарааны компани.....	104
3.11. Судалгааны лаборатори	105
3.12. Судалгааны хүний нөөц	109
3.13. Оюуны өмчийн эрхийн хамгаалалт	112
3.14. Эрдэм шинжилгээний хэвлэн нийтлэл.....	114
3.15. Эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа.....	121

Дөрөв. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	126
4.1. Шутис-ийн багш, ажилтны гадаад томилолт, мэргэжил дээшлүүлэлт	126
4.2. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг	128
4.3. Гадаадын мэргэжилтэн, багш зочин профессор.....	129
4.4. Оюутан солилцоо, гадаадын тэтгэлэг	130
4.5. Гадаадын тэтгэлгүүд	132
4.6. Гадаадын хөрөнгө оруулалт, оу-ын төсөл хөтөлбөр.....	132
Тав. Оюутны хөгжил, үйлчилгээ	136
5.1. Хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа.....	136
5.2. Оюутны санаачилгыг дэмжих төсөл	143
5.2. Оюутны клуб.....	144
5.3. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт	149
5.4. Оюутны үйлчилгээ.....	155
5.5. Оюутны байрны үйлчилгээ	158
5.6. Нэгдсэн арга хэмжээ	159
5.7. Олон нийт нийгэмд чиглэсэн ажил	164
5.8. Хөдөлмөр эрхлэлт	167
5.9. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр.....	170
Зургаа.номын сангийн үйлчилгээ	176
6.1. Шинжлэх ухаан, технологийн номын сан	176
6.2. Номын сангийн үйлчилгээ, фонд бүрдүүлэлт.....	177
6.3. Сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээ.....	181
Долоо. Шутис-ийн чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ.....	188
7.1. Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ.....	188
7.1.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох.....	188
7.2. Шутис-ийн дотоод аудит.....	191
7.3. Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	197
7.4. Байр ашиглалт	213
Найм. Санхүү нягтлан, бодох бүртгэл 218	
8.1. Эргэлтийн хөрөнгө	219
8.1.1. Авлага.....	211
8.2. Бараа материал	222
8.2.1. Эргэлтийн бус хөрөнгө	224
8.2.2. Өр төлбөр, эзний өмчийн шинжилгээ	226
8.3. Орлого	228
8.3.1. Үндсэн үйл ажиллагааны орлого	232
8.3.2. Эрдэм шинжилгээний орлого	236
8.3.3. Туслах үйл ажиллагааны орлого	238
8.3.4. Төсвөөс санхүүжих орлого	239
8.4. Зардал.....	240
8.4.1. Сургалттай холбоотой шууд зардал	243
8.4.2. Шууд бус зардал	246
8.4.3. Оюутны үйлчилгээний зардал	250
8.4.4. Эрдэм шинжилгээний зардал.....	252
8.4.5. Хөрөнгө оруулалтын зардал.....	254
4. Санхүүгийн үр дүн	254

ӨМНӨХ ҮГ

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрхэм хүндэт профессор багш, ажилтан ажиллагсад оюутан залуучууд бид өнгөрсөн хичээлийн жилд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, 60 жилийн ойгоо, хөдөлмөр бүтээлийн өндөр амжилтаар угтах хөдөлгөөн өрнүүлж, багш, ажилтан, оюутан суралцагчид дор бүрнээ бахдам сайхан амжилт гаргасан жил байлаа. 60 жилийн ойгоо манай сургуулийн багш, ажилтан, оюутан суралцагчид дор бүрнээ амжилт гаргаж, хөдөлмөр бүтээлээр угтсан жил байлаа.

ШУТИС-ийн 60 жилийг ойг тэмдэглэх ерөнхий төлөвлөгөө, ойн хүрээнд бүрэлдэхүүн сургууль, нэгж бүрийн ажлын төлөвлөгөөг гарган, ШУТИС-ийн 60 жилийн ойн нэрэмжит багш ажилчдын спортын наадам, “Эрдмийн чуулган-2019”, “Ирээдүйн мэргэжилтэн-бидний оролцоо” нээлттэй хаалганы өдөр, “Оюутны урлагийн XVIII их наадам”, “FICASE 2019” олон улсын эрдэм шинжилгээний хурал, багш, ажилтны “Урлагийн наадам”, “ШУТИС-60” түүхэн гэрэл зургийн цуврал үзэсгэлэн, Ахмадын баяр, “Манлайлагч оюутан” зэрэг хамт олны 40 гаруй бүтээлч ажлыг зохион байгууллаа.


ШУТИС үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлж, CDIO-гийн стандарт, арга зүйг ашиглан инженерийн боловсролын 26 хөтөлбөрийг шинэчлэн хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. “Судалгаанд суурилсан их сургууль” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ахисан түвшний инженерийн сургууль байгуулж, судалгааны лабораториудыг төрөлжүүлэх, олон улсын болон үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх ажлуудыг хийж байна. Энэ хичээлийн жилийн бас нэг онцлог бол үйлдвэрлэл дээр ажил эрхэлж буй ажилчин залуучуудыг мэргэжлээ дээшлүүлэх, инженер, технологийн дээд боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор инженерийн бэлтгэл хөтөлбөр-оройн ангийг бүх бүрэлдэхүүн сургууль сэргээн нээн хичээллүүлэхийг шийдвэрлэсэн явдал юм. Мөн Цахилгаан холбоо, Утасгүй холбоо мэргэжлийн хөтөлбөрийг АНУ-д төвлөрч үйл ажиллагаа явуулдаг олон улсын нэр хүнд бүхий инженер, технологийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн “АВЕТ” байгууллагаар Цахилгаан холбоо, Утасгүй холбоо мэргэжлийн хөтөлбөрийг Монгол улсаас анх удаа амжилттай магадлан итгэмжлүүллээ.

“Ази номхон далайн бүсийн орнуудын оюутан залуусын дунд зохион байгуулагддаг “ABU Robocon” тэмцээн 18 жилийнхээ түүхэнд анх удаа Монгол улсад “ABU Robocon Ulaanbaatar-2019” нэртэй 2019 оны 8 сарын 25-ны өдөр зохион байгуулагдлаа. Манай МХТС-ийн оюутны 1, 2 дугаар багууд ABU-Робокон 2019 тэмцээнд 1 дүгээр байр эзэлж ШУТИС-ийн төдийгүй эх орныхоо нэрийг өндөрт өргөж, баяр дээр баяр нэмлээ. Энэ нь Монгол улсын хувьд анхны бөгөөд түүхэн өндөр амжилт болж байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалт, судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа ШУТИС-ийн шилдэг эрдэмтэн профессор багш, ажилчдыг Монголын багш нарын 53, дэлхийн багш нарын 25 дахь өдрийн баярыг тохиолдуулан ШУТИС-ийн Тусгай өргөмжлөл, профессор, дэд профессор цол, Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит шагнал, Оны шилдэг багшийн шалгаруулалт, профессор багш нарын шилдэг сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага, орчуулгын бүтээлийн шагналаар тус тус шагнаж урамшуулав. Энэ бүх амжилт бол манай эрдмийн хамт олны нөр их хөдөлмөр зүтгэлийн бодит үр дүн, түүхт 60 жилийн ойдоо барьж буй бидний бэлэг юм.

Шинэ хичээлийн жилд бид энэ ололт амжилтаа улам бататгаж их сургуулийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх, судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж эхлэх зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. ШУТИС-ийн эрхэм хүндэт профессор багш, оюутан, суралцагчид та бүхэнд шинэ хичээлийн жилдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе!

ШУТИС-ийн РЕКТОР



Б.ОЧИРБАТ



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШУТИС бүрэлдэхүүн болон харьяа сургууль, ахисан түвшний сургууль, коллеж, ахлах сургууль, сургалт, судалгаа, инновацийн хүрээлэн, төв зэрэг зохион байгуулалтын бүтэцтэй ажиллав.

Улаанбаатар хотод 10, орон нутагт 1, нийт 11 бүрэлдэхүүн сургууль, ШУТИС-Коосен технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв, ШУТИС-ийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуультай үйл ажиллагаа явуулаа.

Өнгөрсөн хичээлийн жилд ШУТИС-ийн захиргаа, удирдлагын түвшинд 5 газар, 8 алба, 4 төвтэй үйл ажиллагаа явуулаа. ШУТИС-ийн захиргаа нь ШУТИС-ийн Захирал, Сургалт, оюутны асуудал эрхэлсэн, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн 5 дэд захирал, Захиргаа, хүний нөөцийн газар, Сургалтын бодлого зохицуулалтын газар, Эрдэм шинжилгээ, инновацийн газар, Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар, Хөрөнгө оруулалт, хангамжийн газар, Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба, Оюутны соёл, үйлчилгээний алба, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба, Маркетинг, олон нийттэй харилцах алба, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба, Байр ашиглалтын нэгдсэн алба, Нээлттэй боловсролын төв, Мэдээллийн технологийн төв, Технологи дамжуулах төв, Эрүүл мэнд, спортын төв, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, ШУТИС-Хэвлэлийн газар үйл ажиллагаа явуулав.

1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг өөрчлөн (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/272 дугаар) тушаалаар ШУТИС-ийн удирдах зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй ажиллав.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.1

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I. Төрийн төлөөлөл			
1	Дарга	Б.Ганбат	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын зөвлөх
2	Дэд дарга	Т.Амаржаргалан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	С.Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
4		Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга
5		Т.Гантогтох	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
6		С.Цэрэнжамц	Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга

7		Н.Бат-Эрдэнэ	Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
8		А.Халиунаа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсролын хэлтсийн дарга
9		Б.Энхтуяа	Нийгэм, эдийн засгийн судалгаа сан төрийн бус байгууллагын тэргүүн
II. Хамт олны төлөөлөл			
10	Гишүүн	Л.Оюунцэцэг	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн профессор
11		Д.Оюун	Геологи, уул уурхайн сургуулийн профессор
12		И.Базаррагчаа	Механик, тээврийн сургуулийн ахлах багш
13		Д.Болор	Эн Си Эс ХХК-ийн гүйцэтгэх захирал
14		Б.Ганбаатар	“ДЦС-3-ийн түлш дамжуулах цехийн шинэчлэл” төслийн удирдагч
15		С.Болд-Эрдэнэ	Геологи, уул уурхайн сургуулийн оюутан

Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А/202 тоот тушаалаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг нэгдүгээр хавсралтаар, Боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсан. Хүснэгт 1.2-д шинэчлэгдсэн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг үзүүлэв.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.2

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I. Төрийн төлөөлөл			
1	Дарга	Д.Бадарч	УИХ-ын даргын Нийгмийн бодлогын зөвлөх
2	Дэд дарга	Т.Амаржаргалан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	С.Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга
4		Б.Гүнчинхүү	Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын референт
5		Ж.Ганбат	СЯ-ны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
6		Т.Гантогтох	Хүнс хөдөө аж, ахуй хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга
7		Х.Мандахцэцэг	ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын дарга
8		Б.Дамдинсүрэн	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн зөвлөх профессор
9		Д.Баяр	БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын ахлах мэргэжилтэн
II. Хамт олны төлөөлөл			
10	Гишүүн	Д.Цолмонбаатар	Механик тээврийн сургуулийн захирал

11		Б.Сэргэлэн	Эрчим хүчний сургуулийн салбарын эрхлэгч
12		Я.Төгөлдөр	Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн салбарын эрхлэгч
13		Д.Болор	Эн Си Эс ХХК-д гүйцэтгэх захирал
14		Ц.Энхбаатар	“ШУТИС-Бидний бахархал” төгсөгч, дэмжигчдийн холбооны тэргүүлэгч гишүүн
15		С.Болд-Эрдэнэ	Геологи уул уурхайн сургуулийн оюутан

ШУТИС-ийн Удирдах зөвлөл өнгөрсөн хичээлийн жил 4 удаа хуралдаж ШУТИС-ийн 2018 оны зарлагын төсөвт өөрчлөлт оруулах, ШУТИС-ийн 2019 оны төсөв батлах, Ахисан түвшний сургууль байгуулах, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль байгуулах, ШУТИС-ийн зарим нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах, хичээлийн байрны төлөвлөлтийг шинэчлэх, Удирдах зөвлөлийн дарга сонгох, томилох, Удирдах зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн даргыг сонгох, Барилга, архитектурын сургуулийн лабораторийн барилга барих газрыг шилжүүлэх, ШУТИС-д эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах, Элсэлтийн хяналтын тоо батлах ШУТИС-ийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх, үндсэн хөрөнгөд бүртгэх, сургалтын нэг кредитийн үнэлгээг тогтоох, оюутны байрны төлбөр, ШУТИС-ийн дэргэд гарааны компани байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, тодорхой шийдвэрүүдийг гаргажээ.

Хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд Удирдах зөвлөлийн гишүүд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018-2019 оны хичээлийн жилд Эрдмийн зөвлөл 4 удаа хуралдаж, зарим сургууль, газар, нэгж, салбар тэнхимийн бүтэц зохион байгуулалт, дүрэм журамд өөрчлөлт оруулах болон эрдмийн ба хүндэт цолд нэр дэвшигчдийг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал

Хүснэгт 1.3

д/д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1	ШУТИС-ийн Хүндэт профессор, профессор цол олгох тухай	2018.10.11	№14, 15
2	ШУТИС-д Ахисан түвшний сургуулиуд байгуулах, зарим бүтцийн нэгжүүдийг өөрчлөн зохион байгуулах тухай, “ШУТИС-ийн түүхэн замнал” цуврал номын явц, цаашид авах арга хэмжээ, ШУТИС-ийн үндсэн сурах бичиг хэвлүүлэх явцын тухай, ШУТИС-д чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх төслийн тухай	2018.12.18,	№16,17,18,19

3	ШУТИС-ийн зарим мэргэжлийн салбар, тэнхимүүдийг өөрчлөх, шинээр зохион байгуулах тухай	2019.01.25	№01
4	ШУТИС-ийн профессор, дэд профессор, Хүндэт профессор цол олгох тухай, “Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2019.06.05	№02,03,04,05,06,07

Түүнчлэн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд эрдэм шинжилгээний хуанли, төлөвлөгөөний дагуух асуудлыг 6 удаагийн хурлаар хэлэлцэж дараагийн шатны хуралд оруулсан байна.

Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал

Хүснэгт 1.4

д/д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл			
1	ШУТИС-ийн Хүндэт профессор, профессор цол олгох тухай	2018.10.10	№02
2	ШУТИС-ийн профессор, дэд профессор, Хүндэт профессор цол олгох тухай	2019.06.03	№01
Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл			
1	Шилдэг залуу судлаачид нэр дэвшихийг дэмжих тухай	2018.10.19	№04
2	Төслийн эцсийн тайлан, “ШУТИС-хүнс” гарааны компанийн тайлан, “ШУТИС-Модон араг, бүтээц” гарааны компани байгуулах тухай, “ШУТИС-ийн барааны тэмдэгт ашиглах журам”-ын төслийн танилцуулга,	2018.12.14	№05
3	Төслүүдийн эцсийн тайлан	2018.12.31	
4	Төслүүдийн эцсийн тайлан хэлэлцэх, Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай	2018.06.18	

Тайлант онд ШУТИС-ийн хүндэт профессор цол 3, профессор цол 1, дэд профессор цол 24 хүн тус тус цол хүртсэн байна.

ШУТИС-ийн “Хүндэт профессор” цол хүртсэн хүмүүс

Хүснэгт 1.5

д/д	Овог нэр	Байгууллага	ЭЗ-ийн тогтоолын дугаар	Захирлын тушаал
1	Хоохор Бадамсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал	2018.10.11, №15	2018.10.15, №А/206
2	Жи Вуук Шин /Gi Wook Shin/	Станфордын их сургуулийн профессор	2019.06.05, №06	2019.06.18, №А/143
3	Жон Хун Ким /Jeong Hun Kim/	Кисвэ мобайл ХХК-ийн захирал	2019.06.05, №06	2019.06.18, №А/143

ШУТИС-ийн профессор, дэд профессор цол хүртсэн хүмүүс

Хүснэгт 1.6

д/д	Овог нэр	Сургууль	Эрдмийн зөвлөлийн тогтоол	Захирлын тушаал
Профессор				
1	Жамсран Амгалан	ДаТС	2019.06.05, №04	2019.06.18, № А/142
Дэд профессор				
1	Доржгочоо Сарангэрэл	МХТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
2	Дагва Барсболд	БАТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
3	Мижиддорж Банзрагч	БАТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
4	Авирмэд Энхбат	БУХС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
5	Сүхбат Туяа	БУХС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
6	Дангаасүрэн Одмаа	БУХС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
7	Цэрэннадмид Сэлэнгэ	ҮТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
8	Цэдэнбазар Энхбаатар	ГХС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
9	Доржжав Болор-эрдэнэ	ЭрТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
10	Галдансамбуу Саран	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
11	Тамжав Баяртөгс	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
12	Намхай Баттулга	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
13	Алтанцэцэг Сарнай	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
14	Вандандоо Өлзийбаяр	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
15	Базаргүр Пүрэвжаргал	ДаТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
16	Мижир Сугар	БАС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
17	Жамц Алтанцэцэг	БАС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
18	Балжаа Оюунчимэг	БАС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
19	Даваагийн Ундармаа	ГУУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
20	Цэен-Ойдов Батсайхан	ҮТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
21	Ганболд Ганчимэг	НБТ	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
22	Дашрэнчин Хандмаа	ХШУС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
23	Галсан Бэхбат	ЭХС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144
24	Ишдорж Цэрэн-Онолт	МХТС	2019.06.05, №05	2019.06.18, № А/144

1.3. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах саналаа бүрэлдэхүүн сургууль, институт, захиргааны газар, алба нэгжээс авч, нэгтгэн батлуулав.

Тайлант хугацаанд захирлын зөвлөлийн хурал батлагдсан төлөвлөгөөний дагуу 30 удаа хуралдаж элсэлтийн хяналтын тоо, төсөв, төсвийн тодотгол, төлөвлөгөө, тайлан баланс, цалин, элсэлт төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, бодлогын баримт бичиг, багш, ажилчдын нийгмийн асуудал, ой тэмдэглэх, уралдаан зарлах, гадаад харилцаа, ахисан түвшний сургууль байгуулах тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл

/хөтөлбөрүүд/-ийн явц, үр дүн, засвар тохижилтын ажил, эрдэм шинжилгээний болон сургалтын нэгдсэн хуанли, цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал болон хурлын шийдвэрийг цаг тухай бүрт нь их сургуулийн <https://www.must.edu.mn/mn/content/t/5> веб хуудаст байршуулан ажиллаж байна.

ШУТИС-ийн захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.7

Д/д	Овог нэр	Албан тушаал
1	Б.Очирбат	ШУТИС-ийн Захирал
2	Х.Энхжаргал	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал
3	Т.Намнан	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал
4	Б.Сүхбат	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал
5	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал
6	Ц.Баатархүү	Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал
7	Н.Ганзориг	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
8	Э.Нинжгарав	Барилга, архитектурын сургуулийн захирал
9	А.Энхбат	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн захирал
10	Л.Пүрэв	Геологи, уул уурхайн сургуулийн захирал
11	Б.Соёлсүрэн	Гадаад хэлний сургуулийн захирал
12	Ц.Батбаатар	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн захирал
13	Д.Цолмонбаатар	Механик, тээврийн сургуулийн захирал
14	Н.Чулуунбанди	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн захирал
15	Ж.Туяацэцэг	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн захирал
16	Д.Ганхуяг	Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн захирал
17	Ч.Мангалжалав	Эрчим хүчний сургуулийн захирал
18	Г.Баттүвшин	Бизнесийн ахисан түвшний сургуулийн захирал
	Я.Наранцэцэг	Е-Нээлттэй институтийн захирал
19	Д.Зоригтхүү	Орхон аймаг дахь Технологийн сургуулийн захирал
20	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
21	С.Болд-Эрдэнэ	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн

1.4. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨЛТ

ШУТИС-ийн хэмжээнд хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд дараах үндсэн ажлыг гүйцэтгэв. Үүнд:

1. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс 2019 оны төсвийн төслийн саналыг хүлээн авч нэгтгэн 2 удаа хэлэлцүүлэг хийж захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Удирдах зөвлөлөөр батлуулах саналыг хүлээн авсан.
2. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 сарын 21-ний өдрийн 14 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2019 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулсан.
3. ШУТИС-ийн УЗ-ийн 2018 оны 12 сарын 21-ний өдрийн 13 тоот тогтоолоор 2018 оны батлагдсан зарлагын төсөвт тодотгол хийсэн.
4. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 2018 оны тодотгосон орлого, зарлагын төсвийг баталгаажуулан нэгжүүдэд илгээсэн.

5. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд 2019 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт, бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулж тараасан.
6. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс батлагдсан төсөвт орлого зарлагын сарын хуваарь авч, нэгтгэн боловсруулж батлуулан тараав.
7. ШУТИС-ийн захирлын 2019 оны 01 сарын 02-ны өдрийн А/04 , 2019 оны 01 сарын 28-ны өдрийн А/30 тоот тушаалуудад үндэслэн бүтцийн өөрчлөлт хийгдсэн БУХС, БАТС, ГХИ, ЕНИ, НБТ-ийн орлого, зарлага, худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан баталж тараав.
8. ШУТИС-ийн багш ажилтнуудад ажлын үр дүнгийн урамшуулал олгохтой холбогдуулан 2018 оны 9 сараас 2019 оны 1 сарыг дуусталх багш ажилтнуудын цалингаас түүврээр хийж тооцоолол хийв.
9. 2020 оны төсвийн төсөл, нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийн саналыг бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс хүлээн авч нэгтгэн боловсруулав.
10. Төрийн өмчийн их дээд сургуулиудын нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийн талаар судалгаа хийсэн.
11. 2019-2020 оны хичээлийн жилийн нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийн талаар танилцуулга боловсруулж захирлын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэв.
12. ШУТИС-ийн УЗ-ийн 2019 оны 06 сарын 03-ны өдрийн хурлаар 2019-2020 оны хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээ, оюутны байрны төлбөрийн саналыг хэлэлцүүлэв.
13. ШУТИС-ийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэлдэхүүн сургуулиудаар сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж 2018 оны 10 сарын 30-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.
14. ШУТИС-ийн 2017-2018 оны үйл ажиллагааны статистик үзүүлэлтүүдийг гаргаж ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2018 оны 10 сарын 30-ны хурлаар хэлэлцүүлэв.
15. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч ШУТИС-ийн нэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулав.
16. ШУТИС-ийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2030)-ийг боловсруулан захирлын зөвлөлд танилцуулж ШУТИС-ийн нийт багш ажилтнуудыг хамарсан хэлэлцүүлэгт оролцов.

1.4.1. Төсөв, төлөвлөлтийн талаар

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн үзүүлэлтийн санхүүгийн жилтэй уялдуулан тооцож тайлагнадаг.


ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд 2019 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийг хүргүүлэн “ШУТИС-2021” мастер төлөвлөгөөний зорилго, зорилтуудын хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг 2019 оны төсөвтэй уялдуулан боловсруулснаараа тус оны төсөв нь онцлог шинжтэй болсон юм. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс ирүүлсэн саналыг хянаж боловсруулан 2 удаа төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулж ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хуралд танилцуулсан. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар төсвийн орлогыг 56,975.6 сая төгрөгөөр, зардлыг 56,975.4 сая төгрөгөөр орлогын зардлын зөрүү 226.5 мянган төгрөгийн эерэг үр дүнтэй байхаар батлуулж бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд хүргүүлэв.

А. ТӨВЛӨРСӨН БУС МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ТАЙЛАН

БСШУСЯ-ны Сайдын 2003 оны №221 тушаалын дагуу 2018-2019 оны хичээлийн жилийн Төвлөрсөн бус мэдээллийн маягт ДБ1-ДБ13 хүртэлх маягтуудыг нэгтгэн хянаж БСШУЯ-д хүргүүлэв. Үүнд:

ДБ-1 Суралцагчид /мэргэжил, анги, хүйсээр/, ДБ-2 Суралцагчдын сургалтын зардал, хангамж /ангиар/, ДБ-3 Суралцагчид /дотоод, гадаад, нас хүйсээр/, ДБ-5 Удирдах ажилтан багш, ДБ-7 Суралцагчдын орон нутгийн харьяалал, ДБ-8 Суралцагчдын шилжилт хөдөлгөөн /гадаад, дотоод, ангиар/, ДБ-9 Ажиллагсад, ДБ-10 Үндсэн багшийн хөдөлгөөн, ДБ-12 Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, ДБ-13 Гадаад суралцагчид.

2016-2017 оны хичээлийн жилд нийтдээ 19866 оюутан, 2017-2018 оны хичээлийн жилд нийтдээ 17187 оюутан суралцсан, 2018-2019 оны хичээлийн жилд оюутны тоо 6,3% -иар буурсан байна.




Зураг 1.1. ШУТИС-ийн суралцагчидын судалгаа /зэргээр/

ШУТИС-д суралцагчдын тоо /орон нутгаар/

Д/д	Орон нутгийн нэр	Бакалавр	Магистр	Доктор
1	Архангай	1034	284	28
2	Баян-Өлгий	208	14	3
3	Баянхонгор	387	21	2
4	Булган	331	17	5
5	Говь-Алтай	405	22	6
6	Дорноговь	262	20	3
7	Дорнод	400	19	0
8	Дундговь	310	20	3
9	Завхан	608	42	7
10	Өвөрхангай	776	53	11
11	Өмнөговь	273	24	2
12	Сүхбаатар	254	61	2


13	Сэлэнгэ	423	45	8
14	Төв	405	36	8
15	Увс	655	30	6
16	Ховд	499	20	7
17	Хөвсгөл	692	59	9
18	Хэнтий	397	25	7
19	Дархан-Уул	446	30	9
20	Улаанбаатар	4981	512	130
21	Орхон	492	127	7
22	Говь-Сүмбэр	91	5	0
23	Бусад	15	6	6
БҮГД		14344	1492	269

Хүснэгт 1.8




Зураг 1.2. ШУТИС-ийн суралцагчидын судалгаа/курсээр/

Суралцагчдыг курсээр нь авч үзвэл 1-р курст хамгийн өндөр буюу 4319 оюутан 2018-2019 оны хичээлийн жилд суралцаж байна.




Зураг 1.3. ШУТИС-д бакалаврын зэргээр суралцагсдын тоо



Зураг 1.4. ШУТИС-д магистр, докторын зэргээр суралцагчдын тоо (орон нутгаар)

Нийт суралцагчдыг аймгаар нь авч үзвэл бакалаврын сургалтад Улаанбаатар хотоос хамгийн их буюу 4981, аймгуудаас Архангай 1034, магистр оюутан Улаанбаатар 512, Архангай 284, доктор оюутан Улаанбаатараас 130, Архангайгаас 28 тус тус суралцаж байна.




Зураг 1.5. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутны тоо

27 гадаад оюутны 44% буюу 12 нь БНХАУ-ын суралцагч байна.

ШУТИС-ийн бакалаврын зэргээр суралцагчдын насны ангилал

Хүснэгт 1.9

Насны бүлэг	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
16 хүртэл	6	3	3
16 настай	40	54	69
17 настай	971	1228	1564
18 настай	3141	3142	2955
19 настай	3463	2869	2800
20 настай	3091	3052	2455
21 настай	2264	2200	2079
22 настай	1342	1263	1091
23 настай	744	665	609
24 настай	529	418	340
25 настай	351	338	251
26 настай	331	262	220
27 настай	252	239	176
28 настай	202	223	191
29 настай	153	163	169
30-34 настай	572	574	584
35-39 настай	263	298	315
40-өөс дээш	218	196	234



Зураг 1.6. Бакалаврын зэргээр суралцагчдын насны ангилал

ШУТИС-ийн нийт оюутны ихэнх нь 18-21 насны залуус байна. Бакалаврын түвшинд 2017-2018 оны хичээлийн жилд 12526 оюутан, 2018-2019 оны хичээлийн жилд хамгийн их буюу 14344 оюутан суралцсан байна.

ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтны тоо

Хүснэгт 1.10

	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
Төв удирдлагын удирдах ажилтан	19	22	25
Төв удирдлагын захиргааны ажилтан	61	66	80
Төв удирдлага дахь аж ахуй, үйлчилгээний ажилтан	84	82	89
Бүрэлдэхүүн сургуулиудын удирдах ажилтан	38	37	36
Бүрэлдэхүүн сургуулиудын захиргааны ажилтан	159	156	128
Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын үйлчилгээний ажилтан	154	152	170
Бүрэлдэхүүн сургууль дахь аж ахуй, үйлчилгээний ажилтан	229	232	213
Нийт багшийн тоо	1005	973	939
Ахмад гэрээт багш	95	78	93
НИЙТ	1844	1798	1773

Удирдах ажилтан, багш нарын тоо /албан тушаалаар/

Хүснэгт 1.11

Д/д	Сургууль	Багш ажилтны тоо	Багшийн тоо	Үүнээс:						
				Салбар тэнхимийн эрхлэгч	Зөвлөх профессор	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Даллагажигч багш
1	БАС	156	104	3	2	1	13	43	38	4
2	БуХС	163	103	4	3	6	8	49	32	
3	БАТС	19	13	1		2	3	5	2	1
4	ГУУС	156	100	5	5	8	11	36	35	
5	ДаТС	134	78	4		2	3	26	42	1
6	МеТС	141	73	4	3	5	8	25	25	3
7	МХТС	161	98	5	2	5	10	31	44	1
8	ҮТС	155	80	4	2	6	6	41	18	3
9	ХШУС	149	108	4	3	4	7	48	39	3
10	ЭХС	117	68	3	2	3	8	22	27	3
11	ГХИ	112	96	3	1	1	2	48	40	1
12	ШУТАС	23	16						16	
15	Коосэн	21	14						14	
14	Захиргаа	213	19	1			1	8	9	
15	НИЙТ	1720	970	41	23	43	80	382	381	20

ШУТИС-ийн профессор багш нарын эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувь

Хүснэгт 1.12

Д/д	Сургууль	Шинжлэх ухааны доктор (Sc.D)	доктор Ph.D	Доктор зэрэгтэй багшийн тоо	Эрдмийн зэрэгтэй багш нарын тоо			
					Академич	Хүндэт профессор	Профессор	Дэд профессор
1	БАС	2	32	33	1	1	5	8
2	БУХС	2	42	44	1		3	15
3	БАТС	1	13	14			3	3
4	ГУУС	5	50	55			10	18
5	ДаТС		16	16				6
6	МехТС	3	29	32		2	4	14
7	МХТС		39	39			4	13
8	ҮТС	3	34	37			4	17
9	ХШУС	2	42	44			4	9
10	ЭХС	3	27	29			3	10
11	ГХИ	2	22	24			1	5
12	Захиргаа	1	25	26			5	13
НИЙТ		24	371	393	2	3	46	131


Дээрх багш нараас Төрийн одонтой 131, Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэгтэй 221 багш ажиллаж байна.

Профессор багш нарын тоо

Хүснэгт 1.13

Багшийн тоо	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
Профессор багшийн тоо	1005	973	939
Ахмад гэрээт багш	95	78	93
Гэрээт багш	132	88	94
НИЙТ	1232	1139	1124

Үндсэн багшийн шилжилт хөдөлгөөний хувьд 46 багш өндөр настны тэтгэвэрт гарч, 59 багш шинээр нэмэгдсэн тоон үзүүлэлт гарсан байна.




Зураг 1.7. Багш нарын тоо /насны ангиллаар/


Б. ПРОФЕССОР БАГШ НАРЫН КРЕДИТИЙН СУДАЛГАА (2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭР)

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институтийн багш ажилтны дундаж орлогыг санхүүгийн жилээр, БАС, ГУУС, ҮТС, ГХИ-иудын багш нарын бодит цалинг албан тушаалын ангиллаар сүүлийн 3 хичээлийн тайланг гарган 2018-2019 оны хичээлийн жилд нь нэгтгэн боловсруулж ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар танилцуулав.


Профессор, багш нарын гүйцэтгэсэн кредит



Зураг 1.8. Профессор багш нарын кредитийн гүйцэтгэл



Зураг 1.9. Профессор, багш нарын кредитийн гүйцэтгэлийн дундаж хувь (сүүлийн 3 хичээлийн жилээр)




Зураг 1.10. Профессор, багш нарын кредитийн гүйцэтгэлийн дундаж хувь (сүүлийн 3 хичээлийн дундажаар)

ШУТИС-ийн профессор багш нарын кредитийн гүйцэтгэл

Хүснэгт 1.17

Албан тушаал	Албан тушаал	Нийт гүйцэтгэсэн кредит
ЭНБД / Багш	1	17.96
ЭНБД / Дэд профессор	1	11.35

Салбар тэнхимийн эрхлэгч / Гэрээт	1	6.68
Салбар тэнхимийн эрхлэгч / Дэд проф	1	27.53
Салбар тэнхимийн эрхлэгч / Проф	14	246.53
Профессор / ГА	1	1.73
Профессор / Салбар тэнхимийн эрхлэгч	4	65.83
Дэд.проф / Салбар тэнхимийн эрхлэгч	6	144.90
Дэд.проф / Ахлах багш	3	55.00
Ахлах багш / Дэд захирал	1	9.18
Ахлах багш / Дэд.проф	7	185.31
Ахлах багш / Дэд.проф / ЭНБД	1	4.74
Ахлах багш / Салбар тэнхимийн эрхлэгч	5	121.06
Ахлах багш / ЭНБД	1	12.67
Ахлах багш /12 сарын 31-ийг дуустал/	2	32.00
Багш / Ахлах багш	7	156.17
Дадлагажигч багш / Багш	7	175.53
Сургалтын мастер / Багш	1	24.81
НИЙТ	64	1,298.96



	Профессор 24%-100%	Дэд профессор 50%-100%	Ахлах багш 25%-100%	Багш 25%-50%
■ Нийт гүйцэтгэсэн кр	177.82	88.61	427.15	23.75
■ Профессор багшийн тоо	19	10	50	2


Зураг 1.11. 2018-2019 оны хичээлийн жилд 25%-100% цагийн ачаалалтай гэрээ хийсэн профессор багш нарын кредитийн гүйцэтгэл

**ШУТИС-ийн салбар, тэнхимүүдийн гүйцэтгэсэн кредит
(сүүлийн гурван жилээр)**

Хүснэгт 1.19

Д.Д	Албан тушаал	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
1	Захирал	6	12	12

2	Дэд захирал	10	11	11
3	ЭНБД	9	11	11
4	Салбар, тэнхимийн эрхлэгч	43	38	45
5	Зөвлөх профессор	25	23	24
6	Профессор	55	42	43
7	Дэд профессор	107	88	82
8	Ахлах багш	401	396	402
9	Багш	298	365	361
10	Дадлагажигч багш	36	20	20
11	Сургалтын мастер	50	96	102
12	Гэрээт багш	218	166	161
13	Бусад	5		
	БҮГД	1263	1268	1274



Зураг 1.12. ШУТИС-ийн профессор багшийн тоо (хичээлийн жилээр)



Зураг 1.13. 2018-2019 оны хичээлийн жилд салбар, тэнхимүүдийн гүйцэтгэсэн кредит





ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. БАКАЛАВРЫН СУРГАЛТ

Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба нь Захирлын зөвлөлийн 2018 оны 5 сарын 08-ны өдрийн хурлаар батлагдсан 2018-2019 оны хичээлийн жилийн Сургалтын нэгдсэн хуанлийн дагуу бакалаврын түвшний сургалтын элсэлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалт төгсөлтийн сургалтын үндсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Мөн ШУТАС, Коосэн ТК, ИТДБ Төслийн хамтарсан бакалавр, бэлтгэл коосен хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг удирдлагаар ханган, байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан ажиллав.

2.1.1. Элсэлт

ШУТИС-ийн Захирлын 2018 оны 05 сарын 04-ний өдрийн А/90 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2018-2019 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн үйл ажиллагаа 07 сарын 01-ээс 07 сарын 10-ны хооронд элсэлтийн комисс зохион байгуулав. Элсэгчдийн бүртгэл, онооны жагсаалтыг тусгай програм хангамжийн тусламжтайгаар гарган, болзол хангасан элсэгчдийн цаашид суралцах мэргэжлийн сонголтыг хийлгэв.

Элсэлтийн үйл ажиллагаа дараах хуваарийн дагуу явагдав. Үүнд:

Бүртгэл: 2018 оны 07 сарын 01-04-ний өдрүүдэд 24 цагийн турш www.elseit.edu.mn веб хаягаар бүртгэв.


Хар зургийн шалгалт:	2018 оны 07 сарын 05-ны өдөр 9.00 цагаас
Онооны жагсаалт:	2018 оны 07 сарын 05-ны өдөр 22.00 цагт
Хуваарь сонголт:	2018 оны 07.06-07.10-ны өдрүүдэд

2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдаж ирсэн хяналтын тооны дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад нийт 4219 оюутан шинээр элсэн суралцлаа.

Шинээр элсэн орсон элсэгчид

Хүснэгт 2.1

Д/д	Сургууль	Тоо
1	Барилга, Архитектурын сургууль	507
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	400
3	Геологи, уул уурхайн сургууль	459
4	Механик, тээврийн сургууль	472
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	467
6	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	414
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	155
8	Эрчим хүчний сургууль	658
9	Гадаад хэлний сургууль	104
10	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	301
11	Орхон аймаг дахь Технологийн сургууль	99
12	Коосэн, хамтарсан хөтөлбөр	183



Зураг 2.1. Элсэгчдийн тоо ба хяналтын тоо


Улаанбаатар хотоос ШУТИС-д бүртгүүлсэн элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо

Хүснэгт 2.2

Бүлэг	Бүртгүүлсэн элсэгчдийн тоо	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 1-ийн оноо	ЭЕШ өгсөн ХИЧЭЭЛ 2-ын оноо
I	1953	567	556
II	189	560	543
III	681	569	571
IV	1884	549	564
V	1066	546	539
VI	48	729	728
VII	22	706	713
VIII	57	706	698
НИЙТ	5900	616	614

Өнгөрсөн хичээлийн жилд бүртгүүлсэн элсэгчдийн тоотой харьцуулахад нийт бүртгүүлсэн элсэгчид 507-оор нэмэгдсэн, Хичээл 1-ийн дундаж оноо 37 оноогоор, Хичээл 2-ын дундаж оноо 10 оноогоор өссөн байна.

Сургалтын төлбөрөө бүрэн төлсөн, суралцах гэрээ байгуулах эрхийн бичиг авсан элсэгчдийг 2018 оны 08 сарын 13-31-ний өдрүүдэд бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын алба бүртгэв.



Зураг 2.2. Улаанбаатар хотоос элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо

“Инженер, технологийн дээд боловсрол” төсөл

БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн бэлтгэл коосэн хөтөлбөрийн элсэлт 5 дахь жилдээ, бакалаврын хамтарсан хөтөлбөр 4 дэх жилдээ барилгын инженер, архитектур, механик инженер мэргэжлээр элсэлт авсан ба БАС, УТС-ийг түшиглэн сургалтын үйл ажиллагаа явуулж байна.


ИТДБ төслийн хөтөлбөрт элсэгчдийн тоо (хичээлийн жилээр)

Хүснэгт 2.3

д/д	Хөтөлбөр	2015	2016	2017	2018
1	Барилгын инженер	39	40	39	44
2	Механик инженер	39	51	52	66
3	Архитектур	19	16	23	22
4	Бэлтгэл коосэн	47	45	36	51
БҮГД		144	152	140	183

Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу хамтарсан бакалаврын 9 (13 групп) анги, Бэлтгэл коосэн хөтөлбөрийн 2 (6 групп) ангийн намар, хавар, өвөл, зуны улирлын хичээлийн хуваарийн зохицуулалт, оюутнуудын хичээл сонголт 2-ыг ЕНИ-тай хамтран удирдлагын мэдээллийн системд оруулж баталгаажуулсан.

ИТДБ төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөр, бэлтгэл Коосэн хөтөлбөрт Монгол улсад 240, Япон улсад 195 оюутан суралцаж байна. Бэлтгэл коосэн хөтөлбөрийн эхний ээлжийн 21 оюутан Япон улсын үндэсний коосэн сургуулиудад суралцан төгсөж ирээд, ШУТИС-ийн бакалаврын түвшний сургалтад үргэлжлүүлэн суралцахаар болоод байна.



Зураг 2.3. ИТДБ төслийн Элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо
ИТДБ төслийн хөтөлбөрт суралцагчдын тоо

Хүснэгт 2.4

д/д	Хөтөлбөр	Суралцагчдын тоо /ШУТИС-д/			Суралцагчдын тоо /Японд/				Нийт суралцаж буй	Төгссөн
		I анги	II анги	Нийт	III анги	IV анги	V анги	Нийт		
1	Бэлтгэл Коосэн	45		45	30	29	29	88	133	21
2	Барилгын инженер	41	30	71	21	21		42	113	
3	Механик инженер	56	36	92	25	27		52	144	
4	Архитектур	18	14	32	6	7		13	45	
Нийт		160	80	240	82	84	29	195	435	21

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас мэргэжлийн болон гадаад хэлний өндөр мэдлэгтэй, заах арга барил сайтай, ерөнхий суурь, мэргэжлийн хичээлийн 71 багшийг сонгон хөтөлбөрийн 67 хичээлийг заалгаж байна. Мөн төслийн нэгжээс япон хэл, ерөнхий суурь хичээлийн 12 багш хичээл зааж байна.

ИТДБ төслийн Хамтарсан сургалт, судалгааны зөвлөлийн хурлыг 3 удаа хийж төлөвлөгдсөн асуудлыг хэлэлцэн, шийдвэрлэв. Үүнд:

- Японы консорциумын 10 сургууль 11 сарын 24, 25-ны өдрүүдэд ШУТИС-д ирж шилжин суралцах шалгалтыг авах ажлыг зохион байгуулав. Шалгалтад 63 оюутан хамрагдсанаас 52 оюутан тэнцэж, шилжин суралцаж байна.
- Төслийн санхүүжилтээр сурах бичиг худалдан авах, хэвлүүлэх сургууль, багш нарын захиалгыг авч хэлэлцүүлэн БАС, МехТС, ХШУС-ийн 11 хичээлийн сурах бичиг хэвлүүлэх, 19 хичээлийн сурах бичиг худалдан авах зардлын тооцоог гарган ИТДБ төслийн нэгжид уламжлаад байна.
- Бакалаврын хамтарсан хөтөлбөрийн сургалтын, хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулан боловсруулах чиглэлээр Японы консорциумын гишүүн сургуулиудад СБЗГ-ын төлөөлөл, БАС, МехТС, ХШУС-ийн дэд захирал, багш

нараас бүрдсэн 3 баг 2018.10.22-11.04-ний өдрүүдэд ажиллалаа. Энэ удаагийн зэргийн бус сургалтыг “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл хэрэгжүүлэх нэгж, АзияСийд төслийн зөвлөх багийн төлөөлөл оролцож, зохион байгуулав. Япон Улсад хөтөлбөр боловсруулах баг тус бүр тусгай удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, ажлын үр дүнг нэгтгэн Токио хот дахь ЖАЙКА Олон Улсын байгууллагын холбогдох удирдлага, албаны хүмүүст тайлагнан, санал дүгнэлт дэвшүүлж харилцан зөвлөлдлөө. Уг зэргийн бус сургалтын хүрээнд шилжин суралцаж буй оюутнуудын ШУТИС-д судалсан хичээлийг дүйцүүлэн тооцсон байдлыг тодорхой болгон, тэдэнд тулгарч буй бэрхшээл, шаардлагуудыг холбогдох талуудад тавьж шийдвэрлүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хөгжүүлэлт хийх чиглэлийг тодорхой болгов.

- 12 сарын 20-ны өдөр Зэргийн бус сургалтын тайланг бүрэлдэхүүн сургуулиудын удирдлага, багш нар, төслийн нэгжийн хүрээнд зохион байгуулж хэлэлцүүлээ.
- Японы консорциумын 10 сургуультай танилцах өдөрлөгийг 6 дугаар сарын 2-ны өдөр ТХН-тэй хамтран зохион байгуулж оюутнуудыг шилжин суралцах сургуулиа сонгох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажиллав.

ИТДБ төслийн хөтөлбөрт хичээл зааж буй багш нарын талаар авсан сэтгэл ханамжийн судалгаа

Хүснэгт 2.5

Д/Д	Асуулга	Намар	Хавар	Дундаж
1	Хичээлийн зорилго, зорилт ойлгомжтой байдаг	4.42	4.29	4.35
2	Үндсэн сурах бичиг, гарын авлага, ном тараах материалын хүртээмж хангалттай	4.20	4.21	4.20
3	Лекц, семинар, лабораторийн хичээлүүд уялдаа холбоотой	4.37	4.26	4.31
4	Сургалтад шинэлэг арга барил, технологи болон программ хангамж ашигладаг	4.26	4.18	4.22
5	Багш хичээлээ дэс дараатай, ойлгомжтой, сонирхолтой заадаг	4.34	4.22	4.28
6	Багш хичээлийн цагийг үр бүтээлтэй, бүрэн ашигладаг	4.35	4.23	4.29
7	Багшийн өгсөн даалгаврын зорилго, агуулга, түвшин, зарцуулах цаг нь тохирсон байдаг	4.30	4.21	4.26
8	Багш оюутныг хүндэтгэн, соёлтой харьцаж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлдэг	4.36	4.25	4.30
9	Багшийн үнэлгээ бодитой, шударга байдаг	4.36	4.25	4.30
Дундаж		4.33	4.23	4.28

Маш сайн-5, сайн-4, дунд-3, хангалтгүй-2, маш хангалтгүй-1 оноо

21 аймагт ШУТИС-ийн 2019/20 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх танилцуулга, сурталчилгаа хийх, ИТДБ төслийн элсэлтийн урьдчилсан сорил авах ажлыг амжилттай зохион байгуулж, энэ ажилд ШУТИС-ийн 20 профессор, багш, төслийн нэгжийн 9 ажилтан хамрагдаж, ШУТИС-аас 6,2 сая төгрөг зарцуулсан. Урьдчилсан шалгалтыг Улаанбаатар хотод 5 дугаар сарын 19, орон нутагт 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Шалгалтад Улаанбаатар хотоос 151 сурагч хамрагдсанаас 50-иас дээш хувийн үнэлгээ авсан буюу тэнцсэн 67 сурагч, 21 аймагт нийт 530 сурагч хамрагдсанаас 81 сурагч тэнцсэн

байна. Нийт 681 ширхэг шалгалтын материалыг засах ажлыг ХШУС-ийн болон төслийн нэгжийн математик, физик, химийн 6 багш хийж гүйцэтгэсэн.

Ерөнхий боловсролын ахлах сургууль

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын ахлах сургуульд инженер, технологийн чиглэлээр 45, дизайны чиглэлээр 20 суралцагч элсэлтийн журамд заасан шалгуурыг ханган 10-р ангид элсэн суралцав.

Ерөнхий боловсролын ахлах сургуульд суралцагчийн тоо

Хүснэгт 2.6

Анги	Бүлгийн тоо	Сурагчийн тоо	Шинээр элссэн сур.тоо
10-р анги	3	65	65
11-р анги	3	64	17
12-р анги	2	27	3
Нийт	8	156	85

“Бакалаврын сургалтын үйл ажиллагаа зохицуулах журам”-д нэмэлт өөрчлөлт орсноор /12.4.4 дэх заалт/ 2018-2019 оны хичээлийн жилээс ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элссэн ахлах сургуулийн төгсөгчийн гүнзгийрүүлэн судалсан хичээлийн кредит, авсан оноог шууд тооцож эхлэв. Үүнд Математик I /S.MT101/ хичээлийн кредит, оноог 42, физик I /S.PH101/ хичээлийг 24 оюутан тус тус тооцуулав.

Ахлах сургуульд цагаар хичээл заах багш нарын материалыг хянаж, хавар, намрын улиралд Захирлын тушаалаар баталгаажуулсан.

Төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо

Хүснэгт 2.7

Төгсөлт	Нийт	ЭЭШ-ийн дундаж оноо			
		Математик	Физик	Хар зураг	Англи хэл
Төгсөгчийн тоо	27	*	*	*	*
Шалгалт өгсөн сурагчийн тоо	*	26	22	10	22
Дундаж оноо	560,5	520	523,7	676,5	601

Ахлах сургуульд төгссөн 24 төгсөгч ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрийг сонгож эрхийн бичиг авав. 2 төгсөгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо босго оноог хангаагүй байна.

ШУТИС-ийн хөтөлбөр сонгосон Ахлах сургуулийн төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо

Хүснэгт 2.8

Бүлэг	Элсэгчийн тоо	ЭЭШ-ийн дундаж оноо			
		Математик	Физик	Хар зураг	Англи хэл
1-р бүлгээс хөтөлбөр сонгосон	12	540	540.1		
2-р бүлгээс хөтөлбөр сонгосон	2	476.5			580
3-р бүлгээс хөтөлбөр сонгосон	10	517.7		676.5	
Дундаж	24	511.4	540.1	676.5	580

ШУТИС-КООСЭН технологийн коллеж

ШУТИС-Коосэн технологийн коллежид нийт 13 ангид 145 суралцагч, 14 үндсэн багш, 42 цагийн багштайгаар сургалтын ажил явагдлаа. 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлтийн шалгуурын болзлыг ханган нийт 27 суралцагч 1-р ангид элсэн 2 группээр хичээллэв.

Суралцагчдын тоо

Хүснэгт 2.9

д/д	Мэргэжил	I анги	II анги	III анги	IV анги	V анги	НИЙТ
1	Цахилгааны инженер	27	12	13	12	12	49
2	Механик инженер		8	6	8		22
3	Барилгын инженер		12	10	12	13	47
НИЙТ		27	32	29	32	25	145

2017-2019 оны хооронд ШУТИС-ийн КООСЭН Технологийн Коллежийн 5 оюутан Япон улсын КООСЭН сургуулиудад 1 сарын дадлага хийсэн. Механик инженерийн 4-р ангийн сурагч Т.Саянжамц Гүнма Коосэнд, Зам барилгын 5-ангийн сурагч Н.Халка Нихонсоогэй компанид үйлдвэрлэлийн дадлага, Цахилгаан электроникийн 4-р ангийн сурагч М.Халиун Хоккайдо Коосэнд тус тус дадлага хийж цаашид Япон улсын JES компанид 4-н жил ажиллах гэрээ байгуулах болсон.

3 мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг бакалаврын холбогдох мэргэжлүүдтэй дүйцүүлэлт хийж баталгаажуулав. Ингэснээр төгсөгчид бакалаврын түвшинд суралцахад Коосен технологийн коллежид үзэж судалсан хичээл, оноог дүйцүүлэн тооцуулах боломжтой боллоо. Захирлын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/141 тоот тушаалаар Коосэн технологийн коллежийн барилгын инженер хөтөлбөрөөр 12, цахилгааны инженер хөтөлбөрөөр 12, нийт 24 оюутанд мэргэжлийн диплом олгов. Барилгын инженер хөтөлбөрөөр суралцаж төгссөн Даваадоржийн Халка, цахилгааны инженер хөтөлбөрөөр суралцаж төгссөн Мягмарсүрэнгийн Халиунаа нарыг шилдэг төгсөгчөөр шалгаруулж, “ШИЛДЭГ ТӨГСӨГЧ” өргөмжлөл, нэг зуун мянган төгрөгөөр шагнав.

Төгсөгчдийн үнэлгээний голч дүн

Хүснэгт 2.10

Хөтөлбөрийн нэр	Голч дүн
Барилгын инженер	2.77
Цахилгааны инженер	3.1
ДУНДАЖ	2.93

Цагийн сургалт

2018-2019 оны хичээлийн жилд цагийн сургалтаар БАС, ГУУС, МехТС, ЭХС, ДаТС, ОрТС-д барилгын инженер, цахилгааны инженер, нисэх техникийн механик, дулааны инженер, авто инженер, уул уурхайн ашиглалтын технологи, ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөрөөр нийт 240 оюутан элссэн.

2018-2019 оны хичээлийн жилд цагийн сургалтаар элссэн оюутны тоо
Хүснэгт 2.11

д/д	Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр	ШУТИС төгссөн	Бусад их, дээд сургууль төгссөн	Нийт элсэгч
1	БАС	Барилгын инженер	12	29	41
2	МехТС	Авто инженер	3	17	20
3		Нисэх техникийн механик	1	8	9
4	ЭХС	Цахилгааны инженер	4	16	20
5	ДаТС	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	0	14	14
6		Барилгын инженер /Иргэний ба үйлдвэрийн барилга/	4	12	16
7		Барилгын инженер /БМУТ/	4	5	9
8		Уул уурхайн ашиглалтын технологи	2	15	17
9		Дулааны инженер	3	10	13
10		Цахилгааны инженер /Цахилгаан систем/	4	30	34
11	ОрТС	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	16	17	33
12		Авто инженер	4	11	15
НИЙТ			57	183	240

Цагийн сургалтын элсэлтийн тоо сүүлийн 3 хичээлийн жилээр
Хүснэгт 2.12

д/д	Сургууль	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
1	БАС	23	33	41
2	ГУУС		20	-
3	ЭХС	14	18	20
4	МТС	23	33	29
5	ДаТС	71	91 /149/	102
6	ОрТС	18	33	48
НИЙТ		149	228 /149/	240

Бакалаврын хөтөлбөрт Цагийн сургалтаар элсэгчдийн тоо жил ирэх тусам өсөж байна. 2017-2018 оны хичээлийн жилд ДаТС-д БСШУСЯ-ны зөвшөөрлөөр бүрэн дунд боловсролтой 149 иргэнийг цагийн сургалтаар элсүүлэн, сургалтыг өдрийн сургалтын хэлбэрээр явуулж байна.

2018-2019 оны хичээлийн жилд цагийн сургалтаар БАС, ГУУС, МехТС, ЭХС, ДаТС, ОрТС-д барилгын инженер, цахилгааны инженер, дулааны инженер, авто инженер, уул уурхайн ашиглалтын технологи, механик инженер хөтөлбөрөөр намрын улиралд 526, хаврын улиралд 427 оюутан суралцлаа.

2.1.2. Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (GPA)

Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт 2018-2019 оны хичээлийн жилийн намрын улиралд 16810 суралцагч 274339 кредит, хаврын улиралд 14639 суралцагч 229568.8 кредит сонгон суралцсан байна.


2018-2019 оны хичээлийн жилд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын тоо (захирлын кредит баталгаажуулах тушаалаар)

Хүснэгт 2.13

д/д	Сур-гууль	Үзүүлэлт	2018-2019 оны хичээлийн жил							
			Бакалавр		Магистр		Доктор		НИЙТ	
			намар	хавар	намар	хавар	намар	хавар	намар	хавар
1	БАС	оюутны тоо	2583	2340	110	121	18	14	2711	2475
		сонгосон кредит	41803	37330	853	872	164	131	42820	38333
2	БУХС	оюутны тоо	1293	1159		24		4	1293	1187
		сонгосон кредит	22134	18408		288		32	22134	18728
3	ГУУС	оюутны тоо	1808	1503	228	193	28	17	2064	1713
		сонгосон кредит	29927	24171	2156	1504	266	143	32349	25818
4	ДаТС	оюутны тоо	1164	752	166	163	0	0	1330	915
		сонгосон кредит	20607.2	13443	2089	1840	0	0	22696.2	15282.8
5	МехТС	оюутны тоо	1631	1457	64	56	12	16	1707	1529
		сонгосон кредит	28043	23675	803	682	118	172	28964	24529
6	МХТС	оюутны тоо	1738	1502	81	69	13	15	1832	1586
1	Оптик инженерчлэлийн технологи	2018-11-14	МХТС-ийн ХДХ-ны хурлын шийдвэр
2	Мультимедиа үйлдвэрлэл ба өргөн нэвтрүүлгийн инженерчлэлийн технологи		
3	“Маркшейдер” хөтөлбөр нээх тухай	2019-04-19	ГУУС-ийн ХДХ-ны хурлын шийдвэр
4	“Газар зохион байгуулалт” хөтөлбөр нээх тухай		
5	“Маркшейдер” хөтөлбөрийг засаж сайжруулсан тухай	2019-06-14	2019-04-19-ний ХЕХ-ны хурлын шийдвэр
6	“Газар зохион байгуулалт” хөтөлбөрийг засаж сайжруулсан тухай		
7	Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай		

8	Байгууллагын сэтгэл судлал хөтөлбөр нээх тухай		2019-04-19-ний ХЕХ-ны хурлын шийдвэр
9	Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай		БуХС-ийн ХДХ-ны хурлын шийдвэр
11	Орхон ТС-ийн Ашигт малтмал баяжуулалтын технологи, Механик инженер, Metallурги, металлын технологи хөтөлбөрүүдэд хийсэн ажлын хэсгийн санал дүгнэлт		ШУТИС-ийн захирлын 2019-04-17-ны 91 тоот тушаал

2.4. НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛЫН ТӨВ


2.4.1. Удирдлага зохион байгуулалтын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх


ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн заалтыг үндэслэн ШУТИС-ийн Захирлын тушаалаар Нээлттэй боловсролын төвийг боловсролын бодлого, сургалтын технологи, сурах үйл ажиллагаа, нээлттэй боловсролын талаар санаа бодлоо чөлөөтэй солилцох, хэлэлцэх, судалгаа, инновацийг хөгжүүлэх, үндэсний болон олон улсын эрдэмтэд, экспертүүд, олон нийтийн санал бодлыг илэрхийлэгчид, профессор багш, суралцахуйн загвар бүтээгч зэрэг хүмүүсийг үйл ажиллагаандаа татан оролцуулах замаар сургалт судалгааг үр дүнтэй зохион явуулах зорилгоор байгуулсан юм. Нээлттэй боловсролын төв нь ШУТИС-ийн Захиргааны харьяанд 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Багшийн хөгжил, насан туршийн боловсролын тэнхим, Дээд боловсролын бодлого, системийн динамикийн лаборатори, Сургалтын технологи, инновацийн лаборатори гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2.4.2. Сургалтын чанар, орчин, хүртээмжийг дээшлүүлэх

- ШУТИС-ийн хэмжээнд өмнө бэлтгэгдсэн E-хичээлийн материалуудыг нээлттэй ашиглах, бүрэлдэхүүн сургууль, харьяа тэнхимүүд хариуцан сургалт, судалгаандаа ашиглах боломж олгох шийдвэрийг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлсэн.
- Нээлттэй боловсролыг хөгжүүлж, сургалтын чанар, орчин хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор судалгааны ажил гүйцэтгэн, үр дүнгээр нь сургалтын материал, судалгааны өгүүлэл бүхий цуврал сэтгүүл мөн видео хичээлүүд боловсруулж бэлтгэн цуврал сургалт, семинарыг Монгол улсын их дээд сургуулийн удирдлага, удирдах албан тушаалтнууд, сургалт хариуцсан мэргэжилтнүүд, судлаач багш нарт зориулан зохион байгуулсан. Дээд боловсролын бодлогын өөрчлөлт цуврал зөвлөмжүүд бэлтгэж хэвлүүлэн, ШУТИС-ийн вэбсайт дээр байрлуулсан. QR код бүхий холбоосоор нэвтрэх боломжийг хангасан.

Нээлттэй боловсролыг хөгжүүлэх, Сургалтын нээлттэй нөөц материалыг хэрхэн бэлтгэх, яаж харгалзах лицензтэй нь олж, зөв лицензтэй ашиглах, өөрсдийн бэлтгэсэн сургалтын нээлттэй нөөц материалыг хэрхэн харгалзах зөв лицензтэй нь интернетэд онлайн байршуулж түгээх, Суралцахуйн дизайн, түүний элементүүд, процессийг хэрхэн зөв үр дүнтэй удирдан зохион байгуулж явуулах талаар цуврал сургалтын материал, видео хичээлүүдийг бэлтгэж интернетэд байршуулсан.





Судалгааны өгүүлэл бүхий цуврал (Occasional Paper) гурван сэтгүүлийг Нээлттэй боловсрол, Сургалтын нээлттэй нөөц материал, Суралцахуйн дизайны чиглэлээр бэлтгэж хэвлүүлсэн.



Зураг 2.16. Судалгааны өгүүлэл бүхий цуврал (Occasional Paper) гурван сэтгүүл

2.4.1 “Эрдэм шинжилгээ, инноваци, судалгаанд суурилсан инновацийг хөгжүүлэх

Эрдэм шинжилгээ, судалгаа

- Тэнхимийн бүх профессор багш нар олон улсын хуралд 5 илтгэл, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 19 илтгэл хэлэлцүүлсэн. Төвийн Эрдмийн зөвлөл нь 2 удаа хуралдаж, докторын сургалтын хөтөлбөрөө бүрэн дүүргэж судалгааны ажлаа 50%-иас дээш гүйцэтгэсэн докторант А.Түвшинбаярын судалгааны ажил, “Монголын үндэсний их, дээд сургуулиудын эрэмбэ тогтоох аргачлал боловсруулах” төслийн ажлын явцыг хэлэлцсэн.
- ШУТИС-ийн 60 жилийн ойг угтсан ШУТИС-ийн профессор, багш нарын багшлахуйн онолын мэдлэг, заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, инженерийн боловсролын сургалтын технологийг боловсронгуй болгох, сургах, суралцахуйн үйл явцыг идэвхжүүлэх, багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлыг 2018.11.12-ны өдөр зохион байгуулж 11 бүрэлдэхүүн сургуулийн 80 гаруй багш оролцлоо.

- Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэл төсөл, ЮНЕСКО-ийн Бангког дахь Оффис хамтран зохион байгуулсан “Дээд боловсролын чанарыг дээшлүүлэхэд холимог сургалтыг хэрэглэх нь” сэдэвт сургалтад “ШУТИС Нээлттэй боловсролын төвийн Мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан инноваци” сэдвээр хичээл заасан.

Гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр:

- International Center for Higher Education Innovation under the auspices of UNESCO (UNESCO-ICHEI) удирдаж буй International Institute of Online Education (ИОЕ) нэртэй Азийн зургаан улсын их сургууль оролцох төсөлд оролцох эхний яриа хэлцлийг хийсэн.
- Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Төр-Хувийн хэвшил-Их сургуулиудын хамтын ажиллагааг системтэй хөгжүүлэх, системийн динамикийн онол хандлагаар, зарим бодит боломжуудыг тооцоолох загвар босгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
- ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй “ШУТИС-ийг олон улсын их, дээд сургуулиудын эрэмбэ /ranking/ тогтоох үйл явцад хамруулах нь” төслийг 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2017, 2018 онд төслийн явцын тайланг хэлэлцүүлж, төслийн удирдагч Ж.Арслан, төслийн багийн гишүүн Б.Анхбаяр нар БНСУ-д болсон QS байгууллагын сургалт-семинарт оролцоод ирсэн.
- БСШУСЯ-ны захиалгат Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй “Монголын үндэсний их, дээд сургуулийн эрэмбэ тогтоох аргачлал боловсруулах нь” төслийг мөн 2016 оноос хэрэгжүүлж, /төслийн удирдагч Ц.Оюун/ дуусган хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

2.4.2 Сургалтын үйл ажиллагаа:

2018-2019 оны хичээлийн жилийн жилд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын инженер, технологийн мэргэжлийн ангиудад

U.IT101 Мэдээллийн технологийн хэрэглээ I

U.IT102 Мэдээллийн технологийн хэрэглээ II

U.CS101 Алгоритм програмчлал

U.CS201 Програмчлалын хэл

S.CS260 Зураг төслийн автоматжуулалт зэрэг хичээлүүдийг бакалаврын түвшинд зааж нийтдээ 3231 оюутанд шинэчилсэн хөтөлбөрөөр суралцав.

2018-2019 оны хичээлийн жилийн намрын улиралд магистр 26, доктор 11 оюутан, хаврын улиралд магистр 28, доктор 10 оюутан “Боловсролын удирдлага”, “Боловсрол судлал”, “Виртуал сургалтын систем” хөтөлбөрүүдээр суралцав.

Хэнтий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Өвөрхангай аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж, эхний 9 оюутан боловсролын удирдлага хөтөлбөрөөр суралцан магистрын диплом гардан авсан. Энэ хичээлийн жилд 12 оюутан магистрын, 6 оюутан докторын сургалтад шинээр элсэж 4 оюутан шилжин ирж суралцлаа. Сургалтын үйл ажиллагаа зохих дүрэм журам, сургалтын хуанлийн дагуу зохион байгуулагдсан. Тус төвийн оюутнуудын 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын үнэлгээний голч дүн магистр оюутнуудын хувьд намрын улиралд 3.40, хаврын улиралд 3.41, доктор оюутнуудын хувьд намрын улиралд 3.41, хаврын

улиралд 3.33, жилийн дундаж голч дүн нь магистр оюутнуудын хувьд 3.40, доктор оюутнуудын хувьд 3.37 байсан.

2.4.3 Төгсөлт:

“Дээд боловсролын удирдлага” мэргэжлээр 4 оюутан докторантурын сургалтын хөтөлбөрөө төлөвлөгөөний дагуу бүрэн судалж дуусан сертификат авсан. Намрын улиралд 10, хаврын улиралд 13 оюутан, нийт 23 оюутан “Боловсролын удирдлага”, “Боловсрол судлал”-ын магистрын, 2 оюутан боловсролын удирдлагын докторын зэрэг хүртэн дипломоо гардан авав.

2.4.4 Багшлах эрх олгох сургалт:

ШУТИС-ийн болон их, дээд сургуулиудын багш нарын багшлах болон мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сурган заах арга зүйн боловсрол олгох түр сургалтыг 4 удаа зохион байгуулж, 132 хүн төгсөж багшлах эрхийн үнэмлэх гардан авлаа.

2.4.5 Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар, уулзалт

“Нээлттэй боловсрол” сэдэвт цуврал сургалт семинарыг зохион байгуулсан. ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төв нь Монгол улсад үр дүнтэй Нээлттэй боловсрол, Боловсролын нээлттэй эх үүсвэр, Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл-МООС-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах үндсэн элементүүд, үйл явц, үе шатыг хэлэлцэх, нэгдмэл ойлголттой болох зорилгоор БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газар, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хэрэгжиж буйд Дээд боловсролын шинэчлэлийн төсөлтэй хамтран 2019 оны 4 дүгээр сарын 06-наас 2019 оны 5 дугаар сарын 31-ний хооронд цуврал сургалт семинарыг зохион байгуулж ажилласан.



Зураг 2.17. “Нээлттэй боловсрол” сэдэвт сургалт семинарыг проф. Д.Бадарч удирдан зохион байгуулж явуулсан.



Зураг 2.18. “Нээлттэй боловсрол” сэдэвт цуврал сургалт семинар



Зураг 2.19 “Сургалтын нээлттэй нөөц материал” сэдэвт цуврал сургалт семинар

“Нээлттэй боловсрол” сэдэвт цуврал сургалт, семинарыг дараах чиглэл, сэдвүүдээр зохион байгуулсан.

“Их сургуулийн сургалтад идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.

ШУТИС-ийн 60 жилийн ойг угтсан ШУТИС-ийн профессор, багш нарын багшлахуйн онолын мэдлэг, заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, инженерийн боловсролын сургалтын технологийг боловсронгуй болгох, сургах, суралцахуйн үйл явцыг идэвхжүүлэх, багшийн

хөгжлийн хөтөлбөр боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой эрдэм шинжилгээний хурлыг 2018.11.12-ны өдөр зохион байгуулж 11 бүрэлдэхүүн сургуулийн 80 гаруй багш оролцлоо.

Нээлттэй боловсрол” сэдэвт цуврал сургалт, семинари

Хүснэгт 2.41

д/д	Сургалт, семинарын сэдэв	Хамарсан хүрээ	Хаана, хугацаа
1	“Нээлттэй боловсрол” сэдэвт сургалт, семинар	БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газар, Дээд боловсролын сургалтын байгууллага: АШУҮИС, МУИС, МУБИС, ШУТИС, ХААИС, СУИС, ХСИС, БХИС, Их Засаг ОУИС, Этүгэн ИС, Хүмүүнлэгийн ИС, Санхүү эдийн засгийн ИС, Улаанбаатар ОУИС, Отгонтэнгэр ИС, Шихихутуг ИС, Мандах ИС, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн удирдлага, менежментийн баг, гишүүд 75 хүн хамрагдсан.	МУИС Номын сангийн 502 тоот, 2019.04.06
2	“Сургалтын нээлттэй нөөц материал” сэдэвт сургалт, семинар	БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газар, Дээд боловсролын сургалтын байгууллага: АШУҮИС, МУИС, МУБИС, ШУТИС, ХААИС, СУИС, ХСИС, БХИС, Этүгэн ИС, Хүмүүнлэгийн ИС, Санхүү эдийн засгийн ИС, Улаанбаатар ОУИС, Отгонтэнгэр ИС, Шихихутуг ИС, Мандах ИС, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн багш, мэргэжилтнүүд 50 хүн хамрагдсан.	ШУТИС-ийн Номын сангийн 603 тоот, 2019.05.17
3	“Нээлттэй боловсрол” сэдэвт зайн сургалт, семинар	МУБИС-ийн багш, Зайн сургалтын төвийн ажилтнууд - 20 хүн, Архангайн багшийн сургууль, Завхан сургууль, Ховд их сургууль, Дорнод их сургуулийн удирдах ажилтан, багш нар 50 хүн хамрагдсан.	МУБИС-ийн Зайн сургалтын төв 203 тоот, 2019.05.22
4	“Суралцахуйн дизайн” сэдэвт сургалт, семинар	БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газар, Дээд боловсролын сургалтын байгууллага: АШУҮИС, МУИС, МУБИС, ШУТИС, ХААИС, СУИС, ХСИС, БХИС, Этүгэн ИС, Хүмүүнлэгийн ИС, Санхүү эдийн засгийн ИС, Улаанбаатар ОУИС, Отгонтэнгэр ИС, Шихихутуг ИС, Мандах ИС, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн багш, мэргэжилтнүүд 50 хүн хамрагдсан.	ШУТИС-ийн Номын сангийн 603 тоот, 2019.05.31

Сургалтын дэвшилтэт арга зүй хэрэглэж буй туршлагаа хуваалцсан энэхүү эрдэм шинжилгээний хуралд:

Тэргүүн байрыг “Оюутны бие даалтын ажлыг үнэлгээний рубрикээр үнэлэх нь” постер илтгэл Орхон аймаг дахь технологийн сургуулийн Техникийн зураг зүйн багш Б.Оюун

Дэд байрыг “Идэвхтэй сургалтын аргыг архитектурын бакалаврын хөтөлбөрийн А.АР226 Архитектурын дизайн-I хичээлд хэрэглэж буй байдал” БАС-ийн Архитектурын салбарын багш Э.Болорцэцэг, А. Өөлүн; Гутгаар байрыг “Компьютерын эд анги сонгох, угсрах виртуал лабораторийг сургалтад хэрэглэсэн туршилтын үр дүн” ЕНИ-ийн Виртуал технологийн тэнхимийн багш А.Түвшинбаяр тус тус эзэлж баялаг ариун туршлагаасаа хуваалцав.



Зураг 2.20. Эрдэм шинжилгээний хурлын явц

ОХУ-ын Эрхүү хотод “Боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцсон.

2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 12-р сарын 22-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн их сургуультай “Боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага” хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Хуралд БХТ-ийн захирал А.Сүнжидмаа, мэргэжилтэн Ч.Туул, ГХС-ийн профессор Х.Навчаа, ХШУС-ийн профессор Ц.Эрхэмбаяр нар үндсэн илтгэл тавьж хэлэлцүүлээ. Уг арга хэмжээнд БХТ-ийн захирал А.Сүнжидмаа, мэргэжилтэн Ч.Туул, Н.Нямсүрэн, ҮТС-ийн БХБ-ийн ахлагч О.Гансайхан, ГХС-ийн БХБ-ийн ахлагч С.Сэржмядаг, багш Х.Навчаа, БАС-ийн БХБ-ийн ахлагч Д.Эрдэнэцэцэг, багш Б.Буянжаргал, ЭХС-ийн БХБ-ийн ахлагч Х.Сарангэрэл, ДаТС-ийн БХБ-ийн ахлагч С.Саруулболд, ОрТС-ийн БХБ-ийн гишүүн Д.Болор-Эрдэнэ, МХТС-ийн БХБ-ийн ахлагч П.Бумдүүрэн, багш Л.Батзориг, МехТС-ийн БХБ-ийн гишүүн Б.Батбаяр, С.Янжинлхам, ХШУС-ийн БХБ-ийн гишүүн Ц.Эрхэмбаяр, БуХС-ийн БХБ-ийн ахлагч Г.Наран-Оюун нар оролцлоо.

Японы Атомын Энергийн Агентлагийн Цөмийн Хүний нөөцийн төв, Цөмийн Энергийн Комисс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль хамтран “Реакторын инженер”-ийн сургагч багшийн дагалдах сургалтыг 2019 оны 1-р сарын 7-ноос 18-ны хооронд Багшийн Хөгжлийн Төв, ХШУС-ийн Физикийн тэнхимтэй хамтран зохион байгуулав.

Уг сургалтад Японы Атомын Энергийн Агентлагийн Цөмийн Хүний нөөцийн төвийн сургагч багш доктор Иппей Амамото, доктор Хидео Накамура, Сатоши Абе нар ирж лекц уншсанаас гадна тус хүний нөөцийн төвийн сургагч багшийн сургалтад сурч, сургагч багшаар бэлтгэгдсэн Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургуулийн ахлах багш доктор, дэд профессор Б. Түмэндэмбэрэл, доктор Ц.Эрхэмбаяр, багш Б. Одонтуяа, Ч. Ариунтөгс, Б. Булгансайхан, Эрчим хүчний

сургуулийн багш Х. Цолмон болон МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургуулийн багш, доктор, дэд профессор С.Одмаа, Б.Мөнхбат, багш Т. Жамъянсүрэн, Мөнхсайхан нар сонирхолтой лекц уншлаа.



Зураг 2.21. Цөмийн реакторын инженерийн сургагч багшийн дагалдах сургалт

Мөн Японы Атомын Энергийн Агентлагийн Цөмийн Хүний нөөцийн төвийн сургагч багш доктор Хидео Накамура “Инженерийн ёс зүй” сэдвээр 2018 оны 1-р сарын 18-нд ШУТИС-ийн бүх профессор багш нарт нээлттэй лекц уншиж, багш нарын сонирхсон асуултад хариулав. Энэхүү сургалтыг Цацрагийн аюулгүй байдалд дотоод хяналт тавих комисс, ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төв хамтран амжилттай зохион байгууллаа.



Зураг 2.22. “Төсөлд суурилсан сургалтыг зохион байгуулах арга зүй” сэдэвт сургалт

Бүрэлдэхүүн сургуулиудын дадлагажигч багш нарын багшлахуйн онолын

мэдлэг, заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх, инженерийн боловсролын сургалтын технологийг боловсронгуй болгох, сургах, сургахуйн үйл явцыг идэвхжүүлэх зорилготойгоор 2019 оны 01-р сарын 25-ны өдөр сургалтыг зохион байгуулав.

ШУТИС-ийн “Оны шилдэг багш нарын Сургалтын үйл ажиллагааны туршлагаас суралцахуй”

Оны шилдэг **Сурган хүмүүжүүлэгч, Зөвлөх, Залуу багш** нарын Сургалтын үйл ажиллагааны дэвшилтэт арга зүй, нэвтрүүлсэн, ашигласан технологи, оюутанд чиглэсэн үйл ажиллагааны туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2019 оны 02-р сарын 21-нээс 02-р сарын 25-ны хооронд 1-203 тоот өрөөнд зохион байгуулж давхардсан тоогоор 60 гаруй багш нар туршлага судаллаа.



Зураг 2.23. Оны шилдэг Судлаач, Бүтээлч багш нарын Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын туршлагаас суралцах сургалт

Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2019 оны 02-р сарын 26-наас 02-р сарын 27-ны хооронд ШУТТН сангийн 405 тоот өрөөнд зохион байгуулж давхардсан тоогоор 50 гаруй багш туршлага судаллаа.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд судлаач багш нарынхаа гадаадад илтгэл хэвлүүлэх зардлыг сургуулиас гаргаж, багш нартаа судалгаа хийх боломж олгон, урамшуулан дэмжиж дэлхийн түвшинд хүрсэн профессор багшийн тоог нэмэгдүүлэх, Оны шилдэг багш нарын бүтээл, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой сургалт амжилттай явагдлаа.

Солонгос, Англи хэлний үнэ төлбөргүй сургалт

Солонгос, Англи хэлний үнэ төлбөргүй сургалтыг БуХС-тай хамтран 2 үе шаттай зохион байгуулав.

Үүнд:

1-р шатны сургалт 2018 оны 9-р сарын 15-наас 12 сарын 15 хүртэл,

2-р шатны сургалт 2019 оны 3-р сарын 01-нээс 5 сарын 15 хүртэл явагдаж 100 гаруй багш хамрагдаж хэлний боловсролоо дээшлүүлэв.

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэлэлцүүлэг

ШУТИС-ийн захирлын 2019 оны 01 сарын 16-ны өдрийн А/16 тоот тушаалаар ШУТИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” боловсруулах 9 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдав. БХТ-ийн захирал А.Сүнжидмаа ажлын хэсгийг удирдан ажиллаж “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг 2019 оны 04-р сарын 26-нд боловсруулж дууссан бөгөөд 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

2019 оны 05 сарын 22-нд ШУТИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн төслийг бүрэлдэхүүн сургуулийн БХБ-ийн ахлагч нарын дунд хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт оролцсон профессор багш нарын асуултад хариулж ярилцан үнэлгээний асуудлыг илүү тодорхой болгохоор тогтлоо.



Зураг 2.24. ШУТИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн сургалт

ШУТИС-ийн “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн төслийг 2019 оны 05 сарын 29-нд салбар, тэнхимийн эрхлэгч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ

3.1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018-2019 оны хичээлийн жилд судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн холбоог өргөжүүлэх, хамтын ажиллагааг шинэ шатанд хүргэх, гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын туршлагыг судлах, нутагшуулах, хамтран ажиллах, судлаачдын чадавхыг нэмэгдүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх арга зүй эзэмшүүлэх, судлаачдын бүтээлийг хэлэлцүүлэх, үнэлэх, олон нийтэд таниулах, сурталчлахад чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Зохион байгуулсан хурал, семинар, хэлэлцүүлэг




Хүснэгт 3.1

№	Огноо	Арга хэмжээ	Хамтарч ажилласан сургууль, байгууллага, үр дүн
1	2018/10/2 5-26	ЭВРИКА-2019 үндэсний хэмжээний ЭШ-ний их хурал 	ШУТИС-иас нийт 32 илтгэгч тус хуралд оролцсон бөгөөд Төрийн ордонд болсон сүүлийн шатны нэгдсэн хуралдаанд “Шилдэг эрдэмтэн судлаач” –аар Г.Төрмөнх /УТС/, “Шилдэг залуу судлаач”-аар Х.Баатарсүрэн /БАС/ нар шалгарлаа.
2	2018/10/2 5-26, 2019/06/0 4-06	“Nature Research Academies”, “Science Communication Training” Сургалт 	2018 оны 10 дугаар сар, 2019 оны 6 дугаар сард тус тус зохион байгуулагдсан энэхүү арга хэмжээнд ШУТИС-ийн 70 судлаач багш нар оролцож, судалгааны бүтээл бичих арга зүй, судлаачийн ёс зүй, мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих зэрэг аргачлалд суралцаж сертификат авсан.
3	2018/11/1 5	“1000-ИНЖЕНЕР” нээлттэй илтгэл” тайлан хэлэлцүүлэг 	ШУТИС-иас Япон улсад зэргийн бус (7), магистр (2), докторын (4) хөтөлбөрүүдэд хамрагдсан төгсөгчид тайлангаа хэлэлцүүлж, цаашид Монгол улсад хэрхэн үргэлжлүүлэн ажиллах, судалгааныхаа ажлыг хэрхэн үр өгөөжтэй хөгжүүлж, олон нийтэд таниулах зэрэг ажлын төлөвлөгөөг танилцуулж нээлттэй хэлэлцүүлэв. Тус үйл ажиллагаанд БСШУСЯ, МУИС, ШУТИС -ийн багш, судлаачид, судалгааны багийн гишүүд идэвхтэй оролцов.
4	2018/11/1 7	Олон улсын инженерийн мэргэжлийн холбоо /IEEE/-ийн нд 10-р бүсийн дэд салбар	IEEE байгууллагын дэд салбарыг Монгол улсад байгуулах саналыг 2018 оны 6-р сард IEEE байгууллагад хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд тус оны 11 сарын 17-нд IEEE-ийн 10-

			<p>р бүсийн дэд салбарыг албан ёсоор байгуулав.</p> <p>2019 оны 6-р сард багтаан Монгол дахь IEEE –ийн дэд салбарын хурлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус хурлын зорилго нь Монгол судлаачдын IEEE гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх, салбарын үйл ажиллагааны бүтэц, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааг тодорхой чиглэлтэй болгох, судлаачдыг татан оролцуулах зэрэг ажлуудыг хэлэлцэнэ.</p>
5	2018/11/21-22	<p>“Шинжлэх ухаан, технологи, инноваци - 2018” үзэсгэлэн</p> 	<p>“Шинжлэх ухаан, технологи, инноваци 2018” үзэсгэлэнд багш, судлаачид хэрэгжүүлж буй шинжлэх ухаан, технологи, инновацийн төсөл, тэдгээрийн үр дүнг харуулсан нийт 15 бүтээл, 23 судалгааны постероор оролцсоноос Эрчим хүчний сургуулийн захирал, доктор Ч.Мангалжалавын “Дулаацуулгын автоматжуулагдсан иж бүрдэл ЦЭМ-18М” бүтээл шилдэг бүтээлийн дэд байранд шалгарлаа. Мөн Уул уурхайн хүрээлэнгийн “Уул уурхайнуудын ТЭЗҮ” цуврал бүтээл нь тусгай байрын шагнал хүртсэн.</p>
6	2018/12/20	<p>“Эрдэм шинжилгээний сэтгүүлийн хэвлэн нийтлэл, тавигдах шаардлага” семинар</p> 	<p>Семинарт ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, алба нэгж, салбар тэнхимийн сэтгүүл эрхлэгчид, редакцын зөвлөлийн гишүүд, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар, эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтнүүд бүхий 60 орчим хүмүүс оролцлоо. ШУТИС олон улсын түвшинд хянагддаг онлайн сэтгүүлтэй болох зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд “Mongolian Geoscientist”, “Mongolian Journal of Applied Science and Engineering” сэтгүүлүүдийн бэлтгэл ажлын талаар тус сэтгүүлүүдийн редакцын зөвлөлийн гишүүд танилцуулга хийв.</p>

7		<p>Эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагаа</p> 	<p>Судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх чиглэлээр Үндэсний хөгжлийн газартай 2019 оны I/14, Багануур технологийн паркт V/16-нд, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, профессор, багш, судлаачдыг чадавхжуулах, харилцан туршлага солилцох зорилготойгоор СЭЗИС-тай хамтын ажиллагааны санамж бичгийг 2019 оны V/24-нд тус тус байгууллаа. Үндэсний хөгжлийн газартай хамтын ажиллагааны хүрээнд Таван толгойн нүүрсний экспортын тээвэр, логистикийн зохион байгуулалтыг сайжруулах бодлогын судалгааны ажлыг МехТС гүйцэтгэсэн /9 сая төгрөг/. Түүнчлэн Нийслэлийн захирагчийн ажлын албатай хамтран ажиллах гэрээ, ажлын төлөвлөгөөг боловсруулж хэлэлцээр зохион байгууллаа.</p>
8	2019/01/18	<p>“Must authors training” судлаачдыг чадавхжуулах сургалт</p> 	<p>Эрдэм шинжилгээ, инновацийн газраас 2018-2019 оны хичээлийн жилд судлаачдыг чадавхжуулах сургалтуудыг хэд хэдэн үе шаттайгаар зохион байгууллаа. “MUST Authors training” сургалтыг ҮТС-ийн нийт 70 гаруй багш судлаачдын дунд 1 дүгээр сарын 16-ны өдөр, мөн бүрэлдэхүүн сургуулийн 140 орчим судлаачдын дунд 1 дүгээр сарын 18-ны өдөр амжилттай явууллаа.</p>
9	2019/02/01	<p>"Олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн сан, оюуны өмчийн ашиглалт ба хэрэглээ" сургалт</p> <p>Жил бүр уламжлал болон 2 сард зохион байгуулагддаг тус сургалтад, БС-ийн ЭНБД, эрдэм шинжилгээ, инновацийн ажилтнууд, номын сангийн мэргэжилтнүүд, ЭШИГ-ын мэргэжилтнүүд зэрэг нэгжүүдийн төлөөлөл бүхий 60 орчим хүнийг хамрууллаа. Сургалтаар олон улсын мэдээллийн сангаас эрдэм шинжилгээний бүтээл, патентын хайлт, шүүлт хийх тухай, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг таниулах, хэрэглэх, инновацийн хуульд орж буй өөрчлөлтүүд зэрэг мэдлэг, мэдээллийг оролцогчдод олгов.</p>	
10	2019/02/25	<p>Профессор багш нарын “Эрдмийн чуулган-2019” ЭШ-ний нэгдсэн хурал</p>	<p>Тус хурлын I шатны шалгаруулалт бүрэлдэхүүн сургуулиуд дээр 2 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд болж, тэдгээрээс шалгарсан 36 илтгэлийг нэгдсэн хурлын 3 салбар хуралдаанаар хэлэлцүүлж, 8 шилдэг</p>


			<p>илтгэлийг тодруулж, батламж, мөнгөн шагналаар урамшууллаа.</p>
11	2019/02/25	<p>“Mongolian geoscientist” олон улсын онлайн сэтгүүл</p> 	<p>“Mongolian Geoscientist” сэтгүүлийг олон улсын түвшинд хянагддаг онлайн сэтгүүл болгох зорилтын хүрээнд 2019 оны 1 сард МУ-ын ШУА-ийн онлайн систем JOL-д оруулсан бөгөөд Google Scholar, Dimensions ЭШ-ний хайлтын системд индекслэгдсэн сэтгүүл боллоо. Энэхүү сэтгүүлийн нээлтийн үйл ажиллагаа 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр болсон бөгөөд Монголын геологийн салбарын анхны онлайн сэтгүүл нөгөө талаас ШУТИС-ийн судлаачдын эрхлэн гаргадаг онлайн сэтгүүл болж байгаа юм.</p>
12	2019/02/27	<p>МҮОНРТ-тэй хамтын ажиллагааны гэрээ</p> 	<p>ШУТИС-ийн эрдэмтэн судлаачдын Японы шилдэг их дээд сургуулиудын эрдэмтэн, судлаачидтай хамтран хэрэгжүүлж буй 10 төслийн судалгааны ажлын үр дүнг нийгэм, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилго бүхий шинжлэх ухаан танин мэдэхүйн цуврал 10 нэвтрүүлэг бүтээх төслийг МҮОНТВ-тэй хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулав.</p>
13	2019/03/1-12	<p>“Хамтарсан судалгаа - шинэ технологи” Монгол-Япон судлаачдын хамтарсан хурал</p> 	<p>БСШУСЯ, Төслийн нэгж, ЭШИГ: Хуралдааны үеэр Хамтарсан судалгааны багуудын ханан илтгэлүүд болон бүтээлийн үзэсгэлэнг гаргаж олон нийтэд танилцуулав. ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн 10 хамтарсан судалгааны төслийн хүрээнд өнгөрсөн 4 жилийн байдлаар Япон улсад зэргийн ба зэргийн бус хөтөлбөрт 200 орчим судлаач, Коосэн, бакалаврын хөтөлбөрт 500 орчим оюутан хамрагдаж, Япон улсаас 100 гаруй зочин судлаачид урт, богино хугацаатай ирж ажилласан байна. Хамтарсан судалгааны үр дүнд эрдэм шинжилгээний гадаад өгүүлэл 111, дотоод өгүүлэл 110, Ашигтай загвар 1, Шинэ технологи 1, Стандарт 1, сургууль хоорондын Хамтын</p>

			ажиллагааны 8 санамж бичиг байгуулсан.
14	2019/04/25	<p>“РОБОКОН-2019” тэмцээн</p> 	<p>“Робокон-2019” тэмцээнийг ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулж шалгарсан 6 баг Үндэсний аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, 2019 оны VIII/25-нд болох Олон улсын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцох багаар ШУТИС-ийн “Цахим алт”, “High Tech” 2 баг шалгарч, бэлтгэлээ хангаж байна.</p>
15	2019/04/20-22	<p>“Монгол инженер-2019” эрдэм шинжилгээний хурал</p> 	<p>МехТС-иас жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг энэ удаагийн эрдэм шинжилгээний хурал “Монгол инженер”-ийг ЗТХЯ-тай хамтран өргөн хүрээнд амжилттай зохион байгууллаа. “Монгол инженер 2019” ЭШ-ний хуралд Автотээврийн Үндэсний төв, ХААИС-ийн ИТС, ҮБХИС-ийн ИМТ, Шинэ Монгол Технологийн ДС-ийн профессор, багш, судлаач, мөн Вагнер Ази тоног төхөөрөмж ХХК, Оюу толгой ХХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Бэрэн группийн инженер, техникийн ажилтнууд судалгааны ажлаа танилцуулан, илтгэл хэлэлцүүлэв.</p>
16	2019/04/05-06	<p>“First International Conference On Applied Sciences And Engineering-Ficase 2019” олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурал</p> 	<p>Тус хуралд гадаадын 7 орны 30, дотоодын 215 орчим эрдэмтэн судлаачид оролцож хэрэглээний математик, хэрэглээний хими, биофизик, биотехнологи, хүрээлэн буй орчин, нано шинжлэх ухааны чиглэлүүдээр 120 орчим илтгэлүүдийг амжилттай хэлэлцүүлээ. “FICASE 2019” хурал нь математик, физик, хими зэрэг суурь шинжлэх ухааны салбарууд анх удаа нэгдэж Монголд хуралдаж байгаагаараа онцлог бөгөөд 2 жилд нэг удаа зохион байгуулагдаж байхаар төлөвлөөд байна.</p>

<p>17</p>	<p>2019/05/07-08</p>	<p>“Монголын инновацийн 7 хоног” арга хэмжээ - “Инновацийн үзэсгэлэн-2019” - “ICIED-2019” олон улсын хурал - “Хакатон” арга хэмжээ</p> 	<p>Монголын инновацийн 7 хоног арга хэмжээний хүрээнд "Инновацийн үзэсгэлэн 2019" арга хэмжээ 5 сарын 7-8 өдрүүдэд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд зохион байгуулагдлаа. ШУТИС-ийн багш оюутны нийт 12 бүтээлээр оролцсон. “ICIED-2019” олон улсын хуралд БНХАУ, Япон, ОХУ, Өмнөд Солонгос, АНУ, Кувейтээс профессор, судлаачид бүхий 140 гаруй хүнийг хамрууллаа.</p>
<p>18</p>	<p>2019/06/03,05</p>	<p>ШУТИС-ийн хүндэт профессор, профессор, дэд профессор цолд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалт, бүтээлийн үзэсгэлэн Хүндэт профессор-2, профессор-1, Дэд профессор-24 нэр дэвшиж, тэдгээрийн холбогдох материал магадлан хийж, үүнээс 25 эрдмийн цолд нэр дэвшигчдийн бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хурал болон Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн нууц санал хураалтаар дээрх 27 багш, судлаачид, эрдэмтдэд цол олгохоор шийдвэрлэв.</p>	
<p>19</p>	<p>2019/05/03,29</p>	<p>“Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сургалт</p> 	<p>“Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сэдэвт сургалтыг нийт 2 удаа 93 багшийг хамруулан зохион байгуулав.</p>
<p>20</p>	<p>2018/12/31, 2019/06/18</p>	<p>Төслийн явц, үр дүн, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаа-ны тайлан хамгаалалт ШУТИС-д хэрэгжиж буй гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийн тайланг ЭШ-ний хуанлийн дагуу хагас жил тутамд БС болон Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэг бөгөөд 2018.12.14, 2019.06.18-нд хэрэгжилт нь дуусаж буй 10 гаруй төслийг хэлэлцүүлээ. 2019 онд ШУТИС-д Улсын захиалгат төсөл: Захиалгат-16, Инновацийн-3, Суурь судалгааны-6, Хамтарсан-10, докторын дараах инноваци-4, ШУА-ийн грант-1 нийт 40 төслийг 2.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр хэрэгжүүлж байна.</p>	
<p>21</p>	<p>2019/06/18</p>	<p>“Гарааны модон араг бүтээц” гарааны компани</p> 	<p>ШУТИС-ийн дэргэд “Гарааны модон араг бүтээц” гарааны компанийг байгуулах саналыг Захирлын зөвлөл, Эрдмийн дэд зөвлөл, мөн УЗ-ийн 2019 оны VI/18-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдэн, шинэ гарааны компанийг байгууллаа.</p>

22	2019/06/24-25	<p>"International Association Of Silkroad Universities" 5th International Conference Торгоны замын бүсийн Олон улсын хурал</p> 	<p>Тус хурлын зорилго торгоны замын бүсийн орнуудын их, дээд сургуулиудын судлаачид, оюутнууд хот төлөвлөлт, архитектур, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр хамтран эрдэм шинжилгээний ажил, судалгаа хийж, тухайн орны соёлыг харилцан түгээх, багш, оюутан солилцоо болон төслийн хүрээнд хоёр тал, олон талт хамтын ажиллагааг дэмжих юм. Энэхүү хурал нь монголд анх удаа зохиогдож буй бөгөөд ШУТИС-ийн талаас Эрдэм шинжилгээ, инновацийн газар зохион байгуулалтаар хангаж ажиллав. БАС-ийн архитектурын салбарын төгсөгчид, судлаачид илтгэл тавьж оролцлоо.</p>
----	---------------	---	---

ШУТИС-ийн хэмжээнд тайлант онд Олон улсын эрдэм шинжилгээний 20 хурал зохион байгуулж, нийт 460 орчим илтгэлийг 533 оролцогч, Улсын хэмжээний Эрдэм шинжилгээний 23 хуралд 455 илтгэл, ШУТИС-ийн багш нарын ЭШ-ний 22 хуралд 355 илтгэл, магистр, доктор оюутны ЭШ-ний 17 хуралд 312 илтгэл, бакалавр оюутны ЭШ-ний 18 хуралд 264 илтгэл тус тус хэлэлцүүлсэн байна. Бүрэлдэхүүн сургуулиуд багш, оюутнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах зорилгоор бусад сургалт семинар-61, уралдаан тэмцээн-33, олимпиад-41, үзэсгэлэн-10 тус тус зохион байгууллаа.



Зураг 3.1. Бүрэлдэхүүн сургуулиудын зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал



Зураг 3.2. Бүрэлдэхүүн сургуулиудын зохион байгуулсан арга хэмжээ

3.2. СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

2018-2019 оны хичээлийн жилд бүрэлдэхүүн сургуулиудын Эрдмийн зөвлөлүүд, мөн Эрдэм шинжилгээ, инновацийн газар нь “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам”, “ШУТИС-ийн Технологийн сангийн журам”-ын холбогдох заалтуудыг үндэслэн ЭШИХА-ны дэд зөвлөлтэй хамтран гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийн явц, үр дүнг хэлэлцэх, төслийн даалгавар, санхүүгийн гүйцэтгэлд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр ажиллав. Тайлант онд дотоод, гадаадын санхүүжилттэй хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүн, гарааны компанийн тайлан болон шинээр байгуулах компанийн танилцуулга, журмын төсөл, ЭШИГ-аас санаачилсан төслийн танилцуулгыг хэлэлцүүлэх зорилгоор "Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл"-ийн хурлаар 2018.12.14 болон 2019.01.31, 2019.06.18-нд нийт 3 удаа хэлэлцүүлж дүгнэлээ. Эдгээр хурлаар 13 төслийн явц, үр дүн, "Гарааны ШУТИС хүнс" ХХК-ийн тайлан, шинээр байгуулах "Гарааны модон араг бүтээц" ХХК-ийн танилцуулга, Барааны тэмдэгт ашиглах журмын хэлэлцүүлэг, Байгууллагын хөгжлийг дэмжих төслийн санал зэрэг нийт 19 асуудал хэлэлцэж шийдвэр гаргасан.

ШУТИС-ийн хэмжээнд нийт дотоодын санхүүжилттэй төсөл хөтөлбөр-48, гадаадын санхүүжилттэй-29, аж ахуйн гэрээт ажил-164 хэрэгжүүлж, нийтдээ 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилттэй эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн байна.

Эдгээр төсөл хөтөлбөр, аж ахуйн гэрээт ажлуудын санхүүжилтээс ШУТИС-ийн хэмжээнд нийтдээ 329.5 сая төгрөгийн шимтгэл төвлөрсөн байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийн нэгдсэн дүн

Хүснэгт 3.2

д/д	Сургууль	ШУТИС-ийн Технологийн сан	2018-2019 оны санхүүжилт, /сая.төг/			
			Улсын захиалгат төсөл /БШУСЯ-ШУТСангаас олгогдсон гадаад болон дотоод төсөл/	Аж ахуйн гэрээт ажил	ОУ-ын санхүүжүүлэгч байгууллагаас санхүүжсэн төсөл /MJEED, ADB, Koica, Erasmus, DAAD, HoRizon 2020 г.м/	Дүн
Бүрэлдэхүүн сургуулиуд:						
1	БАС			603.7	495.0	1,098.69
2	БАТС		4.00	16.0	14.0	34.00
3	БуХС			125.3	-	125.25
4	ГУУС		247.03	855.0	207.6	1,309.61
5	ДаТС		9.90	45.1	-	54.98
6	МехТС	20.0	51.28	240.7	20.0	332.02
7	МХТС	15.0	86.50	27.5	50.6	179.60
8	ҮТС	10.0	359.03	184.1	98.0	651.19
9	ХШУС	10.0	69.51	34.3	56.4	170.21
10	ЭХС		183.92	385.5	250.0	819.43
11	ОМССХ	10.0	37.77	12.8	39.6	100.11
12	ЭШИГ	75.1	75.08		529.9	680.06
13	ГХС	8.0		2.6	27.3	37.87
14	ЕНИ		40.59	52.7	-	93.29
Нэгдсэн дүн		148.1	1,164.6	2585.28	1,788.32	5,686.31

3.3. СУДАЛГААГ ДЭМЖИХ ТЕХНОЛОГИЙН САН

ШУТИС-ийн Технологийн сангаас 2012-2018 онд санхүүжүүлж хэрэгжүүлсэн төслүүдийн мэдээлэлд боловсруулалт судалгаа хийж, мэдээллийн бааз үүсгэж ажиллалаа. Энэ хугацаанд нийт 34 төсөл хэрэгжүүлж, үр дүнд нь нийт -62 /патент, оюуны өмч, өгүүлэл, эшлэл, ном, бүтээл, стандарт, зөвлөмж гэх мэт/ оюуны бүтээл гарсан байна. ШУТИС-ийн Технологийн сангаас жилд дунджаар 170 сая орчим төгрөгийн төсөл хөтөлбөрийг сүүлийн 7 жилд санхүүжүүлсэн байна.

ШУТИС-ийн Технологийн сангаас 2018-2019 оны хичээлийн жилд нийт 8 төсөлд 78 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд тэдгээрийн 6 төсөл нь 2018 оноос шинээр хэрэгжүүлж эхэлсэн төсөл байна. Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Технологийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төслүүдийн ерөнхий мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

ШУТИС, Технологийн сангийн санхүүжилттэй төсөл
Хүснэгт 3.3

д/д	Төслийн нэр	Гэрээний хугацаа	Төслийн удирдагч	Батлагдсан төсөв /сая.төг/	2018-2019 оны санхүүжилт /сая.төг/	Сургуулийн нэр
1	Бэлчээрийн малын баасаар шахмал тулш үйлдвэрлэх	2018.10.01-2019.12.31	Ч.Ганбаатар	10.0	10.0	ОМССХ
2	Цайрын оксидын хэт ягаан гэрлийн мэдрэгчийг хөгжүүлэх боломжийн судалгаа	2018.10.01-2020.02.01	Х.Загарзүсэм	15.0	6.2	МХТС
3	Задлан шинжилгээний дэвшилтэд технологид тулгуурласан хүнсний ургамлыг зохицуулах үйлчлэл-технологийн судалгааг хэрэгжүүлэх нь	2018.10.01-2020.06.01	Э.Энхцэцэг	10.0	9.0	ҮТС
4	Машин сургалтыг үйлдвэрлэлд ашиглах, их сургуулийн жишиг хөгжүүлэлт	2018.10.01-2020.04.31	Ц.Мөнх-Эрдэнэ	10.0	10.0	ХШУС
5	Гадаад оюутанд зориулсан монгол хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах	2018.10.01-2019.06.01	Ч.Оюунгэрэл	8.0	8.0	ГХС
6	Түүхийн дурсгалт зүйл, археологийн олдворыг гурван хэмжээст дижитал технологи ашиглан хадгалах, хамгаалах, судлах	2018.12.01-2019.11.30	Э.Наранбаатар	20.0	4.0	МехТС

7	ШУТИС-ийг Олон улсын их дээд сургуулиудын эрэмбэ тогтоох үйл явцад хамруулах	2018.07.01- 2019.12.31	Ж.Арслан	19.8	6.2	ЭШИГ
8	ШУТИС-ийн түүхэн замнал цуврал боть бичих төсөл	2015.10.01- 2019.07.01	Ч.Авдай	55.3	24.7	ЭШИГ
Нийт				148.1	78.0	-

3.4. УЛСЫН ЗАХИАЛГАТ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

ШУТИС-ийн 2000-2018 онд хэрэгжүүлсэн улсын захиалгат төслүүдийн мэдээллийг холбогдох эх үүсвэрүүдээс судалж, мэдээллийн бааз үүсгэж ажиллалаа. Энэ хугацаанд нийт 194 төсөл хэрэгжүүлж, үр дүнд нь нийт -1596 /патент, оюуны өмч, өгүүлэл, эшлэл, ном, бүтээл, стандарт, зөвлөмж гэх мэт/ оюуны бүтээл гарсан байна.


ШУТИС нь дунджаар улсын захиалгат 2 тэрбум орчим төгрөгийн өртөг бүхий төслүүдийг 2-3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж, үүнээс жилд дунджаар 623 сая орчим төгрөгийг төслийн санхүүжилтэд авч зарцуулж байна.

Улсын захиалгат судалгаа боловсруулалтын ажлын жагсаалт

Хүснэгт 3.4

№	Төслийн төрөл	Эхэлсэн он	Дууссан он	Төслийн тоо	Гэрээний дүн /төгрөгөөр/
1	Захиалгат төсөл	2016	2020	16	1,347,400,000
2	Инновацийн төсөл	2016	2019	3	251,500,000
3	Суурь судалгааны төсөл	2017	2020	6	180,500,000
4	Хамтарсан төсөл	2015	2021	10	379,100,000
5	Докторын дараах инноваци	2017	2019	4	40,000,000
6	ШУА-ийн грант	2018	2018	1	6,500,000
НИЙТ				40	2,205,000,000


2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-д: Захиалгат-16, Инновацийн-3, Суурь судалгааны-6, Хамтарсан-10, докторын дараах инноваци-4, ШУА-ийн грант-1 нийт 40 төслийг 2.2 тэрбум гэрээний үнийн дүнтэй хэрэгжүүлж байгаагаас тус хичээлийн жилд нийт 1.16 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.



Зураг 3.3. ШУТС санхүүжилттэй ШУТИС-д хэрэгжиж байгаа төслүүд

Эх сурвалж: Шинжлэх ухааны салбарын нэгдсэн мэдээллийн сан. "Эрдэм шинжилгээний ажлын тайлан" мэдээллийн сан www.stf.mn

2018-2019 оны хичээлийн жилд улсын захиалгаар гүйцэтгэсэн төслийн нийт мөнгөн дүн, тоо, түүнээс ШУТИС-д төвлөрүүлсэн шимтгэлийн мэдээллийг бүрэлдэхүүн сургууль тус бүрээр боловсруулж доорх Зурагт үзүүлэв.



Зураг 3.4. Улсын захиалгат төслийн тоон мэдээ /сая.төг/

Дээрх зургаас харахад ҮТС - 396 сая төгрөгийн дүн бүхий 11 төсөл, ГУУС- 247 сая төгрөгийн дүн бүхий 7 төсөл, ЭХС-183 сая төгрөгийн дүн бүхий 7 төсөл

хийж гүйцэтгэсэн байна. Тус төслүүдийн санхүүжилтээс ШУТИС-д нийт 115 сая төгрөгийн шимтгэл төвлөрсөн. Мөн 2019 оны эхний хагас жилийн байдлаар дараах төслүүдийн гэрээ шинээр байгуулагдан хэрэгжиж эхлээд байна.

**Шинээр гэрээ байгуулсан төслүүд
/2019 оны эхний хагас жилд/**

Хүснэгт 3.5

№	Төслийн нэр	Бүрэлдэхүүн сургууль	Төслийн удирдагчийн нэр
1	Тогтохын шил гүний магмын бүрдлийн гарал үүсэл, геодинамик орчин, зэсийн хүдэржилт	ГУУС	С.Хишигсүрэн
2	Говийн бүсийн газрын доорх усны тэжээмжийн судалгаа (Загийн усны хоолой газрын доорх усны жишээн дээр)	ГУУС	Д.Энхбаяр
3	Дулаан хадгалах наноматериалын судалгаа	ХШУС	Г.Батдэмбэрэл
4	Нанохэмжээст вольфрам болон молибдений диселенид гарган авах судалгаа	ХШУС	Г.Мөнхсайхан
5	Зарим металлын нанобөөмс тэдгээрийн харилцан үйлчлэлийн судалгаа	ХШУС	Г.Цэрмаа
6	Байгалийн цеолитийн эрдсэлийг модификацид оруулан адсорбцлох чадварыг нэмэгдүүлэх судалгаа	ХШУС	Г.Саран
7	Хатуу тосолгооны материал гарган авах судалгаа	ХШУС	Д.Хандмаа
8	Карбон материалаас графен гарган авах судалгаа	ХШУС	Т.Баттөмөр

3.5. ГАДААДТАЙ ХАМТАРСАН УЛСЫН ЗАХИАЛГАТ ТӨСӨЛ

БСШУСЯ-ШУТсангийн гадаадын байгууллагатай хамтарсан захиалгат төсөл

Хүснэгт 3.6

№	Төсөл, ажлын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Төслийг хамтран хэрэгжүүлж буй улс	Хэрэгжих хугацаа
1	Уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежментийн хөтөлбөрийг боловсруулах	Геологи уул уурхайн сургууль	БНСУ-ын Ёнсей их сургууль	2017-2019
2	Хойд Монголын, хожуу Кайнозойн шүлтлэг базальтын магмын эх үүсгэвэрт далайн царцдас ба карбонат материалын оролцоо	Геологи уул уурхайн сургууль	ОХУ	2018-2020
3	Микро шингэн дэх бактерийг цахилгаан диалектикийн аргаар таних	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Тайвань, Цин хуа их сургууль	2017-2020
4	Ур чадварыг хөгжүүлэх төсөл	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	БНГУ	2018-2019

5	Орхоны хөндий, Өгий нуурын сав газрын цөлжилт, хөрсний эвдрэлийг бууруулах бодлогыг дэмжих экологийн нарийвчилсан үнэлгээ	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Тайвань	2018-2021
6	Бэлчээрийн монгол адууны хүнсний үнэт чанар, түүнд нөлөөлөх генийн судалгаа	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	БНХАУ	2018-2020
7	Уламжлалт болон өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний химийн найрлага, физик химийн шинж чанар, хүнс тэжээл, эрүүл ахуйн аюулгүй байдлын үнэлгээний олон улсын стандарт, аргачлалыг нутагшуулах, мэдээллийн сан бүрдүүлэх	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	БНХАУ	2016-2019
8	Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, экологийн үзүүлэлтийг сайжруулах зорилгоор эргэх буцах давхаргад монголын нүүрсийг шатаах технологийн шинэчлэл ба судалгаа	Эрчим хүчний сургууль	ОХУ	2018-2020
9	Монгол орны өмнөд говийн бүсийн салхины эрчим хүчний нөөц, горимын шинж чанарыг тодорхойлох, Монгол-хятадын салхины эрчим хүчний салбарын хөгжлийн хамтын ажиллагаа	Эрчим хүчний сургууль	БНХАУ	2018-2019
10	Монгол Оросын хоорондын эрчим хүчний тэргүүлэх чиглэлийн шинжлэх ухааны үндсийг боловсруулах	Эрчим хүчний сургууль	ОХУ	2018-2020

Эрдэм шинжилгээний нэгдсэн хуанлийн дагуу 2019 оны 05 сарын 01-нээс 10-ны хооронд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын Эрдмийн зөвлөлийн хурлаар төслүүдийн үр дүнг хэлэлцүүлсэн. Хэрэгжиж дууссан гадаадын санхүүжилттэй төслүүдийн тайланг 2019 оны 06 сарын 18-ны өдөр Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр хэлэлцүүлж, БАТС-д хэрэгжиж буй “Монгол Оросын жишээн дээр Байгалийн тусгай хамгаалалттай бүс дэх аялал жуулчлал болон экологийн баримжаат бизнесийг дэмжих арга механизмыг боловсруулах нь” сэдэвт төслийг сунгаж, БАС-ийн “Ногоон барилгын зураг төсөл”, “Тэр хорооллын дулаалгын төсөл” сэдэвт төслийг амжилттай хэрэгжсэн гэж дүгнэв.

Нийт төслүүдийн үйл ажиллагааны явцын үр дүнг хангалттай болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх санал, зөвлөмж, дүгнэлтийг тус тус өгсөн байна.

3.6. ОЛОН УЛСЫН САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ

ШУТИС-ийн эрдэмтэн, судлаач багш нар 2018-2019 оны хичээлийн жилд Япон, БНСУ, БНХАУ, Тайвань, ОХУ, Европын холбооны улс, АНУ гэх зэрэг орнуудын их, дээд сургууль, байгууллагуудтай хамтран нийт 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 20 орчим эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн болон гүйцэтгэж байна.

Гадаадын байгууллагын санхүүжилттэй нийт төслүүдийн жагсаалт

Хүснэгт 3.7

№	Төсөл, ажлын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Төслийг хамтран хэрэгжүүлж буй байгууллага	Хэрэгжих хугацаа
1	Монгол улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэл болон нөөцийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх төсөл	Барилга, архитектурын сургууль	Европын Холбоо, Чехийн Хөгжлийн Агентлаг	2016-2020
2	Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэгээний өнөөгийн байдал, менежментийн судалгаа	Барилга, архитектурын сургууль	Жайка олон улсын байгууллага	2017-2018
3	Улаанбаатар хотын захын хорооллын эмзэг бүлгийн айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг бууруулах төсөл	Барилга, архитектурын сургууль	Европын холбооны "Жерес" ТББ	2018-2021
4	Ногоон барилгын зураг төсөл	Барилга, архитектурын сургууль	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл /PAGE/	2017-2018
5	Гэр хорооллын дулаалгын төсөл	Барилга, архитектурын сургууль	Улаанбаатар цэвэр агаар төсөл /UBCAB/	2017-2018
6	Монгол Оросын жишээн дээр Байгалийн тусгай хамгаалалттай бүс дэх аялал жуулчлал болон экологийн баримжаат бизнесийг дэмжих арга механизмыг боловсруулах	Бизнесийн ахисан түвшний сургууль	ОХУ-тай хамтарсан	2016-2018
7	НТИС-ШУТИС ГИГАКУ Техно-Парк офис/ NUT-MUST GIGAKU Techno-Park office	Бизнесийн ахисан түвшний сургууль	Япон улсын Нагаока Технологийн их сургууль	2015-2020
8	Сармисны талбайн туршилт/ Garlic field in Agriculture bed test.	Бизнесийн ахисан түвшний сургууль	БНСУ-ын Гунсаны үндэсний их сургууль	2018-2019
9	Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэгчээс урьдчилан сэргийлэх нь	Бизнес, удирдлага хүмүүнлэгийн сургууль	Нээлттэй Нийгэм Форум/Сан	2016-2018
10	Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж	ГУУС, Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл сургалтын төв	Австрали-Монголын эрдэс баялгийн салбар	2018-2019
11	Монголын хожуу девоны үеийн организмын мөхөл, түүний нотолгоо зүсэлтийг илрүүлэх	ГУУС, Стратиграф-Палеонтологийн судалгааны төв	АНУ-ын Аппалачийн их сургууль	2018-2019

12	" Erasmus +, K107 GREB - "Ногоон барилга" - Ухаалаг барилгын инженерчлэлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх"	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Итали Улсын Лауилагийн их сургууль	2017-2019
13	"Erasmus" Paving the way to interregional mobility and ensuring relevance, quality and equity of access - PAWER -	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Итали Улсын Лауилагийн их сургууль	2017-2019
14	Regenerative Medicine Innovation Crossing (REMIX)	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Итали Улсын Трентогийн их сургууль	2018-2020
15	Бохир ус цэвэршүүлэх адсорбент материал (Adsorbent material for Wastewater)	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	БНСУ-ын Материал судлалын хүрээлэн	2017-2019
16	Монгол хүүхдийн биеийн хэмжээний судалгаа боловсруулалт	ҮТС-ийн Хувцас судлалын төв	ХХААХҮЯ-ны захиалгат	2017-2018
17	Бэлчээрийн монгол малын махны чанарын судалгаа	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	БНХАУ-тай хамтарсан	2018-2020
18	"Erasmus +capacity building in the field of higher education	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Турк улсын ЕҮЕ их сургууль	2019-2020
19	"Erasmus+CBHE project: Euro-Mongolian Cooperation for Modernization of Engineering Education" Европ-Монголын инженерийн дээд боловсролыг шинэчлэх	Эрчим хүчний сургууль	Европын холбоо, Софигийн техникийн их сургууль	2018-2020
20	SMARTCITY: Innovative Approach Towards a Master Program on Smart Cities Technology	Эрчим хүчний сургууль	Софигийн технологийн их сургууль	2018-2021

3.7. "ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ" (M-JEED) ТӨСӨЛ

ШУТИС-ийн тэргүүлэх чиглэл болох:

- 1) Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл,
- 2) Эрчим хүч байгаль орчны инженерчлэл,
- 3) Автоматжуулалт, системийн инженерчлэл,
- 4) Био инженеринг чиглэлүүдээр "Инженер технологийн дээд боловсрол" төслийн хамтарсан судалгааны төслүүд тус сургууль дээр хэрэгжиж байна.

Уг төслийн хүрээнд 2015-2019 он хүртэл Япон улсын шилдэг 20 орчим их, дээд сургуульд зэргийн ба зэргийн бус хөтөлбөрт 200 орчим судлаач, Япон улсаас 130 гаруй зочин судлаачид урт, богино хугацаатай ШУТИС дээр ирж ажилласан. Энэ хугацаанд 2 орны хамтарсан судалгааны үр дүнд эрдэм шинжилгээний гадаад өгүүлэл 130, дотоод өгүүлэл 132, эрдэм шинжилгээний гадаад, дотоодод илтгэл 218

хэлэлцүүлж, зохиогчийн эрх-2, ашигтай загвар-1, шинэ технологи-1, стандарт-1, Хамтын ажиллагааны санамж бичиг-8 тус тус байгуулан ажилласан байна.

Хамтарсан судалгааны багуудын “Судалгаа дэмжих сан” жил бүр 10 сая төгрөгийн санхүүжилттэй ба эрдэм шинжилгээ, сургалт, туршилт судалгаа болон бусад үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.

ШУТИС-ийн хамтарсан судалгааны 10 төсөл

Хүснэгт 3.8

№	Төсөл, ажлын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Удирдагч	Хэрэгжих хугацаа
1	Монгол орны эрдэс баялгийн суурь судалгаа	Геологи уул уурхайн сургууль	С.Жаргалан	2015-2023
2	Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй төсөл	Барилга, архитектурын сургууль	Д.Сүнжидмаа	2016-2023
3	Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт	Механик тээврийн сургууль	М.Дэлгэрмаа	2016-2023
4	Монголын тэнгэрийн дэд бүтэц	Механик тээврийн сургууль	Б.Эрдэнэбат	2015-2023
5	Хүрээлэгч орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр	Геологи уул уурхайн сургууль	О.Мөнхцэцэг	2015-2023
6	Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацийн судалгаа	Эрчим хүчний сургууль	Б.Сэргэлэн	2015-2023
7	Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа	Барилга, архитектурын сургууль	Ц.Цоггэрэл	2015-2023
8	Дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ ба ахуйн ухаалаг системийн хөгжүүлэлтийн судалгаа	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Г.Хишигжаргал	2015-2023
9	Монголын хүнсний зарим бүтээгдэхүүний хатаах аргын харьцуулсан судалгаа	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Ц.Одбаяр	2015-2023
10	Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт	Механик тээврийн сургууль	Д.Ганбат	2015-2023

Хамтарсан судалгааны 10 багийн үйл ажиллагааны үр дүнг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын Эрдмийн зөвлөлийн хурлаар 2019.05.01-05.10-ны өдрүүдэд, “ИТДБ” төслийн нэгж (ТХН), Зөвлөх баг (Asia SEED), Сургуулийн ажлын хэсэг (САН) хамтран 2018-2019 оны хичээлийн жилд хоёр удаа төслийн явц, үр дүнг тус тус хэлэлцэж үнэлж, дүгнэн, зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллалаа.

Түүнчлэн хичээлийн жилд 2 удаа хөтөлбөрт хамрагдах судлаачдыг бүртгэж, шат шатны хурлаар оруулж хэлэлцэж, гарсан шийдвэрийг төслийн нэгжид хүргүүлж ажиллаж байна.


Зэргийн /магистр, доктор/ хөтөлбөрт:

2019 оны 4 сараас Япон улсын их, дээд сургуульд суралцах багш, судлаачдын материалыг хянан магадлаж, Сургуулийн ажлын хэсэг (САХ) хэлэлцэн шийдвэрлэж, Төслийн нэгж (ТХН)-д уламжилсан ба 2019 оны 02 сарын 14-ний өдрийн БСШУС-ын сайдын А/66 тоот тушаалаар 1 судлаач, 2 магистр, 8 докторын хөтөлбөрт тус тус хамруулахаар шийдвэрлэсэн.

2019 оны 7-12 сард судалгааны багуудаас докторын хөтөлбөрт 4, магистрын хөтөлбөрт 1 судлаачийг хамруулах шийдвэрийг Төслийн нэгж (ТХН)-д хүргүүлээд байна.

2019 оны байдлаар зэргийн хөтөлбөрөөр ШУТИС-иас нийт магистрантурт 8, докторантурт 28 багш, судлаач суралцаж байна. Одоогийн байдлаар 13 магистр, 4 доктор сургалт, судалгааны ажлаа амжилттай хамгаалж ирсэн байна.

Зэргийн хөтөлбөрөөр суралцагч болон төгсөгчдийн тоон үзүүлэлт



Зураг 3.5.Зэргийн хөтөлбөрт хамрагдсан судлаачид

Зэргийн бус хөтөлбөрт:

2019 оны 1-6 сард зэргийн бус хөтөлбөрт Япон улсын их, дээд сургуульд судалгааны ажлаар суралцах судлаачдын холбогдох материалыг хянан магадалж, Сургуулийн ажлын хэсэг (САХ) хэлэлцэн шийдвэрлэж Төслийн нэгжид хүргүүллээ. 2018 оны 12 сарын 31-ний өдрийн БСШУС сайдын А/848 тоот тушаалаар нийт 5 судлаачдыг тус тус хамруулахаар шийдвэрлэсэн. 2019 оны сүүлийн хагас жилд судалгааны гурван багаас нийт 5 багш, судлаачийг хамруулахаар шийдвэрлэж Төслийн нэгжид (ТХН) саналыг хүргүүлээд байна.

Зочин судлаач хөтөлбөрт:

2019 оны 1-6 сард Зочин судлаач хөтөлбөрөөр Япон улсын их, дээд сургуулиас нийт 11 судлаач, профессор ШУТИС дээр урт, богино хугацаагаар уригдан ажилласан ба 2019 оны 7-12 сард ирж ажиллах судлаачдын ажлын төлөвлөгөөг Сургуулийн ажлын хэсэг (САХ) хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийг Төслийн нэгжид (ТХН) уламжилсан.

Зочин судлаач хөтөлбөрт хамрагдсан байдал

Хүснэгт 3.9

Судалгааны тэргүүлэх чиглэл	Судалгааны сэдэв, Бүрэлдэхүүн сургууль	Магистр	Доктор	Зэргийн бус
1.Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл	1.Монгол орны эрдсийн баялгийн суурь судалгаа (ГУУС)		1	3
	2.Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй төсөл (БАС)	2	1	
	3.Шинэ материалын дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлт (МехТС)		2	1
2.Эрчим хүч, байгаль орчны инженерчлэл	4.Эрчим хүчний дамжуулалт, түгээлтийн инновацийн судалгаа (ЭХС)		1	2
	5. Монгол орны хүрээлэн буй орчин, газар хөдлөлтийн инженерчлэлийн судалгаа (БАС)		2	1
3.Автоматжуулалт, эмбедэд технологи	6. Дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ ба ахуйн ухаалаг системийн хөгжүүлэлтийн судалгаа (МХТС)		4	2
4.Био-инженерчлэл /Хоол хүнс, эм болон био принтинг/	7.Монголын уламжлалт зарим бүтээгдэхүүний хатаах аргын харьцуулсан судалгаа (ҮТС)		1	
	8. Хүний тогтвортой хөгжлийг хангах Био-инженерчлэлийн судалгаа хөгжүүлэлт (МехТС)			2
НИЙТ		2	12	11

Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн тоон үзүүлэлт

Хүснэгт 3.10

Өгүүлэл, илтгэл	Шинэ материал, нөөцийн технологийн инженерчлэл	Эрчим хүч байгаль орчны инженерчлэл	Автоматжуулалт, системийн инженерчлэл	Био инженеринг (хүнс, эм бэлдмэл, биопринтинг)

Өгүүлэл /Гадаад/	3	23	4	-
Өгүүлэл /Дотоод/	12	6	-	1
Илтгэл /Гадаад/	8	7	1	3
Илтгэл /Дотоод/	9	5	3	3

Тоног төхөөрөмж худалдан авалтын хүрээнд

Тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 2019 оны 05 сард төслийн 1-р багцад захиалагдсан судалгааны шинэ тоног төхөөрөмжүүд Барилга архитектурын сургуульд ирж тэдгээрийг хичээлийн I байр, V байр дээр байрлуулаад байна. Нийт 95 сая иений өртөгтэй, Япон улсын Tec International Inc зэрэг нийт 5 компанийн 12 нэр төрлийн 13 ширхэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан.


Нээлттэй судалгааны лаборатори байгуулах ажлын хүрээнд төслийн шугамаар орж ирэх судалгааны зарим тоног төхөөрөмжийг шинээр баригдаж буй VIII байранд байрлуулахаар холбогдох газар санал хүргүүлсэн.



Зураг 3.6. “Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах, ногоон ирээдүй” багийн судалгааны тоног төхөөрөмжүүд


3.8. ГЭРЭЭТ АЖИЛ

ШУТИС-ийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд нийт 164 аж ахуйн гэрээт ажлыг 2.32 тэрбум төгрөгийн санхүүжилттэй гэрээ байгуулж, үүнээс 1.48 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.



Зураг 3.7. Бүрэлдэхүүн сургуулиудын гэрээт ажлын тоо, эзлэх хувь

ШУТИС-ийн хэмжээнд хэрэгжүүлсэн нийт аж ахуйн гэрээт ажлын тоог хувилж үзвэл БАС-48%, БуХС-12%, ГУУС-10%, УТС-9% буюу хамгийн их хувийг эдгээр сургуулиудын профессор, багш нарын гүйцэтгэсэн ажил эзэлж байна.




	ГУУС	БАС	ЭХС	УТС	МехТ С	БуХС	ЕНИ	ДаТС	ХШУС	МХТС	БАТС	ГХС
ШУТИС-10% шимтгэл	85.5	60.01	38.55	22.02	24.07	12.52	5.2	4.5	2.43	2.13	1.6	0.26
2018-2019 онд санхүүжсэн	854.98	603.74	385.52	196.89	240.74	125.25	52.7	45.08	34.3	27.49	16	2.6
Гэрээний дүн	1603.76	970.94	476.19	358.75	261.64	125.25	62.5	45.08	34.3	23.9	16	2.6

Зураг 3.8. Гүйцэтгэсэн аж ахуйн гэрээт ажлын дүн /сая.төг/

Нийт гэрээт ажлын 1.48 тэрбум төгрөгийн орлогыг дүгнэж үзвэл 33% буюу 85,4 сая төгрөгийг ГУУС, 23% буюу 603 сая төгрөгийг БАС, 15% буюу 385 сая төгрөгийг ЭХС-иуд гүйцэтгэсэнээс харвал уул уурхай, барилга, эрчим хүчний

салбарт хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлуудын нэгж үнэлгээ өндөр байгаа нь харагдаж байна.



Зураг 3.9. ШУТИС-д төвлөрүүлсэн шимтгэлд сургуулиудын эзлэх хувь

2018-2019 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн аж ахуйн гэрээт ажлаас ШУТИС-ийн Технологийн санд 73.2 сая төгрөг, бүрэлдэхүүн сургуулиудад 73.2 сая төгрөг нийт 146.4 сая төгрөгийн шимтгэл төлөлт төвлөрсөн.

Үүнээс томоохон үнийн дүн /100 саяас дээш/ бүхий гэрээт ажлыг түүвэрлэн доорх хүснэгтэд харуулав (Нийт гэрээт ажлын 77% буюу 1.15 тэрбум төгрөг).

**Аж ахуйн гэрээт ажлууд
/100 саяас дээш өртөг бүхий/**

Хүснэгт 3.11

№	Гэрээт ажлын нэр	Гэрээт ажлын удирдагч	2018-2019 оны санхүүжилт /сая.төг/	Сургуулийн нэр
1	Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн элэгдсэн эд ангийг сэргээн засварлах дэвшилтэт технологийг сонгох ТЭЗҮ	П.Аюурзана	200.0	МехТС
2	Эрдэнэт-үйлдвэр ХХК-ийн үйлдвэрлэлийн барилгын үндсэн суурь болон даацын хана багануудад техник эксперт хийх	Я.Дүйнхэржав	140.0	БАС
3	Эрчим хүчний хэмнэлттэй дулаан хуримтлуурт цахилгаан хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага стандарт боловсруулах	Ж.Цэен-Ойдов	184.1	ЭХС
4	Голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа	Б.Чинзориг	249.3	ГУУС
5	Эрдэнэтийн нэгдсэн уурхайн гидрогеологи ба инженер	Н.Буянхишиг	172.5	ГУУС

	геологийн нарийвчилсан судалгаа			
6	Их Өлзийт-50 талбайн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	О.Мөнхцэцэг	202.3	ГУУС

3.9. СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН, ТӨВ

Эрдэм шинжилгээний хүрээлэн

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяанд 2018-2019 оны хичээлийн жилд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн, бүрэлдэхүүнд Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн болон Ой модны сургалт судалгааны хүрээлэнгүүд үйл ажиллагаагаа явууллаа.



Зураг 3.10. Хүрээлэнгийн хүний нөөц

Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагааны тайланг 2019 оны 06 сарын 18-ны өдөр Эрдэм шинжилгээ, инноваци хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлээ. Тухайн хичээлийн жилд харьяа бүрэлдэхүүн хүрээлэнгүүд нийт шинжлэх ухаан, технологийн болон суурь судалгааны 14 төсөл хэрэгжүүлснээс 5 төслийн үр дүнг захиалагчид хүлээлгэн өгсөн.

ADB-ийн хөрөнгө оруулалтаар суурилагдсан тоног төхөөрөмжүүд
Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн



Электрон микроскоп SEM-EDX



“Tissue Tek DRS 2000”




Лабораторийн стандарт орчин бүрдүүлэгч кондиционер

Харьяа болон бүрэлдэхүүн хүрээлэнгүүд тайлант хугацаанд аж ахуйн нэгжийн захиалгат ажил нийт 24-ийг гүйцэтгэснээс Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн 15 гэрээт ажлыг гүйцэтгэсэн байна. Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн 2 ашигтай загварын гэрчилгээ авсан бол С.Дашбал “Арьс шир боловсруулах технологийн судалгаа хөгжил”, Г.Надмид, Г.Батчимэг, Ц.Ганболд нарын “Торомны ноолуур” зэрэг ном, сурах бичгийг хэвлүүллээ. Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгээрээ дотоодын сэтгүүлд 7, гадаадын сэтгүүлд 3 өгүүлэл нийтлүүлсэн байна.



Харьяа болон бүрэлдэхүүн хүрээлэнгийн судлаачид нийт 43 өгүүлэл хэвлэн нийтлүүлснээс Уул уурхайн хүрээлэнгийн судлаачид судалгааны өгүүлэл 25, Б.Пүрэвтогтох “Ил уурхайн авто тээвэр” номыг хэвлүүлсэн үр дүнтэй байна. Уул уурхайн хүрээлэн нь лабораторийн нүүрсний шинжилгээнээс гадна Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн ТЭЗҮ-ийн тодотгол, Дорноговь аймгийн Алтан ширээ сумын “Энгэрийн толгод” нүүрсний ордыг ашиглах уурхайн ТЭЗҮ, Дорноговь аймгийн Айраг сумын Дай-Уулын жоншны ордыг ил, далд аргаар ашиглах ТЭЗҮ, Дай-Уулын жонш баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ зэрэг гэрээт ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 3.11. Боловсруулсан ажил, үр дүн

Ой модны сургалт судалгааны хүрээлэн нь тус тайлант хугацаанд ой модны салбарын 4 стандартыг боловсруулж мөн Япон улсын Уцуномияагийн Их сургууль, ШУТИС, МУИС, ХААИС, ШУА-ийн Сорилын ба ерөнхий биологийн хүрээлэн, Газар зүй геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэд оролцсон 3 салбар хуралдаан бүхий олон улсын хурлыг Монгол улсад анх удаа зохион байгууллаа. “Ойн цэвэрлэгээгээр гарах хоёрдогч нөөцийг ашиглан технологийн цавчдас үйлдвэрлэх боломжийн судалгаа” нэртэй шинжлэх ухаан технологийн төслийг хэрэгжүүлж эхлээд байна. UN-REDD хөтөлбөртэй хамтран “Ой, уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт хичээлийн




стандарт боловсруулж ой, уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдаж буй асуудлууд шийдлийн талаар мэргэжлийн ангийн оюутнуудад шаардлагатай мэдлэг олгох G.FI269 хичээл болгож сургалтын хөтөлбөрт оруулж сурах бичгийг хэвлүүлэв. Дулааны техник үйлдвэрийн экологийн хүрээлэнгийн судлаачид “Эргэлдэх буцлах давхаргатай зуухны горимыг судлан бүтээмжийг тодорхойлох” шинжлэх

ухаан, технологийн төсөл, “Монголын эрчим хүчний нэгдсэн системийн хөгжлийн загвар боловсруулах” суурь судалгааны төсөл зэрэг ажлуудыг эхлүүлсэн бол “Хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах арга технологи” инновацийн төсөл, “Хувьсах чадалтай эх үүсвэртэй хоршин ажиллах дулааны аккумуляторын судалгаа” инновацийн төсөл зэрэг ажлуудыг захиалагчид хүлээлгэн өгсөн байна. Мөн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи дамжуулах ажлын хүрээнд Увс аймгийн дулааны II станцын зууханд уутат фильтр суурилуулж, сум суурингийн халаалтад зориулан гаргасан эргэлдэх буцлах давхарга бүхий ДТХ1.0-95/70 маягийн зуухны загварыг боловсруулж Сэлхийн аманд “Замбуулин” хотхоны халаалтад мөн суурилууллаа.

Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагаа

ШУТИС-ийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээ, судалгааны 41 төв үйл ажиллагаа явууллаа. Тус хичээлийн жилээс шинээр Усны барилга байгууламжийн сургалт хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт судалгааны төв, Эрчим хүчний тоон технологийн судалгааны төвүүд шинээр байгуулагдав. Төвүүдийн 2015-2017 оны үйл ажиллагааны тайланг 2018 оны 9 сарын 11-ний өдрийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нийт 8 төвийг татан буулгав. Захирлын зөвлөлийн хурлаар зарим төвүүдийн захирлыг өөрчлөх асуудлыг шийдвэрлэж захирлын 2019 оны 09 сарын 28-ны өдрийн тушаалаар баталгаажууллаа. Төвүүдийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн авч үзвэл:

- Судалгааны төвийн бие даан болон хамтран хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажил 138 байгаагаас Геотехникийн судалгааны төв 24 ажил, Мэдээлэл холбооны технологийн сургалтын төв 23 ажил гүйцэтгэсэн нь өндөр үзүүлэлт болж байна.



Зураг 3.11. Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үндсэн үйл ажиллагаа


- Шинэ технологи, аргачлал боловсруулах, технологи дамжуулалтыг хөгжүүлэх чиглэлд Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Сорилтын төв Үндэсний стандарт MNS 0215 : 2018, MNS 6706 : 2018, MNS 6707 : 2018, MNS 6710 : 2018, MNS 6707 : 2018, MNS 6710 : 2018 зэрэг стандартуудыг боловсруулсан бол Геотехникийн судалгааны төв нь БНБД 50-01.16-гийн аргачлал боловсруулах, Монгол орны цэвдэг хөрсний нөхцөлд Термосифоны арга нэвтрүүлэх болон одоогийн мөрдөж буй MNS –үүдийг судалж нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэснийг онцолж байна.

- Эрдэм шинжилгээний олон улсын хурал, дотоодын семинар, арга хэмжээ зохион байгуулах талаар Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төв, шинээр байгуулагдсан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт судалгааны төвүүд түлхүү ажилласан байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүд нь 461,79 сая төгрөгийн төсөвт ажил гүйцэтгэж үүнээс тайлант хугацаанд 2019 оны 06 сарын байдлаар 360,05 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Төсөл гэрээт ажил гүйцэтгэх журмын дагуу Технологийн санд 18 сая төгрөг, бүрэлдэхүүн сургуульд мөн 18 сая төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлсэн байна.

3.10. ГАРААНЫ КОМПАНИ

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газраас 2018-2019 оны хичээлийн жилд татан буугдах 1, шинээр байгуулагдах 1 гарааны компанийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллалаа.

1. ШУТИС-ийн дэргэд 2015 оны 11 дүгээр сард байгуулагдсан “Гарааны ШУТИС Хүнс” ХХК-ийн үйл ажиллагаа явуулах 3 жил /Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд Гарааны компани байгуулах журмын 1.5-д заасан/-ийн хугацаа дуусаж Гарааны компанийн үүсгэн байгуулагч бөгөөд ШУТИС-ийн ҮТС-ийн профессор Д.Цэцэгээ өөрийн хүсэлтээр гарааны компанийг татан буулгах хүсэлт гаргасан тул гарааны компани татан буугдсан.
2. ШУТИС-ийн ОМССХ-гээс Барилгын тууш модон хийц үйлдвэрлэх “МОДОН АРАГ ХИЙЦ” гарааны компани байгуулах хүсэлт гаргасны дагуу дараах ажлууд хийгдээд байна.



Зураг 3.12. Гарааны компанийн үйл явц

Дээр дурдсаны дагуу ШУТИС-ийн ТУЗ-ийн тогтоол гарсны дараа компанийн тухай хуульд заасны дагуу компанийн дүрэм, холбогдох материал бүрдүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүсэлт гаргаснаар Гарааны компани байгуулагдахад бэлэн болоод байна. Энэхүү компанийг барилгын модон хийц үйлдвэрлэлийн төрөлжсөн үйл ажиллагаа эрхэлдэг “Инжир” ХХК-тай хамтран үүсгэн байгуулахаар тохиролцон ажиллаж байна. Гарааны компанийн үйл ажиллагаанд үүсгэн байгуулагчид дараах эрх, үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:

Үйлдвэрлэл явуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн тоног төхөөрөмж, байр, ажиллах хүчин зэрэг 337,200,000 төгрөгийн анхны хөрөнгө оруулалт “Инжир” ХХК санхүүжүүлж цаашид үйл ажиллагааг хариуцна. Технологийн хөгжүүлэлт, шинэ технологи нэвтрүүлэх, стандарт боловсруулж батлуулах, сургалт сурталчилгаа, технологи нэвтрүүлэлтийн аргачлал, зөвлөмжийн асуудлыг оюуны өмчийн үнэлгээгээр хөрөнгө оруулж буй ШУТИС, Зохиогч нар хариуцна.

Гарааны компанийн хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 3.12


№	Хувьцаа эзэмшигчид	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Инжир” ХХК /Хөрөнгө оруулагч бөгөөд үйл ажиллагаа хариуцагч/	60%
2	“ШУТИС” /Оюуны өмчийн эрх эзэмшигч бөгөөд судалгаа хөгжил, сургалтын техник хэрэгсэл хариуцагч/	20%
3	Зохиогчид Оюуны өмчийн зохиогч бөгөөд технологи хөгжүүлэлт хариуцагч	20%
Нийт		100%



3.11. СУДАЛГААНЫ ЛАБОРАТОРИ

Судалгааны их сургуулийг хөгжүүлэх зорилтын хүрээнд судалгааны лабораторийн ашиглалтыг сайжруулах, салбар дундын нээлттэй лаборатори байгуулах, судалгааны лабораториудын зэрэглэл тогтоох, бүртгэх, мэдээллийн сан, урьдчилсан өгөгдлийн санг бүрдүүлэх, бүрэлдэхүүн сургуулийн лабораторийн орчин, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулж, салбар дундын нээлттэй зарчмаар ажиллуулах нөхцөлийг буй болгох, үр ашгийг нь дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгоход анхаарч бүрэлдэхүүн сургуулиуд дээр үйл

ажиллагаа явуулж байгаа 42 судалгааны лабораторийн өнөөгийн нөхцөл байдалтай ажлын хэсэг танилцав.



Зураг 3.13. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн дээр байгаа лабораториуд

ШУТИС-ийн хэмжээнд бүртгэлжүүлсэн судалгааны лабораторийн үндсэн чиглэл, судалгааны лабораторт ажиллаж буй хүний нөөцийн мэдээлэл, профессор, дэд профессор, гадаадын эрдэмтэн, судлаачидтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэлт, судалгаа боловсруулалтын ажлын гүйцэтгэл, судалгааны ажлын үр дүн, оюуны өмч, хөрөнгө оруулалт хийгдсэн байдал, багш судлаач, оюутнуудыг судалгааны ажилд оролцуулж залуу судлаачдыг бэлтгэх, эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор ахисан түвшний сургалт-судалгаа зэрэг үзүүлэлтээр ШУТИС-ийн “Судалгааны лабораторийн мэдээллийн маягт”-ыг боловсруулан удирдлага болгон ажилласан.


Лабораторийн магадлан итгэмжлэл

Хүснэгт 3.13

Магадлан итгэмжлэл (Үндэсний)	10 лаборатори	Нийт судалгааны лабораторийн 24% нь магадлан итгэмжлэгдсэн байна.
Үндэсний болон ОУ-ын стандарт ашиглалт	21 лаборатори	50%

Байгуулагдсан лаборатори:

2011-2018 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд дээр судалгааны зориулалтаар лабораториудыг шинэчлэсэн буюу шинээр 25 лабораторийг ашиглалтад оруулсан байна. Үүнээс 2017 онд 10 лаборатори байгуулагдсан.




Зураг 3.14. Байгуулагдсан лабораториуд

Лабораторийн хөрөнгө оруулалт


ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад үйл ажиллагаа явуулж байгаа 42 лабораторид ШУТИС болон гадаад, дотоодын компани, аж ахуйн нэгжүүдээс 8 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд, ШУТИС-Бүрэлдэхүүн сургуулийн санхүүжилтээр 14 лабораторид 999,444,863 төгрөг 33%-ийн хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдэж, үлдсэн хувийг нь гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүд санхүүжүүлсэн байна.

Профессор, багш судлаачдын судалгааны 42 лабораторид хийгдсэн судалгаа боловсруулалтын ажлын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 50% нь төсөл, дотоодод эрдэм шинжилгээний өгүүлэл 31%, гадаадад хэвлүүлсэн өгүүлэл 2%, боловсруулсан стандарт 1%, хэлэлцүүлсэн илтгэл 7%, технологийн заавар 9% -ийг тус тус эзэлж байгаа бөгөөд судалгааны ажлын үр дүнд зохиогчийн эрх-1, ашигтай загварын гэрчилгээ-4, патент-1 авсан байна.



Зураг 3.15. Лабораториудад хийгдсэн ажлын үр дүн

Ахисан түвшний сургалт, судалгаа явуулсан байдал



Зураг 3.16. Лаборатори дээр ажилласан судлаач оюутнууд

Лаборатори дээр ажилласан гадаадын профессор, судлаачид

ШУТИС-ийн 6 бүрэлдэхүүн сургуулийн 7 лабораторид 11 улсын 36 профессор, судлаачид хамтарсан төсөл, хөтөлбөр, судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэж байна.

Хамтран ажилласан гадаад профессорууд

Хүснэгт 3.14

Бүрэлдэхүүн сургууль	Салбар	Лабораторийн нэр	Байгуулагдсан он	Гадаадын зочин профессор, судлаачдын /улс, тоо/
ГУУС	Геологи, гидрогеологийн салбар	Хээрийн судалгааны төвийн лаборатори	2012	Япон-4
ХШУС	Химийн инженерчлэлийн салбар	Шинэ материалын лаборатори	2017	Солонгос-1 Итали-1
		Шатах ашигт малтмалын лаборатори	2017	Хятад-2
МехТС	Техникийн механикийн салбар	Биомеханикийн судалгааны лаборатори	2015	Япон-6 Итали-2 Солонгос-1 Тайван-1
ҮТС	Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв	Хүнс судлалын эрдэм шинжилгээ, судалгааны лаборатори	2014	Финлянд-1 Солонгос-2 Герман-1 Итали-1 АНУ-1

БуХС	Хүмүүнлэгийн ухааны салбар	Археологи, этнографийн судалгааны лаборатори	2015	Япон-1 ОХУ-3 Унгар-2 Турк-1 Солонгос-3 АНУ-1
МХТС	Электроникийн салбар	Хагас дамжуулагчийн судалгааны лаборатори	2017	Солонгос - 1

Лабораторийн зэрэглэл, бүртгэлжүүлэлт

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудыг судалгааны чиглэл, гадаадын профессор, судлаачидтай хамтран гүйцэтгэж буй ажлын төрөл, чанар, хэмжээ, хамрах хүрээ, суурилагдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, судалгаа боловсруулалтаас гарсан үр дүн, туршилт шинжилгээ, оношилгоо, лабораторийн магадлан итгэмжлэл, мөрдөн ажиллаж байгаа дүрэм журам, үндэсний болон олон улсын стандарт, судалгааны ажилд судлаачдыг хамруулсан байдал зэрэг дээрх үзүүлэлтэд хамааруулан зэрэглэл, бүртгэлжүүлэлтийг урьдчилсан байдлаар 7 лабораторийг салбар дундын нээлттэй нэгдсэн судалгааны лаборатори, 10 лабораторийг судалгааны лаборатори, 13 лабораторийг сургалт-судалгааны лаборатори гэж төрөлжүүлэн тогтоосон бөгөөд ажлын хэсгийн тайланд санал, дүгнэлт, зөвлөмжийг тодорхой тусгаж ажилласан.

ШУТИС-ийн шинээр баригдаж буй VIII байранд судалгааны лабораторийг байгуулах

ШУТИС-ийн шинээр баригдаж буй VIII байрыг судалгааны нээлттэй нэгдсэн лабораторийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөнтэй холбогдуулан уг байранд байршуулах зориулалт бүхий судалгааны лабораторийн нэрс, тэдгээрт суурилуулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн техникийн үзүүлэлт, шаардлага, лабораторийн тоо, өрөөний тоо, нийт талбайн хэмжээ м², хөрөнгө оруулалтын хэмжээ, төсөв санхүүжилтийн үзүүлэлтийг нэгтгэн боловсруулсан. Үүнд:

1.Одоо ажиллаж байгаа буюу нүүлгэн шилжүүлэх боломжтой салбар дундын нээлттэй нэгдсэн лабораториуд

2.Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд шинээр байгуулагдах судалгааны лаборатори (MJEED)

3.ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын өөрийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулах лабораториуд

4.Аж ахуйн нэгж байгууллагын хандив, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөр шинээр байгуулах гэсэн 4 чиглэлээр нийт 40 лаборатори, 58 өрөө, 3313,51 м.кв талбайн хэмжээ бусад мэдээлэл, саналыг шийдвэрлүүлэхээр ЭШИГ-аас холбогдох удирдлагад хүргүүлж ажиллалаа.

3.12. СУДАЛГААНЫ ХҮНИЙ НӨӨЦ

ШУТИС-ийн чадварлаг мэргэжилтэн, багш, судлаачийг бэлтгэх, тэдний судалгааны ажил хийх нөхцөл боломжоор хангах, эрдмийн зэрэгтэй багш нарын

тоог нэмэгдүүлэх, дэмжих, урамшуулах, судалгааны орчин бүрдүүлэхэд анхааран ажилласан. Үүнд:

Судлаачдыг чадавхжуулах сургалт, семинар зохион байгуулах чиглэлээр.


- ”Author training” сургалт. БСШУСЯ болон Монголын номын сангуудын консорциумтай хамтарсан Springer Nature олон улсын байгууллагын сургагч багшийн 3 удаагийн сургалтад 68 багш оролцож сертификат гардан авлаа /2018.10/25-26, 2019.06/04-06/.
- “Эрдэм шинжилгээний сэтгүүлийн хэвлэн нийтлэл, тавигдах шаардлага” семинар /2019.01 сар/
- “MUST Authors training” сургалтыг 210 орчим судлаачдын дунд зохион байгуулсан /2019/01/16.18/
- “Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сэдэвт сургалтад нийт 2 удаа 93 багш хамруулан зохион байгуулав.



Зураг 3.16.
**“Оюуны өмчийн эрх зүй,
 менежментийн үндсэн ойлголт,
 менежментийг сайжруулах”
 сэдэвт сургалт**

Эрдмийн зэрэг хамгаалсан багш, судлаачдын тоог өсгөх

2018 оны байдлаар ШУТИС-ийн нийт 844 багш нарын 306 буюу 37 хувь нь эрдмийн зэрэгтэй /Статистикийн мэдээ ДБ5/ бөгөөд 40 хувьд хүргэхээр зорилт тавин ажиллаж байна. Тайлант онд 23 багш доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан бөгөөд үүнээс гадаад 11, дотоодод 12 багш хамгааллаа.



Зураг 3.18. Эрдмийн зэрэг хамгаалсан багш нар

Түүнчлэн 2013 оноос хэрэгжиж буй ИТДБ төслийн хүрээнд 2018-2019 онд 2 доктор, 9 магистр төгсөж ирсэн бөгөөд 2019 онд докторантурт 4 багш, магистрантурт 1 судлаач суралцахаар шийдвэрлэгдээд байна.

Судалгаа хийх боломжийг хангах чиглэлээр

Багш нарын судалгааны ажил хийж эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжлийн сурах бичиг, ном зохиол туурвих, инновацийн бүтээгдэхүүн гаргахад дэмжлэг үзүүлэх, боломж нөхцөлөөр хангах зорилготой *бүтээлийн чөлөө олгох* холбогдох дүрэм журам (“ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.4.”Бүтээлийн чөлөө олгох”-2018.12.24-ний А/249)-д өөрчлөлт оруулж, батлагдсан журмыг хэрэгжүүлж байна.

2018-2019 оны хичээлийн жилд 3 багш эрдмийн зэрэг хамгаалах, 1 багш ном сурах бичиг бичихээр бүтээлийн чөлөө авсан.

Бүтээлийн чөлөө авсан багш нар

Хүснэгт 3.15

Д/Д	Багшийн овог, нэр	Сургууль	Чөлөөний хугацаа
1	Л.Удвал	УТС	2018.08.20-2019.02.20
2	Х.Уугантуяа	ХШУС	2018.09.17-2018.12.17
3	Л.Нямжаргал	ХШУС	2018.09.17-2018.12.17
4	Б.Отгончимэг	УТС	2018.10.15-2019.01.15

Судалгааны орчныг бүрдүүлэх чиглэлээр

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /KOICA/-ийн 6 сая долларын санхүүжилттэй төслийг 2019-2022 он хүртэл хэрэгжүүлж байгаа бөгөөд орчин үеийн өндөр технологийн лаборатори байгуулах МХТС-ийн эдэлбэр газарт барих өргөтгөл барилгын ажлын бэлтгэл хийгдсэн.

Шинээр баригдаж буй 8-р байранд 2019 оны намрын улиралд 40 лабораторийг байрлуулж судалгааны нээлттэй орчин бүрдүүлэх ажлын бэлтгэлийг хийгээд байна.


3.13. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд нийт 109 бүтээлд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн. Эдгээрийн 83% нь зохиогчийн эрхийн салбарт хамаарах ба аж үйлдвэрийн салбарт 1 шинэ бүтээлийн патент, 17 ашигтай загварын гэрчилгээ шинээр бүртгэгдлээ.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн байдал


Хүснэгт 3.16

№	Бүрэлдэхүүн сургууль	Шинэ бүтээл	Ашигтай загвар	Зохиогчийн эрх	Нийт
1	БАС			17	17
2	БУХС			4	4
3	ГУУС			10	10
4	ГХС			9	9
5	ДаТС		1	8	9
6	МХТС			20	20
7	МехТС		7	1	8
8	ҮТС	1	5	6	12
9	ХШУС		1	11	12
10	ЭХС		1	2	3
11	ХҮСХХ		2	2	4
12	Уул уурхайн хүрээлэн - УУХ			1	1
	Нийт	1	17	91	109



Зураг 3.19. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгүүдэд хийгдсэн оюуны өмчийн эрхийн хамгаалалт

ШУТИС-ийн хэмжээнд эрхийн хамгаалалт нь хүчин төгөлдөр байгаа оюуны нийт бүтээлүүдийн 14% нь аж үйлдвэрийн өмчийн, 86% нь зохиогчийн эрхийн салбарт хамаарч байна.



Зураг 3.20. Эрхийн хамгаалалт нь хүчин төгөлдөр байгаа оюуны өмч

ШУТИС-ийн хэмжээнд бүтээгдсэн оюуны бүтээлүүдийн дээрх тоон үзүүлэлтүүдийг авч үзвэл аж үйлдвэрийн өмчийн тоо бага байгаа нь багш, ажилчид, судлаач, оюутнуудын оюуны бүтээл туурвих, цаашид эдийн засгийн эргэлтэд оруулах боломж, арга зам, эрх зүйн орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, соёлыг төлөвшүүлэх хэрэгцээг бий болгож байгаа тул тайлант онд бид судлаачдыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулахад анхаарч ажиллалаа. Энэ зорилгоор “Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сэдэвт сургалтыг нийт 2 удаа БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар, Ай Пи Консалтинг ХХК-ийн багш, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгууллаа /Зураг 7.3 /. Эдгээр сургалтууд бүрэлдэхүүн сургуулиуд болон Орхон аймаг дахь Технологийн сургуулийн багш, судлаачдын дунд зохион байгуулагдсан ба нийт 93 хүн хамрагдсан.



Зураг 3.21 “Оюуны өмчийн эрх зүй, менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах” сургалт

3.14. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

“Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл”



2018-2019 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, инновацийн газар болон бүрэлдэхүүн сургуулиуд ISSN1560-8794 дугаартай “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл”-ийн 17 дугаарыг эрхлэн гаргасан бөгөөд 1384 зохиогчийн 709 эрдэм шинжилгээний өгүүллийг сэтгүүлийн зөвлөлийн гишүүдээр техникийн болон агуулгын хянан магадлааг хийлгэж, хэвлэн нийтэлсэн ба урьд онуудтай харьцуулахад өгүүллийн тоо, зохиогчдын тоо өссөн байна.

Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл-ийн хэвлэн нийтлэл

Хүснэгт 3.17

№	Дугаар	Эмхэтгэлийн нэр	Хэвлэгдсэн өгүүллийн тоо	Зохиогчдын тоо
1	15/242	Эрдэнэт үйлдвэрийн 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хамтарсан ЭШ-ний хурлын эмхэтгэл /МехТС, ЭрдТС/	32	75
2	16/243	Цэндийн Гомбодоржийн нэрэмжит “Ногоон технологи ба инноваци” ЭШ-ний хамтарсан хурлын илтгэлүүдийн эмхэтгэл /БАС/	34	71
3	17/244	ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /ЭШИГ/	36	73
4	18/245	ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /ЭШИГ/	33	70
5	19/246	"Уул уурхайн технологи, эдийн засаг, экологи" Уул уурхайн салбарын багш нарын ЭШ-ний бүтээлийн эмхэтгэл /ГУУС/	39	106
6	20/247	“Өрөмдлөг -2018” салбарын ЭШ-ний бүтээлийн эмхэтгэл /ГУУС/	30	41
7	21/248	ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /СБЗГ/	42	65
8	22/249	ШУТИС-ийн магистр, докторын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /СБЗГ/	35	49
9	23/250	Профессор багш, доктор, магистр, бакалавр оюутны Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл /БАС/	36	87
10	24/251	ШУТИС-ийн Профессор, багш нарын эрдмийн чуулганы эмхэтгэл /ЭШИГ/	35	83
11	25/252	"Монгол-инженер 2019" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл /МехТС/	27	65

12	26/253	“Ухаалаг-эрчим хүч- оюутны оролцоо” бакалавр, магистр, доктор оюутны ЭШ-ний хурлын эмхэтгэл /ЭХС/	89	110
13	27/254	ШУТИС-ийн Бакалавр оюутны ЭШ-ний хурлын эмхэтгэл /ОСҮА/	62	150
14	29/257	"Логистикийн 7 хоног" ЭШ-ний бүтээлийн эмхэтгэл /БуХС/	52	65
15	30/258	“Газрын тос-2019” Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /ГУУС/	35	90
16	31/259	Багш, оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл /ДаТС/	44	83
17	32/230	“Эрчим хүч-уул уурхайн цахилгаанжуулалтын дэвшилтэт технологи -2019” /ДаТС/	48	101
НИЙТ			709	1384

Эрхлэн гаргасан “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл” (ISSN1560-8794)



Зураг 3.22. Эрдэм шинжилгээний эмхэтгэлийн тоон үзүүлэлт

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас эрхлэн гаргасан бусад сэтгүүл

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас бие даан эрхлэн гаргадаг сэтгүүлдүүд нь салбарын судлаачдын судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүн, шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилт, цаашдын чиг хандлага зэргийг харуулсан өгүүлэл, нийтлэлийг хэвлэн нийтэлж олон нийтэд түгээн дэлгэрүүлдэг бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 27 дугаарт 323 судалгааны өгүүлийг хэвлэн нийтэлсэн байна.

Бүрэлдэхүүн сургуулиудын эрхлэн гаргасан сэтгүүл

Хүснэгт 3.18

№	БС	Эрхлэн гаргадаг сэтгүүлийн нэр	Олон улсын болон улсын дугаар	Редакцын зөвлөлийн гишүүдийн тоо	Сэтгүүлийн эрхлэгчийн нэр	Жилд гарсан дугаарын тоо	Хэвлэгдсэн бүтээлийн тоо
1	БүХ С	Менежмент ба инноваци	-	21	Л.Оюунцэцэг	4	84
2		Нийгмийн хөгжил асуудал шийдэл	ISSN-2618-1649	8	Б.Долгор	1	24
3	ГҮУ С	"Mongolian geoscientist" сэтгүүл /англи хэлээр/	ISSN-2220-0622	20	Б.Батхишиг Б.Алтанзул Б.Мөнхцэнгэл Х.Цэдулам	1	5
4		Монголын геосудлаач	ISSN 2220-0622	20	Б.Батхишиг Б.Алтанзул Б.Мөнхцэнгэл Х.Цэдулам	1	5
5		Хайгуулчин	ISBN-976-99978-0-497-6	15	Б.Энхжаргал	2	30
6	ҮТ С	Хөнгөн аж үйлдвэр	УБД№ 14201	10	Л.Удвал	4	34
7	ЭХ С	Эрчим хүч & engineering	EECC XXX 124	60	Ч.Мангалжалав	12	87
8	ГХ С	Хавсарга хэл шинжлэл	ISBN: 978-99973-869-8-4	13	Н.Мэнд	2	54

“Шинжлэх ухаан, технологи” танин мэдэхүйн сэтгүүл



Улсын бүртгэлийн ISBN 978-99973-3-588-3 дугаартай “Шинжлэх ухаан, технологи” танин мэдэхүйн сэтгүүлийн нэг дугаарыг Дулааны Техник Үйлдвэрлэл, Экологийн Хүрээлэнтэй хамтран шинжлэх ухаан, техник технологи, инноваци, бүтээгдэхүүн, техник технологийн шийдэл, туршилт, судалгаа мэдээ, мэдээлэл бүхий агуулгын хүрээнд тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын төсөл, гэрээт ажлаар хийгдэж буй судалгаа боловсруулалтын ажлуудыг таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэхээр хэвлэн нийтэллээ. Үүнд: хот суурин, аймгийн төвүүдийн орон сууцны барилгын халаалтын системийг

шинэчлэх, шинэ зуухнууд зохион бүтээж нэвтрүүлэх, бохир ба цэвэр ус боловсруулах технологи, тоноглолын судалгаа туршилтыг явуулах, үйлдвэрлэлийн технологийн экологийн нөлөөллийг судлах, томоохон хотуудын экологийн төлөв байдлыг зурагзүйн аргаар үнэлэх,



Монгол улсын нүүрсний арвин нөөцтэй томоохон ордуудын нүүрсийг Дулааны цахилгаан станц дээр экологид ээлтэй шинэ дэвшилтэт технологиор шатаах чиглэлээр суурь ба хавсарга судалгаа хийж буцлах, эргэлдэх давхаргыг зуухны горим, техникт тохируулан нэвтрүүлэхэд чиглэгдсэн зохион бүтээлт болон техникийн шинэчлэл, зураг төсөл боловсруулан түүнийгээ дулааны станцууд дээр туршиж хэрэгжүүлсэн ажлуудыг уг сэтгүүлд багтаалаа.

“Манай эрдэмтэд” цуврал бүтээл

2018-2019 оны хичээлийн жилд бүрэлдэхүүн сургуулиудын Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр 3 эрдэмтэн багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлүүдээ нэгтгэж, “Манай эрдэмтэд” цувралын ээлжит дугаарыг эрхлэн гаргахаар ажиллаж байна.

“Манай эрдэмтэд” цуврал бүтээл

Хүснэгт 3.19

№	Дугаар	Бүрэлдэхүүн сургууль	Эрдэмтдийн нэр	Зэрэг, цол	Эрдмийн зөвлөлийн шийдвэр
1	70	ГХИ	Р.Наранцэцэг	Хэл шинжлэлийн ухааны доктор (Sc.D), дэд профессор	2018.10.02 ЭЗ-ийн шийдвэр
2	71	БАС	Ж. Цэвэгсүрэн	Монгол улсын гавьяат багш, доктор(Ph.D), профессор	2018.10.26 ЭЗ-ийн шийдвэр
3	72 (28A)	БуХС	Г.Батхүрэл	Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор	2018.11.02 ЭЗ-ийн шийдвэр

Олон улсын онлайн сэтгүүл- “Mongolian Geoscientist”




“Mongolian Geoscientist” (хэвлэмэл ISSN 2220-0622, цахим ISSN 2663-5151) Геологийн салбарын мэргэжлийн сэтгүүлийг олон улсад хянан магадалгаа хийгддэг, онлайн сэтгүүл болгож, Нээлтийн арга хэмжээг 2019 оны 2-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус сэтгүүлийг 2019 оны 1 дүгээр сард ШУА-ийн онлайн систем JOL-д оруулсан бөгөөд Google Scholar, Dimensions эрдэм шинжилгээний хайлтын системд индекслэгдсэн сэтгүүл болж байгаа юм /“Mongolian Geoscientist” сэтгүүлийн онлайн хувилбар: <https://www.mongoliajol.info/index.php/MGS/>

“Mongolian Geoscientist” сэтгүүлд хандалт хийсэн үзүүлэлт

Хүснэгт 3.20

Сэтгүүлийн нэр	Платформ	Print ISSN	Online ISSN	Feb-2019	Mar-2019	Apr-2019	May-2019	Jun-2019
Mongolian Geoscientist	Open Journal Systems	2220-0622	2663-5151	422	175	261	203	1443

Эх сурвалж: JOL-мэдээллийн сан, 2019.06 сар



Зураг 3.23. "Mongolian Geoscientist" сэтгүүлд Хандалтын тоон үзүүлэлт

2019 оны 2 дугаар сараас JOL-ийн мэдээллийн санд орсон тус сэтгүүлийн хэрэглэгчдийн тоон үзүүлэлтийг авч үзвэл 6 дугаар сард хамгийн их буюу 1443 удаа хандсан байна.

ШУТИС-ийн хэмжээнд онлайн сэтгүүлийн цар хүрээг өргөжүүлэхээр “Mongolian journal of Applied Science and Engineering” сэтгүүлийг олон улсад хянан магадалгаа хийдэг дараагийн онлайн сэтгүүл болгох бэлтгэл ажлын хүрээнд “First International Conference on Applied Sciences and Engineering-FICASE 2019” олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд ХШУС зохион байгуулж, эхний дугаарыг гаргасан бөгөөд тус сэтгүүл нь олон улсын индекстэй болоод байна.

Профессор, багш нарын туурвисан бүтээл


ШУТИС-ийн эрдэмтэн, профессоруудын судалгаа, боловсруулалт, бүтээл туурвилын ажлыг их сургуулийн хэмжээнд дэлгэрүүлэх, сургалт-судалгаанд нэвтрүүлэхээр зорин ажиллаж байгаа бөгөөд сурах бичиг, эрдэм шинжилгээний тайлан, цахим ном, сурах бичгийн тоо өмнөх хичээлийн жилээс өссөн дүнтэй байна.

Профессор, багш нарын туурвисан бүтээлийн тоон үзүүлэлт

Хүснэгт 3.21

Сургууль	Нэг сэдэвт бүтээ /Монограф/	Шинжлэх ухаан диссертаци	Докторын диссертаци /Ph.D/	Сурах бичиг	Орчуулгын бүтээл	Гарын авлага	Эрдэм шинжилгээний төслийн тайлан	Цахим ном, сурах бичиг, гарын авлага	Боловсруулсан программ
БАС	0	0	0	7	0	6	0	0	0
БуХС	4	0	3	13	2	11	28	1	0
ГУУС	3	0	0	7	2	6	0	0	0
МехТС	0	0	2	4	0	4	0	0	0
МХТС	0	0	1	4	0	2	2	2	0
ҮТС	0	0	0	7	0	15	0	0	0
ХШУС	2	0	2	10	0	5	2	1	0

ЭХС	5	0	0	9	0	10	0	0	0
ДаТС	1	0	8	0	1	4	0	0	0
ГХС	0	0	1	13	1	2	0	0	0
БАТС	0	0	0	1	1	0	0	0	0
2018-2019	15	0	17	75	7	65	32	4	0
2017-2018	14	0	16	55	9	101	14	0	5



Зураг 3.24. Бүтээлийн төрөл /бүрэлдэхүүн сургууль/

Олон улсад хэвлэгдсэн бүтээлүүд

Хүснэгт 3.22

Бүрэлдэхүүн сургууль	Web of Science, Scopus-ын мэдээллийн санд бүртгэлгүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	Мэргэжлийн түвшинд хянагддаггүй гадаадын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл	Гадаадад зохион байгуулагдсан ОУ-ын хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн бүрэн хэмжээний өгүүлэл	Гадаадад зохион байгуулагдсан ОУ-ын хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн хураангуй өгүүлэл	Дотоодод зохион байгуулагдсан ОУ-ын хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн өгүүлэл
БАС	0	5	14	0	3
БуХС	0	0	6	0	19
ГУУС	5	0	14	7	34
МехТС	0	3	18	0	8
МХТС	4	1	18	0	13
ҮТС	1	1	5	10	5
ХШУС	9	2	11	2	34
ЭХС	0	0	29	0	0
ДаТС	2	0	2	0	15
ГХС	1	0	15	2	20
БАТС	0	1	3	0	11
Нийт	22	13	135	21	162

Олон улсад хэвлэгдсэн бүтээлүүд

Их сургуулийн эрдэм шинжилгээний чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлтүүдийн нэг бол олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд профессор, багш, судлаачид судалгааны ажлын үр дүнгээ хэвлүүлэх явдал бөгөөд тайлант онд тус сургуулийн эрдэмтэн, судлаачид тус мэдээллийн сангуудад нийт 46 бүтээл хэвлүүлж, тэдгээрийн эшлэгдсэн байдал 32, олон улсын түвшинд хянагддаг сэтгүүлд 22 өгүүлэл, гадаадад зохион байгуулагдсан олон улсын хурлын эмхэтгэлд 135 бүрэн хэмжээний өгүүлэл, хураангуй өгүүлэл 21, дотоодод зохион байгуулагдсан олон улсын хурлын эмхэтгэлд 162 өгүүлэл тус тус хэвлүүлсэн.

Олон улсын мэдээллийн сан SCOPUS-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлүүд

Хүснэгт 3.23

ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн бүтээл	2018 /IX-XII сар/	2019 /I-VI сар/	НИЙТ
Хэвлэгдсэн өгүүллийн тоо	23	23	46
Эшлэгдсэн байдал	13	19	32

Эх сурвалж: SCOPUS мэдээллийн сан /2019 оны 06 сарын 25-ны байдлаар/

Гишүүнчлэл

Олон улсын мэргэжлийн сэтгүүл болон мэргэжлийн холбооны гишүүнээр бүрэлдэхүүн сургуулийн 104 багш, эрдэмтэн, профессор ажиллаж байна.

Олон улсын мэргэжлийн сэтгүүд, холбооны гишүүнчлэлийн мэдээлэл

Хүснэгт 3.24

№	Бүрэлдэхүүн сургууль	Гишүүнчлэл
1	БАС	0
2	БуХС	0
3	ГУУС	34
4	МехТС	3
5	МХТС	2
6	ҮТС	0
7	ХШУС	5
8	ЭХС	5
9	ДаТС	4
10	ГХС	51
11	БАТС	0
Нийт		104

3.15. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газар, Технологи дамжуулах төвөөс 2018-2019 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд гадаад, дотоодын хамтран ажилладаг байгууллагуудтай гэрээ, санамж бичгүүдийг байгуулан ажиллаж байна.

Үндэсний хөгжлийн газартай байгуулсан санамж бичиг

ШУТИС нь судалгаанд суурилсан их сургууль болох зорилтын хүрээнд Төр-Их сургуулийн тогтвортой түншлэл, харилцан уялдаатай хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллах гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 14-нд эхлүүлэн хамтран ажиллаж байна. Тус гэрээний зорилго нь Монгол улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, олон улсын хэмжээний болон үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх, ҮХГ-ын судалж буй төслүүд дээр мэргэжлийн дүгнэлт, санал, зөвлөмж гаргах, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээнд суурилсан бодлого, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх замаар төр-эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.



Зураг 3.25. Хамтын ажиллагааны гэрээ байгуулах үеэр

Гэрээнд талуудын хамтран ажиллах төлөвлөгөөг жил бүр баталж, үр дүнг харилцан дүгнэн хэрэгжүүлж ажиллахаар тусгасан бөгөөд төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагаа үргэлжилж байна.

Багануур үйлдвэрлэл технологийн парктay байгуулсан санамж бичиг

ШУТИС-ийн удирдлага, профессор багш нар 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Багануурын уурхай, Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨҮГ-ын үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн энэ үеэр ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан, Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨҮГ-ын дарга Ч.Элбэгсайхан нар хамтран ажиллах 19-5 тоот санамж бичигт гарын үсэг зурлаа.



Зураг 3.26. Багануурын уурхайтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах үеэр

Санамж бичгийн зорилго нь Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, Паркийн төлөвлөж буй үйлдвэрийн төслүүд дээр мэргэжлийн, хөндлөнгийн дүгнэлт, санал, зөвлөмж гаргах, судалгаа шинжилгээнд суурилсан үйлдвэрлэлийн төлөвлөлт гаргахад дэмжлэг үзүүлэх замаар эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршино.

Хамтын ажиллагааг Багануурын уурхайн хаягдал түүхий эдэд суурилсан инновацийн бүтээгдэхүүн гаргах судалгаа (Уурхайн хөрсний шорооны хаягдлаас барилгын материал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн түүхий эд гаргах судалгаа, Уурхайн нүүрс, шорооноос будаг гаргах судалгааны ажил)-ны ажил гүйцэтгэх, ШУТИС-ийн судлаачдын бий болгосон оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад БҮТП-аас дэмжлэг үзүүлэх, БҮТПаркад ШУТИС-ийн оюутнуудыг дадлага хийлгэх зэрэг хамтын ажиллагааг нэн тэргүүнд өрнүүлэхээр ажиллаж байна.

Санхүү эдийн засгийн их сургуультай байгуулсан санамж бичиг

ШУТИС болон Санхүү, эдийн засгийн их сургууль хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр ШУТИС-ийн Захирал Б.Очирбат, СЭЗИС-ийн Ректор Б.Мөнхбаяр нар гарын үсэг зурсан. Санамж бичгийн зорилго нь Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа инновацийн чиглэлээр хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, профессор багш, судлаач, ажилтнуудыг чадавхжуулах, харилцан туршлага солилцоход оршино. Талууд Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов. Профессор багш, ажилтан, оюутнууд сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн ажлын туршлага харилцан солилцох, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, Эрдмийн зөвлөл хоорондын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад анхаарч ажиллах юм.

Гамшиг судлалын хүрээлэнтэй байгуулсан санамж бичиг


ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газар, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичгийг 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгууллаа.

Санамж бичгийн зорилго нь талууд үйл ажиллагаагаа дэмжих, харилцан туршлага солилцох, гамшгаас хамгаалах ажилд тулгарч буй зарим асуудлыг Шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилт, судалгаа шинжилгээнд тулгуурлан шийдвэрлэхэд оршино.




ШУТИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиуд дээр 2018-2019 онд байгуулагдсан гэрээ, санамж бичиг:

Бүрэлдэхүүн сургуулиудын гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагатай 2018-2019 оны хичээлийн жилд Эрдэм шинжилгээ, туршилт судалгааны чиглэлээр нийт 43 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан байна.



Зураг 3.27. Байгуулсан гэрээ, санамж бичигийн тоо /бүрэлдэхүүн сургууль тус бүрээр/



Зураг 3.28. Гэрээ байгуулсан улсууд /тоо, эзлэх хувиар/

2018-2019 оны хичээлийн жилд нийт 43 гэрээг гадаад дотоодын хамтран ажилладаг байгууллагуудтай байгуулсанаас их сургуулиудтай 25, бизнесийн байгууллагатай 11, төрийн байгууллагатай 7 гэрээ байгуулсан байна.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ГАДААД ТОМИЛОЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд: Нийт 380 багш, ажилтан гадаадад томилогдон явж ажилласнаас ШУТИС-ийн зардлаар 187 хүн, хүлээн авагч талын зардлаар 37 хүн, төслийн зардлаар 87 хүн, хувийн зардлаар 10 хүн, ЗГ, байгууллагын зардлаар 14 хүн, ШУТИС, хүлээн авагч тал, төсөл, хувь хүн хамтарсан зардлаар 45 хүн тус тус явсан байна.



Зураг 4.1. ШУТИС-ийн гадаад томилолтын ангилал

Дээрх багш, ажилтнаас 48 хүн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан хөтөлбөр, 51 хүн ЭШ судалгаа, төслийн ажилд оролцох ажлаар, 258 хүн ОУ-ын хурал, сургалт семинарт оролцох ажлаар, 23 хүн ОУ-ын үзэсгэлэн, уралдаан тэмцээнд оролцох ажлаар тус тус гадаадад томилогдон ажилласан байна.

Гадаад томилолтыг 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар бүрэлдэхүүн сургуулиудын түвшинд авч үзэхэд ОУ-ын хурал, сургалт, семинар, хамтарсан хөтөлбөр, төсөл, судалгаа ЭШ, хамтын ажиллагаа хөгжүүлэх ажлаар гадаадад томилогдсон багш, ажилтны тоо давамгайлж байна.

Судалгаанд суурилсан их сургуулийн хүний нөөцийг бэлтгэх зорилтын хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн 36 багш, ажилтан, оюутнууд урт хугацаагаар гадаадын их, дээд сургуулийн магистр, докторантурын сургалтад хамрагдан ОХУ (Магистрантур-20), БНХАУ (Докторантур-2, магистрантур-3), БНСУ (Магистрантур-2, Докторантур-4), Итали (Докторантур-3, магистрантур-2) зэрэг улсад суралцаж байна. Мөн гадаадын их, дээд сургууль, байгууллагатай байгуулсан гэрээ, хамтын ажиллагааны ажлын хэрэгжилтийн хүрээнд ОУ-ын IAESTE байгууллагаар 6 хүн, ERASMUS/MUNDUS төслөөр 6 хүн, Японы Санко сэйки компанийн шугамаар 18 хүн, Акигагийн их сургуульд 2, БНСУ-ын Чусон их сургуульд 10 багш, 9 сургалтын албаны ажилтан, “Санко Сэйки” компанитай

байгуулсан гэрээний хүрээнд ШУТИС-ийн профессор багш, ажилтнууд 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 5 дугаар сарын 22-ны өдрүүдэд Япон улсын их, дээд сургууль, технологийн хүрээлэнгийн сургалтын үйл ажиллагаа, лабораторийн орчин, судалгааны ажлын чиглэл, хүрсэн түвшинтэй танилцаж, туршлага судлахаас гадна өндөр технологийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, чанарын хяналтын системтэй танилцсан.

Гадаад томилолтын чиглэлүүдийг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институтын түвшинд авч үзвэл:

Хүснэгт 4.1

Бүрэлдэхүүн сургууль	БАС	БүХС	ГУУС	MeTC	МХТС	УТС	ХШУС	ЭХС	ГХС	БАТС	ИАТС	ДаТС	ОрТС	Захиргаа	ШУТАС	ШУТИС-КООСЭН-КТ	БҮГД
төсөл, судалгаа ЭШ-ний ажил, хамтын ажиллагаа	5	7	4	9	2	11	15	13	6	1	8	1	0	22	1	1	106
ОУ-ын хурал, суртал, суртал	39	19	26	24	18	15	25	19	27	1	2	1	1	26	5	3	251
ОУ-ын үзэсгэлэн, тэмцээн, дэлгэц	4	0	1	2	5	7	0	2	0	0	0	0	0	2	0	0	23



Зураг 4.2. Магистрантур, докторантурын сургалтад хамрагдаж буй багш, ажилчид, оюутны тоо

4.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

2018-2019 оны хичээлийн жилд гадаадын нийт 22 их дээд сургууль, эрдэм судалгааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ сунгаж, шинээр байгууллаа.

Шинээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан гадаадын их дээд сургууль, байгууллагууд

Хүснэгт 4.2

д/д	Сургууль	Улс	Гэрээний ангилал	Огноо
1	Өвөрмонголын Аж үйлдвэрийн их сургууль	БНХАУ	Техникийн нэр томъёоны толь бичиг хамтран туурвих санамж бичиг	2018.09.06
2	Өвөрмонголын барилгын мэргэжил, технологийн коллеж	БНХАУ	Ха-ны санамж бичиг	2018.11.22
3	Өвөрмонголын Урлагийн дээд сургууль	БНХАУ	ХА-х хэлэлцээр бичиг	2018.11.22
4	Pioneer College of Inner Mongolia University /Үйлс бүтээлийн дээд сургууль	БНХАУ	Ха-ны санамж бичиг	2018.11.25
5	Donghua University, Shanghai	БНХАУ	Ха-ны санамж бичиг	2018.12.10
6	Өвөрмонголын Аж үйлдвэрийн их сургууль	БНХАУ	Official Letter, Protocol of Meeting	2019.03.13
7	China University of Mining and Technology	БНХАУ	Ха-ны санамж бичиг	2019.06.02
8	Shandong University of Science and Technology	БНХАУ	Ха-ны санамж бичиг	2019.06.03
9	National Central University	Тайвань	Оюутан солилцооны гэрээ	2018.07.10
10	National Taiwan University of Science and Technology	Тайвань	Санамж бичиг	2019.05.10
11	Gachon University	БНСУ	MOU on the KOICA Project	2018.09.10
12	Gyeongnam National University of Science and Technology	БНСУ	Memorandum of Agreement	2018.10.17
13	School of Agriculture, Utsunomiya University	Япон	Agreement of Academic Exchange	2018.10.10
14	Уральским федеральным университетом имени первого Президента России Б.Н. Ельнича	ОХУ	Хамтын ажиллагааны гэрээ	2018.11.29
15	Кокшетауским государственным университетом имени Шокана Уалиханова	Казахстан	Хамтын ажиллагааны гэрээ	2019.04.09
16	California University of Management	АНУ	ХА-ны санамж	2018.11.20

	and Sciences, Virginia Campus		бичиг	
17	Brandenburgische Technische Universität Cottbus-Senftenberg	ХБНГУ	Х-ны гэрээ	2018.10.05
18	Technische Universität Bergakademie Freiberg (TUBAF)	ХБНГУ	Ха-ны гэрээ	2019.04.10
19	Technische Universität Bergakademie Freiberg (TUBAF)	ХБНГУ	“Уул уурхайн ашиглалтын технологи” мэргэжлийн 3+2 хөтөлбөрийн сургалтын гэрээ	2019.04.10
20	Izmir Katip Celebi University	БНТУ	ХА-ны протокол	2019.02.22
21	Izmir Katip Celebi University	БНТУ	Mevlana Exchange Programme	2019.06.10
22	The Department of Industrial Engineering of the University of Trento	Итали	MOU, Addendum to the MOU	2019.03.13
	Нийт 22. Үүнд: БНХАУ Тайвань БНСУ Япон ОХУ Казахстан АНУ ХБНГУ Турк Итали	8 2 2 1 1 1 1 3 2 1	Гэрээ-12 Санамж бичиг-10	

Мөн дээр дурдсанаас гадна гадаадын Монгол дахь ОУ-ын байгууллагууд, төлөөлөгчийн газруудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал: Дээд боловсролыг хөгжүүлэх “1000 инженер” төслийн хүрээнд Японы ОУ-ын ЖАЙКА байгууллагатай хамтран ажиллаж сургалт судалгааны чиглэлээр олон төслийг хэрэгжүүлж ажиллаа.

4.3. ГАДААДЫН МЭРГЭЖИЛТЭН, БАГШ ЗОЧИН ПРОФЕССОР

2018-2019 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургууль, сайн дурын болон олон улсын байгууллагаас 19 багш, мэргэжилтэн ШУТИС-д 6 сар, түүнээс дээш хугацаагаар ажиллаж байна.

ШУТИС-ийн гадаадын мэргэжилтэн, багш нар

Хүснэгт 4.3

Харьяалагдах гадаадын байгууллага	Ажиллаж буй сургууль	Тоо
БНСУ-ын WITH байгууллагын мэргэжилтэн	ҮТС	6
БНСУ-ын НИРА байгууллагын мэргэжилтэн	ГУУС	1
БНСУ-ын КОИСА байгууллагын мэргэжилтэн	БАС	1

	ДаТс	3
Японы сайн дурын мэргэжилтэн багш	ГХС	1
АНУ-ын Төрийн департаментийн мэргэжилтэн	ГХС	1
БНХАУ-ын Ханбаны их сургуулийн мэргэжилтэн багш	ГХС	1
БНХАУ-ын Шандуны их сургуулийн мэргэжилтэн багш	ГУУС	1
Японы Нагояа ИС-ийн мэргэжилтэн	ГУУС	2
Гэрээгээр	ЭХС	1
Нийт		18

4.4. ОЮУТАН СОЛИЛЦОО, ГАДААДЫН ТЭТГЭЛЭГ


2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн гадаадын их дээд сургуулиудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд нийт 27 оюутан урт, богино хугацааны оюутан солилцооны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаад байна. БНСУ-ын Чусон их сургуультай байгуулсан ажилтан, оюутан солилцооны гэрээний хүрээнд ШУТИС-ийн БУХС-ийн 15 оюутан, 2 багшийн хамт 2018 оны 1-р сарын 03-ны өдрөөс 1 дүгээр 24-ний хооронд 21 хоногийн мэргэжлийн дадлага хийсэн. БНСУ-ын Улсаны шинжлэх ухаан технологийн институттэй байгуулсан гэрээний хүрээнд ШУТИС-ийн БАС-ийн Архитекторын тэнхимийн бакалаврын түвшний нэг оюутан, Хүрээлэн буй орчны тэнхимийн нэг оюутан зуны судалгааны 2 сарын дадлагад хамрагдсан.

- 2018.11.01-11.15-ны өдрүүдэд Япон улсын Югэ үндэсний технологийн институтэд хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Эрчим хүчний сургуулийн Сургалтын албаны ажилтан, салбарын эрхлэгчийн туслах нар сургуультай танилцаж, дадлага хийж ирсэн.
- 2019.01.13-01.28-ны өдрүүдэд Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн "Нийгмийн ажил", "Олон нийттэй харилцах ажил", "Төрийн удирдлага", "Бизнесийн удирдлага" мэргэжлээр суралцаж буй 14 оюутан БНСУ-ын Чусон их сургууль, Сөүл хотын болон орон нутгийн Нийгмийн халамжийн төвүүдтэй танилцах олон улсын оюутны дадлагад хамрагдсан.
- 2019.01.07-01.12-ны өдрүүдэд Сакура Сайнс төслийн хүрээнд Япон улын Китаюшү хотод "Үйлдвэрийн экологийн инженер" мэргэжлийн 2-р курсийн 10 оюутан танилцах дадлага хийсэн.
- 2019.04.13-04.15-ны өдрүүдэд Механик, тээврийн сургуулийн "Логистик менежмент", "Тээврийн менежмент" мэргэжлийн ангийн 35 оюутан БНХАУ-ын Эрэн хотын зам, тээврийн систем, үйлдвэртэй танилцах дадлагад хамрагдсан.
- 2019.05.30-06.24-ний өдрүүдэд Шандуны ШУТИС-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Гадаад хэлний сургуулиас ШУТИС-ийн 2+2 бакалаврын хөтөлбөрийн болон хятад хэлний орчуулгын мэргэжлийн ангийн 20 оюутны хэлний дадлага зохион байгуулж, хийсэн.
- 2019.07.01-07.28-ны өдрүүдэд БНХАУ-ын Харбины технологийн институтэд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын I-III курсийн 10 оюутан хамрагдана.
- 2019.07.05-08.10-ны өдрүүдэд Барилга, архитектурын сургуулийн Барилгын инженерийн салбарын 20 оюутан ОХУ-ын Уралын Холбооны их сургуультай хамтарсан зуны дадлагад хамрагдав.
- 2018-2019 оны хичээлийн жилд Ерасмус+ кредит солилцооны хөтөлбөрийн хүрээнд Итали улсын Писагийн их сургуулийн оюутан


солилцооны хөтөлбөрт БуХС-ийн нэг докторант багш, 1 докторант оюутан хамрагдсан.

Мөн ГУУС-ийн нэг докторант багш, нэг магистр оюутан, БуХС-ийн нэг магистр оюутан хамрагдахаар сонгогдоод байна.

ШУТИС-д нийт 22 гадаад оюутан суралцаж байна. Үүнээс бакалавр оюутан 14, магистрант 5, докторант 3 оюутан тус тус суралцаж байна.



Зураг 4.3. Гадаад оюутан улс орноор нь ангилсан байдал




Зураг 4.4. Гадаад оюутны тоо бүрэлдэхүүн сургуулиар

ШУТИС-д суралцаж буй гадаад оюутнууд зардлын хэлбэрээр


- Засгийн газрын тэтгэлгээр 10 хүн
- Оюутан солилцоогоор 1 хүн
- Хувийн зардлаар 11 хүн

4.5. ГАДААДЫН ТЭТГЭЛГҮҮД

Японы Санко-Сеики групп, Японы Сүмитомо корпораци, Японы Мицүбиши корпораци, Тоёота-ШУТИС сан зэрэг гадаадын байгууллага, сангийн 37 сая 800 мянган төгрөг, 7000 ам.долларын тэтгэлгийг ШУТИС-ийн 53 оюутанд олгоод байна. Нэг хичээлийн жилд дунджаар 62 оюутан гадаадын тэтгэлэгт хамрагдсан байна.



Зураг 4.5. Гадаад оюутан бүрэлдэхүүн сургуулиар



Зураг 4.6. Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо бүрэлдэхүүн сургуулиар

4.6. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОУ-ЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

2018-2019 оны хичээлийн жилд гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд гадаадын их сургууль, байгууллагаас ШУТИС-ийн судалгаа, сургалтад зориулж нийт 65,690,000 гаруй төгрөг, 34,110 еврогийн шууд ба шууд бус хөрөнгө оруулалт хийгдээд байна. Үүнд

БНСУ-ын Материал судлалын хүрээлэнгийн ШУТИС-ийн ХШУС-ийн Материал судлалын төв дээр хэрэгжих КИМС-Ази төсөл хөрөнгө оруулалт 2017 оны 4 дүгээр сард хийгдсэн.

- Нийт 143,630,000 төгрөгийн санхүүжилт
- Үүнээс 41,750,000 төгрөгийн санхүүжилт орж ирсэн.

Итали улсын Писа хотын их сургууль, ШУТИС-ийн хамтран хэрэгжүүлсэн Ерасмус +кредит солилцоо, КА107 ажилтан солилцооны хөтөлбөрийн санхүүжилт

- Ерасмус + кредит солилцооны хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээ 29750 евро
- Ерасмус + Ажилтан солилцооны хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээ 4360 евро

БНСУ-ын Залуучуудын бодлогын судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэх “Монгол, Солонгосын залуучуудын оролцоо ба улс төрийн оролцоо” сэдэвт богино хугацааны судалгааны төсөл

- Нийт БНСУ-ын Залуучуудын бодлогын хүрээлэнгээс хийх санхүүжилт 23,940,000 төгрөг
- БНСУ-ын КОЙКА байгууллагын хөрөнгө оруулалттай ДаТС-ийн байгуулагдсан “Компьютерын нэгдсэн лаборатори” 30000 ам. доллар





ТАВДУГААР БҮЛЭГ

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨШИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн түүхт 60 жилийн ой болох гэж байгаатай холбогдуулан оюутнуудын ая тухтай суралцах нөхцөл бололцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хөгжлийн олон талт арга хэмжээнүүдийг 2018-2019 оны хичээлийн жилд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусган зохион байгууллаа.

Сургалт, семинар

Хүснэгт 5.1

д/д	Сургалтын нэр	Илтгэгч	Оролцсон оюутны тоо
1	“Бид оюутан боллоо” лекц	Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирлууд, ОСҮА-ны мэргэжилтнүүд	Нэгдүгээр курсийн 971 оюутан оролцлоо.
2	Амжилттай суралцах нь	Бүрэлдэхүүн сургуулиудын эрдэмтэн багш нар	672 оюутан 16 зөвлөх багш
3	Хотын соёл аяны хүрээнд (Гэмт хэрэг, хэв журмын зөрчил, Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх лекц,)	Монголын түүхийн багш нар НЗЦГ, НЦГ, НПП-ын албан хаагчид болон мэргэжилтэн	3700 оюутан 11 багш, ЗЦГ-ын 16 албан хаагч, НЦГ-ийн 3 албан хаагч, НПП-ын 7 албан хаагч
4	“Эрүүл зөв, зохистой хооллолт” болон “Харилцаа ёс зүйн онлайн сургалт”	Онлайнаар зохион байгууллаа.	16800 оюутан
5	“Энтрепренер соёл ба гарааны бизнес” сургалт	БСШУСЯ, Азийн хөгжлийн банк, Дээд боловсролын төслийн ажилтнууд	4 удаагийн цуврал сургалтад нийт 87
6	“Тогтвортой хөгжлийн боловсрол” сэдэвт лекц	Японы Китакюүшү их сургуулийн профессор багш Хитоюүки Мияакэ	50 гаруй оюутан оролцсон

“Хандлага нэрэгч” цуврал лекц

Нийт суралцагч оюутнуудад зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн “Хандлага нэрэгч” цуврал лекцийг нийт 3 удаа зохион байгууллаа. Тус лекцийн зочдоор Лектор Чила (Г.Бадамцэрэн), Хувь хүний хөгжлийн институтын захирал, сэтгэл зүйч М.Алтанцэцэг, ШУТИС-ийн төгсөгч ICT группийн гүйцэтгэх захирал, BLOCKCHAIN PLATFORM монголд анхлан санаачлагч Г.Лхамсүрэн нар оролцлоо. Тус арга хэмжээг амжилттай зохион байгуулсан оюутнууд “Хандлага нэрэгч” клубийг байгуулан ажиллаж байна.



Зураг 5.1 “Хандлага нэрэгч” цуврал лекц

ШУТИС-ийн эрэгтэй оюутнуудад чиглэсэн сургалт

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Оюутны соёл, үйлчилгээний алба хамтран “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд зөвхөн эрэгтэй оюутнуудад зориулан жендерт суурилсан хүний эрхийн суурь зарчмын талаар үндсэн ойлголт, нийгэмд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө эрчүүдийн өөрсдийн оролцоог хангах зорилгоор уулзалт, хэлэлцүүлгийг 2018 оны 12-р сарын 03-ны 12:30-14:30 цагийн хооронд ШУТИС-ийн 1-р байрны хурлын танхимд зохион байгууллаа.



Тус арга хэмжээг ШУТИС-ийн оюутны соёл, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн Д.Цогцолмаа, ХЭҮТ-ийн тэргүүн Б.Сувд нар Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны талаар товч танилцуулга хийж чиглүүлэгчдийг урьж танилцуулж хэлэлцүүлгийг дараах агуулга сэдвийн хүрээнд зохион байгуулав.

- Хүний эрх гэж юу вэ?, Хүний эрхийн суурь зарчим Жендерийн тухай үндсэн ойлголт- Б.Болорсайхан /Бүх нийт боловсролын төлөө үндэсний эвслийн зохицуулагч/
- Гэр бүлийн харилцаа, Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд, Уламжлалт хандлагын талаар ойлголт- Д.Эрдэнэцогт /Эрчүүд гэр бүл хөгжлийн нийгэмлэгийн тэргүүн/
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө эрчүүдийн оролцоо, дэлхийн залуучуудын өнөөгийн чиг хандлага -Ч.Ганжавхлан /Лантуун дохио ТББ-ын тэргүүн /

ШУТИС-ийн Клубүүдийн ахлагч нарт чиглэсэн чадваржуулах сургалт

2019 оны 04-р сарын 04, 08-ны өдрүүдэд ШУТИС-ийн клубийн ахлагч, гишүүдийг чадваржуулах цуврал сургалт явагдлаа. Тус сургалтыг “Хятад хэлний клуб”-ийн зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа /Доктор (Ph.D)/” “Биеэ засаад гэрээ зас Гэрээ засаад төрөө зас” гэх үндсэн ойлголтын дагуу бидний оюутан насны эхлэлээс энэхүү 4 жилийн хугацаанд бид юуг хэзээ нь сурч авах ёстой байдаг хийгээд өөрт



ноогдох орон зайг эзэгнэж, хувь хүнээс бие хүний төлөвшил, төлөвшсөн хүн бусдыгаа манлайлах буюу бусдад нөлөөлөх ур чадварт суралцах, бусдад өөрөөрөө үлгэр дуурайлал үзүүлэх хэмжээний ахлагч та байж чадаж байна уу? гэх мэт багаас эхлээд их рүү нь чиглэсэн маш олон үнэтэй мэдээллийг өгсөн бол ШУТИС-ийн КНЗ-ийн анхны тэргүүн MONCON CONSTRUCTION GROUP-ийн төслийн инженер Э.Энхмандах "Өөрийгөө гололгүй зүтгэж чадваас хэн ч юуг ч бүтээж чадна" гэх ерөнхий ойлголтын дагуу Клуб гэдэг зүйл нь оюутанд ямар чухал чадвар, хүмүүжлийг олгодог болон клубт элсэхээс аваад ахлагчийн ажлыг эрхлэх хүртэл ямархуу давуу талуудыг өөртөө суулгасан, клуб гэх хүрээллээс өөрт суралцсан чадвар, түүний үр шимээр хэрхэн ажиллаж буй талаар их үнэ цэнтэй зөвлөгөө өгч Клубийн ахлагч нарт байх ёстой ур чадвар, үүрэг, мөн зарим зөвлөгөөнүүдийг өглөө. Энэхүү сургалтад нийт 15 клубийн ахлагч оролцлоо.

ШУТИС-ийн Клубүүдийн гишүүдийг чадваржуулах сургалт

ШУТИС-ийн хэмжээнд өөрсдийгөө чөлөөт цагаараа хөгжүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн идэвхтэн гишүүдийг чадваржуулах сургалтыг "Хэрэглээний хөдөлмөр судлалын сургалт судалгааны хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор Н.Болдмаа "Хувь хүний хөгжил, баг хамтын ажиллагаа" сэдвийн хүрээнд лекц уншлаа.



“Өөрчлөлтийн бяцхан түүх” чөлөөт ярилцлага

Уг чөлөөт ярилцлага нь оюутан залуучуудад өөрийгөө хөгжүүлж, өөрчлөлтөд хүрсэн түүхэн амжилт, түүний төлөө тууштай суралцагч, тэмцэгч байхад нөлөөлөх хүчин зүйлийн талаар чөлөөтэй харилцан ярилцах зорилготой үйл ажиллагаа юм. Тус арга хэмжээний зочдоор ШУТИС-д амжилттай суралцаж буй оюутнууд болон төгсөөд амжилтад хүрсэн залуус болох ШУТИС-ийн БАС-ийн ИБҮБ-ын IV курсийн оюутан Батхуяг овогтой Батдэлгэр, ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүнээр ажиллаж байсан Б.Мягмардорж, “Start-Up 2018” ОУ-ын уралдааны тэргүүн байр гранпри шагналын эзэн БАС-ийн Архитектур мэргэжлийн 4-р ангийн оюутан Б.Энх-Амгалан, Оюу Толгой ХХК-ийн ноцтой эрсдэлийн менежментийн зөвлөх Онгой овогтой Энхсонор, АНУ-ын Харвардын Их Сургуульд байгалийн ухааны Докторын зэрэг хамгаалсан Болдын Уянга нарыг урьж хичээлийн I байр “Хурлын танхим”-ын үүдэнд ШУТИС-ийн “Хөтлөгчийн” клубийн оюутнууд хөтлөн явуулж байна.



*Зураг 5.2. “Өөрчлөлтийн бяцхан түүх” чөлөөт
ярилцлага уулзалт*

ШУТИС-ийн төгсөх курсийн оюутнуудад зориулсан цуврал лекц

ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний албанаас санаачлан БУХС-ийн багш нарын “Алтангадас” клубтэй хамтран 2018-2019 оны намрын улиралд төгсөх курсийн оюутнууддаа зориулан “Хөдөлмөрийн зах зээл дээр өөрийгөө хэрхэн борлуулах вэ?” сэдвийн хүрээнд цуврал лекцүүдийг зохион байгууллаа. Оюу толгой ХХК-ны Гадаад харилцааны албаны ахлах мэргэжилтэн Ё.Лхамаа, Олон улсын хүний нөөцийн хөгжлийн академийн захирал Н.Амаржаргал, MSDI-PRO HR CONSULTING LLC-ийн захирал Б.Анхбаяр, БУХС-ийн Бизнесийн удирдлагын салбарын ахлах багш Л. Цэрэнчимэд нар уригдан сонирхолтой лекцүүдийг төгсөх курсийн оюутнуудад уншлаа. Мөн Энэхүү арга хэмжээг цаашид чанаржуулах, өргөжүүлэх хамтран ажиллах үүднээс бид **ИНТЕРНЭШНЛ ЭЙЧ АР АУТСОРСИНГ КОНСАЛТИНГ** компанитай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.



Зураг 5.3 “Хөдөлмөрийн зах зээл дээр өөрийгөө хэрхэн борлуулах вэ?” сэдэвт хүрээнд цуврал лекц

Оюутны эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн

“Эрдмийн чуулган-2019” эрдэм шинжилгээний хурлыг ШУТИС-ийн 60 жилийн ойн хүрээнд Монголын Их, дээд сургуулиудын дунд илүү өргөн хүрээнд зохион байгууллаа. Тус хуралд 70 гаруй илтгэлээр 150 гаруй оюутан, багш нар хамтын судалгаа шинжилгээний ажлаа хэлэлцүүлэн оролцлоо. Эрдмийн чуулган 2 үе шаттайг 4 салбар хуралдаантайг амжилттай зохион байгуулагдлаа.



“Эрдмийн чуулган-2019” чуулганд байр эзэлсэн илтгэлүүд:

Техник, технологийн салбар хуралдааны илтгэлээс

Тэргүүн байр

- МХТС-ийн ЭСА-III курсийн оюутан Б.Билгүүн, Х.Гомбо нар “Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан ухаалаг таяг” илтгэл, Удирдсан багш: Б.Дорж МХТС-ийн ЭС-ын ахлах багш, Доктор (Ph.D)

Дэд байр

- МехТС-ийн YA-IV курсийн оюутан Б.Дэлгэрбаярын “Бага оврын токарийн суурь машины төсөл” илтгэл, Удирдсан багш: Т.Ганбаатар МехТС-ийн Машин үйлдвэрлэлийн салбарын багш

Гутгаар байр

- БАС-ийн ИБҮБ- IV курсийн оюутан А.Доржсамбуу Н.Ууганцэцэг Д.Нацагням М.Очирбат Д.Уранзаяа нарын “Хуучин модон барилгын дам нурууг хүчитгэх туршилт, судалгаа”, Удирдсан багш: О.Алтанзагас, БИС-ын ахлах багш, доктор (Ph.D)

Байгалийн ухаан, экологийн салбар хуралдааны илтгэлээс:

Тэргүүн байр

- МХТС-ийн ЭСА-III курсийн оюутан Н.Даваасүрэн “Нейрон сүлжээ ашиглан гарын хөдөлгөөнөөс тоо таних” илтгэл, Удирдсан багш: Б.Дорж МХТС-ийн ЭС-ын ахлах багш, Доктор (Ph.D)

Дэд байр

- YTC-ийн Биотехнологи-IV курсийн оюутан М.Пүрэвдулам “Кератиназа фермент нийлэгжүүлэгч бактерийн судалгаа” илтгэл, Удирдсан багш: С.Дэлгэрмаа YTC-ийн БШТС-ын профессор, Доктор /Ph.D/, Дэд профессор

Гутгаар байр

- МХТС-ийн ЦХ-хөтөлбөрийн IV курсийн оюутан Т.Мейрамбек, Ц.Ариунболд, Б.Нандинсүвд “Автомат усжуулалтын систем” илтгэл, Удирдсан багш: Б.Цэрэнлхам МХТС-ийн ХС-ын багш

Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар хуралдааны илтгэлээс

Тэргүүн байр

- ЭХС-ийн, СЭХ 2+2,-II хөтөлбөрийн оюутан Б.Амгаланбазар “Монгол, хятад хэлний “тэнгэр”-гэй холбоотой үг хэллэгийн утга, соёл” илтгэл, Удирдсан багш Ц.Эрдэнэзаяа, ГХС-ийн АСТ-ийн ахлах багш, Доктор (Ph.D)

Дэд байр

- БАС-ийн Хүрээлэн буй орчны инженер-II курсийн оюутан Н.Золжаргал “Барилгын материал” сурах бичиг дэх гадаад үгийн хэрэглээнд хийсэн ажиглалт” илтгэл, Удирдсан багш: П.Бямбажав БАС-ийн ахлах багш, магистр

Гутгаар байр

- БуХС-ийн НА-IV курсийн оюутан Ч.Билгүүн “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн өнөөгийн байдал” илтгэл, Удирдсан багш: Б.Бат-Өлзий, БуХС-ийн НУС-ын дэд профессор, доктор (Ph.D) тус тус шалгарч өргөмжлөлөө гардан авлаа.

“Эрдмийн чуулган-2019” шилдэг илтгэлээр шалгарсан бүтээлийн тэргүүн байр найман зуун мянган төгрөг, дэд байр таван зуун мянган төгрөг, гутгаар байр гурван зуун мянган төгрөгөөр тус тус шагнаан урамшууллаа.

Шилдэг удирдагч багшаар:

- Техник, технологийн салбараас Ш.Отгонбилэгийн нэрэмжит ТС-ийн Механикийн тэнхимийн багш. Г.Оюунсүрэн
- Байгалийн ухаан, экологийн салбараас YTC-ийн БШТС-ын профессор, Доктор /Ph.D/, Дэд профессор С.Дэлгэрмаа
- Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбараас ГХС-ийн АСТ-ийн ахлах багш, доктор Ph.D Ц.Эрдэнэзаяа
- Эдийн засаг, менежментийн салбараас БуХС-ийн БУС-ын профессор Доктор /Ph.D/, профессор. Б.Энхтуяа нар шалгарсан байна.



Зураг 5.4. “Эрдмийн чуулган-2019” эрдэм шинжилгээний хурал

“Эрдмийн чуулган-2019” чуулганд байр эзэлсэн шилдэг бүтээлүүд:

Техник, технологийн салбарт

Тэргүүн байр

- “Хүндийн хүчний өдөөгч бүхий төхөөрөмжийн судалгаа хөгжүүлэлт” бүтээлээр МЕХТС-ийн үйлдвэрлэлийн автоматжуулалт IV курсийн оюутан Б.Амарбат, О.Сансармягмар, П.Алтанчимэг, А.Хаш-эрдэнэ, Н.Цэдэн-Иш, Б.Батмөнх нар, удирдсан багш Я.Ренчинванжил Механик, мехатроникийн салбарын дэд профессор, доктор (ph.d)
- “Дулаан солилцуурын төхөөрөмжийн автомат систем” бүтээлээр МЕХТС-ийн үйлдвэрлэлийн автоматжуулалт IV курсийн оюутан, удирдсан багш Ц.Баярсайхан механик, мехатроникийн салбарын дэд профессор, доктор (ph.d)

Дэд байранд

- “Сургалтын зориулалттай 3d принтерийн зохион бүтээлт”-ээр ҮТС-ийн ХҮМТТ V курсийн оюутан Л.Лхагважав, Удирдсан багш Д.Пүрэвмагнай
- “Дотор махан царцмаг” бүтээлээр ҮТС-ийн БШТС III курсийн оюутан Х.Зулхүү, А.Түмэнхүслэн, Б.Дансранцамба нар, удирдсан багш Б.Майзул, доктор (Ph.D), дэд профессор

Гутгаар байранд

- “Автомат тоос сорогч” бүтээлээр ХМТС-ийн Электрон системийн автоматжуулалт хөтөлбөрийн III курсийн оюутан О.Мөнх-Эрдэнэ Г.Ууганбилэг нар, удирдсан багш Ц.Хүрэлбаатар Доктор (Ph.D)
- “Автомашинь цахилгаан тоноглол” бүтээлээр ТТДС АИ-III курсийн оюутан О.Мөнх-Эрдэнэ Г.Ууганбилэг нар, удирдсан багш Ц.Дэлгэр Механикийн тэнхимийн эрхлэгч, Ш.Номин-Эрдэнэ багш

Дизайн бусад салбарт

Тэргүүн байр

- "Е.О.СН III" БАГ" бүтээлээр БАС-ийн Архитектур IV, ХАС- IV курсийн оюутан Б.Энх-Амгалан, Э.Эрдэнэтөгс, О.Мөнхбаяр нар, удирдсан багш О.Ганжаргал, Архитектурын салбарын ахлах багш, магистр

Дэд байр

- “Шинжлэх ухаан технологийн их сургуулийн брэнд хувцасны дизайны шийдэл” бүтээлээр ҮТС-ийн ХД-V курсийн оюутан Э.Цогтбаяр, Удирдсан багш П.Болормаа

Гутгаар байр

- “Үнэт цаасны арилжааны систем” бүтээлээр МХТС-ийн Мэдээллийн системийн IV курсийн оюутан, удирдсан багш Т.Золбоо /Багш/ нар шалгарав.

Шилдэг удирдагч багшаар:

Техник, технологийн салбараас

1. ҮТС-ийн ХҮТИ-ийн салбарын ахлах багш Д.Пүрэвмагнай

2. ТТДС-ийн багш Ц.Дэлгэр

Дизайн бусад салбараас

ҮТС-ийн ДС-ийн багш Б.Гэрэлмаа нар шалгарч БАТЛАМЖ, мөнгөн шагналаар шагнууллаа.



Зураг 5.5. “Эрдмийн чуулган-2019” эрдэм шинжилгээний хурлын шилдэгүүд

5.2. ОЮУТНЫ САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

ШУТИС-ийн Оюутны санаачилгыг тэтгэлэгт төсөл

ШУТИС-ийн Захирлын 2018 оны 12 дугаар сарын 10-ны А/241 тоот тушаалаар батлагдсан комисс “Оюутны бүтээлч санаачилгын тэтгэлэгт төсөл, сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу эхний шатны шалгаруулалт явуулж нийт 15 төслийг Дээд боловсролын шинэчлэл төслийн багт хүргүүлэв. Эдгээр төслөөс 2 дугаар шатны шалгаруулалтад 4 төсөл шалгарч гэрээ байгуулж, эхний шатанд нийт санхүүжилтийн 60 хувь буюу 21 сая төгрөгийг бүрэлдэхүүн сургуулийн дансанд шилжүүлсэн болно.


Оюутны санаачилгын дэмжих тэтгэлэгт төсөл

Хүснэгт 5.2


№	Төслийн нэр	Тэтгэлгийн хэмжээ /мянган төгрөг/
Эрчим хүчний сургууль		
1	Шатны тэргэнцрийн лифт	10000.0
Мэдээлэл холбооны технологийн сургууль		
2	Робот технологийн туршилтын талбай	10000.0
Үйлдвэрлэлийн технологийн сургууль		
3	Бичил биетний гаралтай фермент ялган авч тодорхойлох арга зүйг боловсруулж сургалтад	10000.0

	ашиглах төсөл	
4	Ухаалаг хүлэмжийн үйлдвэрлэл	5000.0
	<i>Нийт дүн</i>	<i>35000.0</i>


Төслийн зургууд:



Зураг 5.6. Робот технологийн туршилтын талбай



Зураг 5.7. Шатны тэргээнцрийн лифт



Зураг 5.8. Ухаалаг хүлэмж

5.2. ОЮУТНЫ КЛУБ

2018-2019 оны хичээлийн жилд клубүүдийн үйл ажиллагааг тогтмол дэмжин нэгдсэн өдөрлөг болон бусад үйл ажиллагааг хамтран зохион байгуулан ажиллав. Намрын улиралд 34 мэргэжлийн болон сайн дурын клуб үйл ажиллагаа явуулж байв. Шинээр элсэхээр 1700 орчим оюутан бүртгүүлсэн байна. Урлагийн клубүүдэд хуваарийн дагуу СУИС-ийн дуу, бүжиг, хөтлөгчийн мэргэжлийн багш нараар хичээлийг нийт 5 сар заалгав.

Клубүүдийн анги танхим

Клубүүдийн үйл ажиллагааг тогтмол дэмжин ажиллаж Хичээлийн I байр “Хурлын танхим”, TV заал, E-604, 405, T-207 хичээлийн байруудад анги танхим болон спорт заалаар тухай бүрт нь ханган ажиллаж байна. Долоо хоног бүрийн лхагва гарагт 5-6 парыг клубийн оюутнуудад өгч спортоор хичээллэх боломж олгож байна. Мөн ОСҮА-ны дэргэдэх

Б.СОН БС-“О”-н “Хурлын танхим” танхимд хичээллэх клубүүдийн ангилал, хичээл
2018-2019 оны хичээлийн жилд (2018 оны 09 сарын 17-22 өдөр) 18 бүртгэл

Төрөл	Анги	Дансанд	Мэргэжл	Дансанд	Цэцэрл	Бизнес	Биеийн
3-р сар	0-10	Хөдөл	Хөдөл	Хөдөл	Хөдөл	Хөдөл	Хөдөл
3-р сар	11-15	Срединг клуб	Б.СОН Хөдөл клуб	Гурвал оруулах клуб	Англи хэл клуб	Хөдөл	Хөдөл клуб
4-р сар	16-20	Б.СОН Бүжгийн клуб	Б.СОН Фитнес 1	Срединг клуб	Б.СОН Магистрал 1	Шинэ оюутан клуб	Хөдөл клуб
5-р сар	21-25	Б.СОН клуб	Б.СОН Орчин үеийн	Б.СОН Магистрал 1	Б.СОН Түүхийн клуб	Хөдөл клуб	Хөдөл клуб
6-р сар	26-30	Б.СОН Фитнес 1	Б.СОН Спорт клуб	Хөдөл клуб	Б.СОН Дүрслэл клуб	Срединг клуб	Хөдөл клуб
7-р сар	31-35	Хөдөл клуб	Хөдөл клуб	Хөдөл клуб	Б.СОН Дүрслэл клуб	Срединг клуб	Хөдөл клуб
8-р сар	36-40	Хөдөл клуб	Хөдөл клуб	Хөдөл клуб	Б.СОН Дүрслэл клуб	Срединг клуб	Хөдөл клуб

Оюутан оёо, үйлдвэрлэл клуб

“Оюутны хөгжил” танхим, “Оюутны бэлтгэлийн өрөө”-нүүдэд хичээллэх клубийн хуваарийг нэгтгэн гарган өгч хичээллүүлж байна.

“Клубүүдийн нээлттэй өдөрлөг-2019”



Тус өдөрлөгийг намар, хаврын улиралд зохион байгуулж байна. Энэхүү өдөрлөгөөр клубийн гишүүнчлэлийг нэмэх, клубийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулдаг ба энэ жил тусдаа байртай МХТС, МехТС, БУХС-д очиж сурталчилгаа хийж ажилласан нь үр дүнтэй байлаа.

Клубүүдийн үйл ажиллагааг улирал бүрийн төгсгөлд профессор багш нараар дүгнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж сайн

ажилласан клубийн оюутнуудыг кредитийн урамшуулалд хамрууллаа.

Клубүүдийн тайлангийн хурал

Намар хаврын улиралд клубүүдийн тайлан хэлэлцэх хурлыг зохион байгуулав. Намар 24, хавар 30 клуб тайлангаа тавьж хэлэлцүүлсэн байна. Тайлангаа хэлэлцүүлсэн сайн дурын клубийн нийт 41 оюутанд 56.5 кредитийн урамшуулал, мэргэжлийн клубийн нийт 37 оюутанд 49 кредитийн урамшуулал тус тус олгосон. Мөн ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн тайлан хэлэлцэх хурлаар шилдгүүдээ шалгарууллаа.



Клубүүдийн шинэ жилийн цэнгүүн

2018 оны 12 сарын 09-нд Оюутны клубүүдийн нэгдсэн шинэ жил Метрополист болж нийт 28 клубийн 150 гаруй оюутан. ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа, мэргэжилтэн Ц.Болдбаатар, Хятад хэлний клубийн зөвлөх багш, ГХИ-ийн ахлах багш, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа, “Анарваан” ардын бүжгийн клубийн зөвлөх багш, ГХИ-ийн ахлах багш Б.Туяа нар оролцлоо.

2018 оны мэргэжлийн шилдэг клубээр ҮТС-ийн Дизайны салбарын “INSPIRATION” клуб, Сайн дурын клубээр “Хятад хэлний” клуб шалгарсан. Оны шилдэг клубийн ахлагчаар тус клубүүдийн ахлагч нарыг тодруулж “INSPIRATION” клубийн ахлагч Мөнхчимэг, “Хятад хэлний” клубийн ахлагч Б.Отгонбаяр нарыг шалгарлаа.



*Зураг 5.8.
Клубүүдийн шинэ жилийн цэнгүүн*

Клубүүдийн хэлэлцүүлэг

“Клубийн оюутны нийгмийн оролцоо, хөгжил” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 сарын 03-нд зохион байгуулсан ба IB, СЭХ, Whizz, Green car, Арга билэг, Залуу зохион бүтээгч, NCN, Хөгжлийн ирээдүй, Martins, AISEC, Хятад хэл, Герман хэл, Япон хэл, БТОК, Соёмбо, Хос уянга, Эрдмийн индэр нийт: 17 клубийн төлөөлөл оролцлоо.

Сайн дурын үйл ажиллагаа /мод тарих/



тарьж усаллаа.

ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клубийн 120 гаруй багш, оюутан Дэлхийн мод тарих өдрийг тохиолдуулан 2019 оны 5 дугаар сарын 11-нд Му клубийн үйл ажиллагаатай танилцаж, мод тарих ажилд оролцлоо. Баянхошууны зүүн салаанд бий болгохоор төлөвлөж буй Ойн төгөл, цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийн арга хэмжээнд оролцож 500 орчим модны нүх ухаж, 300 орчим мод

Хэв журам сахиулах “Соёмбо клуб” шилдэг клуб

ШУТИС-ийн оюутнуудын дэг журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг “Соёмбо” клуб хариуцан үлгэр жишээ ажиллаж байна. Нэг хэсэг үйл ажиллагаа нь доголдоод байсан тус клуб сүүлийн 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа нь жигдэрч 35 оюутны бүрэлдэхүүнтэй ажиллаж ШУТИС-ийн 1, 2 дугаар байруудад тогтмол эргүүлийн ажлыг цагийн хуваарийн дагуу зохион байгуулж байгаа нь оюутнуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой үр дүн үзүүлсээр байгаа юм. Тэр ч утгаараа 2018-2019 оны хичээлийн жилд ажлын үр дүнгээ үнэлүүлж Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсээс талархал гардаж аваад байна.

Клуб хэрхэн үр дүнтэй ажиллаж байгаа талаар нэг ажлыг жишээ болгон онцолж болох юм.

Сүхбаатар дүүрэг 8-хороо, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захиргаа, “Соёмбо” клуб, Эрүүл мэндийн төвийн хамтарсан шалгалтын ажлыг зохион байгуулав. Сүхбаатар дүүргийн 8-р хорооны засаг даргын 2018 оны 09-р сарын 06-ны өдрийн 126 тоот албан бичгийн дагуу Сүхбаатар дүүргийн 8-р хорооны нийгмийн ажилтан, тус хорооны цагдаа, замын цагдаагийн хэлтэс, ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба, Чанар, хяналт шинжилгээ, үнэлгээний алба, Эрүүл мэндийн төв, Соёмбо клуб хамтран 2018-09-14-28-ны хооронд ШУТИС-ийн хичээлийн 1, 2-р байрны 500м орчинд тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх, зөвшөөрөлгүй газарт машин тавих зэрэг асуудлуудад хяналт, шалгалтын ажлыг амжилттай зохион байгуулсан. Тус ажлыг оюутнуудын хамгийн хөл хөдөлгөөнтэй цаг болох 12:00-13:00 цагийн хооронд зохион байгуулсан бөгөөд бусад завсарлагааны цагуудад “Соёмбо” клуб эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулж идэвхтэй хяналт тавьж ажилласан болно.



Зураг 5.9.Эргүүлийн үйл явц

Тус өдрүүдэд нийт: 529 зөрчил илрүүлж, гарсан зөрчлийг арилгасан байна.

Үүнд:

- ШУТИС-ийн оюутан-416
- Бусад сургуулийн-96
- Бусад иргэд-17 байсан


ШУТИС-ийн оюутнуудыг сургууль тус бүрээр нь ангилж үзвэл:

- Эрчим хүчний сургууль-103
- Геологи уул уурхайн сургууль-96
- Барилга архитектурын сургууль-105
- Хэрэглээний шинжлэх ухааны сургууль-76
- Үйлдвэр технологийн сургууль-21
- Мэдээлэл холбооны технологийн сургууль-9
- Бизнесийн удирдлагын хүмүүнлэгийн сургууль-6 оюутнууд байлаа.


Оюутны дуу бүжгийн чуулга

Оюутнуудын санал санаачилгыг дэмжих, урлаг уран сайхнаар дамжуулан оюутнуудыг соён гэгээрүүлэх, төлөвшүүлэх, авьяаслаг, чадварлаг хамт олныг бий болгох зорилгоор оюутны дуу бүжгийн “ШУТИС-ИЙН ЗАЛУУС” байнгын үйл ажиллагаатай чуулга байгуулагдав. Чуулга нь дуулаач, ардын бүжиг, цэнгээнт бүжиг, амьд хөгжмийн хамтлаг, ардын хөгжим, хөтлөгч гэх мэт урлагийн төрлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн жил бүр зохион байгуулагддаг уламжлалт арга хэрмээнүүдэд идэвхтэй оролцохоос гадна ШУТИС-ийн тэмдэглэлт ой, ёслолын баярт бүрэн хэмжээний концерт тавих юм. Мөн гадаадын их дээд сургуулиуд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж ШУТИС-ийн авьяаслаг оюутан залуусыг олон нийтэд сурталчлан таниулна.

2018-2019 оны хичээлийн жилд үйл ажиллагаагаа явуулсан клуб болон гишүүдийн судалгаа



Зураг 5.9. ШУТИС-ийн оюутны сайн дурын клубууд



Зураг 5.10. Мэргэжлийн клубүүдийн нэр

5.3. ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээлд хамруулав.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”, 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тэтгэлэг олгох журам”, Боловсролын зээлийн сангийн захирлын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-23 тоот тушаалаар батлагдсан “Оюутны хөгжлийн зээл”-ийг даатгалд хамруулах хамтын үйл ажиллагааны удирдамж”-ийн дагуу Боловсролын зээлийн сантай тооцоо хийх ажлыг зохион байгуулав.

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжид хамрагдсан байдал

2018-2019 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн тэтгэлгийн 484 оюутны 937 сая 566 мянган 200 төгрөгийн санхүүжилтийн тооцоог Боловсролын зээлийн сантай хийх ажлыг зохион байгуулж ГУУС, ҮТС, ГХИ, БАС-ийн буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтэй 70 оюутны холбогдох материалыг бүрдүүлэлтийг хянаж ажиллав. Буцалтгүй тусламжид хамрагдсан оюутнуудын сүүлийн хоёр жилийн материалыг цахим хэлбэрт шилжүүлэв.

Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн тайлан /2018-2019 он/

Хүснэгт 5.3

л/д	Сургууль	Хөдөлмөрийн чадвараа алдсан өрх		Хөгжлийн бэрхшээлтэй		Бүтэн өнчин		Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх		Нэг өрхийн 3 болон түүнээс дээш		Цаатан		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БАС	43	86679.2	4	8456	20	39097.6	6	6148.2	2	2914		0	75	143295
2	БУХС	59	128419.5	10	15649.1	18	38695.5	5	10228.9	7	15361.4	1	1384.2	10	209738.6
3	БАТС		1384.2		7613.1		0		0		0		0		8997.3
4	ГХИ	0	0	1	3100.8	3	5856	0	0	0	0		0	4	8956.8
5	ГУУС	16	43295.6	5	10672.	15	25174.2	2	19462.	5	7210.4		0	63	105815

4	ГХС	5	6539.2
5	ГУУС	45	59967.5
6	ДАТС	91	114163.53
7	МЕХТС	37	48857.15
8	МХТС	46	74224.95
9	ОРТС	10	13975
10	ҮТС	40	53849
11	ХШУС	12	16453.6
12	ЭХС	53	78248.95
13	НБТ	23	34161.09
Дүн		519	737084.22

Хоёр улсын Засгийн газрын гэрээгээр суралцагч оюутны төлбөрийн санхүүжилт

Засгийн газрын гэрээгээр суралцагч гадаадын 7 оюутанд 11848 мянган 630 төгрөгийн сургалтын төлбөр, 8640 мянган төгрөгийн амьжиргааны зардал, нийт 20488 мянган 630 төгрөгийн тооцоог “Боловсролын зээлийн сан”-тай хийв.

Хоёр улсын Засгийн газрын гэрээгээр суралцагч оюутны сургалтын төлбөрийн санхүүжилт /мянган төгрөг/

Хүснэгт 5.6

№	Сургууль	БНАЛАУ		Казахстан		БНХАУ		ОХУ		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БАС	1	2190							1	2190
2	ГУУС	2	3238.6							2	3238.6
3	МХТС			1	2307					1	2307
4	ХШУС					1	1322.88			1	1322.88
5	БАТС							1	1038.15	1	1038.15
6	ҮТС	1	1752							1	1752
Дүн		4	7180.6	1	2307	1	1322.88	1	1038.15	7	11848.63

Оюутанд замын зардал нөхөн олгосон байдал

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн нийт 953 оюутанд 88 сая 428 мянга 100 төгрөгийн замын зардлыг нөхөн олгов. Үүнэс ДаТС-ийн 37 оюутны 3 сая 302 мянга 100 төгрөг, ОрТС-ийн 9 оюутны 579 мянга 500 төгрөгийн замын зардлыг нөхөн олгосон байна. Авто тээврийн үндэсний төв онлайн борлуулалтын систем, гар утасны онлайн аппликейшн нэвтрүүлж, замын зардлын тийзийн баримт НӨАТ-ын сугалааны дугаартай хэвлэгдэх болсон. Нийт 734 оюутны тийзийн материалыг шалгахад дугаар бүдгэрч харагдахгүй болсон, гар утасны аппликейшнаар регистрийн дугаар, тийзийн дугаар гарч ирэхгүй байгаа Боловсролын зээлийн сантай замын зардлын нөхөн олголтын тооцоо хийхэд хүндрэл гарлаа.

**2018-2019 оны хичээлийн жилийн оюутны
зам зардал нөхөн олгосон байдал**

Хүснэгт 5.7

Д/д	Сургууль	нийт	
		тоо	олгох зардлын дүн /мян.төг/
1	БАС	190	16880.5
2	БУХС	45	3955
3	ХШУС	27	2850
4	МХТС	124	11678
5	МеХТС	119	11884.5
6	ГУУС	125	10460.5
7	ҮТС	141	13147
8	ЭХС	133	13353
9	ГХС	3	338
10	ДАТС	37	3302.1
11	ОРТС	9	579.5
ДҮН		953	88428.1

Сан, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байдал

Хүснэгт 5.8

Д/д	Тэтгэлгийн нэр	Тэтгэлэг авсан оюутны тоо	Нийт тэтгэлгийн хэмжээ /мянган. төгрөг/
1	Ректорын нэрэмжит тэтгэлэг /Шилдэг элсэгч/	11	24546
2	Ректорын нэрэмжит /Шилдэг суралцагч/	10	10764
3	Санко группийн нэрэмжит тэтгэлэг	5	5000
4	МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	1	1200,0
6	Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	4	4000
7	Дэлхийн зөн ОУБ	9	8728.36
8	Жи Си Ар Монголиа ХХК	11	26000
9	Зориг сан	8	11360.6
10	Кристина Нобелийн сан	3	2900
11	Иргэний нисэхийн ерөнхий газар	3	5790
12	Оюу толгой ХХК	6	6149.05
13	Баянхонгор аймгийн ИТХ, ЗД-ын нэрэмжит тэтгэлэг	1	650
14	Тайваний тэтгэлэг	1	1000
15	Эрдэнэс таван толгой	4	3600
16	MONGOLIAN AZRICH төрийн бус байгууллага	1	1000.0
17	Сумитомо корпорацийн нэрэмжит тэтгэлэг	20	26500.0
18	Хаан банк, ТББ	2	4800.0
19	“ШУТИС-Тоёото” сангийн нэрэмжит тэтгэлэг	20	10000.0
20	Мицибуши Корпорацийн нэрэмжит тэтгэлэг	10	10000.0

21	КОИСА тэтгэлэг	1	265.6
22	АВВ групп	1	2390.4
23	Моннис интернейшнл	1	1533
24	Соут Гоби Голд Транс ХХК	1	1500
25	Хятадын Банкны тэтгэлэг	3	3451.5
Нийт дүн		137	173128.51

Оюутнуудад кредит урамшуулал

2018-2019 оны хичээлийн жилд намар, хаврын улиралд ШУТИС-ийн Захирлын 2018 оны 08 дугаар сарын 20-ны А/157 тоот тушаал, 2019 оны 02 дугаар сарын 23-ны А/21 тоот тушаал, ШУТИС ШУТИС-ийн Захирлын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/223 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн оюутнуудад кредит урамшуулал олгох журам”-ын дагуу нийт 1332 оюутанд 2461.5 кредитийн урамшуулал олгов.

Хүснэгт 5.9

№	Төрөл	Тоо	Олгосон кредит урамшуулал хэмжээ
1	Шилдэг суралцагч	857	1494
2	Эрдэм шинжилгээний хурал, олимпиад	72	81
3	Спортын уралдаан тэмцээн	54	164
4	Клуб /Олон нийтийн ажил/	173	223.5
5	Оюутны Холбоо, оюутны зөвлөл	59	289.5
6	Урлаг, соёлын арга хэмжээ	78	98,5
7	Мэргэжлийн уралдаан тэмцээн	39	111
Нийт		1332	1259.5

Ректорын нэрэмжит тэтгэлэг

“Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу оюутны амжилт, амьдралын боломж бололцоо буюу санхүүгийн дэмжлэг зайлшгүй авах шаардлагатай “Шилдэг элсэгч” 11 оюутанд 30 хүртэлх кредитийн хөнгөлөлт буюу 24546 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгож хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагааны үеэр батламжийг гардуулав.

“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-г хамрагдсан оюутны нэрс /Шилдэг элсэгч/

Хүснэгт 5.10

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил	Оюутны код
1	Туяа	Гантуяа	ЭХС	Цахилгаан систем	В181050101
2	Ганзориг	Мөнхзаяа	БАС	Барилгын инженер /япон 2+2/	В181350711
3	Сэргэлэн	Эрдэнэчимэг	МЕХТС	Автомашини ашиглалт, авто аж ахуй	В181140101
4	Баярцогт	Ганбаяр	ҮТС	Механик инженер /япон 2+2/	В181100738
5	Бат-эрдэнэ	Энхмаа	ХШУС	Химийн технологи	В180990014

6	Баярсайхан	Онон	БАС	Барилгын инженер /япон 2+2/	B181350741
7	Цэрэнбат	Батжаргал	МХТС	Мэдээллийн технологи	B180930016
8	Болд	Үүрцайх	Датс	Иргэний ба үйлдвэрийн барилга	B181350010
9	Жанчивсэмбэ	Дамдиндорж	ГУУС	Гидрогеологи	B180800019
10	Энхжаргал	Адьяасүрэн	ҮТС	Оёдлын үйлдвэрлэлийн технологи	B181240010
11	Чулуунбат	Батдорж	ЭХС	Дулааны инженер	B181030101

“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан оюутны нэрс /Шилдэг суралцагч/

Хүснэгт 5.11

Д/д	Овог нэр	Сургууль	Мэргэжил	Оюутны код	Хөнгөлөлт /кредит/
1	Л.Баярхүү	БАС	Иргэний ба үйлдвэрийн барилга	B151350269	15
2	У.Очирболд	БУХС	Санхүүгийн менежмент	B160580500	15
3	Т.Бямбажав	ГХС	Техник, технологийн орчуулга /англи хэл/	B170420212	15
4	А.Давааноров	ГУУС	Уул уурхайн менежмент	B150590604	15
5	С.Цэнд-аюуш	ДАТС	Санхүүгийн менежмент	B170580005	15
6	Ж.Тэлмэнбаатар	МЕХТС	Автомашины ашиглалт, авто аж ахуй	B151140017	15
7	О.Тэргэл	МХТС	Мэдээллийн систем	B170920016	15
8	Э.Хатанболд	ҮТС	Интерьер дизайн	B160220245	15
9	Д.Цэрэндорж	ХШУС	Химийн технологи	B160990102	15
10	О.Бямбажаргал	ЭХС	Цахилгаан систем	B161050236	15

Санко группийн нэрэмжит тэтгэлэг

Санко группийн ерөнхийлөгч Шимизү Такаши “Санко группийн нэрэмжит тэтгэлэг” 5 сая төгрөгийг 5 оюутанд гарын бэлгийн хамт хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр гардуулав.

Хүснэгт 5.12

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил	Оюутны код
1	Батжаргал	Амгаланбазар	ЭХС	Сэргээгдэх эрчим хүч	B171020213
2	Баатарсүрэн	Сэлэнгэ	БАС	Архитектур	B181320012
3	Батцэнгэл	Эрдэнэбилэг	ҮТС	Хүнсний үйлдвэрлэлийн	B141100431

				машин аппарат	
4	Амарсанаа	Ганбаяр	МехТС	Механик системийн загварчлал	B151080037
5	Мэндсайхан	Лхамсүрэн	ЭХС	Дулааны инженер	B181030180

Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг

Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн батламж, 1 сая 200 мянган төгрөг гардуулав.

Хүснэгт 5.13

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил	Оюутны код
1	Аривий	Өсөхбаяр	МехТС	Автомашинны ашиглалт, авто аж ахуй	B151140010

Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 111 дүгээр тогтоол “Шилдэг оюутанд Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу мэдлэг боловсрол, бүтээлч чанар, шинэ санаа, сайн үйлс, авьяас, ур чадвараараа үеийн нөхдөө манлайлж буйгаар нь шалгаруулжээ.

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ШУТИС-ийн 4 оюутанд батламж тэмдэг, 1 сая төгрөгийн мөнгөн тэтгэлгийг гардуулжээ.

Хүснэгт 5.14

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил	Оюутны код
1	Батжаргал	Амгаланбазар	ЭХС	Сэргээгдэх эрчим хүч	B17020213
2	Чойжин	Одончимэг	МехТС	Механик системийн загварчлал	B151080001
3	Алтангэрэл	Сэндэр	ҮТС	Мебель модон эдлэлийн технологи	I.WS13D233
4	Пүрэвдорж	Ширмэнцоож	БАС	Хүрээлэн буй орчны инженер	B171340049

5.4. ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн даатгалд оюутнуудыг хамруулсан байдал


Монгол Улсын “Иргэний даатгалын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-т заасны дагуу Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байгаа Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүн сургуульд суралцаж байгаа өдрийн ангийн суралцагчдын иргэний эрүүл мэндийн даатгалд хамруулах тухай гэрээний дагуу 2018-2019 оны намрын улиралд суралцаж байгаа өдрийн ангийн суралцагчид 2018 оны Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нэг сард 2400

төгрөг, нэг жилд 28800 төгрөгөөр төлж эрүүл мэндийн даатгалд хамрагддаг болж Сүхбаатар дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран 2018-2019 оны хичээлийн жилд суралцаж буй 9257 оюутны судалгааг хүргүүлж 18 дээш насны 4833 оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулав.

Мөн 2018-2019 оны хаврын улиралд Сүхбаатар дүүргийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, ШУТИС 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 30 тоот хамтран ажиллах гэрээ байгуулж 2018-2019 хаврын улиралд суралцагч 7732 оюутны судалгааг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэст гаргаж өгөв.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018.10.09 өдрийн А-1/857 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн даатгалын /health.gov.mn/ сайтаас шалгаж даатгуулагч бүртгэлтэй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын дэвтэр шаардахгүй үйлчилгээ үзүүлэх болсон бөгөөд энэхүү сайтад бүртгэлтэй даатгалд хамрагдсан эсэхийг оюутан бүрээр шалгаж 2018-2019 оны хаврын улиралд 3322 оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулав.

2019 оны эрүүл мэндийн даатгал сард 3200 төгрөг, жилд 38400 төгрөг байна.



Зураг 5.6. Эрүүл мэндийн даатгалд хамруулсан оюутны тоо

Нийтийн тээвэрээр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/740 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6/21 тогтоолоор батлагдсан “Цахим карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Их, дээд сургуулийн оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, сунгах ажлыг зохион байгуулах удирдамж”-ын дагуу 2018-2019 оны хичээлийн жилд оюутнуудад хөнгөлөлттэй зорчих карт олгох болон сунгах ажлыг зохион байгуулж ажиллав.

“Цахим төлбөрийн карт”-ын захиалга авах ажлыг зохион байгуулж бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, Нийслэлийн боловсролын газартай хамтран ажиллаж нийт 6636 оюутан автобусны картыг захиалан автобусаар

хөнгөлөлттэй үнээр зорчиж байгаа бөгөөд үүнээс 2018-2019 оны хаврын улиралд захиалгаас хоцорсон 165 оюутанд нэмэлтээр карт захиалав.

2018-2019 оны хичээлийн жилд автобусны карт захиалсан оюутны тоо


Хүснэгт 5.15

д/д	Сургууль	Шинээр карт захиалсан оюутны тоо	Карт сунгуулсан оюутны тоо	Карт дахин захиалсан оюутны тоо	Нийт
1	БАС	347	544	239	1130
2	БУХС	247	256	111	614
3	ХШУС	87	40	24	151
4	МХТС	362	408	168	938
5	МеХТС	386	358	191	935
6	ГУУС	241	253	119	613
7	ҮТС	357	484	199	1040
8	ЭХС	437	452	189	1078
9	ГХИ	61	37	14	112
10	Коосен Технологийн Коллеж	23	2	0	25
ДҮН		2548	2833	1254	6636

Оюутны цахим карт

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн багш, оюутны цахим картын захиалга авч, цахим картын програмд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж ажиллав. Мөн 2018-2019 онд бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтан болон оюутан суралцагчдын 1903 цахим карт хэвлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

ШУТИС-ийн Удирдах Зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 15, 16, 17 дугаар тогтоолын дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, алба нэгжийн нэрийн өөрчлөлтийг картын бүртгэлийн програмд МХТС-ийн багш Г.Мөнхбатаар хийлгэв.



Зураг 5.7. Цахим карт хэвлэсэн тоо

Оюутан цэрэг хөтөлбөр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан цэрэг”-т мэргэжил олгох сургалтын журам батлах тухай, Монгол Улсын Батлан

хамгаалахын сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаал, “Оюутан цэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/49, А/53 тушаалуудыг үндэслэн “Оюутан цэрэг” сургалтыг явуулдаг.

Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 02 дугаар сарын 22-ны өдрийн хооронд явуулж 231 оюутан бүртгүүлж, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабаас 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн 10/74 тоот албан бичигт заасан квотын дагуу 71 оюутны мэдээллийг хүргүүлсэн.

БСШУСЯ-ын 2019.03.20-нд ирүүлсэн 3/2041 тоот албан бичгийн дагуу Хичээлийн II байрны ТВЗ-д өглөөний 09.30-16.30 цагийн хооронд Бямба, Ням гарагт Үндэсний батлах хамгаалахын их сургуулийн багш нар “Оюутан цэрэг” ерөнхий бэлтгэлийн сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 06-наас 06 дугаар сарын 02-ны өдрийг дуустал явууллаа. Энэхүү сургалтад ШУТИС-ийн 135 оюутан суралцагч суралцлаа.



5.5. ОЮУТНЫ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

2018-2019 оны хичээлийн жилд оюутны 4 оюутны байранд нийт 903 оюутныг хүлээн авч, тав тухтай амьдран суралцах боломжоор ханган ажилласан байна. Байрны ашиглалт, оюутан хүлээн авах ажлын бэлтгэл шалгах ажлыг СБЗГ, ЭМТ-тэй хамтран зохион байгуулж ажлыг сайжруулах талаарх санал хүсэлтийг Хөрөнгө оруулалт, хангамжийн газарт тавьж шийдвэрлүүлсэн.

Оюутны байр

Хүснэгт 5.16

Д/д	Оюутны байр	Сургууль (Оюутны тоо)										Гаднын оюутан	Нийт
		БАС	БуХС	ГУУС	МехТС	МХТС	ҮТС	ХШУС	ЭХС	ГХИ	Коосон		
1	I байр	44		67	12	7	81	6	24	4	6	45	296
2	III байр	42	134	19	3	11	7	20	92	1		28	357
3	IV байр		2			99	1					25	127
4	V байр	1	1	5	86	1	2		1			66	163
	Нийт	87	137	91	101	118	91	26	117	5	6	124	903

5.6. НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Хичээлийн шинэ жилийн нээлт



дарга Т.Амаржаргалан, ШУТИС-ийн захирал Б.Очирбат, “Санко” группийн ерөнхийлөгч, ШУТИС-ийн “Хүндэт профессор” Шимизү Такаши, ШУТИС-ийн дэд захирал Х.Энхжаргал, Т.Намнан, Б.Сүхбат, Л.Баяр-Эрдэнэ, Ц.Баатархүү ЗХНГ-ын дарга Н.Ганзориг болон бүрэлдэхүүн сургуулийн захирал бусад холбогдох



хүмүүс оролцов. Нээлтийн үйл ажиллагааны эхэнд “Оюутан цэрэг” сургалтад амжилттай суралцсан онц буудагч, онц сурлагатан, тамирчин, дайчин цол тэмдэгтэй оюутан цэргүүд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн тугийг залав. Нээлтийн ажиллагааны үеэр ШУТИС-ийн “Хүндэт профессор” цолыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейханд гардуулав. Мөн ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлгийг 2018-2019 оны хичээлийн жилд ШУТИС-д шинээр элссэн шилдэг элсэгчдээс шалгаруулан 11 оюутан, Санко группийн нэрэмжит тэтгэлгийг 5 оюутанд гардуулан өглөө. Үйлдвэрлэлийн технологийн сургуульд “Механик инженер /Япон 2+2” хөтөлбөрөөр элссэн Б.Ганбаяр элсэгчдийг төлөөлөн үг хэлж, Оюутны холбооны дарга С.Болд-Эрдэнэ, шинээр элссэн орсон нийт оюутнууд “Оюутны тангараг” өргөж, хичээлийн жилийн анхны хонх дуугарав.

2018-2019 оны намрын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн намрын улирлын бакалаврын 81, магистрын 43 дахь удаагийн төгсөлт 2019 оны 1 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд болж



төгсөлтийн ёслолын ажиллагааг зохион байгуулав.

2018-2019 оны намрын 327 магистрын зэргийн диплом, 994 бакалаврын зэргийн дипломтой төгссөнөөс онцлох дипломтой 20, дипломын зэрэгтэй 57 оюутан төгсөв. Түүнчлэн ГУУС-ийн БНХАУ-ын Шандунь сургуультай хамтарсан Геодези 2+2 хөтөлбөрөөр 1, ЭХС -ийн Хойд Хятадын Эрчим хүчний сургуультай хамтарсан Цахилгаан хангамж 2+2 хөтөлбөрөөр 14, ЭХС-ийн БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай хамтарсан Био инженерчлэл 2+2 хөтөлбөрөөр 7, МЕХТС-ийн Япон-ын Niigata их сургуультай хамтарсан Механик инженер 2+2 хөтөлбөрөөр 2 төгсөгч тус тус төгсөн гарлаа.

2018-2019 оны хаврын улирлын төгсөлтийн ёслолын ажиллагаа

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн үүсч байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн өмнө 2018/2019 оны хичээлийн жилийн хаврын улирлын бакалаврын 82, магистрын 44 дэх удаагийн төгсөлт 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр “Буянт-Ухаа” спорт цогцолборт ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн төгсөлтөөр доктор 14, магистрын 341, бакалаврын 1524 мэргэжлийн дипломтой 81, онцлох дипломтой 42 оюутан төгсөв.



Төгсөлтийн ёслолын арга хэмжээнд УИХ-ын гишүүн А.Ундраа, УИХ-ын даргын нийгмийн бодлогын зөвлөх, ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дарга Д.Бадарч, БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын дарга Т.Амаржаргалан, ШУТИС-ийн захирал Б.Очирбат болон бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирлууд, эрдэмтэн багш, төгсөгчид оролцлоо. Төгсөлтийн арга хэмжээг ШУТИС-ийн Захирал Б.Очирбат, УИХ-ын даргын нийгмийн бодлогын зөвлөх, ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дарга Д. Бадарч нар нээж үг хэллээ.



Энэ удаагийн төгсөлтөөр ГУУС-ийнт БНХАУ-ын Шандунь сургуультай хамтарсан Геодези 2+2 хөтөлбөр, ЭХС-ийн Хойд Хятадын Эрчим хүчний сургуультай хамтарсан Цахилгаан хангамж 2+2 хөтөлбөрөөр 1 төгсөгч, ЭХС-ийн БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай хамтарсан Био инженерчлэл 2+2 хөтөлбөрөөр 2, ЭХС-ийн Хойд Хятадын Цахилгаан эрчим хүчний сургуультай хамтарсан


Дулааны инженер 2+2 хөтөлбөрөөр 2, МехТС-ийн Японы Niigata их сургуультай хамтарсан Механик инженер 2+2 хөтөлбөрөөр 2, МХТС-ийн Москвагийн Холбоо, мэдээллийн техникийн их сургуультай хамтарсан Утасгүй холбоо мэргэжлээр 4, Холбооны сүлжээ холболтын технологи хөтөлбөрөөр 2 төгсөгч төгслөө.



Зураг 5.8 Төгсөлтийн ёслолын ажиллагаа

Тэтгэлэг олгогчдын өдөрлөг

“Тэтгэлэг хөтөлбөрүүд, Оюутны хөгжлийн зээл, эрсдэлийн даатгал” танилцуулах өдөрлөг 2018 оны 10 дугаар сарын 16-ны Мягмар гарагт Хурлын танхимд боллоо. ШУТИС-иас оюутнуудад олгодог тэтгэлэг хөтөлбөрүүд, кредит урамшуулал, хөнгөлөлтийн мэдээллийг оюутнуудад хүргэв.



Боловсролын зээлийн сангийн Зээлийн албаны мэргэжилтэн Ш.Зоригоо “Боловсролын зээлийн сан”-аас хэрэгжүүлж буй “Оюутны хөгжлийн зээл”-ийн талаар оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Мөн Хаан даатгалын байгууллага хариуцсан мэргэжилтэн “Эрсдэлийн даатгал”-ын талаар оюутнуудад танилцуулав.

Мөн өдөрлөгийн үеэр 2017 оны “Поско Ти Жи Парк” сангийн тэтгэлэгт Барилга, архитектурын сургуулийн оюутан Б.Билгүүнзаяа тэтгэлэгт хэрхэн хамрагдах вэ талаар туршлагаасаа оюутнууддаа хуваалцлаа.

ШУТИС-ийн 60 жилийн ойг угтан зохион байгуулсан “Элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөг”-ийн тэмцээн



Оюутны соёл үйлчилгээний алба, Оюутны холбоо, ХШУС-ийн Биеийн тамирын спортын тэнхим хамтран Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 60 жилийн ойг угтан элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 2018 оны 10 дугаар 15-19-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 17 баг тамирчид өрсөлдсөнөөс эрэгтэй 9, эмэгтэй 8 баг оролцсон. ШУТИС-ийн нийт элсэгчид авьяас чадвар, авхаалж

самбаа, хурд хүчээ дайчлан оролцож шилдгүүдээ тодруулав. Эрэгтэй баг тамирчдаас тэргүүн байрт Эрчим хүчний сургууль, дэд байрт Механик тээврийн сургууль, гутгаар байрт Геологи уул уурхайн сургууль, эмэгтэй баг тамирчдаас тэргүүн байрт Эрчим хүчний сургууль, дэд байрт Мэдээлэл холбоо технологийн сургууль, гутгаар байр Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль тус тус шалгарлаа. Эрэгтэй шилдэг тоглогчоор Эрчим хүчний сургуулийн оюутан У.Чингүүн, эмэгтэй шилдэг тоглогчоор Эрчим хүчний сургууль оюутан М. Цэлмэг шалгарав.

ШУТИС- 60 жилийн ойг угтан зохион байгуулсан “Оюутны спортын 6 төрөлт IV их наадам”

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Оюутны спортын 6 төрөлт IV их наадам амжилттай болж өндөрлөлөө. Энэ жилийн хувьд Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн их сургууль үүсгэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойг угтан зохион байгуулагдсанаараа онцлог байв. Энэхүү спортын наадамд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүн болон салбар 11 сургуулийн 700 гаруй баг тамирчин спортын 6 төрлөөр 2018.11.05-19-ний өдрүүдэд оюун ухаан, авьяас чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ дайчлан өрсөлдөж шилдгүүдээ шалгаруулсан бөгөөд багийн дүнгээр Барилга архитектурын сургууль шилжин явах цомын эзэн боллоо.

Шагнал гардуулах үйл ажиллагаанд Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Х.Энхжаргал, Оюутны соёл, үйлчилгээний албаны дарга Н.Санчирбаатар, Сургалтын хөтөлбөр, бүртгэлийн албаны дарга Д.Батдорж, Биеийн тамир спортын тэнхимийн эрхлэгч О.Баатарзоригт, Оюутны холбооны тэргүүн С.Болд-Эрдэнэ, 2005-2008 оны Оюутны холбооны тэргүүн Далайцэрэн, Батцогт, Сагсан бөмбөгийн Sharks багийн хамт олон хүрэлцэн ирлээ.



Зураг 5.9. “Оюутны спортын 6 төрөлт IV их наадам”

ШУТИС-60 жилийн ойг угтан зохион байгуулсан урлагийн XVIII их наадам

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Оюутны соёл, үйлчилгээний алба, оюутны холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оюутны урлагийн XVIII их наадам нь эхний шат 3 дугаар сарын 28,29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, гала тоглолт 04-р сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа. Энэхүү наадмын шүүгчдийн бүрэлдэхүүнд УГЗ, хөгжмийн зохиолч, удирдаач М.Булган, маск продакшны жүжигчин Г.Лхагвацэрэн, moon dance хамтлагийн бүжигчин олон улсын хэмжээний мастер А. Саруулзаяа, ШУТИС-ийн ОСУАлбаны мэргэжилтэн, урлаг судлаач Ц.Болдбаатар нар ажилласан юм. Урлагийн их наадам нийт 9 төрлөөр явагдсан юм. Үүнд : Цэнгээнт бүжиг, уран уншлага, хамтлаг дуу, гоцлол дуу, чөлөөт бүжиг, гоцлол бүжиг, гоц үзүүлбэр, жүжигчилсэн тоглолт, гоцлол хөгжим гэсэн төрлүүд багтсан бөгөөд багийн дүнгээр Барилга архитектурын сургууль 2 дахь жилдээ дараалан шилжин явах цомын эзэд боллоо. Шагнал гардуулах үйл ажиллагаанд Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Х.Энхжаргал, Оюутны соёл, үйлчилгээний албаны дарга Н.Санчирбаатар, Барилга архитектурын сургуулийн захирал Э.Нинжгарав, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн захирал А.Энхбат, Гадаад хэлний сургуулийн захирал Б.Соёлсүрэн нар оролцсон юм.

“MUST CUP-2019” хөлбөмбөгийн тэмцээн

ШУТИС-ийн нийт оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “MUST CUP 2019” хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 он 5-р сарын 10-нд Бага тэнгэрийн амны NATIONAL SPORT CAMPUS-д амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд бүрэлдэхүүн сургуулиудын 9 баг оролцсон юм. Тус тэмцээнийг монголын хөл бөмбөгийн холбооны мэргэжлийн

шүүгчид шүүсэн бөгөөд хаалтын үйл ажиллагаанд Оюутны соёл, үйлчилгээний албан дарга Н.Санчирбаатар, мэргэжилтэн Г.Анударь нар оролцсон юм. Тэмцээнд Эрчим хүчний сургууль тэргүүн байр эзэллээ.



Зураг 5.10. “MUST CUP-2019” хөлбөмбөгийн тэмцээн

5.7. ОЛОН НИЙТ НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АЖИЛ

Гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гуравласан гэрээ

ШУТИС-ийн хүрээнд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулах хүрээнд Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Э.Ганбат, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дарга, хурандаа Б.Даваазул, ШУТИС-ийн захирал Б.Очирбат нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гуравласан гэрээнд гарын үсэг зурсан.

Энэхүү гэрээний зорилго нь сургуулийн орчинд оюутан залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллах, оюутан залууст архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын тухай хуулийг сурталчлан танилцуулж, архи, тамхигүй орчныг бүрдүүлэх юм. Тиймээс бид энэхүү зорилго чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж үр дүнгээ дүгнүүлэн СБД-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургуулиудаас 3-р байранд шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа. Мөн “Соёмбо” клубийн ажлыг тусгайлан үнэлж Талархал, мөнгөн шагналаар шагнав.



Зураг 5.11. Гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гуравласан гэрээ

Сүхбаатар дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс ШУТИС-ийн хамт олонд талархал гардуулав

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндсэн үүргээ биелүүлэх, хамтын ажиллагааны ажлын үр дүнг дүгнэх уулзалт 2018 оны 12 дугаар сарын 28-нд 203 тоот танхимд боллоо. Тус арга хэмжээнд ШУТИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ц.Баатархүү, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, доктор, дэд профессор Н.Ганзориг, ОСҮА-ны дарга Н.Санчирбаатар, ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа, СБД-ийн ГХУС салбар зөвлөлийн дарга Э.Ганбат, СБД-ийн Цагдаагийн I хэлтсийн УСА-ны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Саруултуяа, “Соёмбо” клубийн гишүүн оюутнууд оролцлоо.



Зураг 5.12. ШУТИС-ийн хамт олонд талархал гардуулав

ШУТИС-ийн хамт олонд оюутан залуучуудыг гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд оюутны оролцоог нэмэгдүүлж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачилгатай оролцож бусад их дээд сургуулиудаа манлайлан ажилласан гэж дүгнээд СБД-ийн ИТХ, Цагдаагийн газраас ТАЛАРХАЛ гардууллаа.

Мөн НЦГ-аас зохион байгуулсан “Оюутан эргүүл”-ийн нэгдсэн арга хэмжээнд сайн ажилласан ШУТИС-ийн оюутны хэв журам, ёс суртахуун сахиулах “Соёмбо” клубийн нэр бүхий 6 гишүүн оюутныг мөнгөн урамшууллаар урамшуулав.

ШУТИС-ийн оюутан залуус “Unfriend хөдөлгөөн”-д нэгдэв

Оюутан залуусыг цахим гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдний цахим орчин дахь зүй зохистой хэрэглээг бий болгох, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Unfriend хөдөлгөөн” 2018 оны 09 дүгээр сарын 05-наас 27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.



Зураг 5.13. ШУТИС-ийн оюутан залуус “Unfriend хөдөлгөөн”-д нэгдэв

Тус арга хэмжээний хүрээнд Төрийн ордонд зохион байгуулсан “Таны хүүхдийг танихгүй хүн хүмүүжүүлж байна” хэлэлцүүлэгт ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа оролцсон. Мөн “UNFRIEND” аяны нэгдсэн арга хэмжээг ШУТИС-ийн Сургалтын хөтөлбөр бүртгэлийн алба, Оюутны соёл үйлчилгээний алба, Маркетинг, олон нийттэй харилцах алба, ХШУС-ийн сургалтын алба хамтран зохион байгуулж 400 гаруй оюутныг хамрууллаа.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, ШУТИС-ийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Х.Энхжаргал “Unfriend хөдөлгөөн”-ий элч дуучин Б.Анхбаяр, Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Ч.Мөнхбат, цагдаагийн дэд хурандаа Д.Бүрэнбаатар нар оролцож оюутан залуусыг цахим гэмт хэрэг, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өглөө

Арга хэмжээний төгсгөлд ШУТИС-ийн оюутнууд ХААИС-ийн оюутнуудыг “Unfriend хөдөлгөөн”-д нэгдэхийг уриалсан юм. Мөн “Соёмбо” клубийн оюутнуудад “Харилцаа ёс зүйн” сургалт ШУТИС-БуХс-ийн ахлах багш Юмжирмаа лекц уншсан бөгөөд СДЦ-н 8-р хорооны хошууч Саруултуяа “Гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хууль сурталчлах” лекц зохион байгуулж тараах материал тарааж лекцийн төгсгөлд “Соёмбо” клубийн өрөөгөөр зочлон заавар зөвлөгөө өгч ажиллав.

Нэг хором аян

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгах, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх” зорилгоор ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэрэг бүртгэх алба, JCI Монгол төрийн бус байгууллагатай хамтран "ОЙЛГОЛЦОХ 1 ХОРОМ" аяныг өрнүүлж 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр их, дээд сургуулийн 3000 орчим оюутан, залуучуудад хандлага, зөв амьдрах ухаан, харилцааны соёл, хуулийн хариуцлага, сэтгэл зүйн талаар нийгмийн салбар болгоны төлөөллийн олны танил хүмүүсээр сургалт, ярилцлагын арга хэмжээг UB Palace-д зохион байгуулсан ба уг арга хэмжээнд ШУТИС-ийн 464 оюутныг зохион байгуулж оролцов. Энэхүү "ОЙЛГОЛЦОХ 1 ХОРОМ" аяны сургалтын арга хэмжээнд ШУТИС-ийн 10 багш, 460 гаруй оюутан, үүнээс ШУТИС-ийн Оюутны холбоо, оюутны зөвлөлийн 80 гаруй идэвхтэн гишүүн, Соёмбо клубийн 10 гишүүн оролцлоо.



Зураг 5.14. Нэг хором аян

5.8. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

“Нэг өрх-Нэг ажлын байр” өдөрлөг

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Цагийн ажлын бирж, Хувийн 15 хөдөлмөрийн бирж, 70 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамарсан Нэг өрх-Нэг ажлын байр өдөрлөг 2018 оны 09-р сарын 19,20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд ШУТИС-ийн 10 оюутан цагийн ажил хийж оролцов.

Нэг өрх- нэг ажлын байр “Хөдөлмөр эрхлэлтийн форум-2018”

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас санаачлан нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Карьер хөгжлийн төвтэй хамтран Нэг өрх – нэг ажлын байр “Хөдөлмөр эрхлэлтийн форум-2018” арга хэмжээг 2018 оны 12-р сарын 04-ний өдөр зохион байгуулав. Форумд нийслэлийн Засаг даргын орлогч Д.Энхтөр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, НИТХ-ын Тэргүүлэгч Нийгмийн бодлогын хорооны дарга Д.Мөнхжаргал, НИТХ-ын төлөөлөгч М.Халиунбат, нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга П.Батхүлэг, Карьер хөгжлийн төвийн захирал Д.Ерөө болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүд оролцов.


Энэ форумгаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг нийгмийн олон талт оролцоонд тулгуурлан шийдвэрлэх боломж, гарц, шийдлүүдийг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, техник технологийн болоод менежментийн өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага түүнийг хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэн холбогдох газруудад хүргүүлэхээр болов. Мөн форумын үеэр Тэсо ХХК, Говь ХХК, Таван богд групп зэрэг топ аж ахуй нэгжүүдэд хамтран ажиллах саналаа хүргүүлээ.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас санаачлан зохион байгуулдаг үйлдвэртэй танилцах аялалд оюутнуудаа оролцуулав

Эрдэнэт Үйлдвэртэй танилцах аялал 2018 оны 11 сарын 1, 2-ны өдрүүдэд зохион байгуулагдав. Уг аялалд 22 их дээд сургууль оролцсон бөгөөд ШУТИС-иас Гадаад хэлний сургуулийн оюутан У.Бишрэл, Геологи уул, уурхайн сургуулийн оюутан Б.Ану нар оролцов.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газраас зохион байгуулдаг бүтээн байгуулалттай танилцах аялал Монгол улсдаа хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хамгийн том компани болох “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”ХК-д зохион байгуулав.



Зураг 5.15. Үйлдвэртэй танилцах аялал

“Ажлын байрны үзэсгэлэн яармаг-2019”

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Ажлын байрны үзэсгэлэн яармаг-2019” өнгөрөгч мягмар гаригт буюу 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдлаа. Өдөрлөгийг ШУТИС-ийн төгсөгчдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл зөвлөгөө хүргэх, ажил олгогчийн зүгээс хүний нөөцийн бодлого, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг таниулах, төгсөгчдийн талаар нарийвчилсан мэдээлэл авах, сонгон шалгаруулалт хийх, ШУТИС болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор, хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг олон талт үйл ажиллагааг нэг дор зохион байгуулснаараа онцлог байлаа.

Уг өдөрлөгт Оюутны соёл, үйлчилгээний албатай хамтран ажилладаг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, iCareer, Эко констракшн ХХК, Голомт банк, Магнай трейд ХХК, Жи мобайл ХХК, Номин холдинг, Мобиком ХХК, MCS Asia Pacific Brewery LLC, Тээвэр хөгжлийн банк, Арвижих энерги ХХК, Их мянган инженерчлэл ХХК, Мацүзакаяа ХХК, Ачит ихт ХХК, Таван богд групп, Мобиком Корпораци, Номин констракшн, Ddish Tv , Юнител корпораци, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, МАК групп, Хишиг Арвин ХХК, Итали зайрмаг “Gelat” ХХК, Жи Си Ар Монголиа ХХК, Анунгоо ХХК, Тэгшт Плант ХХК, Топ гласс ХХК, Моннис групп, Монцемент Билдинг материалс ХХК, Эм Эм Си Жи ХХК, гэсэн 30 гаруй байгууллагууд оролцлоо.

Мөн 700 гаруй оюутан цахим анкет бөглөсөн ба ажил олгогч байгууллагуудад танилцуулан, ажлын байрны захиалгын дагуу мэргэжлийн чиглэлээр төгсөгч оюутнуудын мэдээллийг өгсөн болно. Тус өдөрлөгт 1100 нээлттэй ажлын байр зарлагдаж 615 оюутныг цагийн болон байнгын ажлын байраар хангагдах боломж бүрдлээ.



Зураг 5.16. “Ажлын байрны үзэсгэлэн яармаг-2019”

“Тохирох ажилд нь зөв хүнийг-2019”


“Тохирох ажилд нь зөв хүнийг-2019” танилцуулах лекц, тестийн арга хэмжээ ШУТИС-ийн I хурлын танхимд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд ШУТИС-ийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Х.Энхжаргал, Карьер хөгжлийн төвийн захирал Ц.Булган, “LendMn”-ийн захирал В.Баярсайхан, Харвардын Бизнесийн сургуулийн төгсөгч, ЗГХЭГ-ийн даргын зөвлөх О.Батнайрамдал нар оролцов.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын төгсөх курсийн 250 орчим оюутан уг лекцэд оролцож ажлын байран дахь хандлага, ур чадварыг тодорхойлох /Professional Profile/-тестээр үзүүлж ICareer.mn веб сайтад оюутнууд мэдээллээ байршуулж эхэлсэн.

“LendMn” захирал В.Баярсайхан “Ажил олгогчид төгсөгчдөөс юу хүлээж байна вэ?”, Харвардын Бизнесийн сургуулийн төгсөгч, ЗГХЭГ-ын даргын зөвлөх О.Батнайрамдал “Дэлхийд өрсөлдөх боловсон хүчин” сэдвээр оюутнуудад илтгэл тавилаа. Оюутнууд илтгэгчдээс сонирхсон асуултаа асууж харилцан санал бодлоо солилцсон үр дүнтэй арга хэмжээ болж өнгөрлөө.

Хурлын танхимд зохион байгуулсан арга хэмжээ

Хурлын танхимд хурал зөвлөгөөн, лекц семинар, урлагийн тоглолт, сургалт гэх мэт 346 удаагийн 1447 цагийн арга хэмжээ зохион байгуулагдсан.



Зураг 5.17. Зохион байгуулсан арга хэмжээ


5.9. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн эрүүл мэндийн үзлэг 08 дугаар сарын 14-нөөс 09 сарын 01-ний хооронд болж 3878 оюутан хамрагдсан.

Үзлэгийн дүн :



Зураг 5.18. Үзлэг, оношлогоонд хамрагдсан байдал



Зураг 5.19. Өвчний байдал оношоор эзлэх хувь

Үзлэгийн бэлтгэл ажил (удирдамж, журам, зарлал, мэдээлэл, урьдчилан сэргийлэх үзлэгт шаардлагатай эм тариа бусад ажлын бэлтгэл, зохион байгуулалтад оролцож байгаа оюутнуудад хяналт тавьж ажиллаа.

Амьсгалын замын халдвараас урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ сургалтад оюутнуудаа хамруулж, цээж гэрэлд харуулж зөвлөгөө өгч ажилласан.


2018-2019 оны хичээлийн жилд Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн амбулаторийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө

**Амбулаторийн үзлэгийн тоо
/Давхардсан тоогоор/**

Хүснэгт 5.17

Д/д	Сар	Үзлэгийн төрөл							Нийт
		Дотор	Шүд	Тариа	Нөхөн сэргээх	БүХС	МХТС	МТС	
1	09 сар	107	365	214	100	354	131	88	1359
2	10 сар	95	427	345	117	73	138	94	1289
3	11 сар	105	515	254	206	50	90	111	1331
4	12 сар	57	197	196	197	97	167	0	911
5	1 сар	70	334	117	158	98	200	50	1027
6	2 сар	74	322	107	105	138	310	58	1114
7	3 сар	100	267	218	167	138	390	75	1355
8	4 сар	107	653	286	269	152	120	48	1635
9	5 сар	85	538	287	236	188	242	43	1619
БҮГД НИЙТ		800	3618	2024	1555	1288	1788	567	11640

Тайлбар: Эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн мэдээг авч үзэхэд улирлын чанартай ачаалал байгаа нь зарим кабинетуудаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тооноос хамаардаг.



Зураг 5.11. Эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэг

Тайлбар: Эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн мэдээг авч үзэхэд улирлын чанартай ачаалал байгаа нь зарим кабинетуудаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тооноос хамаардаг.

- Хүчилтөрөгчийн коктейлиор 393 оюутан, багш, ажилчдад үйлчилсэн. Оюутны 1, 3, 4, 5-р байрны Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр дотор эрхтэн системийн үзлэг, зөвлөгөө, БЗДХ-ийн эрт илрүүлэг үзлэг, ХДХВ/ДОХ, тэмбүү сорил шинжилгээ, сүрьеэ эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 1008 оюутан хамрагдав.
- ШУТАС-ийн 75 сурагчийг 08 сарын 28-31, 11 сарын 06-нд Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа
- ШУТИС-ийн КООСЕН хамтарсан хөтөлбөрийн 124 оюутныг 08 сарын 24-нөөс 09 сарын 01-ний хооронд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө өглөө. Мөн 14 оюутны ТВС үзлэг, цээж гэрэлд харах шинжилгээ авлаа.
- ШУТИС Эрүүл мэндийн төвийн салбар БуХС-ийн дотуур байранд 1 өрөөг нэмж тохижуулан “Эрүүл мэндийн өдөрлөг”-т оролцсон. Өдөрлөгт шүд амны хөндийн үзлэг хийж, биеийн өөхжилт тодорхойлж ажиллав.
- “Цусаа бэлэглэж амьдрал хайрлая” аяныг 10 сарын 08, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, ШУТИС-ийн 200 оюутан багш ажилчид хамрагдаж цусаа бэлэглэв. Энэ үеэр оюутнуудад мэдээлэл өгч, судас боож, анхны тусламж үзүүлж, мэдээлэл сурталчилгааны ажил хийлээ.
- Дэлхийн чихрийн шижинтэй тэмцэх өдрийг угтан ҮТС-ийн ШТСТ, ОСҮА-тай хамтран 4 өртөөт үйл ажиллагааг 11 сарын 16-нд нийт оюутан, багш ажилчдын дунд зохион байгуулж, 40 хүнд дотрын эмчийн үзлэг, зөвлөгөө, бүртгэл, ерөнхий хэмжилт, хүчилтөрөгчийн коктейлиор үйлчлэв.
- Оюутны холбоо, оюутны соёл үйлчилгээний албатай хамтран Дэлхийн ХДХВ/ДОХ-той тэмцэх өдөрлөгийг 11 сарын 30-ны өдөр 6 өртөөт үйл ажиллагаа зохион байгуулсан.
 - 1-р өртөө сурталчилгааны материал тараах, БЗДХ-ыг таниулах, хамгаалах талаар мэдээлэл өгөв. /сургалт-24 оюутанд, хамгаалах хэрэгсэл-30 хайрцаг, гарын авлага-1200 хүнд, ном 2 төрөл-50 хүнд/

- 2-р өртөө Эсэ бичлэгийн уралдаанд 7 бүтээл ирснээс 26 хүн үнэлгээ өгч 1, 2, 3-р байр шалгаруулав.
- 3-р өртөө Гар зургийн уралдаанд 5 бүтээл ирснээс 25 хүн үнэлгээ өгч 1, 2, 3-р байр шалгаруулав.
- 4-р өртөө Мари стопс эмнэлэгтэй хамтран 67 оюутныг ХДХВ/ДОХ-ын түргэвчилсэн шинжилгээнд хамруулж зөвлөгөө өглөө.
- 5-р өртөө Хүчилтөрөгчийн коктейлиор 59 хүнд үйлчилсэн.
- 6-р өртөө АХА тэмцээнд 100 гаруй оюутан оролцож 1, 2, 3-р байр шалгаруулав.
- ЧД-ийн V цэцэрлэгийн 10 бүлгийн нийт 307 хүүхдэд 11 сарын 23-нд, 33-р сургуулийн 1А ангийн 45 сурагчдад 12 сарын 19-нд шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө болон сургалт, витаминжуулалтын аян явуулсан.
- МХТС-ийн нийт 53 оюутан, МСҮТ-ийн 1-р ангийн 104 сурагчийг шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө, сургалтад хамруулж, үүнээс 16 оюутныг Эрүүл мэндийн төвийн Шүдний кабинетад эмчлэн ажилласан. Өмнөх жилийн үзлэгт хамрагдсан суралцагчдын 29% нь эмчлэгдсэн байгаа нь бидний үзлэг, сургалт, эрүүлжүүлэх ажлын үр дүн гарч байгаа нь харагдаж байна. Шинээр элсэн орж буй суралцагчдын шүдний өвчлөл, тамхинаас үүдэлтэй чулуу, буйлны үрэвсэл, шүд угаахын ач холбогдол, шүд цоорлын хүндрэл, шүднээс үүдэлтэй идээт үрэвсэл ихсэж байна.
- Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, голомтын арга хэмжээ, үзлэг зөвлөгөөг 02 сарын 25-наас 28-ны өдрүүдэд нийт 3823 хүнд өгч, үрэвсэлтэй 288, сургалт сурталчилгааг 5177, зөвлөмжийг 2645 хүнд өглөө.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлд хийсэн ажил

- Спорт явган аялалд 513 эмэгтэй оюутан хамрагдаж 20, 1065 эрэгтэй оюутан хамрагдаж 23 оюутанд анхны тусламж үйлчилгээ үзүүлээ.
- Оюутны дөрвөн дотуур байр /I, III, IV, V/-удын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөл байдлыг байр тус бүрээр үнэлж 2018 оны 12 дугаар сарын 12-нд ШУТИС-ийн хичээлийн болон оюутны байруудын үйл ажиллагаа, ашиглалтын талаар ажлын хэсгийн тайланг танилцуулсан.
- MUST CUP-2018 тэмцээн, оюутны “Намрын тэргүүн”, “Элсэгчдийн аварга” шалгаруулах, “Оюутны улсын аварга шалгаруулах”, “Багш, ажилчдын 5 төрөл” тэмцээнд эмчээр ажиллав.
- ШУТАС-ийн 11, 12-р ангийн нийт 29 сурагчдад “Стрес гэж юу вэ? Хэрхэн зохицуулж сурах вэ?” Сургалт явуулж, “Темпераментын сорил авч, дүгнэлт гарган багш нарт нь танилцуулав.
- Сүхбаатар дүүргийн тамгын газраас “Залуучуудын дундах БЗДХ, ХДХВ-ийн тархлыг бууруулахад бидний оролцоо” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг нь Залуучуудын холбооны байранд зохион байгуулагдсан.
- “Дотуур байранд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисыг зөв найруулж хэрэглэх тухай” сургалтыг Монголын дотуур байрны багш нарын нэгдсэн холбоотой хамтран нийт 9 их дээд сургуулийн 38 үйлчилгээний ажилчид хамрагдсан бөгөөд тус сургалтын үеэр ариутгалын бодисыг найруулах аргачлал, зааварчилгааг хэвлэмэл байдлаар тараав.

- ШУТИС хичээлийн 1, 2, 3-р байруудад “Агь нарын овоо” ХХК-иар шавж устгал, халдваргүйжүүлэлт хийлгүүлж, ШУТИС-ийн Эрүүл мэндийн төв хяналт тавин ажилласан.
- МУ-ын Гамшгаас хамгаалах хууль болон галын аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 339, 340-р тогтоолын дагуу ШУТИС-ийн 1, 2-р байрны нийт 19 багш, ажилчдад “Амилуулах суурь тусламж” бэртэж гэмтсэн үед боолт хийх үзүүлэн сургалтыг зохион байгуулсан. Гамшгийн сургуулилтад Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний “Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бүлэг”-ийг ахалж жагсаалд бэлэн байдлаа шалгуулсан.
- “Эрүүл оюутан-Хөгжлийн түүчээ” аяны хүрээнд Оюутны 1-р байрны 130 оюутанд Сүрьеэ, БЗДХ-ийн эрт үеийн үзлэг, шинжилгээнд хамруулж ажилласан.
- Хаврын спорт явган аяллын хичээлд хамрагдах 436 эрэгтэй оюутнуудад “Хачигт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга”, БЗДХӨ-ийн талаар сургалт явуулсан.
- “Улаан бурхан өвчинд цэг тавья” аянд нэгдэж 120 оюутанд Улаан бурхны вакцин хийсэн.
- “Хачигт энцефалит”-ийн вакциныг СБД-ийн Эрүүл мэндийн төвийн халдвар судлаач их эмч Т. Марзияа, вакцинач Б. Оюунтунгалаг, ЭМТөвийн сувилагч Ч.Доржпалам, Б.Эрдэнэчимэг нар хамтран “Хээрийн дадлага” хийх ГУУС, УТС нийт 253 оюутныг вакцинд хамруулсан.

Мэргэжил мэдлэг дээшлүүлэх чиглэлд хийсэн ажил

“Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлэг, “Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь”, “Шүдний эмнэлгийн цэвэрлэгээ халдваргүйтгэлийн бодис”, НМХГ, АШУҮИС-иас хамтран “Шүдний эмнэлгийн үйл ажиллагаанд анхаарах асуудал”, “Анагаах ухааны ёс зүй, хандлага, эрх зүй” сэдэвт сургалтыг ШУТИС-ийн Эрүүл мэндийн төвийн ажилчдад зохион байгууллаа.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ЗУРГАА.НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН

ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн номын сан нь 2018-2019 оны хичээлийн жилд цахим үйлчилгээ, олон улсын мэдээллийн санг таниулан сурталчлах, уншигчдын тав тухтай орчныг бүрдүүлэх, профессор багш, судлаачид, уншигчдадаа хандсан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, номын санч, үйлчилгээний ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран ажиллалаа.

Тус хичээлийн жилд номын сан нь Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирлын удирдлагад үйл ажиллагаагаа явууллаа. ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр ШУТТНС-ийн “Үйл ажиллагаа зохицуулах журам”-ыг хэлэлцүүлж, 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/232-р тушаалаар шинэчлэн батлуулав.


Номын сангийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч электрон каталог, мэдээллийн сангуудад QR Code үүсгэж, уншигчид гар утсаа ашиглаж ном, мэдээллийн хайлт хийх, цахим ном унших, лавлагаа мэдээллийг авах, ном материалаа онлайнгаар сунгах боломжийг бүрдүүллээ. Мөн Lib4u програмын веб хувилбарыг ашигласнаар үйлчилгээний чанар сайжирч, уншигчдад мэдээллийг түргэн шуурхай хүргэж байна.

2018/19 оны хичээлийн жилд санхүүгийн тайлан хэлэлцүүлэх, тайлан мэдээ, бичиг хэрэг хөтлөлт, номын сангийн тодорхой нэгжүүдийн үйл ажиллагааг шинэчлэх ажлуудыг амжилттай хийлээ. Номын сангийн нэг цэгийн үйлчилгээгээр профессор багш нарын ном сурах бичиг, бичиг хэрэг, хувилах, хэвлэх үйлчилгээнээс гадна хүрээлэнгүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гэрээний дагуу хэрэглэгчдэд хүргэж байна. Номын сангийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг уншигчдаас тогтмол авч үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

ШУТТНС-аас “Нээлттэй хаалганы өдөр”, “Соёл урлагийн ажилтны өдөр”, “Дэлхийн номын өдөр”-ийг тус тус хөтөлбөрийн дагуу профессор багш нарын номын нээлт-хэлэлцүүлэг, гадаад дотоодын хэвлэлийн газруудын хэвлэмэл болон цахим номын үзэсгэлэн-худалдаа, солилцоо болон оюутан уншигчдад зориулсан олон талт соёлын хөтөлбөрт ажлуудыг тус тус өргөн хүрээнд амжилттай зохион явууллаа.

Тус хичээлийн жилд номын сангийн хурлын танхим, оюутны уншлагын танхимд сургуулийн захиргаа, бүрэлдэхүүн сургууль, төрийн болон хувийн хэвшлийн дотоодын болон гадаадын байгууллагууд, ШУТИС-д олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын зохион байгуулсан 14,960 орчим оролцогчдыг хамарсан (давхардсан тоогоор) 174 удаагийн эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт семинар, албан уулзалтуудыг зохион байгуулсан байна.

ШУТИС-ийн хөрөнгө оруулалт хангамжийн газартай хамтран ажиллаж, хурлын танхимд орчин үеийн технологийн дэвшилтэт 210 инчийн LED дэлгэц болон сүүлийн үеийн үзүүлэлттэй зөөврийн компьютерыг (notebook) шинээр авч синхрон орчуулгатай, онлайн хурал зохион байгуулах боломжийг бүрдүүлж ажиллалаа. Мөн тус хурлын танхимын суудлын тоог нэмэгдүүлснээр тав тухтай орчныг бий болголоо.



Зураг 6.1. Хурлын танхимын ашиглалт /хурлын тоогоор/

Гадаад харилцааны хүрээнд ОХУ-ын АСВ, Горная книга, Русский мир, БНХАУ-ын “Боловсрол, номын экспорт импорт” хэвлэлийн газруудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж, профессор багш, судлаач, уншигчдаас мэргэжлийн номын захиалга авах, номын үзэсгэлэн худалдааг тогтмол явуулж байна.

Тус хичээлийн жилд “Springer Nature” мэдээллийн сангаас хамгийн олон өгүүлэл таталт хийсэн байгууллагыг шалгаруулах “High Usage Award 2018” уралдаанд “Springer Nature High Publication Growth Award”, “Springer Nature High Usage Award” номинациар тус тус тэргүүн байр эзэлсэн амжилтыг үзүүллээ.

Номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулж, докторантур 2, магистрантур 3 номын санч тус тус суралцаж мэдлэг, мэргэжлээ дээшлүүлж байна.

Номын сангийн уншлагын танхимуудыг цэцэгжүүлэн, номын санчид ногоон тохилог орчинд уншигчдад соёлч, боловсон, нээлттэй мэдээллийн үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн ажиллалаа.

6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ

2018/2019 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Төв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БуХС, МТХС, МехТС, ДаТС, ОрТС/ номын сангаас бүрдсэн 6 салбар номын сан 1998 уншигчийн суудалтайгаар давхардсан тоогоор 225,088 уншигчдад 277,588 ном, материалаар үйлчилгээ хүргэж ажиллалаа. Үйлчилгээний талаар уншигчдын дунд онлайн санал асуулга, судалгааг тогтмол явуулж, тэдний санал, хүсэлтийг үйлчилгээндээ тусган жилээс жилд өргөжин ажиллаж байна.



ШУТИС нь ном, хэвлэмэл материалаар үйлчилгээг хүргэхээс гадна цахим үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээ, шинэ номын мэдээ-мэдээлэл, лавлагаа номзүй, хувиран олшруулах, эрэлт хэрэгцээтэй цөөн хувьтай болон хуучин номыг е-хэлбэрт оруулах, сэргээн засварлах, олшруулах, техник, технологийн мэдээ,

мэдээллийг веб сайтад тавих, төрөлжсөн электрон мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг хүргэж байна.

2018/19 оны хичээлийн жилийн номын сангийн үйлчилгээний статистик мэдээ


Хүснэгт 6.1

д/д	Номын сан	Уншигчийн тоо	Олгосон номын тоо
1	Төв номын сангийн нэгжүүд	Уншлагын танхим №1	16,200
		Уншлагын танхим №2	18,762
		Уншлагын танхим №3	26,868
		Үндсэн фонд /Сурах бичиг/	83,986
		Эрдэм шинжилгээний номын фонд	38,042
		Эрдэм шинжилгээний уншлагын танхим	4,171
		Тогтмол хэвлэлийн уншлагын танхим	5,800
	ҮТДС-ийн уншлагын танхим	2,222	
1	Төв номын сан	158,035	196,051
2	БуХС-ийн номын сан	19,294	20,638
3	МехТС-ийн номын сан	12,948	13,714
4	МХТС-ийн номын сан	16,139	25,648
5	ДаТС-ийн номын сан	11,942	15,499
6	ОрТС-ийн номын сан	6,730	6,038
	НИЙТ:	225,088	277,588




Зураг 6.2. Статистик мэдээллийг номын сангийн үйлчилгээний мэдээлэл. ("Lib4u" програмаас гаргасан)

Энэ хичээлийн жилд электрон каталогаар 57,641 уншигч хандаж, номын хайлт хийсэн байна. Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 30 орчим нэр төрлийн гадаад сэтгүүл, 10 орчим нэр төрлийн монгол хэвлэл захиалан уншигчдын хүртээл болгож байна. Ном сэргээн засварлах, хувилах үйлчилгээгээр эрэлт хэрэгцээ ихтэй 221 нэр төрлийн 1049 ном, сурах бичгийг сэргээн засварлаж үйлчилгээнд гаргаж, багш нарын захиалгын дагуу зохиогчийн эрх нь шийдвэрлэсэн ном, сурах бичгийг хувиран олшруулах үйлчилгээ үзүүлээ.



Зураг 6.3. Мэргэжлийн сэтгүүлийн судалгаа




Зураг 6.4. Гадаад хэвлэлийн захиалгын судлагаа

Фонд бүрдүүлэлт: ШУТИС-ийн фонд бүрдүүлэлт нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн хийгддэг. Тус журмын 4.3-т ШУТИС-ийн суралцагчийн (бакалавр, магистр, доктор оюутан) төлбөрийн 1.5%-аас доошгүй хөрөнгийг номын сангийн фонд бүрдүүлэлтэд зориулна гэж заасан байдаг. Фонд бүрдүүлэлтийн төсвийн 60%-д бүрэлдэхүүн сургуулиуд мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, үлдсэн 40%-д номын сан профессор багш нарын захиалгыг үндэслэн олон улсын нэр хүнд бүхий хэвлэлийн газруудаас сургалт судалгааны ном, мэдээллийн сан авах журмын дагуу 2018-2019 оны хичээлд EBSCO мэдээллийн сангийн


- **Energy & Power Source**
- **Applied Science & Technology Source Ultimate**
- **Engineering Source**
- **Computers & Applied Sciences Complete**

дөрвөн багцыг үргэлжлүүлэн 2 дахь жилдээ 46,1 сая орчим төгрөгөөр авч, профессор багш, судлаачид, уншигчдыг судалгаа хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлээ хэвлүүлэх боломжийг бүрдүүлж ажиллалаа. ОХУ-ын томоохон

хэвлэлийн газруудтай хамтран ажиллаж, профессор багш нарын захиалгын дагуу 2017, 2018 онд хэвлэгдсэн техник технологийн 7,7 сая гаруй төгрөгийн 113 гаруй нэр төрлийн ном, сурах бичгийг авч сургалт, судалгаанд ашиглаж байна.



Зураг 6.5. Мэргэжлийн чиглэлийн цахим номын судалгаа





Зураг 6.6. Номын сангийн цахим ном

ШУТИС-ийн номын фонд бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт /Сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгаа/

Хүснэгт 6.2

№	Номын сан	2016 он			2017 он			2018 он			2019оны эхний хагас жил		
		Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	ШУТТөв номын сан	679	4,329	121,586,877	312	3,715	107,917,815	326	4,345	115,898,840	60	977	38,886,632
2	БУХС номын сан	166	1,460	26,263,509	137	1,652	32,628,210	133	1,002	29,912,000	39	392	7,008,500
3	МехТС номын сан	66	616	9,315,130	116	1,280	16,208,000	15	1,572	38,692,000	8	1085	8,152,500
4	МХТС номын сан	28	248	6,095,217	62	367	10,146,751	21	273	7,885,053	12	164	2,857,200

5	ДаТС номын сан	24	248	2,467,500	13	106	2,290,000	84	193	4,513,000	80	173	2,805,800
6	ОрТС номын сан	45	1,331	18,864,998	118	464	10,723,000	81	2,136	25,217,300	16	355	4,711,000
НИЙТ :		1,008	8,232	184,593,231	758	7584	179,913,776	660	9,521	222,118,193	215	3,146	64,421,632



Тоо ширхгээр

Үнийн дүнгээр

Зураг 6.7. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа

6.3. САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан тус хичээлийн жилд цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад анхаарч олон улсын нээлттэй мэдээллийн сангийн эрх авах, төрлийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг төрөлжүүлэн ажиллалаа.

Цахим сан хөмрөгийн баяжилт:

ШУТИС нь шинэ номын мэдээ-мэдээлэл, лавлагаа номзүй, хувиан олшруулах, онлайнар номын захиалга хийж профессор багш, судлаачдын мэдлэг чадвар, чадавхыг сайжруулах, эрэлт хэрэгцээтэй цөөн хувьтай болон хуучин номыг е-хэлбэрт оруулах, сэргээн засварлах, олшруулах, орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслийг нэвтрүүлэхэд анхаарч тус



хичээлийн жилд ном ариутгагч төхөөрөмж, А3 болон том хэмжээт ном, материалыг богино хугацаанд сканердаж цахим хэлбэрт оруулах хүчин чадал бүхий **Czur m3000** маркийн сканерыг авч үйлчилгээндээ ашиглаж байна.

IDS Smart Bookshower ном ариутгагч төхөөрөмж нь номыг нанотехнологиор ариутгалын бодис бүхий 254nm UV-C гэрлээр ном доторх нянг 99,9% арилгах боломжтой юм. **Czur m3000** маркийн сканер нь нэг хуудсыг 1.2 секундэд уншиж, ном, материалыг задлахгүйгээр сканердаж, текстийг word excel pdf-р хөрвүүлэх боломжтой.

2018-2019 оны хичээлийн жилд LIB4U.net програм хангамжийг төв болон бүрэлдэхүүн сургуулийн номын сангийн үйлчилгээнд амжилттай ашиглаж байна. LIB4U.net програм хангамж нь үүлэн технологит суурилсан, найдвартай, тасралтгүй ажиллагаа бүхий дата төвүүдэд байрласан тул номын сангийн мэдээллийн баазын аюулгүй байдал бүрэн хангагдсан. Бүртгэгдсэн уншигчид зохиогчийн эрх шийдэгдсэн цахим номыг бүрэн текстээр нь дурын газраас унших, гэрээр авсан ном, материалын хугацааг онлайнаар холбогдон сунгуулах, мэдээлэл авах зэргээр цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн нь профессор багш, судлаач, уншигчдын талархлыг хүлээсэн үйлчилгээний нэг хэсэг болсон.

Е-Ном, эрдэм шинжилгээ, судалгааны материал бүхий 1600 гаруй номын фондтой дотоод сүлжээгээр унших боломж бүхий “Цахим номын сан” веб сайтыг тогтмол баяжуулж веб сайтад байршуулан уншигчдын хүртээл болгосоор байна. Цахим номын сангийн фондод зохиогчийн эрх шийдэгдсэн бүтээлүүдийг цаасан хэлбэрээс хөрвүүлэн ISSUU, Flip PDF Professional програмыг ашиглан тодорхой хамгаалалтайгаар бүрэн эхээр нь оруулж, баяжилт хийж уншигчдад хүргэж байна. <http://www.must-library.edu.mn/gnews/19>

ШУТИС-д магистр, докторын зэрэг хамгаалж буй эрдэмтэн, судлаачдын судалгаа, шинжилгээний (диссертаци, магистрын бүтээл) ажлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэж номын сангийн веб сайтыг “Судалгааны сан” цонхонд (<http://www.must-library.edu.mn/page/show/id/395>) нээлттэй байрлуулсан. Тус санд 380 орчим судалгааны ажлын товч агуулгыг оруулсан бөгөөд тогтмол баяжуулан ажиллаж байна.

Мэдээллийн сангуудыг ашигласан байдал:

Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн 20 орчим олон улсын мэдээллийн сангийн эрхийг авч судлаачдын хүртээл болгож байна. Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалт, статистик, татгалзлын судалгааг тогтмол гарган үр дүнгээс хамаарч цаашид ямар төрлийн мэдээллийн сан эрэлт хэрэгцээтэй байгаад дүгнэлт хийж, тухайн салбарын мэдээллийн сангийн эрх авах, е-номын захиалгад тусган ажиллаж байна.

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн номын санд өөрийн санхүүжилтээр 1, БСШУЯ-ны санхүүжилтээр 2, Монголын номын сангуудын консорциумын гишүүнчлэлээр 10 гаруй олон улсын мэдээллийн сангаар үйлчилгээ үзүүлж байна.


ОУ-ын SPRINGER NATURE мэдээллийн сангийн татгалзал, профессор багш нараас авсан судалгааны үр дүнд тулгуулан EBSCO мэдээллийн сангийн Energy & Power Source, Applied Science & Technology Source Ultimate, Engineering Source, Computers & Applied Sciences Complete багцуудын эрхийг 2 дахь жилдээ авч профессор, багш, судлаачдад сургалт явуулж, мэдээллийн сангийн QR Code ашиглалтын зөвлөмж болон хандалтын статистик мэдээг тухай бүр вэбсайт, нийгмийн сүлжээний хэрэгслээр хүргэж байна.

EBSCO мэдээллийн сангийн хандалтын судалгаа

Хүснэгт 6.3


Platform	User Activity	Reporting Period Total	Oct-2018	Nov-2018	Dec-2018	Jan-2019	Feb-2019	Mar-2019	Apr-2019	May-2019
EBSCOhost	Regular Searches	9997	885	1253	1238	1631	1222	1280	1601	887

EBSCOhost	Database Sessions	3112	409	394	380	404	371	382	374	398
EBSCOhost	Full-Text Requests	1392	179	178	270	274	110	98	138	145



Зураг 6.8. EBSCO мэдээллийн сангийн хандалтын судалгааны хураамж

БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн газрын санхүүжилтээр олон улсын Springer Nature мэдээллийн сангийн (<https://link.springer.com/>) 1997 оноос хойших 2,409 гаруй эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүлийг профессор багш нар судалгаа шинжилгээний ажилдаа идэвхтэй ашиглаж байна.




Зураг 6.9. Олон улсын Springer Nature мэдээллийн сангийн хандалт

*Springer Nature мэдээллийн
сангийн хандалтын судалгаа*

Хүснэгт 6.4

Сэтгүүл	Материалын төрөл		2019				
	HTML	PDF	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
Нийт хандалтын тоо	632	976	224	343	418	443	181

22,000 орчим мэргэжлийн сэтгүүлийг нэгтгэсэн SCOPUS мэдээллийн сангаас ШУТИС-ийн багш нарын бүтээлийн хэвлэгдсэн өгүүллийн тоо, тэдгээрийн эшлэгдсэн байдлыг тоймлон дараах байдлаар үзүүлж байна.



Зураг 6.10. ШУТИС-ийн профессор багш, судлаачдын Scopus мэдээллийн санд бүртгэгдсэн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, эшлэгдсэн байдал

СОЁЛЫН ХӨТӨЛБӨРТ АЖЛУУД

Тус хичээлийн жилийн эхэнд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг уламжлал ёсоор зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд гадаадын хэвлэлийн газруудын болон профессор багш нарын техник технологийн шинэ номын үзэсгэлэн, худалдааг зохион явуулж, ерөнхий эрдмийн болон мэргэжлийн 780 орчим ном, сурах бичиг, гадаадаас захиалсан сургалт, судалгааны 330 гаруй цахим ном, сэтгүүлийн үзэсгэлэн гаргаж, элсэгч оюутнуудад зориулж номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулах сургалтыг ОСҮА-тай хамтран зохион байгууллаа.

Монголын соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан номын санч мэдээллийн ажилтнуудын дунд “Номын сан сургалт судалгааны орчин болох нь” эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион явууллаа. Тус арга хэмжээнд ШУТИС-ийн Төв, бүрэлдэхүүн болон орон нутгийн сургуулийн 40 гаруй номын санч-мэдээллийн ажилтнууд оролцсон. Тус эрдэм шинжилгээний хуралд “Их дээд сургуулийн номын сан сургалт, судалгааны орчин болох нь”,

Номын сан судалгааны орчин, бүтээлч санаачилгыг дэмжих нь”, “Lib4u програмын нэмэлт боломжийг ашиглах” сэдвээр илтгэлүүдийг тус тус хэлэлцүүлсэн.

2018/19 оны хичээлийн жилд Дэлхийн номын өдөр-2019 арга хэмжээг зохион байгуулж Ардын уран зохиолч, СГЗ Т.Галсантай “Зохиогч-уншигчийн уулзалт”, оюутан залуусын авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор оюутны соёл үйлчилгээний албатай хамтран “Оюутан нас” яруу найргийн уралдаан, профессор багш нарын бүтээлийг таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд номын нээлт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ШУТИС-ийн БАТЛАМЖ олгов.

ШУТИС-ийн хамт олноо манлайлан, үр бүтээлтэй ажилласан номын санчид БСШУСЯ-ны “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Жуух бичиг”-ээр шагнагдлаа.





ДОЛООДУГААР БҮЛЭГ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ


ШУТИС-ИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

7.1. ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ШУТИС-ийн захирлын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн тушаалаар Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албыг албаны дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний 3 орон тоотойгоор байгуулж, албаны үндсэн чиг үүргийг тодорхойлж 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан Хяналт, шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирлаар батлуулсан.

Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний албаны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлыг 2018-2019 оны хичээлийн жилд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажил явагдаж байна.



Зураг 7.1. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015

Бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажлыг “ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн тайлан”-д оруулсан билээ.

Эхлүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна.

Ажлын хэсгийг шинэчлэн 26 хүний бүрэлдэхүүнтэй Захиргаа болон бүрэлдэхүүн сургуулийн төлөөллийг оролцуулан байгуулж, ШУТИС-д чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө болон төсвийг ШУТИС-ийн Захирлын 2019 оны 02 сарын 19-ний А/44 тоот тушаалаар батлуулсан.

ISO 9001 стандартын шаардлагаар дараах ажлууд хийгдсэн. Дугаарлалт нь стандартын бүлэг болно. Үүнд:

7.1.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

ШУТИС-ийн төлөв байдлыг ойлгохын тулд бидний зорьсон үр дүн, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг тодорхойлж, түүнд SWOT шинжилгээний аргаар дүн шинжилгээ хийсэн.

Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг ойлгох

ШУТИС-д хамаарах сонирхогч талуудыг тодорхойлж, тэдэнд хамаарах мэдээлэл, шаардлагад дүн шинжилгээ хийсэн.

	БАГА СОНИРХОЛ	ИХ СОНИРХОЛ	
ИХ НӨЛӨӨ	<u>ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ</u> Бусад ажилтан Суралцагч Зөвлөх профессор, ахмад багш /500-аад хүн байна/ Гэрээт ажилтан Эцэг эх, асран халамжлагч Банк, санхүүгийн байгууллага Төгсөгчдийн холбоо	<u>ГОЛ ТОГЛОГЧ</u> БСШУЯ, Удирдах зөвлөл Их сургуулийн удирдлагууд Багш нар Хөдөлмөрийн зах зээл Хамтарсан төсөл, гэрээт ажил хэрэгжүүлдэг байгууллага Сургалтын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллага ШУТИС-ийн оюутны холбоо Өрсөлдөгчид Зорилгот бүлэг /ЕБСургуулийн суралцагчид ба Мэргэших сонирхолтой хүмүүс/ Үйлдвэрчний эвлэл Оюутныг дадлага хийлгэдэг байгууллага	ИХ НӨЛӨӨ
БАГА НӨЛӨӨ	<u>ЧУХАЛ БИШ</u> Сайн дурын ажилтан Шүүх, цагдаагийн байгууллага	<u>АНХААРАЛДАА АВАХ</u> Гадаад, дотоодын магадлан байгууллага Баталгаажуулалтын байгууллага Бусад төрийн захиргааны байгууллагууд	БАГА НӨЛӨӨ
	БАГА СОНИРХОЛ	ИХ СОНИРХОЛ	

Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц


ШУТИС-ийн хэмжээнд байнга давтагддаг, чиг үүрэгт тусгасан үйл ажиллагаануудаар үйл явцыг тодорхойлж, тус бүрт зураглал хийсэн. Одоогоор нийт 143 үйл явцыг тодорхойлсон байна.

Үйл явц тус бүрийн алхмуудыг нарийвчлан тодорхойлж зураглал хийсэн. Уг үйл явцын зураглал нь оролт, үйл явц, гаралт, оролцоо гэх 4 баганаар илэрхийлэгдсэн. Тухайн үйл явцад үндсэн эсвэл туслах үүргээр оролцож, үр дүн гаргаж буй ажилтан буюу нэгжүүдийн оролцоог тэмдэглэхдээ RACI товчлолыг ашиглана.

RACI тайлбар:

- [R] responsibility - Хариуцан хийж, гүйцэтгэх;
- [A] accountability - Тухайн үйл явцад хариуцлага хүлээх, батлах;
- [C] consulted - Тухайн үйл явцын талаар харилцан зөвлөлдөх, оролцох, хамтрах;
- [I] informed - Үйл явцын талаар мэдээлэх;

Дээрх үйл явцуудад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “ШУТИС-ийн үйл явцын загвар”-ыг гаргасан.



Зураг 7.2. “ШУТИС-ийн үйл явцын загвар”

Чанарын бодлого боловсруулах, мэдээлэх

ШУТИС-ийн чанарын бодлого, чанарын зорилт болоод түүнд хүрэх төлөвлөгөө /ISO 9001-6.2/-г ШУТИС-ийн Захирлын 2019 оны 03 сарын 22-ны өдрийн А/70 тоот тушаалаар батлагдсан.

ЧАНАРЫН БОДЛОГО

“Олон улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлж, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох манлайлагчдыг бэлтгэдэг судалгааны их сургууль болно.”

ЧАНАРЫН ЗАРЧИМ

- Суралцагч, тэдний эцэг эх ажил олгогч, ажилтнуудын хүлээлт ба хэрэгцээнд төвлөрнө.
- ШУТИС-ийн бүх шатны нэгж дэх манлайлагчийн үнэт зүйл, загварыг бий болгож, хэвшүүлнэ.
- Их сургуулийн чанарын менежментийн тогтолцоонд хүн бүрийг оролцуулж, тэдний чадамжийг хөгжүүлнэ.
- Үйл ажиллагааг ойлгомжтой, харилцан уялдаатай (дэс дараалал) болгоход үйл явцын арга, хандлагыг ашиглана.
- Гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулна.
- Өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргана.
- Харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэнэ.
- Нийгмийн өмнө хариуцлагатай байна.
- Боловсролын бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй, эрх тэгш байлгана.
- Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.
- Боловсролын ёс зүйн хэм хэмжээг баримтална.

ЧАНАРЫН ЗОРИЛТ (2019-2021)

1. ШУТИС-ийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх
2. ШУТИС-ийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох
3. Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх
4. Хүний нөөцийн сургалт, хөгжлийг дэмжих
5. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг дээшлүүлэх
6. Харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

Мэдлэг ойлголт

ШУТИС-д нэвтрүүлж буй чанарын менежментийн тогтолцоог багш, ажилтнуудад ойлгуулах, мэдээлэх үүднээс ажлын хэсгээс гадна нийт 11 удаагийн давхардаагүй тоогоор **335** хүнд сургалт, семинар хийсэн байна. Үүнд:

2018.11.29 салбар, тэнхимийн эрхлэгч, дэд захирал, ЭНБД нар (ирц 90%)

2019.01.03 ШУТИС-Захиргааны ажилтнууд (ирц 80%)

2019.01.07 БАС нийт ажилтнууд

2019.02.20 ШУТИС-Захирлууд (ирц 80%)

2019.03.11 БуХС, БАС, ХШУС дэмжих баг (ирц 75%)

2019.03.11 ШУТИС-Газар, албадын дарга нар (ирц 30%)

2019.04.01-04.05 Нийт бүрэлдэхүүн сургуулиуд дээр байгуулсан дэмжих багийн гишүүд (ирц 90%)

Баримтжуулсан мэдээлэл

ШУТИС-ийн үйл ажиллагаанд ашиглагдах, хөтлөгдөх баримт бичиг болох бодлого, дүрэм, журам, заавар, маягтын агуулга, бүтэц, хэв загварыг ижилтгэж үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах, журамлах зорилгоор дараах журмыг боловсруулж, ШУТИС-ийн Захирлын 2019 оны 05 сарын 31-ний А/129 тоот тушаалаар **ШУТИС-БМ-ЖУ01** кодтой “ШУТИС-ийн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журам”-ыг батлуулсан. Журмыг хэрэгжүүлж, мөрдүүлэх ажлууд хийгдэж байна.

Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ

ШУТИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратеги чиглэл болон удирдлагын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж үнэлэх, үл тохирлыг залруулах ажлыг зохион байгуулах зорилгоор дараах журмыг боловсруулж, ШУТИС-ийн Захирлын 2019 оны 05 сарын 31-ний А/129 тоот тушаалаар **ШУТИС-ЧХ-ЖУ01** кодтой “ШУТИС-ийн үйл ажиллагаанд чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг батлуулсан. Журмыг хэрэгжүүлж, мөрдүүлэх ажлууд хийгдэж байна.

7.2. ДОТООД АУДИТ

ШУТИС-д ЧМТ нэвтрүүлэх ажлын хэсгээс эхний ээлжид 15 гишүүнийг сонгож Дотоод аудиторын эрх авхуулах, туршлага судлах, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Эдгээр 15 хүн БНХАУ, Өмнөд Солонгос, Энэтхэг улсуудад суралцаж, амжилттай төгсөн, олон улсын эрхтэй Аудиторын гэрчилгээг авч чадсан.



Зураг 7.3. Дотоод аудит хийх үе шатууд



Зураг 7.4. Аудиторын гэрчилгээ

Аудиторын эрх авсан гишүүд нь дотооддоо сургалт, танилцуулга хийж “ШУТИС-д ЧМТ-ны дотоод аудит” хийх бэлтгэл ажлыг хангаж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2018 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилт хагас жилийн хугацаанд дараах арга хэмжээг авч ажиллаа. Тухайлбал:

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, захиргаа, санхүүгийн үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй явуулах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран 2019 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2019 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан багш оюутнуудад авлигын хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаарх мэдээллийг түгээх ажлын хүрээнд сургуулийн профессор багш, ажилтан, оюутан суралцагчдад авлигын эсрэг хууль, тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг сургуулийн дотоод сүлжээ, мэдээллийн самбар, нийт профессор багш ажилтан ажилчдын хурал, цуглаан, захирлын зөвлөлийн хурал зэргээр дамжуулан мэдээлэл өгч ажилласан.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвөөс 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулсан нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын үйл ажиллагаанд ШУТИС-ийн 68 албан тушаалтныг хамруулсан.



Зураг 7.5. Нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын үйл ажиллагаанд хамрагдав.

Авлигатай тэмцэх газраас 4 төрлийн сурталчилгааны зурагт хуудас /шударга нийгмийн төлөө хамтдаа, мэдүүлэг гаргагч танд, ХАСХОМ, Албан тушаалтан/ авч бүрэлдэхүүн 14 сургууль, 4 хүрээлэнд тарааж, багш оюутнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах энэ талаарх мэдээллийг түгээх ажлыг зохион байгууллаа.

Сургуулийн цахим хуудсанд Авлигатай тэмцэх газрын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмын холбогдох баннерыг байрлуулсан. Мөн түүнчлэн Авлигатай тэмцэх газраас өгсөн үүргийн дагуу ХАСУМ, ХАСХОМ, Ашиг сонирхлын зөрчил гэсэн 3 төрлийн видео шторкийг сургуулийнхаа цахим хуудсанд байрлуулсан.

7.2.1. Мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажил

ШУТИС-ийн хэмжээнд 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2019 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тайлант жилийн 2 дугаар сарын 15-ны дотор /хуулийн хугацаанд/ сургуулийн мэдүүлэг гаргагч 68 албан тушаалтнуудын 2018 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргаж, мэдүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж, 100% хамруулсан. Улмаар хуулийн хугацаанд багтааж 2018 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайланг гарган Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан Спортын Яаманд хүргүүлсэн. 2018 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаагүй, хууль зөрчсөн асуудал гараагүй. Он гарснаар шинээр удирдах албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 9 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/, материалыг АТГ-аар хянуулах ажлыг зохион байгуулж, холбогдох дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж, томилогдсноос хойш хуулийн хугацаанд багтаан дээрх албан тушаалтнуудын 2018 оны ХАСХОМ-ыг гаргуулах ажлыг зохион байгуулсан. 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт шалгалт хийх, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон ажилтан ажилчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 40 мэдэгдлийг сургуулийн ЭБАТ-д хүлээн авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэж байна. 2018 оны мэдүүлэг, мэдэгдэл цаасан сууриар болон мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүрэн бүртгэгдэн хууль, журмын дагуу хадгалагдаж байна. Мөн 2018 оны ЭБАТ-ын бүртгэлүүд цаасан болон цахим системийн бүртгэлүүд бүрэн хийгдсэн болно.

Байгууллагын ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой оюутан суралцагч, иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор www.must.edu.mn нэр дээр сургуулийн цахим хуудсыг байршуулан ажиллуулж байгаа бөгөөд сургуулийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, цаг үеийн мэдээ мэдээлэл, зохион байгуулж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг оруулж тогтмол баяжуулан ажиллаж байна.

ШУТИС-ийн удирдлагаас гаргаж байгаа шийдвэрийн ил тод байдлыг хангах зорилгоор Удирдах зөвлөлийн болон Захирлын зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын тов, хурлын тэмдэглэлээс сургуулийн цахим хуудсанд байршуулж, профессор багш, оюутан суралцагчдад танилцуулсан болно.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2019 оны төсөв санхүүгийн мэдээлэл, 2018/2019 оны сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг тогтоосон Удирдах зөвлөлийн тогтоол, 2019 оны орлого зарлагын төсөв, ШУТИС-ийн 2019 онд бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, Төсвийн орлого, зарлагын 2019 оны сар бүрийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж хэвшсэн бөгөөд Шилэн данс цэсийг сургуулийн цахим хуудсанд шинээр бий болгон холбогдох мэдээллээр баяжуулан ил тод мэдээлж байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим хуудсанд нээлттэйг байршуулсан. ШУТИС-ийн хэмжээнд 2019 оны эхний хагас жилийн хугацаанд төрийн болон өөрийн хөрөнгөөр нийт 8 удаа бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд үүнээс 1 худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулж, урилга тендерийн зар, мэдээллийг Өнөөдөр, Өдрийн сонин, сургуулийн цахим хуудасны

шилэн данс цэсэд байршуулан тавьж олон нийтэд мэдээлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтын дагуу үнэлгээний хорооны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөллийг оролцуулж хамтран ажилласан.

Худалдан авах ажиллагааны цахим системд батлагдсан төлөвлөгөөг оруулж, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам, Сангийн ямаар батлуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсгийн гишүүд 6 удаа мэргэжил арга зүйн сургалтад хамрагдсан байна. Үүнд:

6 сигма - PMI institute

Dacum analysis буюу ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх арга - Observe consulting

Процессын сайжруулалт - Гүйцэтгэлийн төгөлдөршилд ХХК

Blended learning буюу холимог сургалтын арга – БСШУЯ-наас зохион байгуулсан.

ISO 21001:2018 стандартыг хэрэгжүүлэх болон дотоод аудитор - Энэтхэг улс, Мумбай, IRCLASS company

ISO 9001:2015 стандартын дотоод аудитор – БНХАУ, Бээжин, SGS company

Мөн бид дотоодын ISO 9001 нэвтрүүлсэн байгууллагатай танилцах, туршлага судлах аяллыг зохион байгуулсан.



Зураг 7.4. ТТАХаагчийн "Ногоон эмнэлэг"



Зураг 7.5. "Орчлон international school" танилцах үйл ажиллагаа

ШУТИС-ийн оюутны дотуур байрны үйл ажиллагаанд хийсэн хяналт, үнэлгээ

ШУТИС-ийн оюутны I, III, IV, V дотуур байрны үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, хууль, журам, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг гаргаж, оюутны амьдрах нөхцөл сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээний санал боловсруулсан. Санал дүгнэлт:

7.2 ШУТИС-ИЙН ДОТООД АУДИТ

Дотоод аудитын алба нь Монгол улсын төсвийн тухай хууль, ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” ШУТИС-ийн ректорын 2009 оны “ШУТИС-ийн дотоод хяналт шалгалтын журам”, “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ын хүрээнд аудитын ажлыг гүйцэтгэж байна.

Хяналт шалгалтын ажлын талаар

ШУТИС-ийн удирдлагын өгсөн үүрэг, 2018 онд төлөвлөгөөний дагуу 2018 оны сүүлийн хагас жилд Барилга архитектурын сургууль, Ой модны сургалт судалгааны хүрээлэн, Коосэн технологийн коллежийн санхүүгийн ерөнхий байдал, хүндрэлд орж байгаа шалтгаан, нийтлэг гарч байгаа зөрчлүүдийг илрүүлэх зорилгоор сүүлийн 2-3 жилийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж холбогдох зөвлөмж зааврыг тухай бүрд нь өгч ажилласан.

2018 онд бүрэлдэхүүн сургуулиуд болон ОМСС-ны хүрээлэнд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, санхүү нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, төсөл гэрээт ажил, сургалтын төлбөр, профессор багш нарын ажлын гүйцэтгэл гэсэн зургаан чиглэлд удирдамж гарган дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Дотоод аудитын шалгалтын үр дүнгийн тайлан, цаашид сайжруулах зөвлөмжийг сургуулийн удирдлагуудад танилцуулан зөвлөмжийг сургуулийн удирдлагууд болон санхүүгийн ажилтнуудад өгч тухай бүрд нь танилцуулав.

2019 оны эхний хагас жилд Ой модны сургалт судалгааны хүрээлэн, Коосэн технологийн коллеж, МХТС-ийн 2017-2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж үр дүнг ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар танилцуулахад бэлтгэв.

Дотоод аудитын үр дүнгээр БАС, Ой модны сургалт судалгааны хүрээлэн, Коосэн технологийн коллеж, МХТС-д Нягтлан бодох бүртгэл тайлагнал, Үндсэн хөрөнгө, бараа материал, Худалдан авалттай холбоотой, Төсөл гэрээт ажил -11 зөвлөмж, профессор багш нарын ажлын гүйцэтгэлээр зөвлөмж өгч ажиллалаа.

Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн талаар

ШУТИС-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.6-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилт, шимтгэл төлөлтийг бодитой гаргах, төслийн үр дүнгийн хэрэгжилтийг сайжруулах” ажлын хүрээнд БАС-ийн 2016-2017 оны хооронд хэрэгжсэн 4 төсөл, 9 төвийн 350.7 сая төгрөгийн төсөл гэрээт ажил, ОМССХ-ийн 2017-2018 оны хооронд хэрэгжсэн 233.8 сая төгрөгийн 15 төсөл, гэрээт ажил, Мэдээлэл холбоо технологийн сургуулийн 2017 оны 16 төслийн, 2018 онд 23 төсөл гэрээт ажлын санхүүжилт зарцуулалтад, шалгалт хийж үр дүнг тооцож цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулав.

ШУТИС-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Авлага өр төлбөрийг бууруулах” чиглэлээр санхүү нягтлан бодох бүртгэлийн албатай хамтран бүрэлдэхүүн сургууль салбар

нэгжүүдийн санхүүгийн тайлан балансаа бүртгэлтэй авлага өр төлбөрийг бууруулах удирдамжийн дагуу ажлын явцыг хэлэлцүүлж дүгнэлт зөвлөмж өгсөн.

ШУТИС-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.2-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийгдэх “Оюутны үйлчилгээг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” чиглэлээр оюутны 1-р байрны төлбөр, ашиглалтын байдалд шалгалт явуулж дүгнэлт зөвлөмжийг өгсөн.

Төлөвлөгөөний тусгай ажил үйлчилгээний хэсэгт тусгагдсан ажлын дагуу бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн ажилтнуудад бүрэлдэхүүн сургуулиудад гарч байгаа нийтлэг алдаа, зөрчил дутагдлын талаар 2 удаа мэдээлэл хийж цаашид анхаарах зөвлөмжийг өгөв.

7.3. МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд их сургуулийн сургалт судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд танилцуулан сурталчлах, байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны хамрах хүрээг дотоод, гадаадад тэлэх, байнгын болон зорилтот хэрэглэгчийг сэдэлжүүлэх зорилгоор 5 чиглэлээр ажиллав. Эдгээр ажлуудыг маркетингийн идэвхжүүлэлтийн иж бүрдэл арга хэрэгслүүдийг ашиглан гүйцэтгэсэн болно.

ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдрүүд

Тус хичээлийн жилд ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, их сургуулийн үйл ажиллагааг сурталчлах, бүх шатны сургалтын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явууллаа.

- “ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдөр”-ЕБС-ийн нийгмийн ажилтанд зориулсан
- “Ирээдүйн мэргэжилтэн-ШУТИС-ийн Оролцоо”-ЕБС-ийн сургуулиуд дээр очиж ажиллах
- “ШУТИС-ТУР”-их сургуулийн сургалтын орчинд сурагчдыг хүлээн авах
- “Боловсролын үзэсгэлэн яармаг”-олон нийтийг хамарсан боловсролын үзэсгэлэнд оролцох

“ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ

Нийслэлийн Боловсролын Газартай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, багш нарын дунд “ШУТИС-ийн Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2018 оны 11 дүгээр сарын 13-нд зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь ЕБС-ийн нийгмийн ажилтан, багш нарын оролцоотойгоор сурагч бүр өөрсдийн хэрэгцээ, сонирхолд тулгуурлан ирээдүйн мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх, адил тэгш боломжоор хангах, хүртээмжтэй мэдээлэл өгөх, бүх шатны боловсролын байгууллагын уян хатан хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдэв.



Зураг 7.6. ЕБС-ийн нийгмийн ажилтан багш нарын уулзалт

ШУТИС-ийн СХБА-ны дарга Д.Батдорж их сургуулийн сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөр, мэргэжлүүдийн талаарх мэдээллийг хүргэсэн бол Е-нээлтэй институтын захирал Я.Наранцэцэг “Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх веб хуудас”, MeTC-ийн салбарын эрхлэгч Д.Ганбат “Сургалтад дижитал педагог нэвтрүүлж буй туршлага, боломж”-ийн талаар танилцуулав.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, сургалтын албаны ажилтнууд сургалт, судалгааны орчин, сургалтын үйл ажиллагааг, оюутны клубүүд өөрсдийн хийсэн бүтээлүүдээ танилцуулав.



Зураг 7.7.ЕБС-ийн нийгмийн ажилтан багш нар ШУТИС-ийн оюутны бүтээлүүдтэй танилцаж байна

Тус арга хэмжээний үеэр нийслэлийн 1, 2, 11, 16, 17, 21, 25, 31, 33, 40, 44, 55, 59, 85, 87, 97, 111, 114, 115, 120, 132, 133, “Кингс Кидс”, “Төгс дэлгэрэх”, “Шилдэг” зэрэг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд цаашид хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа мөн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ШУТИС-ийн удирдлага, хамт олонд талархаж буйгаа илэрхийлсэн юм. Маркетинг, олон нийттэй харилцах алба нь тус арга хэмжээг зохион байгуулснаар ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллах хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Тус арга хэмжээний үр дүнд доорх чиглэлээр хамтран ажиллахаар болсон. Үүнд:

- 9-12 ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг “Нийгмийн ажилтны цаг” хичээлийн хүрээнд зохион байгуулах;
- Төгсөх ангийн эцэг, эхийн уулзалт зохион байгуулж сургалтын хөтөлбөр, мэргэжлийн талаар танилцуулга хийх;

- Сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;
- ЕБС-иудад ажиллаж байгаа мэргэжлийн бус нийгмийн ажилтанд мэргэшүүлэх чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;
- ШУТИС-КООСЭН сургуулийн электроникийн дугуйланг үргэлжлүүлэн ЕБС-д ажиллуулах г.м.

“ИРЭЭДҮЙН МЭРГЭЖИЛТЭН -ШУТИС-ИЙН ОРОЛЦОО”

2018-2019 оны хичээлийн жилд Маркетинг, олон нийттэй харилцах алба нь Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчидтай уулзалт, сургалт зохион байгуулан урьдчилан боловсруулсан график төлөвлөгөөний дагуу ажилласан юм. Мөн нийслэл хотын алслагдмал бүс болох Сонгино-Хайрхан дүүргийн Өлзийт хороолол, Шувуун фабрик, Баянхошуу дахь ерөнхий боловсролын сургуулиудад ажилласан болно.

Уулзалт семинарын чиглэл:

Их сургуулийн видео танилцуулга


Их сургуулийн сургалтын хөтөлбөр, мэргэжлийн танилцуулга

Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх web хуудасны танилцуулга

Сургалтын тодорхой хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулга

Нийслэлийн “Төгсдэлгэрэх”, “Шилдэг”, “Орчлон”, “Баянзүрх” цогцолбор сургууль, Өлзийт хорооллын 59 сургууль, Шувуун Фабрикийн 26, 10 сургууль, Сонгино-Хайрхан дүүргийн алслагдмал сургуулиуд болох 122, 123 сургууль, 17, 115, 59, 55, 21, 133, 111, 11, 44, 21, 33, 15, 87, 16, 132 сургуулийн 9-12 ангийн 1000 гаруй сурагчдад ШУТИС-ийн сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааны талаар танилцууллаа.

ШУТИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛАХ АЖЛЫН ГРАФИК



ХӨТӨЛБӨР

1. Их сургуулийн сургалтын танилцуулга видеонууд
2. “Их сургуулийн сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөр, мэргэжлүүд” танилцуулга
“Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх web хуудас” танилцуулга
Сургалтын хөтөлбөр бүртгэлийн алба
Маркетинг, олон нийттэй харилцах алба
3. Сургалтын хөтөлбөр, мэргэжлийн танилцуулга
Бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш нар
4. Чөлөөт ярилцлага

Жич: Тус хөтөлбөрийн хүрээнд нарийвчилсан сургалтын хөтөлбөрөө танилцуулах хүсэлтэй салбарын эрхлэгч, багш нар Маркетинг, олон нийттэй харилцах албанд бүртгүүлнэ үү. Холбоо барих: 2224

Зураг 7.8. ЕБС-иуд дээр ажиллах ажлын график

Тус арга хэмжээнд ШУТИС-ийн СХБА, ХШУС, ЭХС, БУХС-ийн Технологийн менежментийн салбарын багш нар, Геологи, эрдэс баялгийн музейн хамт олон, БАС-ийн “Аравт” клубын оюутнууд хамтран ажилласан юм.

Мөн тус ажлын хүрээнд хөдөө орон нутгийн сурагчтай уулзах уулзалтуудыг зохион байгуулж Хөвсгөл, Булган аймгууд, Эрдэнэ хотод биечлэн ажиллаж, нийт 21 аймагт мэргэжил сурталчлах чиглэлээр ажилласан багш нарт сурталчилгааны материал бэлтгэн өгсөн болно.

Эрдэнэт хот, Булган аймаг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй оюутан, залуучууд, хүүхэд багачуудад эерэг хандлага, зөв хүмүүжил, төлөвшил олгох зорилготой “Эерэг хандлага, хөгжил 2019” төслийн багийнхантай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, хүртээмжтэй мэдээлэл өгөх, ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг танилцуулах зорилгоор 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Булган, Орхон аймагт ажилласан.



Зураг 7.9. Эрдэнэт хот, Булган аймгийн сурагчидтай уулзсан уулзалтын үеэр

Хөвсгөл аймаг: 2019 оны 05 дугаар сарын 08-наас 12-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллаж ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл, видео сурталчилгаа, сургуулийн үйл ажиллагааны талаар РРТ-ийг дэлгэрэнгүй тайлбарлан өгч уулзалтад ирсэн сурагчдын сонирхсон асуултад хариулж ажилласан.



Зураг 7.10. ШУТИС-ийн хөтөлбөр, элсэгчдэд тавигдах шаардлагыг талаар танилцуулга хийв .



Мөн уулзалтын үеэр ирсэн сурагчдын дунд асуул хариултын тэмцээн явуулж амжилттай оролцсон 2 сурагчид ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль болох Үйлдвэрлэлийн сургуулийн суралцах урилгаар шагнав.

“ШУТИС-ТУР” АРГА ХЭМЖЭЭ

Тайлант хичээлийн жилд Маркетинг, олон нийттэй харилцах алба нь “ШУТИС ТУР” арга хэмжээг шинээр санаачлан зохион байгуулсан. Тус аялын зорилго нь их сургуулийн орчин үеийн сургалт, судалгааны орчныг сурагчдад танилцуулах, их сургуулийн хичээлийн явцтай биечлэн танилцах, хичээлд оролцож үзэх боломжийг бүрдүүлэх, суралцах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, улмаар инженер, технологийн мэргэжил сонгож ШУТИС-д суралцах хүсэл сонирхлыг төрүүлэх, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

“ШУТИС-ТУР” танилцах аялалд 2018-2019 оны хичээлийн жилд “Эрдмийн Ундраа” ахлах сургуулийн ахлах ангийн 150 сурагч, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын “Билиг” дунд сургуулийн 62 сурагч, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 41 сурагч, Нийслэлийн Төгс дэлгэрэх дунд сургуулийн 39 сурагч, 1 дүгээр сургуулийн 11, 12 ангийн 150 сурагч, 78-р сургуулийн 45 сурагч г.м хамрагдаад байна.

**ШУТИС-ийн НЭЭЛТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР
“ИРЭЭДҮЙН МЭРТЭЖИЛТЭЙ – БИЦВИЙ ОРОЛЦОО”**

Зорилго: Сурагч бүр өөрсдийн зарчлах, сонирхсон, гутгалын мэдлийг амжилтаар сонгогчид дамжжиг үзүүлж, адил тэгш боломжор энгэр, гуртэмтэй мэдээлэл өгч зорилготой.

Зохион байгуулагч: ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба

Хаяа: 2019 оны 01 сарын 13-н өдөр (Пүтэвч), 14:00-17:00 цаг

Хаяа: ШУТИС-ийн Хичээлийн I, II дугаар байр, ШУТИС

Оролцогч: Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 60 сурагч

Даруу тал: Орон явц цаг хугацааг өөр сонгогчид өөрөөр өөрсөдөө гуртэмтэй мэдээлэл бүх цагтайн боловсролын байгууллын үнэ цэнийг сайнхан амжилтаар

ХӨТӨЛБӨР		
Сэдэв	Байршил	
14.00-14.20	ШУТИС-ийн Видео танилцуулга Х.Отгон-Эрдэнэ, ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах албаны дарга, доктор (Ph.D)	Хичээлийн I байр, Эрдэмийн төлөөллийн өрөө 203
14.20-14.40	Их сургуулийн сургалтын үйл ажиллагаа, хичээл, мэргэжлүүд Д.Балдорж, ШУТИС-ийн Сургалтын хэлтэс бүрэлдэхүүн албааны дарга	Хичээлийн II байр, ТБ 34-42
14.45-14.55	Шинэчлэл тууш гичээлийн явцтай танилцах Э.Сонгоо, ШУТИС-ийн Албаан	Хичээлийн II байр, ТБ 34-42
15.00-15.30	Сургалт, судалгааны лабораторийн танилцуулга Г.Саран, ШУТИС-ийн Өдөр сайрагч, доктор (Ph.D), Өдөр сайрагч	Хичээлийн I байр, Т байр
16.00-16.10	Ялон Утсын их сургуулиар хамтарсан сургалтын хичээлийн танилцуулга А.Оюунбаатар, Сургалтын боллого, зохицуулалтын газар	Хичээлийн II байр
16.20-16.50	ХЭШ-ийн сургалт, судалгааны орчны танилцуулга Э.Пүрэвдорж, ХЭШ-ийн Өдөр сайрагч, доктор (Ph.D), Өдөр сайрагч	Хичээлийн II байр, Түрөөвсөр
17.00-17.30	Шинэчлэл тууш, илчлэлийн үнэ цэнийг сургуулийн төв нь шинэчлэл танилцах Э.Энхтүвшин, ШУТИС-ийн ШУТИС-ийн мэргэжлийн	ШУТИС-ийн байр

Холбоо барих утас: 99247798, 99148148

**ШУТИС-ийн НЭЭЛТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР
“ИРЭЭДҮЙН МЭРТЭЖИЛТЭЙ – БИЦВИЙ ОРОЛЦОО”**

Зорилго: Сурагч бүр өөрсдийн зарчлах, сонирхсон, гутгалын мэдлийг амжилтаар сонгогчид дамжжиг үзүүлж, адил тэгш боломжор энгэр, гуртэмтэй мэдээлэл өгч зорилготой.

Зохион байгуулагч: ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах алба

Хаяа: 2019 оны 02 дугаар сарын 22-н өдөр (Баян), 14:00-16:30 цаг

Хаяа: ШУТИС-ийн Хичээлийн I, II дугаар байр, ШУТИС

Оролцогч: Нийслэлийн “Эрдэмийн Ундраа” ахлах сургуулийн 100 сурагч

Даруу тал: Орон явц цаг хугацааг өөр сонгогчид өөрөөр өөрсөдөө гуртэмтэй мэдээлэл бүх цагтайн боловсролын байгууллын үнэ цэнийг сайнхан амжилтаар

ХӨТӨЛБӨР		
Сэдэв	Байршил	
14.00-14.20	ШУТИС-ийн видео танилцуулга Х.Отгон-Эрдэнэ, ШУТИС-ийн Маркетинг, олон нийттэй харилцах албаны дарга, доктор (Ph.D)	Хичээлийн I байр, Эрдэмийн төлөөллийн өрөө 203
14.20-14.30	“ХЭШ тууш” сэдэв мөргөлдүүд, “Ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” Д.Пүрэвдорж, ШУТИС-ийн Сургалтын боллого, зохицуулалтын албаан- дарга, доктор (Ph.D), Өдөр сайрагч	Хичээлийн II байр, ТБ 34-42
14.30-14.55	“Ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” гичээлийн явцтай танилцах Д.Энхтүвшин, ШУТИС-ийн Албаан	ШУТИС-ийн байр, ТБ 34-42
14.55-15.10	“Шинэчлэл тууш, илчлэлийн үнэ цэнийг сургуулийн төв нь шинэчлэл тууш танилцах” Э.Энхтүвшин, ШУТИС-ийн ШУТИС-ийн мэргэжлийн	ШУТИС-ийн байр, Түрөөвсөр
15.15-16.30	Сургалт, судалгааны лабораторийн танилцуулга Сурвалж, ирээдүйн оролцогч, зарим нэг дэвсгэрийн хэлтэс, судалгааны газар уураг, лаборатори, фотобанк, гичээлүүд Х.Халхуур, ХЭШ-ийн Өдөр сайрагч, доктор (Ph.D), Өдөр сайрагч	Хичээлийн II-20 байр
16.30-16.50	Ялон Утсын их сургуулиар хамтарсан сургалтын хичээлийн танилцуулга А.Оюунбаатар, Сургалтын боллого, зохицуулалтын газар	Хичээлийн II байр
16.50-17.30	Дураанын уураг	

Холбоо барих утас: 99247798, 99148148

Зураг 7.11. “ШУТИС-ТУР” танилцах аялалын удирдамж

2019 оны 3 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд “ШУТИС-ТУР” аялалд “Нийслэлийн шилдэг 100 сурагч” төсөлд хамрагдсан төгсөх ангийн 200 сурагч оролцож сургалтын үйл ажиллагаатай танилцлаа. Тус арга хэмжээний үеэр ХШУС-ийн багш М.Энхцэцэг өөрийн боловсруулан гаргасан “Математикийн элсэлтийн шалгалтын бодлого, тайлбар” гарын авлагаа сурагчдад дурсгаж, ЭЕШ-д хэрхэн бэлтгэх талаар үнэтэй зөвлөгөө өгсөн юм.



Зураг 7.12. “ШУТИС-ТУР” аяллын сурагчдад ХШУС-ийн багш М.Энхцэцэг боловсруулан гаргасан номоо бэлэглэв

Мөн тус төслийн хүрээнд ШУТИС-ийн танилцуулга материалыг хөдөө орон нутагт, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тараах ажлыг зохион байгуулсан.

МОНХА-наас “Миний төрөлх сургууль” челленжийг санаачлан, тус ажлыг эхлүүллээ. Эхний уулзалтаар Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, академич Х.Энхжаргал багшийн төгссөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг урьж “Миний төрөлх сургууль” уулзалтыг зохион байгуулсан юм. Тус арга хэмжээнд нийслэлийн 39 дүгээр сургуулийн 10, 11, 12 ангийн сурагчид оролцсон юм.




Зураг 7.13. “Миний төрөлх сургууль” арга хэмжээний үеэр

“БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГУУД

“Боловсролын шинэчлэл-2019” үзэсгэлэн яармаг 2019 оны 4 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд “Мишээл экспо төвд” зохион байгуулагдаж ШУТИС-ийн МОНХА нь СХБА-тай хамтран оролцлоо. Үзэсгэлэнгийн зорилго нь дээд боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, боловсролын бодлогын асуудлыг сурталчлах, боловсролын салбарын хөгжлийн түвшин,

өнөөгийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах юм. “Боловсролын шинэчлэл-2019” үзэсгэлэнд ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчид оролцсоноор нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлүүдийн талаар мэдээлэл авч, мэргэжлээ зөв сонгоход нь мэргэжлийн багш туслалцаа үзүүлсэн юм. Түүнчлэн их, дээд сургууль, коллежид элсэгчдэд шалгалтаа өгөх болон бүртгүүлэхэд нь шаардлагатай заавруудын талаар танилцуулах, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл өгсөн.



Зураг 7.13. “Боловсролын шинэчлэл-2019” үзэсгэлэнгийн үеэр

Үзэсгэлэнд ШУТИС-ийн СБЗГ, МОНХА, бүрэлдэхүүн сургуулиуд, Коосэн технологийн коллеж, ахлах сургууль оролцож эцэг, эх, сурагчдад өөрсдийн үйл ажиллагааг танилцууллаа. Тус үзэсгэлэнд төрийн болон хувийн хэвшлийн сургууль, МСҮТ болон гадаадын их дээд сургууль, сургалтын төв, сургалт судалгааны нийт 90 гаруй байгууллага оролцож өөрсдийн үйл ажиллагааг танилцуулах, сургалтын хөтөлбөр болон мэргэжил сурталчлах, танилцуулга тараах, урлагийн тоглолт гэх мэт элсэгчдэд зориулсан олон үйл ажиллагаа боллоо.

Монголын залуучуудын шинэ давлагаа төрийн бус байгууллагаас зохион байгуулсан “NEW EDUCATION EXPO” үзэсгэлэнд 2019 оны 6 дугаар сарын 8-наас 9-ний өдрүүдэд бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш нартай хамтран оролцож сургалтын хөтөлбөр, мэргэжлүүдээ ЕБС сургуулийн төгсөгчдөд танилцуулав.

ШУТИС-ийн сурталчилгааны контент бэлтгэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

ШУТИС-ийн сургалтын хөтөлбөр, оюутанд үзүүлэх үйлчилгээ, сургалтын орчин нөхцөлийн талаар хэрэглэгч, олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой сурталчилгааны контентыг сургалтын хөтөлбөр, сургалтын хамтарсан хөтөлбөр, сургалтын тэтгэлэг, сургалтын орчин, их сургуулийн бүтээн байгуулалт гэсэн чиглэлүүдээр бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.

1. Бүрэлдэхүүн сургууль, ШУТИС-КООСЭН технологийн коллежийн сургалтын хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн видео танилцуулга



ШУТИС-ийн оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн видео танилцуулга:



ШУТИС-ийн “Эрдэм шинжилгээ, инновацийн төв байр”-ны видео танилцуулга:



ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойд зориулсан “Мөнхөд дурсагдах гавьяа” баримтад кино:



Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр (сонин, телевиз, сайт г.м) дамжуулан сурталчлах арга замыг сонгон ажилласан бөгөөд олон хүнд нэг зэрэг хүрэх боломжтой, нэг сонсогч, үзэгч, уншигчдад ноогдох зардлын хэмжээ бага зэрэг давуу талтай байлаа. Тус ажлын хүрээнд мэдээллийн илгээлтийг бэлтгэхдээ 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлтийн үйл ажиллагаанд чиглүүлэн ШУТИС-ийн үйл ажиллагааны давуу талыг таниулах, нэр хөндийг өсгөх, тодорхой имижийг бүрдүүлэх, хоногшуулах гэсэн чиглэлээр ажилласан. Нийт бэлтгэсэн телевизийн мэдээ 91, үүнээс төлбөртэй 41, төлбөргүй 50 (EAGLE TV, TV9, TV5, NTV, UBS, MYONPT, Mongol HD TV, TV6, Боловсрол), телевизийн ярилцлагын нэвтрүүлэг 3, сонин, сэтгүүлийн ярилцлага 5, сайтын мэдээлэл, телевизийн цуврал нэвтрүүлэг 13 бэлтгэн хүргэсэн байна.

Телевизийн мэдээний жагсаалт /төлбөртэй мэдээ: 42/

Хүснэгт 7.3

№	Хэвлэлийн гарчиг	Нийтлэгдсэн төрөл	Байгууллага огноо	Яриа өгсөн хүмүүс	Оролцсон сургууль
1	Нэмэлт элсэлт авч байна	Мэдээ	EAGLE TV 2018-08-17	Д.Батдорж	ШУТИС-сургалтын алба
2	Нэмэлт элсэлт авч байна	Мэдээ	TV9 2018-08-17	Д.Батдорж	ШУТИС
3	Нэмэлт элсэлт мэргэжлийн танилцуулга	Гэгээн өглөө	TV5 2018-08-20	Сарнай П.Булга Ж.Хашбат	ХШУС ҮТС МТС
4	МеХТС-ийн автомашин засварын лабораторийн нээлт	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV мэдээ 2018-08-27	Ц.Цэвээнжав	МеХТС
5	ШУТИС-ийн Инженерийн бэлтгэл ангийн элсэлт авч байна	“Энэ Өдөр” мэдээллийн хөтөлбөр 19:30 цагт	TV9 мэдээ 2018-08-27	П.Булга Х.Энхжаргал	ХШУС ШУТИС-захиргаа
6	МеХТС-ийн автомашин засварын лабораторийн нээлт	Мэдээ	EAGLE TV	Ц.Цэвээнжав	МеХТС
7	Инженерийн бэлтгэл ангийн элсэлт авч байна	Танд тустай агшин Үгэн зар	UBS 2018-08-27-29	Мэдээ бэлтгэж өгсөн	ШУТИС

8	Инженерийн бэлтгэл ангийн элсэлт авч байна	Танд тустай агшин Үгэн зар	TV5 2018/08/30-09/03	Мэдээ бэлтгэж өгсөн	ШУТИС
10	Д.Мандал агсны эмгэнэл	Эмгэнэл	TV9 2018-08-30	Эмгэнэл бэлтгэж өгсөн	ШУТИС ЭХС
11	Хичээлийн шинэ жилийн нээлт, MeXTC-ийн лабораторийн нээлт	“Энэ Өдөр” мэдээллийн хөтөлбөр 19:30 цагт	TV9 2018-09-03	Б.Очирбат Д.Цолмонбаатар	ШУТИС MeXTC
12	Хичээлийн шинэ жилийн нээлт, MeXTC-ийн лабораторийн нээлт	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2018-09-03	Б.Очирбат Д.Цолмонбаатар	ШУТИС MeXTC
13	Монгол-Японы хамтарсан олон улсын уламжлалт 13 дахь удаагийн семинар	“Энэ Өдөр” мэдээллийн хөтөлбөр 19:30 цагт	TV9 2018-10-1	Ч.Мангалжалав	ШУТИС ЭХС
14	Монгол-Японы хамтарсан олон улсын уламжлалт 13 дахь удаагийн семинар	Мэдээ	TV5 2018-10-01	Ч.Мангалжалав	ШУТИС ЭХС
15	Коосэн технологийн коллежийн шинээр элссэн суралцагчдын тангараг өргөх ёслол	“Энэ Өдөр” мэдээллийн хөтөлбөр 19:30 цагт	TV9 2018-10-15	Ж.Арслан Макото Күрүсү	ШУТИС Коосэн
16	ШУТИС-ийн хөтөлбөр АВЕТ-р магадлан итгэмжлэгдэв.	Мэдээ	Eagle 2018-10-16	Ц.Цогзолмаа /Сайд/ Ж.Ариунболд	ШУТИС БСШУСЯ
17	ШУТИС-ийн хөтөлбөр АВЕТ-р магадлан итгэмжлэгдэв.	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2018-10-16	Б.Очирбат Ж.Ариунболд	ШУТИС БСШУСЯ
18	Коосэн загварын лабораторитой боллоо	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2018-10-23	Масато Такаока Б.Очирбат	ШУТИС
19	Ирээдүйн мэргэжилтэн-Бидний оролцоо Нээлттэй хаалганы өдөр	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2018-11-13	Х.Энхжаргал	ШУТИС
20	Цахилгаан хангамжийн CDIO лабораторийн нээлт	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2018-11-30	Ч.Мангалжалав MCS захирал	ШУТИС ЭХС
21	Антарктид судлал	Гэгээн өглөө нэвтрүүлэг	ТВ5 2018-12-03	Дүгэржав	ШУТИС ГУУС
22	ШУТИС-ийн 60 жилийн ойг угтан зохион байгуулж	MASS.TV.OFFICIAL/videos	Mass.mn 2018-11-05	Х.Энхжаргал О.Баатарзоригт	ШУТИС

	буй Оюутны спортын 6 төрөлт IV их наадмын нээлт				
23	ШУТИС ҮХГ-тай хамтран ажиллах гэрээ зурлаа	Мэдээ	EAGLE TV 2019-01-14	Б.Очирбат Б.Баярсайхан	ШУТИС
24	ШУТИС ҮХГ-тай хамтран ажиллах гэрээ зурлаа	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2019-01-14	Б.Очирбат Б.Баярсайхан	ШУТИС
25	ШУТИС ҮХГ-тай хамтран ажиллах гэрээ зурлаа	Мэдээ	TV5 2019-01-14	Б.Очирбат Б.Баярсайхан	ШУТИС
26	Төгсөгчдөд ажлын байр зуучлах “MUST-NETWORKING BREAKFAST” арга хэмжээ	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2019-01-22	Х.Энхжаргал Д.Цогзолмаа	ШУТИС
27	Төгсөгчдөд ажлын байр зуучлах “MUST-NETWORKING BREAKFAST” арга хэмжээ	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-01-22	Х.Энхжаргал Д.Цогзолмаа	ШУТИС
28	Газар хөдлөлтийн чичирхийлэлтэй уялдуулж тооцоолол хийж байна.	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-03-27	Э.Нинжгарав	ШУТИС БАС
29	FICASE-2019 ОУЭШХурал	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-04-05,06	Б.Очирбат Д.Ганхуяг	ШУТИС ХШУС
30	Ган гүүр тэмцээн	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2019-04-12		
31	Эрдмийн чуулган бүтээлийн үзэсгэлэн	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-04-17	Т.Намнан	ШУТИС
32	Дэлхийн номын өдөр	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-04-25	Ч.Гулнар	ШУТИС
33	Инновацийн 7 хоног	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-05-09	Т.Намнан	ШУТИС
34	Инновацийн 7 хоног	Мэдээний хөтөлбөр	NTV 2019-05-09	Т.Намнан	ШУТИС
35	Механик тээврийн сургалтын лаб нээлт	Мэдээ	TV5 2019-05-14	Б.Баярсүрэн	ШУТИС- Мехтс
36	Механик тээврийн сургалтын лаб нээлт	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2019-05-14	Ж.Цолмонбаатар	ШУТИС Мехтс
37	ШУТИС-60 гэрэл зургийн үзэсгэлэн	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-05-17	Х.Энхжаргал	ШУТИС
38	ШУТИС-60 гэрэл зургийн үзэсгэлэн	Мэдээний хөтөлбөр	NTV 2019-05-17	Л.Баяр-Эрдэнэ Ю.Болдбаатар	ШУТИС
39	ШУТИС-60 гэрэл зургийн үзэсгэлэн	Live мэдээ	Масс тв 2019-05-17	Б.Чулуун	ШУТИС
40	Ухаалаг эрчим хүч илтгэл	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-05-28	Б.Очирбат	ШУТИС- ЭХС

41	Ухаалаг эрчим хүч илтгэл	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV 2019-05-28	Б.Очирбат	ШУТИС-ЭХС
42	Ухаалаг эрчим хүч илтгэл	Мэдээ	TV5 2019-05-28	Б.Очирбат	ШУТИС-ЭХС

Төлбөргүй мэдээ: 50

Хүснэгт 7.4

№	Хэвлэлийн гарчиг	Нийтлэгдсэн төрөл	Байгууллага огноо	Яриа өгсөн	Оролцсон сургууль
1	ШУТИС-ийн дотуур байрны бүртгэл, төлбөрийн мэдээлэл	Мэдээний хөтөлбөр 20:00 цагт	NTV мэдээ 2018-08-23	Х.Оюунхишиг	ШУТИС Оюутны хөгжлийн алба
2	Хүндэт профессо, Профессор цол хүртлээ.	Цаг мэдээллийн хөтөлбөр	МҮОНРТ	Б.Очирбат Х.Бадамсүрэн Ж.Баатархүү	ШУТИС
3	Коосэн загварын лабораторитой боллоо.	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-10-23	Масато Такаока Б.Очирбат Ц.Байгалмаа	ШУТИС
4	ШУТИС-ийн коосэн политехник коллежийн төгсөгчид японд ажиллах урилга авав.	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-10-23	Ж.Арслан	ШУТИС Коосэн
5	Явган хүний гарц байгуулах нь зам тээврийн хөдөлгөөнд хэрхэн нөлөөлөх вэ?	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-10-25	Б.Болд	ШУТИС БАС
6	Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-11-05	А.Арвинбаяр	ШУТИС ҮТС
7	Антарктид судлал	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-11-28	Л.Дүгэржав	ШУТИС
8	Цахилгаан хангамжийн CDIO лабораторийн нээлт	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-11-30	Б.Сэргэлэн С.Эрдэнэ Д.Гэрэлт-Од	ШУТИС ЭХС
9	Эко машин	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-12-05	Б.Мөнгөнсар	ШУТИС ХХТГ
10	Хумсны лакны хор хөнөөл	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-14	Б.Өлзийдэлгэр	ШУТИС ХШУС
11	Сахарын хэрэглээ	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2018-12-17	Н.Сугар	ШУТИС ҮТС
12	Сав баглаа боодол бүтээгдэхүүнээсээ илүү өртөгтэй байна.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-18	Ж.Туяацэцэг	ШУТИС ҮТС
13	Монгол эрдэмтэд өөрсдөө өндөр үр дүнтэй технологи бий болголоо.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-20	Б.Лхагвадулам	ШУТИС БАС

14	Монгол залуусын бүтээсэн машин олон улсын тэмцээнд гуравдугаар байр эзэллээ.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-20	Д.Бадрах	ШУТИС MeTC
15	Худалдагчийн санал болгосон барилгын материал чанарын баталгаатай эсэхийг.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12	Б.Мөнхбаяр	ШУТИС БАС
16	Уух усаа үнэлэх, хамгаалах, зохицуулах боломж бидэнд бий.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12	С.Чулуунхуяг	ШУТИС БАС
17	Манай улсаас дэлхийд байдаггүй ховор эрдэнэс олддог.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12	Д.Чулуун	ШУТИС ГУУС
18	Нано инженерчлэлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж эхэллээ.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-25	Г.Батдэмбэрэл	ШУТИС ХШУС
19	Сэргээгдэх эрчим хүчний мэргэжил	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2018-12-25	П.Бямбацогт	ШУТИС ЭХС
20	Антарктид тивд судалгааны бааз ажиллана.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-01-17	Б.Очирбат Л.Дүгэржав	ШУТИС ГУУС
21	Төгсөгчдөд ажлын байр зуучлах “MUST-NETWORKING BREAKFAST” арга хэмжээ	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-01-22	Х.Энхжаргал Д.Цогзолмаа	ШУТИС ОСУА
22	1,5 гэсэн тэмдэглэгээтэй хуванцар савыг хүнсэндээ хэрэглэхэд аюулгүй.	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-08	М.Наранцэцэг	ШУТИС ХШУС
23	Автомашингаас ялгарах хорт утааны нөлөө /судалгаа/	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-15	Ж.Мягмаржав	ШУТИС MexTC
24	ШУТИС-ийн багш ажилчдын спортын наадам	Спорт мэдээ	МҮОНРТ 2019-01-19	М.Амаржаргал	ШУТИС ХШУС
25	ШУТИС барилгын салбарт шинэ технологи нэвтрүүлнэ	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-03-06	Ц.Сарантуяа	ШУТИС БАС
26	Газар хөдлөлтийн чичирхийлэлтэй уялдуулж тооцоолол хийж байна.	Мэдээ	Star TV 2019-03-27	Д.Дашжамц Р.А.Мангушив С.Нямдорж	ШУТИС БАС

27	Газар хөдлөлтийн чичирхийлэлтэй уялдуулж тооцоолол хийж байна.	Мэдээ	МҮОНРТ 2019-03-27	Д.Дашжамц А.Батсайхан Э.Ганзориг	ШУТИС БАС
28	Газар хөдлөлтийн чичирхийлэлтэй уялдуулж тооцоолол хийж байна.	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2019-03-27	Д.Дашжамц А.Батсайхан Э.Ганзориг	ШУТИС БАС
29	Газар хөдлөлтийн чичирхийлэлтэй уялдуулж тооцоолол хийж байна	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-03-27	Д.Дашжамц А.Батсайхан Э.Ганзориг	ШУТИС БАС
30	ШУТИС-ийн 81 дэх төгсөлт	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-01-23,24	Б.Очирбат Х.Энхжаргал	ШУТИС
31	ERASMUS-GREB “NGB center of Mongolia” сургалтын төвийн нээлт	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-20	Т.Намнан	ШУТИС
32	ШУТИС-ийн “Mongolian Geoscientist” ОУ-ын онлайн сэтгүүлийн нээлт	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-25		ШУТИС ГУУС
33	Эрдмийн чуулган-2019 ШУ-ны илтгэл	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-25	Х.Энхжаргал Д.Цогзолмаа	ШУТИС
34	Дэлхийн усны өдөр нээлттэй семинар	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-02-25	Н.Буянхишиг	ШУТИС ГУУС
35	Газар хөдлөлтийн инженерчлэл ба геотехникийн асуудал	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-03-13	Э.Нинжгарав Д.Дашжамц	ШУТИС БАС
36	Газар хөдлөлтийн инженерчлэл ба геотехникийн асуудал	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-03-13	Э.Нинжгарав Д.Дашжамц	ШУТИС БАС
37	Газар хөдлөлтийн инженерчлэл ба геотехникийн асуудал	Цагийн хүрд	МҮОНРТ 2019-03-13	Э.Нинжгарав Д.Дашжамц	ШУТИС БАС
38	4 сарын 1-ээс Япон улсад суралцах 98 оюутан батламжаа авлаа.	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-03-15	Б.Очирбат	ШУТИС
39	1000 инженер төслийнхөн МҮОНРТ хамтын ажиллагааны гэрээ байгуулав.	Цагийн хүрд	МҮОНРТ 2019-03-27	Б.Очирбат	ШУТИС
40	Ficase-2019 ОУЭШХурал	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-04-5,6	Б.Очирбат Д.Ганхуяг	ШУТИС ХШУС
41	Ficase-2019 ОУЭШХурал	Мэдээ	Боловсрол тв 2019-04-05,06	Б.Очирбат Д.Ганхуяг	ШУТИС ХШУС

42	Эрдмийн чуулган	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-04-17	Д.Цогзолмаа	ШУТИС
43	Эрдмийн чуулган бүтээлийн үзэсгэлэн	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-04-26	Тэнгис Билгүүн (оюутан)	ШУТИС
44	Эрдмийн чуулган бүтээлийн үзэсгэлэн	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2019-04-26	Тэнгис Билгүүн (оюутан)	ШУТИС
45	Дэлхийн номын өдөр	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-04-30		ШУТИС ШУТТНС
46	Инновацийн 7 хоног	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-05-6,13	Т.Намнан Оюунгэрэл	ШУТИС БУХС
47	ERASMUS GREB хурал	News 6 Мэдээллийн хөтөлбөр	TV6 2019-06-06	Сараа	ШУТИС БАС
48	Урт хугацааны хөгжлийн хөтөлбөр	Ийглийн мэдээ	EAGLE TV 2019-06-10	Б.Очирбат	ШУТИС
49	Хөрсний бохирдол ба гүний ус	Оргил мэдээллийн цаг	Mongol HD TV 2019-06-11	Б.Наранчимэг	ШУТИС ГУУС
50	Хэлэлцүүлэг	Мэргэжил сонголт			

Өдөр тутмын сонинд хэвлүүлсэн сонины ярилцлага
Хүснэгт 7.5

№	Сонин	Дугаар	Сэдэв	Холбогдох ажилтан	Зорилго
1	“EDUCATION” сэтгүүл	2019.03.23- №01 х.67-69	ШУТИС “QS university ranking asia”-д гишүүнээр элсэхээр бэлтгэж байна	Сургалт эрхэлсэн захирал Х.Энхжаргал	ШУТИС-ийн сургалт, судалгааны орчны мэдээлэл
2	“EDUCATION” сэтгүүл	2019.03.23- №01 х.70-77	ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрүүд	Д.Батдорж	ШУТИС-ийн сургалт, судалгааны орчны мэдээлэл
3	“Үндэсний тойм” сэтгүүл	2019.06.24 №25(414)	Эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдийн 95 хувийг манай сургууль бэлтгэн гаргаж байна.	Ч.Мангалжалав	ЭХС-ийн захирал
3	“Үндэсний тойм” сэтгүүл	2019.06.10 №23(412)	ШУТИС нано шинжлэх ухаан, инженерчлэлийн анги шинээр нээсэн	Г.Зоригт	ХШУС-ийн багш
4	“Нээлтэй хаалга” сонин	2018.08.31-9.7 №19(197)	Монголын металлургийн салбарын “дива”	М.Дэлгэрмаа	МТС-ийн профессор
5	“Нээлтэй хаалга” сонин	2018.10.26- 11.2 №41(219)	Боломж бүхэн байгаа бид зөв хандлагатай мэргэжилтэн бэлтгэх хэрэгтэй	Н.Эрдэнэхүү	МХТС-ийн дэд захирал

Сайт дээр гарсан мэдээ мэдээллийн жагсаалт

Хүснэгт 7.6

№	Огноо	Сайт/холбоос	Сэдэв
1	NER.MN 2018-06-26 20:34:22 GMT +8 / 43336 удаа уншсан	http://ner.mn/p/944	ШУТИС-ИЙН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ 2017 ОНЫ 07 ДУГААР САРЫН 1-НЭЭС ЭХЭЛНЭ
2	MONTSA ME.MN 2018-12-05 11:35:07	https://montsame.mn/mn/read/173384?fbclid=IwAR2o_u4srNJ0d8Sr92NX4-a8pWXyc36y9JO8LvZITK938Mf0xqNgTD5GTpk	ШУТИС хиймэл дагуул хөөргөнө.
3	MONTSA ME.MN 2019-04-12 17:41:57	https://montsame.mn/mn/read/186122?fbclid=IwAR2SP7_XDDKjtMcUJ6Hu5AxX XcUxn1BmmoC3-wouRGCU7nMbwKpIkXXxnOw	Хэрэглээний шинжлэх ухааны чиглэлээр олон улсын эрдэмтэд чуулав
4	NER.MN 2018-05-25 18:36:52 Уншигчийг тоо: 3691	https://montsame.mn/mn/read/192999	Монгол Улсын урт хугацааны бодлогыг боловсруулахад ШУТИС-ийн профессор, багш нарын саналыг тусгана.
5	N24	https://www.n24.mn/a/2601?fbclid=IwAR3iczQjJ-ar5mIY2_Vw5TUGoHGdEhPwN26owGU8cOpubFTzmS2q_jn5sUY	ШУТИС ирэх 30 жилд хамгийн их эрэлтэй байх мэргэжлүүдээр элсэлт авна.

“Эх сурвалж нэвтрүүлэг” - 11 удаа

Хүснэгт 7.7

№	Албан тушаал	Нэр	Ярилцах чиглэл
1	ҮТС-ийн захирал	Ж.Туяацэцэг	Хүнсний инженер
2	ХШУС-ийн захирал	Д.Ганхуяг	Математик загварчлал
4	БАС-ийн захирал	Э.Нинжгарав	Барилгын инженер
5	БУХС-ийн захирал	Д.Ганбаатар	Олон улсын бизнесийн менежмент
6	ГУУС-ийн профессор	Д.Энхбат	Геологи
7	МТС-ийн ЭНБ дарга	Н.Пүрэвдорж	Механик инженер
8	ГХС-ийн дэд захирал	Н.Энхбаатар	Хэл шинжлэл
9		Р.Төрбат	Мэдээллийн технологи
10	ЭХС-ийн захирал	Ч.Мангалжалав	Дулааны инженер
11	Дарханы ТС-ийн захирал	Ц.Батбаатар	Нанотехнологи
12	ММХТС-ийн дэд захирал	Н.Эрдэнэхүү	Мэдээллийн технологи

ШУТИС-ийн түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн

ШУТИС үүсэж байгуулагдсаны 60 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд их сургуулийн түүхэн он жилүүдийг тод томруун харуулах, үе үеийн профессор багш нарын сургалт, судалгааны ажлын үр дүн, ололт амжилтыг олон

нийтэд түгээн дэлгэрүүлэх, хамт олны найрсаг хамтын ажиллагаа, харилцааг төгөлдөршүүлэх, их сургуулийн соёлыг сурталчлах зорилготой гэрэл зургийн үзэсгэлэнг 2 шаттай тус тус зохион байгуулсан.

Үзэсгэлэн I: 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Үзэсгэлэн II: 2019 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр

Үзэсгэлэн I: ШУТИС-ийг үүсгэн байгуулсан 1959 оноос эхлэн 1999 оныг хүртэлх түүхэн үйл явдлыг харуулсан 60*80 хэмжээтэй 60 зураг, 40*60 хэмжээтэй 60 зураг нийт 120 зургийг бэлтгэн их сургуулийн нийт хамт олон, оюутан залуусад танилцуулж, EAGLE, NTV, “Эх түүхийн жимээр” нэвтрүүлэг, MASS TV-гээр шууд дамжуулан сурталчилсан.

Үзэсгэлэн II: ШУТИС-ийн 60 жилийн ойг тохиолдуулан 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 60*80 хэмжээтэй 100, 40*60 хэмжээтэй 100 гэрэл зураг нийт 200 зургийн үзэсгэлэн зохион байгуулсан.

Тус үзэсгэлэнгийн үр дүн:

Их сургуулийн профессор, багш, хамт олны гэрэл зургийн хальсанд буулгасан түүхэн үнэт бүтээлүүдийг нэгтгэн цуглуулж, сан үүсгэв. Их сургуулийн онцлог, хэв шинж, үзүүлж буй үйлчилгээ, сургалт, судалгааны орчныг гэрэл зургаар дамжуулан оюутан, сурагчид болон нийгэмд танилцуулсан. Их сургуулийн үе үеийн профессор багш нарийн сургалт, судалгааны ажлын үр дүнг гэрэл зургийн агшинд буулгасныг олон нийтэд хүргэсэн. Их сургуулийн үйл ажиллагаа, түүх, соёлыг гадаад, дотоодод сурталчилсан. ЕБС-ийн сурагчдад зориулсан “ШУТИС-ТУР” аялалд ашиглаж байна.

7.4. БАЙР АШИГЛАЛТ

Тайлангийн хугацаанд сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах ажил үйлчилгээг үзүүлэв.

Хичээлийн шинэ жил, өвөлжилтийн бэлтгэлийг хангах, зуны засвар тохижилтын ажлыг тодотгох ерөнхий үзлэг, шалгалтыг хийж төлөвлөгөө гарган, мөрдөн ажиллаа. Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, дүнг нэгтгэн илэрсэн доголдлыг засварлах ажлыг зохион байгууллаа. Тайлант онд хичээлийн байрнуудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон халаах хэрэгслийн хаалт винтель, сгон контур, муфтыг шинэчлэн солилоо. Хичээлийн I, II, V байрны ажлын даралт даахгүй болсон цэвэр усны магистраль болон халаалтын шугамыг хэсэгчлэн сольж засварлалаа. Хичээлийн II, V байрны хэрэглээний халуун усны болон халаалтын бойлерыг задалж цэвэрлэн сэргээн засварлаж, хичээлийн 2 дугаар байрны халуун усны хурдны ф80 мм-ийн 3 секц бойлерыг 300 кВт/цаг хүчин чадал бүхий ялтсан дулаан солилцуураар солив. Оюутны III байрны халаалтын системийг угаалгав. Хичээлийн байрны халаалтын насост тосолгоо үйлчилгээ хийж, зарим дулааны узелийн манометр, термометрийг шинэчиллээ. Эдгээр засвар үйлчилгээний ажилд халаах хэрэгслийн хаалт, винтель, сгон, контур, муфтыг нийтдээ 120 ширхэг, төрөл бүрийн хөндлөн огтлол бүхий 300 гаруй метр урт ган хоолой оржээ.

Хичээлийн I, II, III байр орчмын гадна ариутгах татуургын 200 гаруй у/м шугамыг улирал тутам угаах, 15ш худгийг лайдах ажил хэвшил болсон байна. Хичээлийн жилийн хугацаанд угаалтуур, суултуур, босоо шугам, гадна худаг бөглөрсөн нийт ариутгах татуургын давхардсан тоогоор 119 дуудлага хүлээн авч цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж ажиллаа. Ариутгах татуургын дуудлага өнгөрсөн

оноос 65 дуудлагаар буурсан байна. Ус хангамжийн угаалтуураас ус алдсан 25, уян холбоосоос ус алдсан 21, суултуурын почкиноос ус алдсан 49 дуудлага, вителээс ус алдсан 3 дуудлага давхардсан тоогоор нийт 98 дуудлага хүлээн авсан нь өнгөрсөн оноос 12 дуудлагаар буурчээ.

ШУТТНС, хичээлийн II байрны нийт 5ш цахилгаан шатны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан техникийн үзлэг, үйлчилгээг гэрээт байгууллагаар хийлгэж гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллав. Лифтний ээлжит магадлалыг Улаанбаатар НӨҮГ-аар хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгах талаар гэрээт байгууллагатай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хичээлийн I, II, III, IV, V байр, ШУТТНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, лавлагаа мэдээлэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллалаа. Энэ хичээлийн жилд телефон аппаратын, холбооны кабелийн нийт 136 дуудлага ирж 2 аппарат ашиглалтаас гарч 134 дуудлагын гэмтлийг тодорхойлж засвар, үйлчилгээ хийв. Олон дахин давтагдсан гэмтэл гардаг газруудын шалтгаан нөхцөлийг тодорхойлж ажиллав. Дотуур холбооны АТС TD-510 станцын 16-н хэрэглэгчийн картыг шинэчлэв. Хичээлийн 5-р байрны 1-р давхрын холбооны монтажийг 4-р давхар луу бүрэн шилжүүлэв.

Хичээлийн болон оюутны байрнуудын цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан, цахилгаан системийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цахилгааны 27 ш ерөнхий, 62 ш групп шитэнд техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Хичээлийн V болон оюутны III байрны гадна тэжээлийн кабель гэмтсэнийг муфтэлж сэргээн засварлав. Хичээлийн V байранд байрлах БАС-ийн барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторид шинээр 308V-ын тэжээл оруулж шинээр шит угсарч Японы засгийн газрын 1000 инженер төслийн хүрээнд хэрэгжиж буй “Дулааны цахилгаан станцын хаягдал үнсийг барилгад ашиглах ногоон ирээдүй” төслөөр суурилагдсан тоног төхөөрөмжүүдэд монтаж татаж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хичээлийн VII байрны 380V-ын групп шит, авто засварын урланд 380V-ын шит, хичээлийн IV байрны групп шитийг тус тус шинэчилж, IV байрны 380V-ын тэжээлийн кабелиг сольж сайжруулсан. Наалт хатгамлын лабораторид 308V-ын тэжээл татаж холболт хийсэн. Инкубацийн барилгын гадна цахилгаан хангамжийн КТПН-4432-н трансформаторт хэмжилт, туршилт тохируулга хийлгэж хэвийн ажиллагааг хангасан. Тайлант онд разетка, унтраалга, гэрэл солих, цахилгаан хэрэгсэл суурилуулах, тэжээл татах, сургуулийн гадна орчинд зохиогддог арга хэмжээний үеэр цахилгаан тэжээл татах зэрэг ажлуудыг ямар нэг гомдол чирэгдэлгүй гүйцэтгэж ажилласан байна. Мөн түрээсэлж байгаа талбайн цахилгаан хэрэгсэлд тусад нь тоолуур зүүж цахилгааны өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгууллаа.

“ШУТИС-ийн 2019 оны хамтын гэрээ”-ний ХАБЭА-н нөхцөл бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Эрүүл мэнд, спортын төвтэй хамтран үйлчлэгч нарт сургалт явуулав. Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтэд хяналт тавилаа. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав. Оюутны соёл үйлчилгээний алба, Эрүүл мэнд, спортын төвтэй хамтран Оюутны байрны орчинд нэгдсэн шалгалтыг хийж, авч хэрэгжүүлэх ажил үүргийг байр тус бүрээр гарган холбогдох бүрэлдэхүүн сургуулиудад зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Цайны газрын үйл ажиллагаанд Эрүүл мэнд, спортын төв, Оюутны холбоо болон Үйлдвэрчний нэгдсэн эвлэлтэй хамтран үзлэг, шалгалтыг хийж хяналт

тавин ажиллав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу нэгдсэн дадлага сургалтыг зохион байгуулав.

“Соргог” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн Дорнод монгол секьюрити байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна. Харуулын албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулж холбогдох үүрэг даалгаврыг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Мөн дээрх байгууллагуудын ажлын тайланг бичгээр авч үнэлгээ хийж байна.

Хичээлийн I, II байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг гаргаж, автомашин нэвтрүүлэх зөвшөөрлийг шинэчлэн автомашин эзэмшигчдэд олгож зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.

Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.

Тайлант онд Удирдах зөвлөлийн 2018 оны 14 тоот тогтоолоор батлагдсан 2019 оны хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллалаа.



НАЙМДУГААР БҮЛЭГ

САНХҮҮ НЯГТЛАН, БОДОХ БҮРТГЭЛ

НАЙМ. САНХҮҮ

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 144,079.97 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 61.0% буюу 54.59 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Эргэлтийн хөрөнгө 29.9 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 70.1 хувийг эзэлж эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 18.3 хувиар буурч хөрөнгийн бүтцэд өөрчлөлт орсон байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 7.1 хувь, эзний өмч 92.9 хувийг тус тус эзэлж эзний өмчийн дүн нийт хөрөнгөд эзлэх хувь өмнөх оноос 2.8 хувиар өсжээ.

БАЛАНСЫН БҮТЭЦ, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.1

д/д	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2017 он		2018 он		Өөрчлөлт	
		дүн	Дүнд эзлэх хувь	дүн	Дүнд эзлэх хувь	Абсолют	Харьцангуй
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	33,969.26	38.0	34,413.10	23.9	443.84	1.3
2	Авлага	7,359.98	8.2	6,015.22	4.2	-1,344.76	-18.3
3	Бараа материал	1,634.68	1.8	1,898.37	1.3	263.69	16.1
4	Урьдчилж гарсан зардал	59.14	0.1	765.55	0.5	706.41	1194.5
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,023.07	48.1	43,092.24	29.9	69.18	0.2
1	Биет хөрөнгө	46,117.10	51.5	93,435.00	64.8	47,317.90	102.6
2	Биет бус хөрөнгө	342.60	0.4	7,552.72	5.2	7,210.12	2104.5
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,459.70	51.9	100,987.72	70.1	54,528.02	117.4
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	89,482.77	100.0	144,079.97	100.0	54,597.20	61.0
1	Богино хугацаат өр төлбөр	8,748.73	9.8	10,206.11	7.1	1,457.38	16.7
2	Урт хугацаат өр төлбөр	72.07	0.1	67.10	0.05	-4.97	-6.9
	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	8,820.80	9.9	10,273.21	7.1	1,452.41	16.5
1	Засгийн газрын сан	23,542.83	26.3	30,748.33	21.3	7,205.50	30.6
2	Хуримтлагдсан үр дүн	37,054.15	41.4	41,942.63	29.1	4,888.48	13.2
3	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,064.99	22.4	61,115.80	42.4	41,050.81	204.6
	ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	80,661.97	90.1	133,806.76	92.9	53,144.79	65.9
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	89,482.77	100.0	144,079.97	100.0	54,597.20	61.0

8.1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Эргэлтийн хөрөнгө мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материалаас бүрдэж байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 443.84 сая төгрөгөөр, бараа материал 263.69 сая төгрөгөөр нэмэгдэж, авлага 1.3 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл; мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 1.3% буюу 443.84 сая төгрөгөөр нэмэгдэж, авлага 18.3% буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан харин бараа материалын хувьд 16,1% буюу 263.69 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 34.41 тэрбум төгрөг, үүнээс 10.0 тэрбум төгрөг нь сургалтын төлбөр, оюутны байр, гэрээт ажил, төслийн урьдчилж орсон орлого байна. (Урьдчилж орсон орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 1.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 34.41 тэрбум төгрөгөөс урьдчилж орсон орлогыг хасаж тооцооноор тайлант оны шилжих үлдэгдэл нь 24.20 тэрбум төгрөг болжээ. Бүрэлдэхүүн сургуулиудын мөнгөн хөрөнгийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулбал:

МӨНГӨН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)


Хүснэгт 8.2

д/д	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он		2018 он		Өөрчлөлт	
		дүн	Дүнд эзлэх хувь	дүн	Дүнд эзлэх хувь	Абсолют	Харь-цангуй
1	БАС	5,573.86	16.4	4,475.30	13.0	1,098.56*	19.7*
2	БУХС	1,282.89	3.8	1,392.35	4.0	109.45	8.5
3	ГУУС	783.01	2.3	640.09	1.9	-142.92	-18.3
4	ДАРТС	478.55	1.4	806.18	2.3	327.62	68.5
5	МЕХТС	953.32	2.8	959.89	2.8	6.57	0.7
6	МХТС	2,144.19	6.3	1,909.10	5.5	-235.09	-11.0
7	ҮТС	1,130.87	3.3	936.55	2.7	-194.32	-17.2
8	ХШУС	1,302.38	3.8	1,213.18	3.5	-89.20*	-6.8*
9	ЭХС	3,046.08	9.0	4,007.91	11.6	961.84	31.6
10	Е-НИ	270.29	0.8	260.15	0.8	-10.15	-3.8
11	ГХИ	388.19	1.1	467.61	1.4	79.42	20.5
12	АХЛАХ СУРГУУЛЬ	801.07	2.4	741.48	2.2	-59.59	-7.4
13	КООСЕН ТК	84.27	0.2	82.26	0.2	-2.01	-2.4
14	ОУДБСТ	50.66	0.1	80.70	0.2	30.04	59.3
15	ОМССХ	19.24	0.1	4.59	0.0	-14.65	-76.1
16	ХЭВЛЭХ ГАЗАР	42.83	0.1	87.43	0.3	44.60	104.1
17	ЗАХИРГАА	249.57	0.7	604.25	1.8	354.68	142.1
18	ЭШИГ	870.51	2.6	959.06	2.8	88.56	10.2
19	ЭРДЭМНЕТ	180.71	0.5	147.05	0.4	-33.66	-18.6
20	ТӨВЛӨРСӨН	14,190.9 1	41.8	14,454.6 9	42.0	263.78	1.9
21	ШУТНСАН	125.85	0.4	183.29	0.5	57.44	45.6

НИЙТ	33,969.2 6	100.0	34,413.1 0	100.0	443.84	1.3
-------------	-----------------------	--------------	-----------------------	--------------	---------------	------------

* - ШУТИС-ийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/87 тоот тушаалын дагуу БАС 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр 1,4 тэрбум төгрөг, ХШУС 2018 оны 9 дүгээр сарын 28-ний өдөр 150 сая төгрөг бүхий санхүүгийн үр дүнгийн мөнгөн хөрөнгийн дүнг төвлөрүүлсэн.

Мөнгөн хөрөнгийн хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 443.84 сая төгрөг буюу 1.3%-иар нэмэгдсэн байна. Төвлөрсөн санд 14.4 тэрбум төгрөг төвлөрсөн байгаа нь 2013 оноос ШУТИС-ийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн, ШУТИС-ийн захиргаанаас банкнуудтай хийгдсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу харилцах данс болон хадгаламжийн хүүгийн үлдэгдэлд тооцсон мөнгөн хөрөнгүүд хамаарч байна. Мөн магистр, доктор оюутны сургалт, судалгааны төлбөрийг захиргааны дансанд төвлөрүүлсэн 604.25 сая төгрөг болох мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.



Зураг 8.1. ШУТИС-ийн 2018 оны балансын бүтэц

ШУТИС-ийн хэмжээнд мөнгөн хөрөнгийг өмнөх оноос 100 сая төгрөг түүнээс дээш дүнгээр нэмэгдүүлсэн ЭХС, БАС, ДарТС, БУХС-иуд орж байна. Үүнээс ШУТИС-ийн хэмжээнд хамгийн өндөр дүнгээр ЭХС 961.84 сая төгрөгөөр мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлсэн байна. Харин мөнгөн хөрөнгийг өмнөх оноос 100 сая төгрөг түүнээс доош дүнгээр бууруулсан ГУУС, МХТС, ҮТС-иуд орж байна.

2018 оны байдлаар нийт мөнгөн хөрөнгийн 42 хувь нь ШУТИС-ийн төвд, 11.6 хувь нь ЭХС-д, 13 хувь нь БАС-д хамаарагдаж байна.

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 144.04 тэрбум төгрөг хүрч өнгөрсөн оноос 54.5 тэрбум төгрөг буюу 61.0 %-иар өсжээ. Нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгө 29.9%, эргэлтийн бус хөрөнгө 70.1%, өр төлбөр эзний өмчид өр төлбөр 7.1%, эзний өмч 92.9% тус тус эзэлж байна.

8.1.1.АВЛАГА

Авлага урьд оны мөн үетэй харьцуулахад 18.3 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан нь байгууллагатай холбоотой авлага 1.8 тэрбум төгрөгөөр, боловсрол зээлийн сангийн авлага 424 сая төгрөгөөр, сургалтын төлбөрийн авлага 171 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Тухайлбал ШУТИС-ийн БАС, БУХС, ГУУС, ХШУС, МХТС, ҮТС, ЭХС, Захиргаа зэрэг 8 бүрэлдэхүүн нэгжүүдийн 1029 кв.м талбай бүхий 1.6 тэрбум төгрөгийн авлагад бүртгэсэн үндсэн хөрөнгийн бүртгэлийн зөрчлийг арилгуулсан. Дээрх зөрчил нь Үндэсний аудитын газрын 2015 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 5/57 тоот албан шаардлага өгөгдсөн ТӨХ-ийн зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө худалдан авсан асуудал юм. Уг асуудлыг ТӨБЗГ даргын 2018 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 273 тоот тушаалын дагуу төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамруулж, 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн ТӨБЗГ-ийн хянан шалгалтад уг асуудлыг танилцуулан шийдвэрлүүлсэн болно. Тайлант оны жилийн эцсийн байдлаарх авлагыг төрлөөр харуулбал:

- Сургалтын төлбөрийн авлага хувиараа төлөх оюутны авлага - 2,333.95 сая төгрөг
- Тогтмол зардлын санхүүжилтийн авлага - 2,639.12 сая төгрөг (БСШУСЯам)
- Дараа тайлангаар болон хувь хүмүүстэй холбоотой - 357.11 сая төгрөг
- Байгууллагатай холбоотой – 685.05 сая төгрөг байна.

Дараах хүснэгтэд бүрэлдэхүүн сургууль тус бүрийн тайлант жилийн нийт авлага болон сургалтын төлбөрийн авлагыг харуулав.

НИЙТ АВЛАГА БОЛОН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН АВЛАГА, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.3

Д/Д	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он	Үүнээс: Сургалтын төлбөрийн авлага					Дүнд эзлэх хувь
				2017 он	2018 он		Өөрчлөлт		
					Дүн	авлага эз.хувь	Абсолют	Харьцаа	
1	БАС	1,337.24	1,201.20	310.36	279.83	23%	-30.53	-9.8%	12%
2	БУХС	1,237.11	1,155.22	518.86	526.76	46%	7.89	1.5%	22%
3	ГУУС	1,082.60	537.64	477.07	492.74	92%	15.68	3.3%	21%
4	ДарТС	264.26	277.22	183.70	204.02	74%	20.33	11.1%	9%
5	МХТС	383.84	461.11	122.04	72.46	16%	-49.58	-40.6%	3%
6	МХТС	465.14	547.39	143.02	128.15	23%	-14.87	-10.4%	5%
7	ҮТС	746.50	516.78	85.79	86.97	17%	1.18	1.4%	4%

8	ХШУС	233.14	16.90	22.70	15.65	93%	-7.05	-31.0%	1%
9	ЭХС	357.90	228.28	170.18	162.41	71%	-7.77	-4.6%	7%
10	Е-НИ	36.74	18.13	10.03	12.94	71%	2.91	29.0%	1%
11	ГХИ	57.38	93.98	41.72	29.53	31%	-12.19	-29.2%	1%
12	АХ.СУР	211.18	192.66	128.62	122.75	64%	-5.87	-4.6%	5%
13	КООС.ТК	192.12	153.07	163.70	122.37	80%	-41.33	-25.2%	5%
14	ОУДБСТ	166.84	135.05	166.84	135.05	100%	-31.79	-19.1%	6%
15	ОМССХ	9.65	0.00	-	-				
16	ХЭВ.ГАЗ	43.11	37.49	-	-				
17	ЗАХ	93.22	83.52	-	-				
18	ЭША	422.25	329.64	-	-				
19	ЭР.НЕТ	85.41	71.12	-	-				
20	ШУТНС	11.63	0.12	-	-				

2018 онд ШУТИС-ийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн 1/637 тоот “Санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, өр авлагыг барагдуулах чиглэлээр авах арга хэмжээний тухай” албан даалгавар гарч авлагыг бууруулах чиглэлээр ажилласан. Албан даалгаврын хүрээнд удирдамж болон ажлын төлөвлөгөө гарган бүрэлдэхүүн сургуулиудын авлагыг бууруулах чиглэлээр эзэн холбогдогчийг хайх, хаягийг тодорхойлох, анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, эвлэрүүлэн зуучлах ажлууд хийгдсэн. Мөн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд авлага шинээр үүсэх эрдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс сургалтын төлбөр төлөх үйл ажиллагаанд батлан даалтын гэрээ хийхээр зааварчилсан.

Нийт авлагын хувьд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд нийтлэг буурсан байгаа нь ШУТИС-ийн авлагад бүртгэлтэй үндсэн хөрөнгийн зөрчлийг арилгуулан хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой юм. Харин сургалтын төлбөрийн авлагын хувьд өмнөх оноос 152,9 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагад сургалтын төлбөрийн авлага ГУУС-д 92%, ХШУС-д 93%, Коосен ТК-д 80% эзэлж байна. Өнгөрсөн хугацаанд сургалтын төлбөрийн авлагыг бууруулсан бүрэлдэхүүн нэгжүүдэд МехТС 40.6%, ХШУС 31%, ГХИ 29.2%-иар бууруулж үр дүнтэй ажилласан байна. Тухайлбал МехТС 2018 онд шинээр сургалтын төлбөрийн авлага үүсгэхгүйгээр ажилласан байна. Гэсэн хэдий ч 2018 онд сургалтын төлбөрийн авлагаа бууруулаагүй БУХС 1.5%, ГУУС 3.3%, ДарТС 11.1%-иар нэмэгдүүлсэн байна. Мөн 2018 онд шинээр сургалтын төлбөрийн авлагыг БУХС 124 сая төгрөгөөр, КоосенТК 122.3 сая төгрөгөөр тус тус үүсгэж хангалтгүй үр дүнтэй ажилласан байна.

Нийт авлагад тогтмол зардлын санхүүжилтийн авлага өмнөх оноос 65.2 хувиар буюу 1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2.6 тэрбум төгрөгт хүрч нийт авлагын 43.9 хувийг эзэлсэн байна. Энэхүү авлага нь Боловсролын тухай хуулийн 40.1-д заасан төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардлыг төрөөс санхүүжүүлнэ хэмээн заасан хуулийн заалттай үүссэн авлага байна.

8.2. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл нь 2018 оны эхэнд 1,634.68 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацааны туршид 1,993.39 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,729.7 сая төгрөгөөр хорогдож, жилийн эцэст 1,898.37 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 16.1% буюу 263.69 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материал хасагдсан шалтгаан нь 1,70 тэрбум төгрөгийн бараа материал зарцуулсан, 19.3 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн бараа

материал худалдсан, 8.3 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, аж ахуйн материал, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлсийн бараа материалыг данс хооронд шилжүүлсэн байна.

Бараа материалын нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл:

- Бараа материалыг худалдан авсан – 1,729.45 сая төгрөг
- Үнэ төлбөргүй - 258.58 сая төгрөг /2018 оны 12 сарын 27-нд Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжаар Коосен ТК-д 213.67 сая төгрөгийн бараа материал өгсөн/
- Бусад хэлбэрээр буюу данс хооронд нэмэгдсэн -5.3 сая төгрөг байна.

Бараа материалын бүтцийн хувьд тусгай зориулалттай материал - 71.7 хувь, бэлэн бүтээгдэхүүн – 0.6 хувь, бичиг хэргийн материал - 9.5 хувь, аж ахуйн материал – 1.6 хувь, сэлбэг хэрэгсэл – 0.3 хувь, засварын материал – 1 хувь, хүнсний материал – 0.2 хувь, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс – 4.3 хувь, бусад бараа материал - 10.7 хувийг тус тус эзэлж байна. Бараа материалын үлдэгдлийг бүрэлдэхүүн сургуулиудаар харуулбал:

БАРАА МАТЕРИАЛЫН ҮЛДЭГДЭЛ, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.4

д/д	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он	Өөрчлөлт	
				Абсолют	Харьцангуй
1	БАС	23.58	26.59	3.01	12.8%
2	БУХС	29.05	54.98	25.93	89.2%
3	ГУУС	22.01	18.14	-3.86	-17.6%
4	ДАРТС	71.26	70.94	-0.31	-0.4%
5	МЕХТС	16.95	59.30	42.35	249.9%
6	МХТС	53.28	35.93	-17.35	-32.6%
7	ҮТС	1,260.11	1,225.28	-34.83	-2.8%
8	ХШУС	1.16	16.18	15.02	1290.0%
9	ЭХС	44.56	39.34	-5.22	-11.7%
10	Е-НИ	3.33	3.89	0.56	16.9%
11	ГХИ	3.49	3.61	0.13	3.6%
12	АХЛАХ СУРГУУЛЬ	4.01	3.98	-0.03	-0.7%
13	КООСЕН ТК	11.55	222.12	210.57	1823.6%
14	ОУДБСТ				
15	ОМССХ	0.33	3.75	3.43	1046.3%
16	ХЭВЛЭХ ГАЗАР	0	3.68	3.68	
17	ЗАХИРГАА	89.64	110.40	20.75	23.2%
18	ШУТНСАН	0.39	0.26	-0.13	-33.2%
	НИЙТ	1,634.68	1,898.37	263.69	16.1%

Дээрх хүснэгтээс харахад ШУТИС-ийн нийт бараа материалын 64.5 хувийг ҮТС, 11.7 хувийг “ШУТИС-Коосен” ТК эзэлж байна.

8.2.1. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 130,176.19 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 28,9 хувиар нэмэгдсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгө 59,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнд 4.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр, 4.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг аж ахуй нэгжээс, олон нийтийн байгууллагаас, гадаад зээл тусламжаар, бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй, хандиваар бэлтгэж, 48.2 тэрбум төгрөгийн дүн дахин үнэлгээний нэмэгдэл, 1.9 тэрбум төгрөгийн данс хооронд, бараа материалаас шилжүүлсэн зэрэг шалтгаантай байна. Харин тайлант онд үндсэн хөрөнгө 30.2 тэрбум төгрөгөөр хасагдсан ба үүнд 29.9 тэрбум төгрөгийн дүн дахин үнэлгээний хорогдол, 910.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, 70.2 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн бүртгэсэн байна.

Тайлант онд 2013 онд ашиглалтад орсон 180 айлын орон сууцны барилгын подвалын В1 давхрыг Хемон ХХК, Немон ХХК-аас худалдан авах гэрээний дагуу өөрийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 54 тоот ТӨБЗГ-ын даргын тогтоолын 2.2-т зөвшөөрсний дагуу 1029 кв.м талбай бүхий 1,636.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий зоорины давхар хөрөнгийг данс бүртгэлд тусгасан. Мөн 2018 оны 12 сарын 27-нд Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжаар Коосен ТК-д 3,135.36 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгө хандивласан байна. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ямар нэг үндсэн хөрөнгө болон урсгал засварын зориулалтаар капитал засвар ажлууд хийгдээгүй байна.

Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл:

- Үндсэн хөрөнгийг худалдан авсан – 4,988.35 сая төгрөг
- Үнэ төлбөргүй авсан – 4,291.70 сая төгрөг
- Бусад хэлбэрээр буюу данс хооронд, дахин үнэлгээний нэмэгдлээр -50,243.7 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийн хувьд барилга байгууламж - 58.9 хувь, авто тээврийн хэрэгсэл – 1.0 хувь, машин тоног төхөөрөмж - 25.0 хувь, тавилга эд хогшил – 4.3 хувь, номын фонд – 1.8 хувь, дуусаагүй барилга байгууламж – 2.2 хувь, бусад хөрөнгө – 0.2 хувь, програм хангамж – 1.1 хувь, бусад биет бус хөрөнгө - 5.5 хувийг тус тус эзэлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн данс бүртгэлд үндсэн хөрөнгийг нэмэгдүүлээгүй. Харин Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.5, 5.6-д төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ хэмээн хуульчилсан байдаг.

Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд ҮТС-д 60.8 сая төгрөгийн угаах машин, хээлэгч машин, холбогч машин, компьютерын дэлгэц, 30.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, МехТС-д 73.5 сая төгрөгийн өөдөө инженеринг тоног төхөөрөмж, 7.4 сая төгрөгийн сандал ширээ, 16.4 сая төгрөгийн classroom management software 3D sculpting and modeling програм хангамжийн үнэ төлбөргүй гадаад зээл тусламжаар үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 11 сарын 20-ны өдрийн 557 тоот тогтоол, 2018 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн А-5/4261 тоот

албан бичгийн дагуу дараах нэр төрлийн 910.89 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсан. Үүнд:

- Тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл 742.36 сая төгрөг
- Тавилга, эд хогшил 114.07 сая төгрөг
- Ном, сурах бичиг 16.76 сая төгрөг
- Программ хангамж 25.65 сая төгрөг
- Бусад хөрөнгө 12.04 сая төгрөг

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 12 сарын 21-ний өдрийн 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 тоот тушаал, ТӨБЗГ-ийн даргын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот, 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 367 тоот тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон дахин үнэлгээг хийсэн. Дахин үнэлгээний удирдамжийн дагуу ШУТИС-ийн Захирлын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/231 тоот, 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 тоот тушаалын дагуу бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн хооронд 32 нэр төрлийн 1,7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн данс хооронд, хөрөнгийн эзэмшигч тус бүрд шилжүүлэлтийг хийсэн. Мөн ШУТИС-ийн захирлын 2018 оны 10 дугаар сарын 01-ний А/198 тоот тушаал гарч ШУТИС-ийн газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын хэсэг, ажлын төлөвлөгөөг батлан ажилласан болно. Барилга байгууламжийн дүнг бүрэлдэхүүн сургуулиудаар харуулбал:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.5

д/д	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он	Өөрчлөлт		Дахин үнэлгээ нэмэгдэл	Өөрчлөлт хувь	Тайлбар	
				Абсалют	Харьцангуй			Тоо	шир. кв.м
1	БАС	6,000.34	9,651.43	3,651.09	60.8%	6,486.95	108%	9	14,499.03
2	БУХС	9,933.13	11,708.98	1,775.86	17.9%	6,393.00	64%	10	15,440.75
3	ГУУС	110.01	619.25	509.23	462.9%	102.03	93%	13	1,361.58
4	ДАРТС	11,108.05	14,690.00	3,581.95	32.2%	7,088.19	64%	10	18,853.94
5	МЕХТС	6,756.96	6,609.09	-147.87	-2.2%	4,520.93	67%	11	10,041.61
6	МХТС	6,653.26	8,603.60	1,950.35	29.3%	4,544.03	68%	5	12,204.10
7	ҮТС	8,361.74	8,750.07	388.33	4.6%	2,220.65	27%	16	15,915.75
8	ХШУС	103.44	327.53	224.10	216.7%	32.46	31%	5	509.33
9	ЭХС	89.14	244.92	155.78	174.8%	81.01	91%	3	458.60
10	Е-НИ								
11	ГХИ	8.60	13.66	5.05	58.8%	13.66	159%	1	176.70
12	АХ.СУР	5.80	71.05	65.25	1125.1%			1	170.01

13	КООСЕН ТК								
14	ОУДБСТ								
15	ОМССХ	121.50	121.50	0.00	0.0%			2	152.60
16	ХЭВ.ГАЗА Р								
17	ЗАХИРГАА	13,671.3 4	15,309.1 8	1,637.84	12.0%	9,609.44	70%	10	24,723.7 2
18	ЭШИГ								
19	ЭРДЭМНЕ Т								
20	ТӨВЛӨРС ӨН								
21	ШУТНСАН								
	НИЙТ	62,923.3 0	76,720.2 5	13,796.9 5	21.9%	41,092.32		96	114,507.7

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хүрээнд нийт 344,751 кв.м газар эзэмших эрхийг 7,2 тэрбум төгрөгөөр, 114,507 кв.м 96 ширхэг барилгыг 76,7 тэрбум төгрөгөөр үнэлж 41,09 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт үндсэн хөрөнгийн дүн 130.17 тэрбум төгрөг, бөгөөд хуримтлагдсан элэгдэл нь 29,1 тэрбум төгрөг, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг нь 100,98 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн байна.

8.2.2. ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийт өр төлбөр дүнгээрээ 10,273.21 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 16.5 хувь буюу 1,452.41 сая төгрөгөөр өсч, эзний өмчийн дүн урьд оноос 65.9 хувь буюу 53,144.86 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 4,862.72 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан бөгөөд урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 64.4 хувиар буюу 1,905.22 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН БҮТЭЦ, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.6

д/ д	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2017 он		2018 он		Өөрчлөлт	
		дүн	Дүнд эзлэх хувь	дүн	Дүнд эзлэх хувь	Абсолют	Харьцангуй
1	Богино хугацаат өр төлбөр	8,748.70	9.8	10,206.11	7.1	1,457.4 1	16.7
2	Урт хугацаат өр төлбөр	72.10	0.1	67.10	0.0	-5.00	-6.9
	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	8,820.80	9.9	10,273.21	7.1	1,452.4 1	16.5

1	Засгийн газрын сан	23,542.8 0	26.3	30,748.33	21.3	7,205.5 3	30.6
2	Хуримтлагдсан үр дүн	37,054.1 0	41.4	41,942.63	29.1	4,888.5 3	13.2
3	Өмнөх үеийн үр дүн	34,096.6 0	38.1	37,079.91	25.7	2,983.3 1	8.7
4	Тайлант үеийн үр дүн	2,957.50	3.3	4,862.72	3.4	1,905.2 2	64.4
5	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,065.0 0	22.4	61,115.80	42.4	41,050. 80	204. 6
ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН		80,661.9 0	90.1	133,806.76	92.9	53,144. 86	65.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН		89,482.7 0	100. 0	144,079.97	100. 0	54,597. 27	61.0


Нийт өр төлбөр, эзний өмч өнгөрсөн оны мөн үеийнхээс 61.0 хувь буюу 54,597.27 сая төгрөгөөр, нэмэгдэж 144,079.97 сая төгрөгт хүрчээ. 2017 оны байдлаар нийт өр төлбөр эзний өмчийн харьцаа 9.9 хувийг өр төлбөр, 90.1 хувийг эзний өмч хамаарч байсан бол 2018 оны байдлаар нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчийн 7.1 хувийг өр төлбөр, 92.9 хувийг эзний өмч эзэлж байна.

Харин нийт өр төлбөрийн 99.3 хувийг богино хугацаат өр төлбөр, 0.7 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Богино хугацаат өр төлбөрийн бүтцийг авч үзвэл,

- Бакалаврын оюутны сургалтын төлбөр, урьдчилж олсон орлого – 8,819.79 сая төгрөг
- Магистрын оюутны сургалтын төлбөр, урьдчилж олсон орлого – 351.4 сая төгрөг
- Доктор оюутны сургалтын төлбөр, урьдчилж олсон орлого – 116.24 сая төгрөг
- Бусад, урьдчилж олсон орлого – 598.77 сая төгрөг
- Хувь хүнд өгөх өглөг – 93.71 сая төгрөг
- Байгууллагад өгөх өглөг – 224.91 сая төгрөг
- Бусад өглөг – 1.29 сая төгрөг

Богино хугацаат өр төлбөр дүнгээрээ 10,206.11 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 16.7 хувь буюу 1,457.41 сая төгрөгөөр өсчээ. Харин урт хугацаат өр төлбөр 67.1 сая төгрөгт хүрч 6.9 хувиар буурсан байна. Санхүүгийн тайлангийн шинжилгээний хүрээнд өрийн дарамт харьцангуй байхгүй байна.

Нийт өр төлбөр: Богино хугацаат өр төлбөрийн нийт хөрөнгөнд эзлэх хувь 99.3 хувь болж, урьд оны мөн үетэй харьцуулбал 0.2 хувиар өссөн байна. Богино хугацаат өр төлбөрт сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлогын эзлэх хувь 96.9 хувь болж урьд оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөрт эзлэх хувь 0.4 хувиар буурсан байна. Нийт урьдчилж орсон орлого 9,886.20 сая төгрөг болжээ.



Зураг 8.2. ШУТИС-ийн 2018 оны өр төлбөр, эзний өмчийн бүтэц

Урт хугацаат өр төлбөр болон нэг жилийн хугацаанд богино хугацаанд бусад өр төлбөрт ТӨХ-ны 436 тоот тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ХК-ий зээлийн хөрөнгөөр бэлтгэсэн халаалтын цогц төхөөрөмжүүдийн төлбөр болох урт хугацаат зээлийн үлдэгдэл (67.1 сая төгрөг), хувь хүн байгууллагат өгөх өглөг 318.62 сая төгрөг байна.

Эзний өмч: Засгийн газрын хувь оролцоо 21.3 хувь, хуримтлагдсан үр дүн 29.1 хувь, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 42.4 хувиар бүрдүүлж байгаа бөгөөд тайлант онд 4,862.72 сая төгрөгт хүрч өмнөх оноос 1,905.22 сая төгрөгийн үр дүнтэй ажиллажээ.

8.3. ОРЛОГО

ШУТИС-ийн нэгтгэсэн орлого болон бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн тайлант оны орлогыг үндсэн үйл ажиллагааны, эрдэм шинжилгээний, туслах үйл ажиллагааны, төсвөөс санхүүжигдэх гэсэн орлогын төрлүүдэд хуваан авч үзлээ. Орлогын дүнг санхүүгийн балансын Санхүүгийн үр дүнгийн (СТ-2А) тайлангаас авч, ШУТИС төв, бүрэлдэхүүн нэгжүүдийн хоорондын сургууль хоорондын тооцооны орлогыг хасаж тухайн тайлант хугацааны орлогыг тооцлоо.

ТАЙЛАНТ ҮЕИЙН НИЙТ ОРЛОГО, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.7

Үзүүлэлт	2017 он	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх %	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Тоо	Хувь		
Шилжих үлдэгдэл	-	13,450.73					
I. Үндсэн үйл ажиллагааны орлого	36,454.60	34,241.75	37,906.74	3,665.0	110.7	70.9	104.0
Сургалтын төлбөрийн орлого	35,354.50	32,232.2	37,076.59	4,844.4	115.0	69.3	104.9
Түр сургалтын орлого	1,100.10	2,009.5	830.15	-1,179.4	41.3	1.6	75.5
II. Эрдэм шинжилгээ орлого	3,477.39	3,639.7	3,918.77	279.1	107.7	7.3	112.7
III. Туслах үйл ажиллагааны орлого	4,906.85	2,858.64	5,060.59	2,202.0	177.0	9.5	103.1
Оюутны байрны орлого	649.08	704.3	706.22	1.9	100.3	1.3	108.8
Түрээсийн орлого	135.62	181.9	113.03	-68.9	62.1	0.2	83.3
Бусад орлого	4,122.2	1,972.4	4,241.3	2,268.9	215.0	7.9	102.9
IV. Төсвөөс санхүүжих	7,333.5	2,784.8	6,615.7	3,830.9	237.6	12.4	90.2
Тайлант үеийн орлого	52,172.33	43,524.90	53,501.82	9,976.9	122.9	100.0	102.5
Нийт орлогын дүн		56,975.63					

Тайлант онд нийт орлого 53,501.82 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урьд оны мөн үеийн гүйцэтгэлээс 2.55 хувь буюу 1.32 тэрбум төгрөгөөр өсөж, төлөвлөснөөс 22.9 хувь буюу 9.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:

- Сургалтын төлбөрийн орлого- 4.87 хувь буюу 1.7 тэрбум төгрөгөөр өссөн
- Түр сургалтын орлого- 24.5 хувь буюу 270.0 сая төгрөгөөр буурсан
- Эрдэм шинжилгээний орлого – 12.6 хувь буюу 441.4 сая төгрөгөөр өссөн
- Оюутны байрны орлого - 8.8 хувь буюу 57.1 сая төгрөгөөр өссөн
- Түрээсийн орлого - 16.6 хувь буюу 22.6 сая төгрөгөөр буурсан
- Бусад орлого - 2.89 хувь буюу 119.2 сая төгрөгөөр өссөн
- Төсвөөс санхүүжих орлого 9.7 хувь буюу 717.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ.

Орлогын төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулахад түр сургалтын орлого, түрээсийн орлого төсөвтөө хүрээгүй. Бусад орлогын хувьд орлогын төлөвлөгөө

биелсэн үзүүлэлттэй гарчээ. Тухайлбал: Сургалтын төлбөрийн орлого төлөвлөснөөс 4.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн 10 тоот тогтоолоор 2018 онд элсэн суралцагчдын сургалтын төлбөрийг 19 хувиар, 2018 оноос өмнө элсэн суралцагчдын сургалтын төлбөрийг 16 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой сургалтын төлбөрийн орлого 15 хувиар давж биелсэн байна. Тухайн үеийн багш, ажиллагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой 4.7 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байгааг сургалтын төлбөрийн орлогын зөрүүгээс бүрэн санхүүжүүлсэн байна. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд төлөвлөсөн шинээр 3939 суралцагчид элсэн суралцсан байна.

Түр сургалтын орлого төлөвлөснөөс 41.3 хувиар 1,179.4 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Түр сургалтын орлогын хувьд өмнөх онд 1.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бол 2018 онд өмнөх оноос 270.0 сая төгрөгөөр буурч 830 сая төгрөгт хүрсэн байна. 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдсөн шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу түр сургалтын орлогод мэргэжил дээшлүүлэх болон курс дамжааны богино хугацааны сургалтын төлбөр хамаарна.


Эрдэм шинжилгээний орлого төлөвлөснөөс 7.7 хувь 279.1 сая төгрөгөөр давж биелсэн. Эрдэм шинжилгээний орлогын гүйцэтгэл нэмэгдэхэд БСШУСЯ-ны “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд гадаад төслийн санхүүжилтийн эх үүсвэртэй бүрэлдэхүүн сургуулиуд хөрөнгөөр болон мөнгөн хөрөнгөөр олгосон 1.4 тэрбум төгрөгийн эрдэм шинжилгээний орлогууд бүртгэгдсэн байна.

Оюутны байрны орлого төлөвлөсөн дүнгээс 1.9 сая төгрөгөөр нэмэгдэн 100.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Тайлант онд БУХС, ДаТС, МХТС, ҮТС, МехТС-ийн оюутны байранд ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн 09 тоот тогтоолоор баталсан нэг оюутны байрлах тарифийг мөрдөн ажилласан. Оюутны байрны орлогын түвшин баталсан төсвийн дагуу өмнөх оноос 57.1 сая төгрөгөөр илүү өндөр гарсан байна. Түрээсийн орлого төлөвлөсөн дүнгээс 68.9 сая төгрөгөөр буурч 62.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Түрээсийн орлого буурсан гол шалтгаан нь ТӨБЗГ-ын 2016 оны 10 сарын 27-ний дүрэм журмын дагуу түрээслэх талбайн хэмжээ буурсан, мөн түрээсийн гэрээний дагуу нийт төлбөрийн 20 хувийг ТӨБЗГ уруу шилжүүлдэг болсонтой холбоотой.

Бусад орлого төлөвлөснөөс 2.2 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин нэмэгдсэний 2.0 тэрбум төгрөг нь банкны хүүгийн орлого, ҮТС-688.0 сая төгрөг нь цайны газрын орлого, Эрдэмнэт төв-120.86 сая төгрөгийн орлогууд байгаа юм. Үүнээс гадна ШУТНС-35.22 сая төгрөг, ОУДБСТ-6.6 (хурлын өрөөний төлбөр, анги танхим тохижилт, багшийн эрхийн сургалт) сая төгрөгийг, ШУТИС Төв-85.0 сая төгрөг Тоёото сан сургалтын тэтгэлэг, ЭШИГ- 11.9 сая төгрөгийн орлогыг ЭШ-ний сэтгүүл, эмхэтгэлийн орлогоор бий болгожээ. Мөн зуны сургалт болон оюутны карт хэвлэх, оюутны сонголтын төлбөр гэх мэт оюутны үйлчилгээнээс 403.78 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Төсвөөс санхүүжих орлого төлөвлөснөөс 6.6 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин нэмэгдсэн байна. Санхүүгийн тайлангийн шинжилгээний хүрээнд санхүүгийн үр дүнгийн тайланг ашигласан тул аккрузул сууриар тооцогдсон байдаг. Тиймээс төсвөөс санхүүжих орлогод тогтмол зардлын 1.4 тэрбум төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн байна. Мөн 2018 оны 12 сарын 27-нд Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжаар Коосен ТК-д 3.1 тэрбум төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийн хандивын хөрөнгөөр авсан орлогын санхүүжилтийг үндсэн хөрөнгөд тусгасантай холбоотой.

Сургуулиудын төсвийн орлогыг гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:



Зураг 8.3. ШУТИС-ийн 2018 оны бүрэлдэхүүн нэгжийн сургалтын төлбөрийн орлогын төсөв, гүйцэтгэл

Тайлант онд баглагдсан төсвөөс БУХС, ДарТС, ЭХС бүрэлдэхүүн нэгжүүд орлогын төлөвлөгөөгөө 20 хувиас дээш биелүүлсэн харин ГУУС, ЕНИ, ГХИ, Ахлах сургууль, КоосенТК бүрэлдэхүүн нэгжүүд орлогын төсвийн төлөвлөгөөгөө биелүүлээгүй байна. Нийт тайлант үеийн орлого болон сургалтын төлбөрийн орлогыг өмнөх үеийн орлогын үзүүлэлттэй болон нийт орлогод эзлэх сургалтын төлбөрийн орлогыг бүрэлдэхүүн нэгж тус бүрээр харьцуулахад:

- БАС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 3.6 хувиар буюу 243.37 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 86 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- БУХС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 0.7 хувиар буюу 33.1 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт орлогын 86 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ГУУС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 1.9 хувиар буюу 114.6 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 75 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ДарТС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 44.7 хувиар буюу 2.6 тэрбум төгрөгөөр буурч, нийт орлогын 83 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна. Өнгөрсөн онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хичээлийн байр баригдсан байна.
- МехТС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 6.0 хувиар буюу 284.31 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт орлогын 76 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- МХТС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 5.1 хувиар буюу 255.46 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 88 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ҮТС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 9.4 хувиар буюу 559.84 сая төгрөгөөр нэмэгдэн, нийт орлогын 64 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ХШУС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 9,7 хувиар буюу 107.25 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 87 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.

- ЭХС тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 8.5 хувиар буюу 502.81 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 87 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ЕНИ тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 29.3 хувиар буюу 25.5 сая төгрөгөөр нэмэгдэн, нийт орлогын 14 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ГХИ тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 9.4 хувиар буюу 49.75 сая төгрөгөөр нэмэгдэн, нийт орлогын 78 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- Ахлах сургууль тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 15.2 хувиар буюу 89.16 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 84 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- Коосен ТК тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 9 дахин буюу 3.5 сая төгрөгөөр нэмэгдэн, нийт орлогын 11 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.
- ОУДБСТ тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 26.0 хувиар буюу 52.83 сая төгрөгөөр буурч, нийт орлогын 65 хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.

Тайлант онд өмнөх онтой харьцуулахад БУХС, ДарТС, МехТС, ХШУС, ЭХС, КоосенТК зэрэг бүрэлдэхүүн нэгжүүд сургалтын төлбөрийн орлогоо нэмэгдүүлэн ажилласан байна. Харин БАС, ГУУС, ЕНИ, ГХИ, АС зэрэг бүрэлдэхүүн нэгжүүд өмнөх оноос орлогын дүн буурсан үзүүлэлттэй гарчээ.

8.3.1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

ШУТИС-ийн үндсэн үйл ажиллагааны орлого нь бакалавр, магистр, доктор, ахлах сургууль болон МСҮТ, Коосен ТДС-ийн сургалтын төлбөр, түр сургалтын орлогоос бүрдэж байна. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 37,906.74 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 10.7 хувь буюу 3.6 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГО, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.8

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
1.Боловсрол зээлийн сан	1,228.54	-	1,122.74	1,122.7		3.0	91.4
2. Төлбөртэй сургалтын орлого	34,125.97	33,302.20	35,953.85	2,651.7	108.0	94.8	105.4
Бакалаврын сургалтын төлбөр	29,910.46	29,307.0	31,456.03	2,149.0	107.3	83.0	105.2

Магистрын сургалтын төлбөр	2,885.12	2,599.6	3,052.14	452.6	117.4	8.1	105.8
Докторын сургалтын төлбөр	342.00	325.64	391.09	65.4	120.1	1.0	114.4
Бусад /МСҮТ, Ахлах сургууль/	988.40	1,070.00	1,054.60	-15.4	98.6	2.8	106.7
3.Түр сургалтын орлого	1,100.10	939.0	830.15	-108.9	88.4	2.2	75.5
Нийт орлого	36,454.60	34,241.20	37,906.74	3,665.5	110.7	100.0	104.0

ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааны хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилийн хаврын улиралд бакалавр оюутан 260.0 гаруй мянган кредитийн хичээл, 2018-2019 оны намрын улиралд 240.0 гаруй мянган кредитийн цагийн хичээл сонгож тайлант жилд нийт 500.0 гаруй мянган кредит цагийн хичээл сонголт хийжээ. Тайлант онд сургалтын төлбөрийг бүтцээр нь орлогын төсөв, гүйцэтгэлээр харьцуулан үзэхэд:

- Бакалаврын сургалтын төлбөрийн орлого төсвийн гүйцэтгэлээр 7.3 хувь буюу 2.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 5 хувиар 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэн төсөв биелэлт хангасан,
- Магистрын сургалтын төлбөрийн орлого төсвийн гүйцэтгэлээр 17.4 хувь буюу 452.6 сая төгрөгөөр, өмнөх оноос 6 хувиар 167 сая төгрөгөөр нэмэгдэн төсөв биелэлт хангасан,
- Докторын сургалтын төлбөрийн орлого төсвийн гүйцэтгэлээр 20.1 хувь буюу 65.4 сая төгрөгөөр, өмнөх оноос 14 хувиар 49.1 сая төгрөгөөр нэмэгдэн төсөв биелэлт хангасан,
- Харин МСҮТ, Ахлах сургуулийн сургалтын төлбөрийн орлогын төсвийн гүйцэтгэл 98.6 хувь гарч хараахан төсвийн биелэлт хангагдаагүй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 83 хувийг бакалаврын сургалтын төлбөрийн орлого, 8.1 хувийг магистрыг сургалтын төлбөрийн орлого, 1 хувийг докторын сургалтын төлбөрийн орлого, 2.8 хувийг ахлах сургууль болон МСҮТ, Коосэн ТДС-ийн сургалтын төлбөрийн орлого, 2.2 хувийг түр сургалтын орлого бүрдүүлж байна. Мөн боловсролын зээлийн сангаар дамжин өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 105.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлого буурсан үзүүлэлтэй гарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого болох сургалтын төлбөрийн орлого болон түр сургалтын орлогыг бүрэлдэхүүн сургууль, нэгж тус бүрээр өмнөх оны дүнтэй харьцуулсан болон орлогын төсвийн гүйцэтгэлээр тодорхойлсон. ШУТИС-ийн хэмжээнд сургалтын төлбөрийн орлогын гүйцэтгэлээр тэргүүлэгч сургуулиудад БАС, ЭХС-иуд хамаарагдаж байна. Харин түр сургалтын орлогын төсвийн гүйцэтгэл 88.4 хувиар гарчээ. Мөн түр сургалтын орлого өмнөх оноос буурсан үзүүлэлтэй гарсан байна.

**СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, БҮРЭЛДЭХҮҮН
НЭГЖҮҮДЭЭР
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.9

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
			Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
1	БАС	5,835.84	4,934.43	5,623.65	-212.19	-3.6%	114%
2	БУХС	4,054.67	3,452.45	4,239.05	184.38	4.5%	123%
3	ГУУС	4,671.40	4,600.00	4,404.53	-266.87	-5.7%	96%
4	ДАРТС	2,311.82	2,077.10	2,757.28	445.46	19.3%	133%
5	МЕХТС	3,554.60	3,304.93	3,821.99	267.39	7.5%	116%
6	МХТС	4,147.17	4,061.87	4,181.31	34.14	0.8%	103%
7	ҮТС	4,146.99	4,143.59	4,198.35	51.36	1.2%	101%
8	ХШУС	956.01	689.00	873.41	-82.60	-8.6%	127%
9	ЭХС	5,285.11	4,445.83	5,552.46	267.35	5.1%	125%
10	Е-НИ	21.84	16.69	16.01	-5.83	-26.7%	96%
11	ГХИ	484.87	448.43	451.34	-33.53	-6.9%	101%
12	АС	466.24	429.00	418.45	-47.79	-10.2%	98%
13	КТК	360.75	450.00	441.22	80.47	22.3%	98%
14	ОУДБСТ	136.82	57.91	97.54	-39.28	-28.7%	168%
	Дүн	36,447.82	33,111.20	37,076.59	628.77	1.7%	

БАС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 3.6 хувиар буюу 212.19 сая төгрөгөөр, ГУУС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 5.7 хувиар буюу 266.87 сая төгрөгөөр, ХШУС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 8,6 хувиар буюу 82.6 сая төгрөгөөр, ЕНИ сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 26.7 хувиар буюу 5.83 сая төгрөгөөр, ГХИ сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 6.9 хувиар буюу 33.53 сая төгрөгөөр, Ахлах сургууль сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 10.2 хувиар буюу 47.79 сая төгрөгөөр, ОУДБСТ тайлант үеийн нийт орлого өмнөх оноос 28.7 хувиар буюу 39.28 сая төгрөгөөр буурсан байна.

БУХС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 4.5 хувиар буюу 184.38 сая төгрөгөөр, ДарТС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 19.3 хувиар буюу 445.46 сая төгрөгөөр, МехТС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 7.5 хувиар буюу 267.39 сая төгрөгөөр, МХТС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 0.8 хувиар буюу 34.14 сая төгрөгөөр, ҮТС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 1.2 хувиар буюу 51.36 сая төгрөгөөр, ЭХС сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 5.1 хувиар буюу 267.35 сая төгрөгөөр, Коосен ТК сургалтын төлбөрийн орлого өмнөх оноос 22.3 дахин буюу 80.47 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**ТҮР СУРГАЛТЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, БҮРЭЛДЭХҮҮН
НЭГЖҮҮДЭЭР
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.10

Д/Д	Бүрэлдэхүүн сургуулийн нэгжийн нэр	Ахлах сур, Коосэн, МСҮТ			Түр сургалт		
		Төсөв	гүйцэтгэл	биелэлт %	төсөв	гүйцэтгэл	биелэлт %
1	БАС					24.29	
2	БУХС				10.00	7.18	71.84%
3	ГУУС				300.00	234.13	78.04%
4	ДТС	96.00	105.73	110.13%	15.00	15.25	101.67%
5	МехТС	95.54	89.21	93.37%	50.00	66.11	132.21%
6	МХТС				71.00	74.04	104.27%
7	ҮТС				13.50	51.99	385.10%
8	ХШУС				80.00	17.82	22.27%
9	ЭХС				180.00	217.18	120.66%
10	Е-НИ				31.00	0.38	1.23%
11	ГХИ				135.00	61.59	45.62%
12	Ахлах сургууль	429.00	418.45	97.54%			
13	КТК	450.00	441.22	98.05%			
14	ОУДБСТ				33.50	46.60	139.09%
15	ОМССХ				20.00	11.58	57.89%
16	ШУТНС					2.02	
	ДҮН	1,070.54	1,054.60		939.00	830.14	

Ахлах сургууль, Коосен, МехТС-ийн МСҮТөвийн суралцагчийн төлбөр дутуу биелэлттэй байгаа нь коллеж болон ахлах сургуульд суралцагчдын сургалтын төлбөрөө бүрэн төлж барагдуулдаггүй байгаатай холбоотой юм. Сургалтын төлбөрөө төлөхгүй байгаа гол шалтгааны нэг бол тухайн өрхийн амьжиргааны түвшинтэй холбоотой асуудал юм.

Бүрэлдэхүүн сургуулиуд түр сургалтыг зохион байгуулснаар тухайлбал ГУУС-ийн эрдэс баялгийн судалгаа, Геомэдээлэл сургалтын төв, Газрын тос сургалт судалгааны төв, Уурхайн хөгжлийн сургалтын төвүүд нь зөвлөх инженерийн сургалт болон түр сургалтын зохион байгуулж 234.13 сая төгрөг, ЭХС зөвлөх инженерийн түр сургалтыг зохион байгуулснаас 217.18 сая төгрөг, ХШУС өвөл,

зуны сургалтуудыг зохион байгуулснаас 17.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж бүрэлдэхүүний бусад МехТС, МХТС, ҮТС, ОУДБСТ-иуд төсөвлөсөн дүнгээс түр сургалтын орлогоо нэмэгдүүлэн ажиллажээ. Харин БУХС, ГУУС, ХШУС, ЕНИ, ГХИ, ОМССХ зэрэг бүрэлдэхүүн нэгжүүдийн түр сургалтын орлого төсөвлөсөн дүндээ хүрээгүй байна.

8.3.2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГО

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орлогын үзүүлэлт нь мастер төлөвлөгөө болон судалгааны сургуульд шилжих гол шалгуур үзүүлэлтүүдийн нэг бөгөөд удирдлагын хүрээнд авч үздэг гол ач холбогдолтой үзүүлэлт юм. Тайлант онд эрдэм шинжилгээний орлого нь 3.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.69 хувиар буюу 441 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөвтэй харьцуулахад 8.1 хувь буюу 295.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Тайлант онд ШУТСангаас 732.88 сая төгрөгийн гэрээт ажил хийж гүйцэтгэсэн байна. Мөн БСШУСЯ-нд хэрэгжиж буй Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэл төслөөс 326.82 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, урсгал засварын ажлыг хийж эрдэм шинжилгээний орлогыг нэмэгдүүлсэн байна. 2018 оны төсвийн хүрээнд төрийн захиргааны болон ДБШТ-өөс санхүүжүүлж буй эрдэм шинжилгээний орлогыг төсөвлөөгүй байна. Харин эрдэм шинжилгээний орлогын үндсэн ангилал болох дотоод төсөл гэрээт ажил, гадаад төсөл гэрээт ажлын хүрээнд эрдэм шинжилгээний орлогыг төсөвлөсөн боловч 2018 оны гүйцэтгэл дүнгээр эрдэм шинжилгээний орлого хангаагүй гүйцэтгэл дүнтэй гарсан байна.

Эрдэм шинжилгээний орлогын нийт орлогод эзлэх хувь өнгөрсөн оноос 2.7 пунктээр буурч нийт орлогын 7 хувийг эзлэх болсон байна. Нийт гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний орлогын 27.04 хувийг ШУТС-ын болон Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын орлого бүрдүүлж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГО, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.11

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
I. Эрдэм шинжилгээний орлого	2,255.13	3,623.48	2,859.06	-764.4	78.9	73.0	126.8
Гадаад, төсөл гэрээт ажил		783.0	640.62	-142.4	81.8	16.3	
Дотоод, төсөл гэрээт ажил	2,255.13	2,840.5	2,218.45	-622.0	78.1	56.6	98.4
Бусад				0.0		-	
II. ШУТСан	453.01		732.88	732.9		18.7	161.8
III. ДБШТөсөл	769.24		326.82	326.8		8.3	42.5
Нийт орлого	3,477.38	3,623.48	3,918.76	295.3	108.1	100.0	112.7

Тайлант онд эрдэм шинжилгээний гадаад, дотоод төсөл гэрээт ажлын орлого 2.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны түвшинд байсан бол төсвийн гүйцэтгэл 81.8 хувьд хүрч орлогын төлөвлөгөө 764.4 сая төгрөгөөр тасарсан байна. Эрдэм шинжилгээний орлогын төсөвлөлт болон гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд тус бүрээр харьцуулахад:

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ,
БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.12

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он		Өмнөх оноос өөрчлөлт		Гүйцэтгэл хувь
			Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Хувь	
1	БАС	345.14	353.00	648.20	303.06	87.8%	184%
2	БУХС	108.11	70.00	110.95	2.84	2.6%	158%
3	ГУУС	850.31	700.00	1,144.50	294.19	34.6%	163%
4	ДАРТС	1.82	105.00	51.19	49.37	2712.9%	49%
5	МЕХТС	21.85	49.00	235.04	213.20	975.8%	480%
6	МХТС	151.13	500.00	60.32	-90.81	-60.1%	12%
7	ҮТС	239.89	306.80	593.89	354.00	147.6%	194%
8	ХШУС	57.71	60.00	71.60	13.88	24.1%	119%
9	ЭХС	276.56	550.00	523.68	247.12	89.4%	95%
10	Е-НИ	14.80	80.50	94.31	79.51	537.2%	117%
11	ОМССХ	115.98	174.50	110.99	-4.99	-4.3%	64%
12	ЭШИГ	71.84	204.68	296.79	224.95	313.2%	145%
	НИЙТ	2,255.13	3,208.48	3,941.46	1,686.33	74.8%	123%

Эрдэм шинжилгээний орлогыг БАС, ГУУС, ДарТС, МехТС, ҮТС, ЭХС, ХШУС зэрэг бүрэлдэхүүн нэгжүүд өмнөх оноос эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын орлогоо нэмэгдүүлсэн. Мөн эрдэм шинжилгээний орлогоо БАС, БУХС, ГУУС, МехТС, ҮТС, ХШУС эрдэм шинжилгээний орлогын төсвөө ханган ажилласан бол МХТС, ДарТС, ЭХС, ОМССХ эрдэм шинжилгээний орлогын төсвөө ханган биелүүлж чадаагүй байна. Эрдэм шинжилгээний дүрэм журмын дагуу 2018 онд ЭШИГ 170 сая төгрөгийн технологийн санд эрдэм шинжилгээний орлого /шимтгэл/ төвлөрүүлсэн байна. Тухайлбал: ГУУС 60.2 сая төгрөг, БАС 26.9 сая төгрөг, ҮТС 30.6 сая төгрөг, ЭХС 21.3 сая төгрөг, БУХС 5.3 сая төгрөг, МехТС 3.1 сая төгрөг, МХТС 3.0 сая төгрөг, ХШУС 4.0 сая төгрөг, ЕНИ 4.7 сая төгрөг

8.3.3. ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Туслах үйл ажиллагааны орлогод түрээсийн, хүүгийн, оюутны үйлчилгээний, үйлдвэрлэл үйлчилгээний болон бусад орлогыг оруулж тооцсон бөгөөд орлогын гүйцэтгэл 5,060.59 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1.7 дахин давж биелжээ. Харин урьд оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 3.13 хувь буюу 153.74 сая төгрөгөөр өссөн байна.

ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.13

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлого д эзлэх хувь	2018 / 2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
Оюутны байрны орлого	649.08	704.3	706.22	1.9	100.3	14.0	108.8
Түрээсийн орлого	135.62	181.9	113.03	-68.9	62.1	2.2	83.3
Хүүний орлого	1,911.79	-	2,058.75	2,058.7		40.7	107.7
Оюутны үйлчилгээ орлого	270.06		403.78	403.8		8.0	149.5
Үйлдвэр, үйлчилгээ	1,574.91	1,398.50	1,390.84	-7.7	99.5	27.5	88.3
Бусад орлого	359.17	573.94	373.02	-200.9	65.0	7.4	103.9
Гадаад валют зөрүү	6.22		14.95	15.0		0.3	240.4
Нийт орлого	4,906.85	2,858.64	5,060.59	2,202.0	177.0	100.0	103.1

Оюутны байрны орлого: Тайлант онд БУХС, МехТС, МХТС, ҮТС, ДарТС зэрэг бүрэлдэхүүн нэгжүүдийн оюутны байрны орлогын гүйцэтгэл дүн 706.2 сая төгрөгт хүрч 100.3 хувийн гүйцэтгэлтэй төсөвлөсөн дүнгээ ханган ажилласан. Сүүлийн жилүүдэд оюутны байрны төлбөрийг өсгөхгүйгээр тогтвортой барьж байсан.

Түрээсийн орлого: ШУТИС-д 20 гаруй аж ахуйн нэгж, хувь хүнд цайны газар, талбай, гарааш түрээслүүлдэг. Төрийн өмчийн хорооны тогтоолоор түрээсийн м.кв-ын үнэ 2016 онд өссөн. Энэхүү тарифаар бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд түрээсийн үнэ ханшийг мөрдлөг болгон төсөвлөсөн хэдий түрээслэгч газруудад ТӨБЗГ-аас хэрэгжүүлж буй дүрэм журмаар түрээслэгч газрууд төрийн санд 3 сарын түрээсийн төлбөртэй тэнцэхүйц мөнгийг байршуулах, түрээсийн тендерт ялахын тулд үндэслэлгүй үнийг санал тавьж тендерт ялж түрээсээ төлж чадахгүйд хүрсэн зэрэг шалтгааны улмаас энэхүү орлого тасарсан. Мөн өмнө нь түрээслэж байсан талбай, цайны газрыг өөрийн аж ахуйн зориулалтаар ашиглах болсон.

Хүүгийн орлого: ШУТИС-ийн захиргаанаас Хаанбанк, Голомтбанк, Улаанбаатар хотын банктэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 01 сарын 30-ний өдрийн 02 тоот

шийдвэрийн дагуу арилжааны банканд хөрөнгө оруулалтын зориулалттай мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулахаар шийдвэрлэсэн. Өмнөх оноос 7.7 хувиар 40.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний орлого: Үйлдвэр үйлчилгээний орлого 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарч төсөвлөсөн дүндээ хараахан хүрээгүй болно. Үйлдвэрлэл, үйлчилгээний орлогод ҮТС-иас цайны газрын орлого 629.6 сая төгрөг, Эрдэмнэт төвийн үйл ажиллагааны орлого 407.0 сая төгрөг, ХГазар-328.0 сая төгрөг хамаарагдаж байна.

Бусад орлого: Бүрэлдэхүүн сургуулийн бусад орлогод хурлын заалны төлбөр, ромбын төлбөр, багш нарын хичээл таслалт, горхийн полигоны айлуудаас орсон төлбөр, түрээсийн гэрээтэй газруудын цахилгааны төлбөр гэх мэт орлогууд багтсан.

8.3.4 ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ОРЛОГО

Төсвөөс санхүүжүүлэх орлогод тогтмол зардлын санхүүжилт буюу төвлөрсөн төсвөөс санхүүжих, орон нутгийн төсвөөс санхүүжих МСҮТ болон лецейн хувьсах зардал, оюутны унааны хөнгөлөлт, тусламжийн орлогыг оруулж тооцсон. Тайлант онд төсвөөс санхүүжигдэх орлого өнгөрсөн оноос 9.79 хувиар 717.78 сая төгрөгөөр буурсан, төсвөөс 2.3 дахин буюу 3.8 тэрбум төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй гарсан.

ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ОРЛОГО, НЭГДСЭН ДҮНГЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.14

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
Тогтмол зардлын санхүүжилт	1,359.21	2,053.02	1,441.29	-611.7	70.2	21.8	106.0
Орон нутгийн санхүүжилт /Лецей хувьсах зардал/	176.52	91.35	109.87	18.5	120.3	1.7	62.2
Хувьсах зардлын санхүү /МСҮТ/	279.66	362.34	281.72	-80.6	77.8	4.3	100.7
Оюутны унааны хөнгөлөлт	144.04	152.12	121.17	-31.0	79.6	1.8	84.1
Тусламжын орлого /хөрөнгийн/	5,374.07	126.00	4,661.68	4,535.7	3,699.7	70.5	86.7
Нийт орлого	7,333.50	2,784.84	6,615.73	3,830.9	237.6	100.0	90.2

Тайлант онд төсвөөс санхүүжигдэх орлого нь төлөвлөснөөс 2.3 дахин 3.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь 2018 оны 12 сарын 27-нд Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжаар Коосен ТК-д 3,1 тэрбум төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийн хандивласан хөрөнгийн эх үүсвэрийг тусламжийн орлогоо

бүртгэсэнтэй холбоотой юм. Нийт төсвөөс санхүүжүүлэх орлогын 70.5 хувийг тусламжийн орлого, 21.8 хувийг тогтмол зардлын санхүүжилт эзэлж байна.

Тогтмол зардлын санхүүжилт: Тайлант онд улсын төсвөөс тогтмол зардлын санхүүжилтэд 200 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс тайлант хугацаанд шинээр үүсгэсэн тогтмол зардлын авлагыг хассанаар 1,441.29 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. ШУТИС-д 2016 онд 667.0 сая төгрөг, 2017 онд 930.0 сая төгрөг, 2018 онд 1,041.0 сая төгрөг нийт 2,639 сая төгрөгийн гэрэл, цахилгаан, дулаан, халаалт, цэвэр, бохир усны зардал гарсан хэдий ч төлөгдөөгүй авлагаар бүртгэгдсэн байна.

Орон нутгийн санхүүжилт: Ахлах сургууль, Коосен Технологийн коллежийн суралцагчийн хувьсах зардалд 109.87 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Гүйцэтгэл дүн төсөвлөсөн дүнгээс 18.5 сая төгрөгийн илүү дүнтэй санхүүжилт хийгдсэн байна.

Хувьсах зардлын санхүүжилт: МСҮТөвийн суралцагчдын хувьсах зардал 281.72 сая төгрөгт хүрч өнгөрсөн оноос 0.7 хувиар 2.07 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч төсвийн гүйцэтгэл 77.8 хувь буюу 80.6 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан.

Оюутны унааны хөнгөлөлт: ШУТИС-ийн хэмжээнд оюутны унааны хөнгөлөлтийн зардалд 121.17 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Оюутны унааны хөнгөлөлтийн зардалд өмнөх оноос 15.8 хувиар, төсвөөс 20.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Тусламжийн орлого: Гадаад орны Засгийн газар болон олон улсын байгууллага, дотоодын байгууллага, хувь хүнээс хариу төлбөргүй олгосон буцалтгүй тусламж, мөн эх үүсвэрээр санхүүжиж буй төслийн орлого хамаардаг.

8.4. ЗАРДАЛ

Тайлант оны зарлагыг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/237 тоот тушаалаар батлагдсан ШУТИС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.9 зардлын бүртгэл, горимын дагуу сургалттай холбоотой шууд, шууд бус, оюутан үйлчилгээний зардал, эрдэм шинжилгээ, инновацийн зардал, хөрөнгө оруулалтын зардал гэсэн бүтэцтэй авч үзлээ. Зарлагын дүнг санхүүгийн тайлангийн Санхүүгийн үр дүнгийн (СТ-2А) тайлангаас авч, ШУТИС төв, бүрэлдэхүүн нэгжүүдийн хоорондын сургууль хоорондын тооцооны орлогыг хасаж тухайн тайлант хугацааны зарлагыг тооцлоо.

Тайлант онд төсвийн зардлын гүйцэтгэл 48,639.1 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 8,336.3 сая төгрөгөөр дутуу, 85.4%-ийн гүйцэтгэлтэй гарч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 1.17 хувь буюу 575.7 сая төгрөгөөр буурсан байна. Нийт зардлын 62.3 хувийг сургалтын үйл ажиллагааны зардалд, 29.3 хувийг шууд бус зардалд, 7.5 хувийг эрдэм шинжилгээ төсөл, гэрээт ажлын зардалд, 0.8 хувийг оюутны үйлчилгээний зардалд, 0.1 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна.

ТАЙЛАНТ ҮЕИЙН НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.15

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлог од эзлэх хувь	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
I. Сургалттай холбоотой шууд зардал	28,593.22	32,083.45	30,303.20	1,780.3	94.5	62.3	106.0
II. Шууд бус зардал	16,597.33	10,990.7	14,243.00	3,252.3	129.6	29.3	85.8
III. Оюутны үйлчилгээний зардал	612.24	520.2	403.15	-117.1	77.5	0.8	65.8
IV. Эрдэм шинжилгээ, инновацийн зардал	3,303.88	4,483.12	3,637.50	-845.6	81.1	7.5	110.1
V. Хөрөнгө оруулалтын зардал	108.15	8,897.9	52.25	8,845.6	0.6	0.1	48.3
Нийт зардал	49,214.82	56,975.41	48,639.10	-8,336.3	85.4	100.0	98.8

Бүтцээр урьд оны гүйцэтгэлтэй харьцуулан авч үзвэл:

- Сургалттай холбоотой шууд зардал 5,98 хувиар 1,710.0 сая төгрөгөөр өссөн
- Шууд бус зардал 14.19 хувиар 2.3 тэрбум төгрөгөөр буурсан
- Оюутны үйлчилгээний зардал 34.15 хувиар 209.1 сая төгрөгөөр буурсан
- Эрдэм шинжилгээ, инновацийн зардал 10.1 хувиар 333.6 сая төгрөгөөр өссөн
- Хөрөнгө оруулалтын зардал 51.6 хувиар 55.9 сая төгрөгөөр буурч гарсан байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулан авч үзвэл:

- Сургалттай холбоотой шууд зардал 94.5 хувь, 1,7 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй
- Шууд бус зардал 29.6 хувиар буюу 3.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн
- Оюутны үйлчилгээний зардал 77.5 хувь буюу 117.1 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй
- Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны зардал 81.1 хувь буюу 845.6 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй
- Хөрөнгө оруулалтын зардал 0.6 хувь буюу 8.8 тэрбум төгрөгийн дутуу гарсан байна.

Сургалттай холбоотой шууд зардал: Сургалттай холбоотой шууд зардал дутуу гүйцэтгэлтэй гарсан шалтгаан нь багшийг дэмжих зардал, мэргэжил дээшлүүлэх зардал, ахмадын арга хэмжээний зардал, ойн арга хэмжээний зардал зэрэг багш нарын үйл ажиллагаатай холбоотой зардал, лаборатори, дадлага,

сургалтын бичиг хэргийн зардал, интернэт үйлчилгээний зардал, е сургалтын зардал зэрэг хичээл практикийн зардал буурсантай холбоотой байна.


Шууд бус зардал: Шууд бус зардал өмнөх оноос буурсан боловч төвөөс хэтэрсэн гол шалтгаан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 237 сая төгрөгөөр болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний 4.7 тэрбум төгрөгийн элэгдэл хорогдлын зардал гарч шууд бус зардал өссөнтэй холбоотой байна.

Оюутны үйлчилгээний зардал: Оюутны үйлчилгээний зардал дутуу гүйцэтгэлтэй гарсан шалтгаан нь оюутны тооноос хамааралтай оюутны унааны хөнгөлөлтийн зардал, оюутны тэтгэлэг, урамшууллын зардал буурсантай холбоотой.

Эрдэм шинжилгээ, инновацийн зардал: Эрдэм шинжилгээ, инновацийн зардал төсөвлөсөн хэмжээнээс дутуу гүйцэтгэлтэй гарсан шалтгаан нь төлөвлөсөн зарим эрдэм шинжилгээний ажил хийгдээгүйтэй холбоотой байна. Тухайлбал ГУУС-ийн Эрдэнэт үйлдвэртэй хамтарсан эрдэм шинжилгээний төслийн зарцуулалт түр зогссон.

Хөрөнгө оруулалтын зардал: Хөрөнгө оруулалтын зардал өнгөрсөн 2018 онд харьцангуй бага хийгдсэн. Учир нь 2018 оны 3 сарын 1-нд багш, ажиллагчдын цалинг 10 хувиар нэмсэнтэй холбоотой хөрөнгө оруулалт болон худалдан авалтын зардлыг түр хугацаанд зогсоосон. Мөн 2018 оны 10 сарын 1-ээс цалинг тодорхой түвшинд дахин нэмсэнтэй холбоотой худалдан авалт, хөрөнгө оруулалтын зардлыг царцааж, шаардлагагүй бол уг зардлыг гаргахгүй байхаар захиргаанаас удирдамж өгсөн.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сургууль тус бүрээр харуулбал:



Зураг 8.4. ШУТИС-ийн 2018 оны бүрэлдэхүүн нэгжийн зарлагын төсөв, гүйцэтгэл

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн хувьд тэвчиж болох зардлуудыг хойшлуулж, зардлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлснээр зардлаа нийт дүнгээр нь бууруулан ажилласан. Тайлант хугацаанд ДарТС, МехТС, ҮТС, ОУДБСТ, Хэвлэлийн газар зэрэг нэгжийн хувьд батлагдсан төсвөөс нийт зардлаа хэтрүүлсэн байна.

8.4.1. СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ

Сургалттай холбоотой зардлын гүйцэтгэл 30.3 тэрбум төгрөг хүрч төлөвлөснөөс 1.7 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Үүний 147 сая төгрөг нь сургалттай холбоотой шууд зардлын цалин, НДШ-ийн зардал, 1,3 тэрбум төгрөг нь хичээл практикийн зардал, 162 сая төгрөг нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал байна. Сургалттай холбоотой шууд зардлын 82.9 хувийг багш, цагийн багш, сургалтын албаны ажилтан, хичээлийн туслах ажилтны үндсэн болон нэмэгдэл цалин, илүү цагийн хөлс эзэлж байна. Үүнд ШУТАС, КООСЭН багтсан үзүүлэлт юм.


СУРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.16

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлогод злэх хувь	2018/ 2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
Үндсэн болон нэмэгдэл цалин	23,391.70	25,272.79	25,125.27	-147.5	99.4	82.9	107.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,364.69	1,606.2	1,444.09	-162.1	89.9	4.8	105.8
Томилолтын зардал /гадаад, дотоод/	39.45	425.3	383.71	-41.6	90.2	1.3	972.7
Багшийн арга хэмжээ	1,836.72	1,931.42	1,872.61	-58.8	97.0	6.2	102.0
Хичээл практик зардал	1,960.66	2,847.71	1,477.52	-1,370.2	51.9	4.9	75.4
Нийт зардал	28,593.22	32,083.45	30,303.20	-1,780.3	94.5	100.0	106.0

Хичээл практикийн зардал 1.4 тэрбум төгрөгт хүрч, урьд оны гүйцэтгэлээс 24.6 хувь буюу 4831 сая төгрөгөөр, төсвөөс 51.9 хувь буюу 1,3 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Хичээл практикийн зардалд лабораторийн зардал 192.9 сая төгрөг, сургалтын зардал 18.0 сая төгрөг, дадлагын зардал 108.6 сая төгрөг, сургалтын бичиг хэргийн зардал 41.3 сая төгрөг, интернэтийн зардал 51.5 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Сургалттай холбоотой цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал 25.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 99.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 147.5 сая төгрөгөөр дутуу, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 7.4 хувиар буюу 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Зураг 5. ШУТИС-ийн 2018 оны сургалттай холбоотой шууд зардал

ПРОФЕССОР, БАГШ НАРЫН ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР
(сая төгрөгөөр)

Хүснэгт 8.17

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2017 он	2018 он		Өөрчлөлт		Багш дундаж цалин
			Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
1	БАС	1,937.61	2,061.98	2,030.91	93.29	4.8%	1,458,084
2	БУХС	2,330.64	2,488.89	2,322.44	-8.21	-0.4%	1,590,367
3	ГУУС	1,988.12	1,918.32	1,892.28	-95.84	-4.8%	1,556,571
4	ДАРТС	1,364.93	1,491.32	1,469.51	104.58	7.7%	1,384,901
5	МЕХТС	1,676.66	1,862.97	1,775.15	98.49	5.9%	1,585,764
6	МХТС	1,446.26	1,624.49	1,555.03	108.77	7.5%	1,461,166
7	ҮТС	1,693.46	1,728.85	1,702.90	9.45	0.6%	1,269,386
8	ХШУС	2,013.46	2,167.08	2,151.98	138.52	6.9%	1,566,137
9	ЭХС	1,335.68	1,455.00	1,409.38	73.70	5.5%	1,247,461
10	Е-НИ	327.33	361.14	332.15	4.82	1.5%	1,399,942

11	ГХИ	1,626.72	1,606.09	1,602.49	-24.23	-1.5%	1,365,172
12	АС	260.64	234.05	193.77	-66.87	-25.7%	1,273,177
13	КТК	197.40	273.17	259.71	62.31	31.6%	1,240,338
14	ОУДБСТ	15.13	27.49	27.49	12.36	81.7%	1,309,218
15	ОМССХ	2.34	32.01	2.48	0.14	6.0%	
16	ЗАХ	47.23	53.54	53.54	6.31	13.4%	
17	ЭШИГ	27.40	20.00	5.54	-21.87	-79.8%	
	НИЙТ	18,291.01	19,406.38	18,786.73	495.72	2.7%	

Сургалттай холбоотой цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал БАС, ДарТС, МехТС, МХТС, ХШУС, ЭХС, КТК зэрэг бүрэлдэхүүн нэгжүүдийн хувьд профессор багш нарын цалингийн зардал өмнөх оноос өссөн байна. Харин БУХС, ГУУС, ГХИ сургуулиудын хувьд цалингийн зардал буурсан байна.

БАГШ, АЖИЛЛАГЧТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.18

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
Багш дэмжих	453.3	372.38	-81.0	82.1	1.2
Мэргэжил дээшлүүлэх	251.5	175.87	-75.6	69.9	0.6
Ахмадын арга хэмжээ	80.3	61.40	-18.9	76.5	0.2
Багш, ажилтны арга хэмжээ	200.5	181.62	-18.9	90.6	0.6
Ойн арга хэмжээ	13.5	1.39	-12.1	10.3	0.0
Бусад	932.3	1,080.0	147.7	115.8	3.6
Нийт	1,931.42	1,872.61	-58.8	97.0	6.2

Багш, ажиллагчтай холбоотой зардалд багшийг дэмжих зардал, мэргэжил дээшлүүлэх зардал, ахмадын арга хэмжээний зардал, багш ажилтны арга хэмжээний зардал, ойн арга хэмжээний зардал зэрэг зардлууд хамаарч байна. Багш ажиллагчдын зардал 1.8 тэрбум төгрөгт хүрч төсвөөс 97 хувиар буюу 58.8 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. 2018 онд ШУТИС-ийн захиргаанаас багш, ажиллагчдын цалин нэмсэнтэй холбоотойгоор зардлыг царцаах, зогсоох, зардлыг бууруулах чиглэлээр удирдлагаар ханган ажилласан.

Багшийг дэмжих зардал: Тайлант онд 372.28 сая төгрөгт хүрч төсөвлөсөн дүнгээс 82.1 хувиар буюу 81 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан.

Мэргэжил дээшлүүлэх зардал: Тайлант онд 175.87 сая төгрөгт хүрч төсөвлөсөн дүнгээс 69.9 хувиар буюу 75.6 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан.

Бусад зардал: Багш ажиллагчтай холбоотой бусад зардалд багш нарын ээлжийн амралтаар явах унааны зардал, тэтгэвэрт гарсан багшид олгох тэтгэмжийн зардал, багш нарын эмчилгээний зардал, бүтцийн өөрчлөлтийн тэтгэмжийн зардал, багш нарт олгосон шагнал урамшууллын зардал хамаарагдаж байна. Тэтгэмжтэй холбоотой төсөвлөсөн дүнгээс 147.7 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХИЧЭЭЛ ПРАКТИКТАЙ ХОЛБООТОЙ ШУУД ЗАРДАЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.19

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
Лаборатори	934.3	741.38	-192.9	79.3	2.4
Е сургалт	67.6	49.62	-18.0	73.4	0.2
Дадлага	330.8	222.20	-108.6	67.2	0.7
Сургалтын бичиг хэрэг	200.3	159.04	-41.3	79.4	0.5
Интернет үйлчилгээ	353.6	302.07	-51.5	85.4	1.0
бусад	961.2	3.22	-958.0	0.3	0.0
Нийт	2,847.71	1,477.52	-1,370.2	51.9	4.9

Хичээл практиктай холбоотой шууд зардалд лабораторийн зардал, е сургалтын зардал, дадлагын зардал, сургалтын бичиг хэргийн зардал, интернэт үйлчилгээний зардлууд хамаарч байна. Хичээл практикийн зардал нийт зардалд 4.9 хувийг эзэлж байна. Мөн 2018 онд ШУТИС-ийн захиргаанаас багш, ажиллагчдын цалин нэмсэнтэй холбоотойгоор зардлыг царцаах, зогсоох, зардлыг бууруулах чиглэлээр удирдлагаар ханган ажилласан.

Лабораторийн зардал: Лабораторийн зардал тайлант онд 741.38 сая төгрөгт хүрч төсөвлөсөн дүнгээс 79.3 хувиар буюу 192.9 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан.

Е сургалтын зардал: Е сургалтын зардал тайлант онд 49.62 сая төгрөгт хүрч төсөвлөсөн дүнгээс 73.4 хувиар буюу 18.0 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан.

Бусад зардал: Хичээл практикийн холбогдолтой бусад зардалд лаборатор болон е сургалт, дадлага, сургалтын бичиг хэрэг, интернет үйлчилгээний зардлаас бусад хичээл практикийн зардлын хамааруулдаг. Бусад зардал тайлант онд харьцангуй бага гарсан байна.

8.4.2. ШУУД БУС ЗАРДАЛ

Тайлант онд шууд бус зардал 14.243 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 29.6 хувиар буюу 3.2 тэрбум төгрөгөөр, урьд оны гүйцэтгэлээс 14.19 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт зардлын дүнд шууд бус зардлын эзлэх хувь 29.3 хувь байна. Шууд бус зардлын дийлэнх төрөл зүйл дээр хэмнэгдсэн бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бусад зардал хэтэрсэн дүнтэй байна. Өнгөрсөн хугацаанд тайлант оны төсвийг батлахдаа шууд бус зардлын төсвийг зардлын төрөл зүйл бүрээр хянан бууруулж батлахыг Удирдах зөвлөлөөс чиглэл болгосон. Энэ нь Монгол Улсын Их хурлын 47 тоот тогтоол, Засгийн газрын 141 тоот тогтоол зэрэг эрх зүйн хүчинтэй баримт бичгийг мөрдөн ажиллахыг зааварласан. Тиймээс захиргааны бичиг хэрэг, шуудан холбоо, тээврийн

зардлуудын нормыг бууруулан шинэчлэн тогтоосон нормативыг мөрдөн ажилласан. Бусад зардал хэтэрсэн гол шалтгаан нь 2018 онд Засгийн газар, Сангийн сайдын баталсан дүрэм журмын дагуу ТӨБЗГ-ийн даргын шийдвэрээр үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой элэгдлийн зардал төсөвт тусгагдаагүй байна. Мөн ҮТС-ийн цайны газрын үйл ажиллагааны зардал болон Эрдэмнэтийн төвийн үйл ажиллагааны зардал хамаарч байна.

ШУУД БУС ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.20

Үзүүлэлт	2017	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь	2018/2017
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй		
Үндсэн болон нэмэгдэл цалин	6,734.80	6,607.05	6,210.26	-396.8	94.0	43.6	92.2
Хангамж бараа материал, эд хогшил зардал	443.83	1,185.51	521.59	-663.9	44.0	3.7	117.5
Урсгал засвар	786.01	1,146.2	838.41	-307.8	73.1	5.9	106.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	672.59	736.00	973.60	237.6	132.3	6.8	144.8
Бусад зардал	7,960.10	1,315.93	5,699.14	4,383.2	433.1	40.0	71.6
Нийт зардал	16,597.33	10,990.72	14,243.00	3,252.3	129.6	100.0	85.8

Үндсэн болон нэмэгдэл цалин: Удирдлагын болон захиргааны ажилтны цалин, нэмэгдэл, урамшууллын зардал 6.2 тэрбум төгрөгт хүрч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 7.79 хувь буюу 524.5 сая төгрөгөөр буурсан, төсвөөс 94 хувиар буюу 396.8 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Хангамжийн бараа материал, эд хогшил зардал: Хангамжийн бараа материал, эд хогшил зардал 521.59 сая төгрөгт хүрч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 17.52 хувь буюу 77.8 сая төгрөгөөр нэмэгдэн, төсвөөс 44 хувиар буюу 663.9 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Урсгал засвар: Тайлант онд урсгал засварын зардалд 838.41 сая төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 6.67 хувь буюу 52.4 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөвлөсөн зарим засварууд хийгдээгүйгээс төсвөөс 73.1 хувь буюу 307.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ: Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 973.60 сая төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 44.75 хувь буюу 301.0 сая төгрөгөөр нэмэгдэж, төсвөөс 32.3 хувиар хэтэрч 237.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад зардал: Шууд бус зардлын бусад зардалд үйлдвэрлэл, үйлчилгээний зардал, элэгдэл хорогдлын зардал, найдваргүй авлагын зардал, валютын ханшийн зөрүүний зардал, үндсэн хөрөнгө хассан гарзын зардал хамаардаг. Бусад зардал тайлант онд харьцангуй бага гарсан байна. Тайлант онд бусад зардалд 5.60 тэрбум төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 28.4 хувь буюу 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвөөс 4.3 дахин буюу 4.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ЭЛЭГДЭЛ, ХОРОГДОЛЫН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.21

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2018 он		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
1	БАС		398.84			8%
2	БУХС		354.62			7%
3	ГУУС		211.92			4%
4	ДАРТС		308.32			6%
5	МЕХТС		567.47			12%
6	МХТС		479.29			10%
7	ҮТС		1,037.54			22%
8	ХШУС		155.94			3%
9	ЭХС		420.69			9%
10	Е-НИ		105.32			2%
11	ГХИ		18.67			0.4%
12	АС		71.41			1%
13	КТК		29.30			1%
14	ОУДБСТ		14.17			0.3%
15	ОМССХ		10.56			0.2%
16	ХГ		93.99			2%
17	ЗАХ		508.62			11%
18	Енэт		11.09			0.2%
	НИЙТ	-	4,797.75			100%

Нийт шууд бус зардлын 33.7 хувийг, шууд бус зардлаас 4.3 дахин төсвөөс хэтэрсэн зардал нь элэгдэл хорогдлын зардал байна. Элэгдэл хорогдлын зардлыг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдээр авч үзвэл ҮТС хамгийн өндөр буюу 22 хувийг, МехТС 12 хувийг, МХТС 10 хувийг, Захиргаа 11 хувийг эзэлж байна. Элэгдэл хорогдлын зардлыг төсвийн хүрээнд төсөвлөөгүй байна. Шууд бус зардлаас хангамжийн бараа материал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг дэлгэрэнгүй задлан авч үзье.

Хангамжийн бараа материал, эд хогшил зардалд бичиг хэргийн зардал, тээвэр шатахууны зардал, шуудан холбоо интернэгийн зардал, ном хэвлэлийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн худалдан авах зардал, эм

бэлдмэлийн зардал, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, багаж техник хэрэгслийн зардал, тавилгын зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал хамаардаг. Тайлант хугацаанд хангамжийн бараа материал, эд хогшлоос бичиг хэргийн зардал, багаж техник хэрэгслийн зардал төсвийн дүнгээр хэтэрсэн бусад зардлын хувьд төсвөөс хэтрээгүй дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

**ХАНГАМЖИЙН БАРАА МАТЕРИАЛ, ЭД ХОГШИЛ ХУДАЛДАН
АВАХ ШУУД БУС ЗАРДАЛ (сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.22

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абсалют	Харьцангуй	
Бичиг хэрэг	50.1	87.97	37.8	175.5	0.6
Тээвэр шатахуун	50.1	49.19	-0.9	98.3	0.3
Шуудан холбоо, интернет	43.7	27.29	-16.4	62.4	0.2
Ном, хэвлэл	441.4	120.12	-321.3	27.2	0.8
Ахуйн эд зүйлс /бага үнэтэй, түргэн элэгдэх/	183.5	146.09	-37.4	79.6	1.0
Эм бэлдмэл	33.3	31.09	-2.2	93.4	0.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	46.1	40.08	-6.0	86.9	0.3
Багаж техник хэрэгсэл		5.29	5.3	#DIV/0!	0.0
Тавилга	281.2	5.21	-276.0	1.9	0.0
Хөдөлмөр хамгаалал хэрэгсэл	56.1	9.26	-46.8	16.5	0.1
Хангамж бараа материал, эд хогшил зардал	1,185.51	521.59	-663.9	44.0	3.7

Бичиг хэргийн зардал: Тайлант онд бичиг хэргийн зардалд 87.97 сая төгрөгт хүрч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 1.89 хувь буюу 1.6 сая төгрөгөөр нэмэгдэн, төсвөөс 75.5 хувиар хэтэрсэн буюу 37.8 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй гарчээ.

Ном хэвлэлийн зардал: Тайлант онд ном хэвлэлийн зардалд 120.12 сая төгрөгт хүрч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал 55.22 хувь буюу 42.7 сая төгрөгөөр нэмэгдэн, төсвөөс 27.2 хувиар буюу 321.3 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Тавилгын зардал: Тайлант онд тавилгын зардалд 5.21 сая төгрөгт хүрч урьд оны гүйцэтгэлтэй харьцуулбал бараг 95 хувь буюу 100.0 орчим сая төгрөгөөр буурсан, төсвөөс бараг 100 хувиар буюу 276.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. 2018 онд ШУТИС-ийн захиргаанаас багш, ажиллагчдын цалин нэмсэнтэй холбоотойгоор зардлыг царцаах, зогсоох, зардлыг бууруулах чиглэлээр удирдлагаар ханган ажилласан.

**БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ШУУД БУС
ЗАРДАЛ
(сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.23

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлого д эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
Аудит, баталгаажуулалт		61.83	61.8	#DIV/0!	0.4
Мэдээлэл, сурталчилгаа	106.0	107.74	1.7	101.6	0.8
Мэдээлэл, технологи	37.5	22.01	-15.5	58.6	0.2
Харуул хамгаалалт	297.4	291.07	-6.3	97.9	2.0
Оношлогоо, даатгал, банк, санхүү, өмгөөлөл	39.5	25.88	-13.6	65.5	0.2
Төлбөр хураамж, татвар, гишүүний төлбөр	86.0	289.97	203.9	337.0	2.0
Магадлан итгэмжлэлийн зардал /дотоод, гадаад/	169.5	175.11	5.6	103.3	1.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	736.00	973.60	237.6	132.3	6.8

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд аудит, баталгаажуулалтын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, мэдээлэл, технологийн зардал, харуул хамгаалалтын зардал, оношилгоо, даатгал, банк санхүүгийн зардал, төлбөр хураамж, татвар гишүүний төлбөрийн зардал, магадлан итгэмжлэлийн зардал хамаарч байна. Тайлант хугацаанд төлбөр хураамж, татвар, гишүүний төлбөрийн зардал 3.3 дахин, магадлан итгэмжлэлийн зардал 3.3 хувиар хэтэрсэн ба бусад зардлын хувьд төсвөөс хэтрээгүй дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Төлбөр хураамж, татвар, гишүүний төлбөр: Тайлант онд төлбөр хураамж, татвар гишүүний төлбөрийн зардалд 289.97 сая төгрөгт хүрч төсвөөс 3.3 дахин буюу 203.9 сая төгрөгөөр хэтэрсэн гүйцэтгэлтэй гарчээ.

8.4.3. ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

Оюутны байгууллагын үйл ажиллагааг дэмжих, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг урамшуулах, урлаг, спортын наадмыг зохион байгуулах, оюутанд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөх зэрэг ажлуудад тайлант онд 403.15 сая төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 34.15

хувь буюу 209.1 сая төгрөгөөр, төсөвлөснөөс 77.4 хувиар буюу 30.5 сая төгрөгөөр тус тус буурчээ.

ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.24

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
Оюутны эрдэм шинжилгээ, судалгаа	134.9	104.37	-30.5	77.4	2.6
Оюутны спорт, урлаг	101.5	132.58	31.1	130.6	3.2
Магистр, докторын	15.9	4.99	-11.0	31.3	0.1
Оюутны тэтгэлэг хөнгөлөлт, урамшуулал	117.8	38.13	-79.6	32.4	0.9
Оюутны унаа	150.1	123.08	-27.0	82.0	3.0
Нийт зардал	520.23	403.15	-117.1	77.5	9.9

Оюутны үйлчилгээний зардлын 60 хувийг оюутны эрдэм шинжилгээний зардалд, 40 хувийг оюутны урлаг спортын арга хэмжээнд зарцуулах нормтойгоос тайлант онд оюутны эрдэм шинжилгээний зардалд 25.89 хувийг, оюутны спорт урлагийн арга хэмжээнд 32.89 хувийг зарцуулсан байна. Иймд оюутны үйлчилгээний зардлын зохицуулалтыг шинэлэх, өөрчлөх, оюутны судалгаа, шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, оюутанд бүтээлч ажил хийхэд дэмжлэг үзүүлэх замаар оюутны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэл рүү анхааран ажиллах шаардлагатай байна. Мөн Оюутны хөгжил үйлчилгээний алба, ШУТИС-ийн оюутны зөвлөлтэй хамтран зохион байгуулж буй ажлуудаа уялдуулан төсвийн төсөлд тусгадаг зарчимд шилжин ажиллах шаардлагатай байна.

Тайлант онд ШУТИС-ийн захирлын нэрэмжит, Тоёото корпораци, Мицубиши, БНСУ-ын тэтгэлэг, Сүмэтомо корпораци, Posco сан, бусад сан ААНБ, ТББ-аас нийт 60 гаруй оюутанд 38.13 сая төгрөгийн тэтгэлэг болон сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна.

Оюутны эрдэм шинжилгээ, судалгаа: Тайлант онд оюутны эрдэм шинжилгээ, судалгааны зардалд 104.37 сая төгрөгт хүрч төсвөөс 77.4 хувь буюу 30.5 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Нийт оюутны үйлчилгээний зардлын 25.89 хувийг уг зардал эзэлж байна.

Оюутны спорт, урлаг: Тайлант онд оюутны спорт, урлагийн зардалд 132.58 сая төгрөгт хүрч төсвөөс 30.6 хувь хэтэрсэн буюу 31.1 сая төгрөгөөр нэмэгдсэн гүйцэтгэлтэй гарчээ. Нийт оюутны үйлчилгээний зардлын 32.89 хувийг оюутны спорт, урлагийн зардал эзэлж байна.

Магистр, докторын: Тайлант онд магистр, докторын оюутны зардалд 4.9 сая төгрөгт хүрч төсвөөс 31.3 хувь буюу 11.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Нийт оюутны үйлчилгээний зардлын 1.24 хувийг магистр, докторын оюутны зардал эзэлж байна.

Оюутны тэтгэлэг хөнгөлөлт, урамшуулал: Тайлант онд оюутны тэтгэлэг хөнгөлөлт, урамшууллын зардалд 123.08 сая төгрөгт хүрч төсвөөс 82.0 хувь буюу 27.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Нийт оюутны үйлчилгээний зардлын

9.4 хувийг оюутны оюутны тэтгэлэг хөнгөлөлт, урамшууллын зардал эзэлж байна. 2018 онд ШУТИС-ийн захиргаанаас багш, ажиллагчдын цалин нэмсэнтэй холбоотойгоор зардлыг зогсоох, үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр удирдлагаар ханган ажилласан.

8.4.4 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

2018 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөн ажиллаж байна. Уг бодлогын баримт бичгийн хүрээнд эрдэм шинжилгээний орлого, зарлагын бүртгэлийг өөрчлөн сайжруулсан. Тиймээс ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн эрдэм шинжилгээний орлого, зарлагыг дараах төрөл хэлбэрээр бүртгэсэн болно. Тайлант онд 3,637.5 сая төгрөг зарцуулсан нь урьд оны гүйцэтгэлээс 10.10 хувь буюу 333.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, төсөвлөснөөс 81.1 хувиар буюу 845.6 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.25

Үзүүлэлт	2018		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх хувь
	Төсөв	Гүйцэтгэл	Абслют	Харьцангуй	
Багш, ажилтны арга хэмжээ		322.28	322.3		7.9
ШУТСангийн арга хэмжээ		388.20	388.2		9.5
ДБШТөсөл		241.39	241.4		5.9
ШУТИСТөсөл		54.93	54.9		1.3
Гэрээт ажил		1,650.56	1,650.6		40.3
Инноваци	311.6	27.74	-283.9		0.7
бусад		952.43	952.4		23.3
Нийт зардал	4,483.1	3,637.50	-845.6	81.1	88.9

Эрдэм шинжилгээний зардалд багш, ажилтны арга хэмжээний зардал, ШУТ сангийн арга хэмжээний зардал, Дээд боловсрол шинэчлэл төслийн зардал, ШУТИС-ийн технологийн сангийн зардал, гэрээт ажлын зардал, инновацийн зардал зэрэг төрөл ангилалтай байна. Эрдэм шинжилгээний зардал болон орлогын ангилал нь эх үүсвэрийн ангиллаар ангилагдсан байна. Харин төсөл хөтөлбөр бүрийн дотор нь төслийн гэрээт ажилтны цалин хөлс, гадны байгууллагаар хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээний төлбөр, гадаад, дотоод томилолтын зардал, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, их сургуулийн лаборатори, судалгаа туршилтын бааз, багаж, тоног төхөөрөмж ашигласны шимтгэл зэрэг зардлын төрлүүдтэй. Тайлант хугацаанд нийт орлогын 7.5 хувийг эрдэм шинжилгээний зардал эзэлж байна.

ШУТИС-ийн 2018 оны зарлагын төсөвт эрдэм шинжилгээний зарлагыг төсөвлөхдөө төсөл, гэрээт ажлын зардлаар тооцсон ба эрдэм шинжилгээ, инновацийн зардлын төлөвлөлтийг нэгтгэн хийгээгүй байна. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын зардлын төсвийг бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд тус бүрээр харьцуулахад:

**ТӨСӨЛ, ГЭРЭЭТ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ,
БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)**

Хүснэгт 8.26

№	Бүрэлдэхүүн сургууль нэгжүүд	2018 он		Өөрчлөлт		Дүнд эзлэх хувь
		Төсөв	Гүйцэтгэл	Абсолют	Харьцангуй	
1	БАС	283.70	505.19	221.5	178.1	17.3
2	БУХС	193.45	191.33	-2.1	98.9	6.6
3	ГУУС	1,246.00	1,096.54	-149.5	88.0	37.6
4	ДАРТС	27.88	25.68	-2.2	92.1	0.9
5	МЕХТС	323.90	221.31	-102.6	68.3	7.6
6	МХТС	123.95	83.28	-40.7	67.2	2.9
7	ҮТС	617.13	270.56	-346.6	43.8	9.3
8	ХШУС	113.95	84.31	-29.6	74.0	2.9
9	ЭХС	495.62	191.34	-304.3	38.6	6.6
10	Е-НИ	129.50	47.87	-81.6	37.0	1.6
11	ГХИ	7.00	4.13	-2.9	59.0	0.1
12	АС	3.00	0.60	-2.4	20.0	0.0
13	КТК	-		0.0		-
14	ОУДБСТ			0.0		-
15	ОМССХ	112.00	38.64	-73.4	34.5	1.3
16	ХГ			0.0		-
17	ЗАХ	6.38	6.37	0.0	99.8	0.2
18	ЭШИГ	378.68	151.49	-227.2	40.0	5.2
19	Енэт			0.0		-
20	ТӨВ	-		0.0		-
21	ШУТНС	-		0.0		-
	НИЙТ	4,062.13	2,918.62	-1,143.5	71.8	100.0

Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын зардлын гүйцэтгэлээс харахад тайлант онд эрдэм шинжилгээний зардал 2,918.62 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 71.8 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

ШУТИС-ийн сургууль, бүрэлдэхүүн нэгжүүдээс БАС эрдэм шинжилгээний зардлыг 78.1 хувь буюу 221.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Харин бусад бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн хувьд эрдэм шинжилгээний зардлын гүйцэтгэл дутуу гарсан байна. Тухайлбал: ҮТС 43.8 хувь буюу 346.6 сая төгрөгийн төсвийн дутуу гүйцэтгэлтэй, ЭХС 38.6 хувь буюу 304.3 сая төгрөгийн төсвийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

8.4.5 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ

Тайлант онд ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21 өдрийн 13 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2018 оны төсөвт өөрчлөлт оруулсан. Тодотгосон төсвөөр ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгжүүдийн орлогын төсөвт, төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүйгээр, зардлын төсвийн зүйл ангийг дотор шилжүүлэх зөвшөөрлийг олгосон. Мөн хөрөнгө оруулалт, худалдан авалт, засварын зардлыг хавсралтаар баталж өгсөн. Тодотгосон төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 8.8 тэрбум төгрөг батлагдсаны барилга байгууламжийн хөрөнгө оруулалтад 7,0 тэрбум төгрөг, лаборатори, тоног төхөөрөмжийн зардалд 1,628.18 сая төгрөг, эд хогшил худалдан авахад 227.0 сая төгрөгийг тус тус баталсан.

ШУТИС-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл нь 52.25 сая төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайлангаар урт хугацаат хөрөнгө худалдан авалтын зардлын дүн 2.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ. Шинжилгээний хүрээнд санхүүгийн үр дүнгийн тайлангаар дүгнэж байгаа тул аккруэл суурийг барьж шинжилгээгээ хийсэн. Мөн 2018 оны бүтцийн өөрчлөлтөөр хөрөнгө оруулалтын хангамжийн газарт хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.5, 5.6-д төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ хэмээн хуульчилсан байдаг. Тиймээс хөрөнгө оруулалтын чиглэлээр БСШУСЯ-ны холбогдох газарт хүсэлтээ албан тоотоор өгсөн.

4. САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагааг дүгнэж санхүүгийн үр дүнг тооцох шаардлагатай. Юуны өмнө 2018 он болон 2019 онд өөрчлөн шинэчлэн баталсан ШУТИС-ийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журмын хүрээнд санхүүгийн үр дүнтэй ажилласан нэгжийн удирдлага, багш, ажилтан хамт олныг /санхүүгийн ажилтны хувьд балансын урамшуулал/ үр дүнгээр шагнаж урамшуулахаар заасан байдаг. Мөн санхүүгийн үр дүнгүй хариуцлага алдсан удирдлага, санхүүгийн ажилтанд анхааруулах, дахин алдаа дутагдал гаргахаас сэргийлэх шаардлагатай юм.

Тайлант оны бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүүгийн үр дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнгээр СТ2А, мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээр СТ4А, шилжих үлдэгдэлд суурилсан үр дүнгээр тооцон үр дүнгийн урамшуулал өгөх боломжтой бүрэлдэхүүн нэгжийг тодорхойлсон болно.

2018 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН БОЛОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.27

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	Санхүүгийн үр дүн тайлан			Мөнгөн хөрөнгийн тайлан		
		Орлого	Зарлага	Үр дүн	Орлого	Зарлага	Үр дүн

1	БАС	7,162.12	8,120.65	-958.52	7,677.85	8,776.41	-
2	БУХС	6,010.16	5,882.42	127.74	6,525.86	6,416.40	109.46
3	ГУУС	5,980.77	6,309.86	-329.10	6,321.18	6,464.10	-142.92
4	ДАРТС	3,345.36	3,171.23	174.13	3,559.36	3,231.74	327.62
5	МЕХТС	5,516.51	5,928.91	-412.40	5,869.53	5,862.96	6.57
6	МХТС	4,782.43	5,054.97	-272.54	4,996.67	5,231.76	-235.09
7	ҮТС	6,612.90	7,008.68	-395.78	6,678.99	6,873.31	-194.32
8	ХШУС	4,109.24	4,310.41	-201.17	4,388.71	4,477.91	-89.20
9	ЭХС	6,528.71	5,890.95	637.76	7,552.54	6,590.70	961.84
10	Е-НИ	1,122.35	1,196.86	-74.51	1,213.34	1,223.49	-10.15
11	ГХИ	2,542.36	2,489.73	52.63	2,663.12	2,583.70	79.42
12	АС	498.52	524.79	-26.27	559.01	618.61	-59.59
13	КТК	3,907.54	478.15	3,429.39	458.56	460.57	-2.01
14	ОУДБСТ	150.75	142.65	8.09	180.42	150.38	30.04
15	ОМССХ	159.17	185.60	-26.43	168.90	183.55	-14.65
16	ХЭВЛЭХ ГАЗАР	444.86	538.09	-93.24	522.43	477.84	44.60
17	ЗАХИРГАА	6,459.06	3,675.01	2,784.05	7,128.02	6,773.34	354.68
18	ЭШИГ	521.08	537.81	-16.73	1,471.09	1,382.53	88.56
19	ЭРДЭМНЕТ	120.86	174.67	-53.81	134.97	168.63	-33.66
20	ТӨВЛӨРСӨН	6,267.06	5,813.04	454.01	9,730.78	9,467.00	263.78
21	ШУТНСАН	665.97	610.55	55.41	789.66	732.22	57.44
	НИЙТ	72,907.76	68,045.04	4,862.72	78,590.99	78,147.14	443.85

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнгээр тодорхойлж байгаа үр дүн нь тухайн нэгжийн тайлант хугацаанд олсон аккруэл сууриар тооцсон орлого болон зарлагын зөрүү юм. Энэхүү үзүүлэлтээр авч үзэхэд БУХС, ДарТС, ЭХС, ГХИ, ОУДБСТ, ШУТНомын сан нэмэх буюу эерэг үр дүнтэй гарсан байна. Мөн БАС мөнгөн гүйлгээний тайлангийн хүрээнд эерэг үр дүнтэй болох боломжтой юм. Бусад нэгжүүдийн хувьд үр дүн хангалтгүй буюу хасах үр дүнтэй ажилласан байна. ШУТИС нэгдсэн дүнгээр санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4.8 тэрбум төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайлангаар 443.8 сая төгрөгийн эерэг үр дүнтэй гарсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого, зарлагын дүнгээс бүрэлдэхүүн нэгжүүдийн хоорондын тооцоо болох сургууль хоорондын орлого, сургууль хоорондын зарлагын дүнг хасаж санхүүгийн үр дүнгийн тайлан дээрх орлого, зарлагын үзүүлэлтийг цэвэрлэн үр дүнг тооцвол цэвэр санхүүгийн үр дүн гарах боломжтой юм. Тайлант оны бүрэлдэхүүн нэгжүүдийн санхүүгийн цэвэр үр дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнгээр СТ2А орлого, зарлагын үзүүлэлт дээр бүрэлдэхүүн сургууль, нэгж бүр дээр тооцсон.

САНХҮҮГИЙН ЦЭВЭР ҮР ДҮН, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.28

№	Нэгжүүд	2017 он			2018 он					
		Орлого	Зарлага	Цэвэр үр дүн	Төсөв			Гүйцэтгэл		
					Орлого	Зарлага	Цэвэр үр дүн	Орлого	Зарлага	Цэвэр үр дүн
1	БАС	6,794	5,337	1,457	5,670	6,666	-996	6,550	4,698	1,852
2	БУХС	4,917	5,100	-183	4,051	5,164	-1,113	4,950	4,954	-4
3	ГУУС	5,996	4,806	1,190	5,642	4,627	1,015	5,881	4,577	1,305
4	ДАРТС	5,998	2,890	3,108	2,679	2,885	-206	3,315	3,079	236
5	МЕХТС	4,762	4,499	263	4,252	4,448	-196	5,046	4,681	365
6	МХТС	5,018	4,036	982	5,069	4,164	905	4,763	3,937	825
7	ҮТС	5,967	5,499	468	6,265	5,330	934	6,527	5,629	898
8	ХШУС	1,107	3,580	-2,474	854	3,660	-2,805	999	3,619	-2,619
9	ЭХС	5,895	3,799	2,097	5,288	4,176	1,113	6,398	3,581	2,818
10	Е-НИ	87	1,026	-939	181	1,292	-1,111	113	1,103	-991
11	ГХИ	528	2,352	-1,824	625	2,271	-1,646	577	2,217	-1,640
12	АС	588	619	-31	490	740	-250	499	475	24
13	КТК	382	348	34	450	518	-68	3,908	453	3,454
14	ОУДБСТ	204	208	-5	91	119	-28	151	132	19
15	ОМССХ	188	183	5	440	440	0	150	182	-32
16	ХЭВЛЭХ	325	354	-28	450	405	45	445	488	-43
17	ЗАХ	492	3,073	-2,581	486	5,946	-5,460	570	3,647	-3,078
18	ЭШИГ	511	618	-107	205	609	-405	315	418	-103
19	ЭРНЕТ	407	402	5	70	270	-200	121	175	-54
20	ТӨВ	1,902	23	1,879		2,566	-2,566	2,151	3	2,147
21	ШУТНС	104	464	-360	46	664	-617	74	591	-517
	НИЙТ	52,172	49,214	2,959	43,306	56,975	-13,670	53,502	48,639	4,863

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн аккруэл сууриар тооцсон орлого болон зарлагын дүнгээс сургууль хоорондын орлого, зарлагыг хасаж цэвэрлэсэн орлого, зарлагын зөрүүгээр цэвэр үр дүнг тооцон гаргасан. Энэхүү үзүүлэлтээр авч үзэхэд БАС, ГУУС, ДАРТС, МехТС, МХТС, ҮТС, ЭХС КоосенТК зэрэг бүрэлдэхүүн нэгжүүд нэмэх буюу эерэг үр дүнтэй гарсан байна. Харин БУХС, ХШУС, ЕНИ, ГХИ сөрөг буюу хасах үр дүнтэй гарсан байна. ШУТИС нэгдсэн дүнгээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн цэвэрлэсэн дүнгээр 4.8 тэрбум төгрөгийн эерэг үр дүнтэй гарсан байна.

Тайлант онд ШУТИС нэгдсэн дүнгээр санхүүгийн үр дүн 4,8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеээс 64.36 хувь буюу 1.9 тэрбум төгрөгөөр, төсвийн дүнгээс үеээс 100.0 хувь буюу 4.8 тэрбум төгрөгөөр илүү үр дүнтэй ажилласан байна.

Манай ШУТИС-ийн хэмжээнд дүрэм журмаар баталгаажуулаагүй боловч санхүүгийн үр дүнг тооцоходоо шилжих үлдэгдэл буюу мөнгөн хөрөнгөд суурилсан үзүүлэлтээр өнгөрсөн хугацаануудад тооцож иржээ. Энэхүү үзүүлэлт нь бүрэлдэхүүн нэгжийн жилийн эцсийн харилцах банкны дансны үлдэгдэл дүн болох мөнгөн хөрөнгөөс сургалтын төлбөр болон оюутны дотуур байрны урьдчилж төлсөн орлого, НДШ, татвар, байгууллага, хувь хүнд болон сургууль хооронд өгөх өглөг, төсөл гэрээт ажлын зарцуулаагүй үлдсэн дүн, дараа жилийн төсөвт зарцуулахаар баталсан дүн зэрэг 4 үзүүлэлтийг хасаж тооцон гаргасан мөнгөн хөрөнгөөр олгож болох үр дүн юм.

САНХҮҮГИЙН ҮР ДҮН, БҮРЭЛДЭХҮҮН НЭГЖҮҮДЭЭР (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.29

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	Үр дүн /шилжих үлдэгдэл/					
		Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	УОО /сургалт төлбөр, бусад/	Өглөг	ЭША зарцуулагдаагүй үлдэгдэл	2019 онд шилжих үлдэгдэл	Мөнгөн үр дүн
1	БАС	4,475.30	1,820.16	24.12	177.53	40.00	2,413.49
2	БУХС	1,392.34	812.01	39.26	21.15		519.92
3	ГУУС	640.09	1,350.98	49.05	451.32	195.00	-1,406.26
4	ДАРТС	806.17	469.67	17.06	32.13		287.31
5	МЕХТС	959.88	875.16	33.08	88.56		-36.92
6	МХТС	1,909.10	1,153.74	24.87	54.55		675.94
7	ҮТС	936.55	1,236.17	124.92	344.58	140.58	-909.70
8	ХШУС	1,213.17	260.70		18.76		933.71
9	ЭХС	4,007.91	1,506.81	2.18	208.19	20.00	2,270.73
10	Е-НИ	260.14	1.55	0.40	57.56	25.00	175.62
11	ГХИ	467.61	147.59		1.22		318.80

12	АС	741.48	124.28	2.03		140.00	475.17
13	КТК	82.26	65.80	0.01		147.00	-130.55
14	ОУДБСТ	80.69	4.82	0.00	27.84	50.00	-1.97
15	ОМССХ	4.59	2.00				2.59
16	ХЭВЛЭХ ГАЗАР	87.43	53.27	0.80		30.00	3.36
17	ЗАХИРГАА	604.25		58.71			545.54
18	ЭШИГ	959.06				350.00	609.06
19	ЭРДЭМНЕТ	147.05	1.44				145.61
20	ТӨВЛӨРСӨН	14,454.68		79.92			14,374. 76
21	ШУТНСАН	183.28		18.43			164.85
	НИЙТ	34,413.03	9,886.1 5	474.8 4	1,483.40	1,137.5 8	21,431. 06

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үр дүнгийн үзүүлэлт, мөнгөн гүйлгээний тайлангийн үр дүнгийн үзүүлэлт, сургууль хоорондын орлого, зарлагыг хассан цэвэрлэсэн дүнгээрх санхүүгийн үр дүнгийн тайлангийн үр дүнгийн үзүүлэлт, мөнгөн хөрөнгөд үндэслэсэн шилжих үлдэгдлийн үр дүнгийн үзүүлэлт зэрэг 4 үр дүнгийн үзүүлэлтэд эерэг буюу хангалттай сайн үр дүнтэй ажилласан бүрэлдэхүүн сургуульд ЭХС, ДарТС хамаарагдаж байна. Мөн 2018 онд БАС ШУТИС-ийн захирлын А/87 тоот тушаалын дагуу төвлөрсөн санд 1.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бөгөөд уг дүнгээр орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний эерэг үр дүн гарсан байна. Тиймээс БАС 4 үр дүнгийн үзүүлэлтэд эерэг буюу хангалттай үр дүнтэй ажилласан байна. Харин мөнгөн хөрөнгөд суурилсан шилжих үлдэгдэл, санхүүгийн үр дүнгийн тайлангийн цэвэрлэсэн дүнгээрх үр дүнгийн үзүүлэлт БАС, ДарТС, МХТС, ЭХС эерэг үр дүнтэй гарсан байна.

Харин дээрх үр дүнгийн үзүүлэлтэд ОМССХ, ЕНИ хувьд сөрөг үр дүнтэй буюу хангалтгүй үр дүнтэй гарсан байна.

